МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

ИРГЭНИЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ, ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ /ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЕРӨНХИЙ АНГИ/

Судалгааны төрөл: **Хуулийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээ**
Судалгааны код: **БГСТ-25/005**

ЗАХИАЛАГЧ: Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн

ГҮЙЦЭТГЭГЧ: С.Нарантунгалаг

Улаанбаатар хот
2025 он

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН 2024 ОНЫ 115 ДУГААР ЗАХИРАМЖААР БАЙГУУЛАГДСАН ИРГЭНИЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ТАНИЛЦАЖ, САНАЛ ДҮГНЭЛТ ГАРГАХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСЭГТ МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮҮРЭГ БҮХИЙ I БАГ (I ХЭСГИЙН I-IV ДЭД ХЭСЭГ)

Судалгааны багийн ахлагч:

С.Нарантунгалаг	*Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хувийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ахлах ажилтан* *IY дэд хэсгийн Найм, Есдүгээр бүлэг*

Судалгааны багийн гишүүд:

Т.Болор-Эрдэнэ	*Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш,* *I дэд хэсгийн Нэг, Хоёрдугаар бүлэг, II дэд хэсгийн Гуравдугаар бүлэг*
Б.Лхагвасүрэн	*Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгч* *II дэд хэсгийн Дөрөвдүгээр бүлэг*
Н.Дариймаа	*Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн* *II дэд хэсгийн Дөрөвдүгээр бүлэг*
Б.Хишигбаатар	*Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн Ерөнхий шүүгч* *III дэд хэсгийн Тавдугаар бүлэг*
Э.Золзаяа	*Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Шүүгч* *III дэд хэсгийн Зургадугаар бүлэг*
М.Түвшинжаргал	*Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга* *III дэд хэсгийн Долдугаар бүлэг*

“ИРГЭНИЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ, ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ” СУДАЛГААНЫ ТАЙЛАН

АГУУЛГА

УДИРТГАЛ.....1

I ДЭД ХЭСЭГ. ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАА, ХУУЛЬ ТОГТООМЖ.....3

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....3

ХОЁРДУГААР БҮЛЭГ ҮҮСЭХ ҮНДЭСЛЭЛ, ХАМГААЛАЛТ, ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААНД ЭРХ, ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 8-13 ДУГААР ЗҮЙЛИЙН ХЭРЭГЖИЛТ ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ.....15

II ДЭД ХЭСЭГ. ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААНД ОРОЛЦОГЧИД 14-24 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН ХЭРЭГЖИЛТ ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ.....27

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ИРГЭН.....27

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХУУЛИЙН ЭТГЭЭД.....41

III ДЭД ХЭСЭГ. ХЭЛЦЭЛ.....56

ТАВДУГААР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....56

ЗУРГАДУГААР БҮЛЭГ. ХҮЧИН ТӨГӨЛДӨР БУС ХЭЛЦЭЛ.....68

ДОЛДУГААР БҮЛЭГ. ТӨЛӨӨЛӨЛ.....82

IV ДЭД ХЭСЭГ. ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙ ДЭХ ХУГАЦАА.....92

НАЙМДУГААР БҮЛЭГ. ХУГАЦААГ ТОДОРХОЙЛОХ, ТООЛОХ.....92

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦАА.....97

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БГБХН	Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл
БСБ	Боловсрол сургалтын байгууллага
ГХОХХН	Гадаадын хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл
ГҮТББ	Гишүүдэд үйлчлэх төрийн бус байгууллага
ЗГБХН	Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл
ИХ	Иргэний хууль
ИХШХШтХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
УДШ	Улсын дээд шүүх
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман улс
ХЭУБтХ	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль
ХХН	Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл
ТБАГ	Төрийн байгууллагын албан газар
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Дэлхийн улс орнуудын эрх зүйн тогтолцоог харьцуулалт 5
Хүснэгт 2. Амины эрх, сэтгэл санааны хохирол, шүүхийн практик 13
Хүснэгт 3. Харьцуулалт 25
Хүснэгт 4. Хуулийн этгээдийн хэлбэр тоон үзүүлэлт 52
Хүснэгт 5. Харьцуулалт 82

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 115 дугаар захирамжаар Иргэний хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтан, мэргэжилтэн, судлаачдыг татан оролцуулж, мэдээлэл, судалгаа гаргуулан дүн шинжилгээ хийлгэх хүрээнд судалгааны багуудыг томилон ажиллуулсан.

“Иргэний хуулийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдлын дүн шинжилгээ, үр дагаврын үнэлгээ” судалгааг нийт 41 судлаач, мэргэжилтэн дараах чиглэлээр 5 багт хуваарилагдан гүйцэтгэсэн:

1.Иргэний хуулийн ерөнхий анги
2.Эдийн ба эдийн бус баялгийн эрх зүй
3.Үүргийн эрх зүй
4.Гэрээний эрх зүй
5.Гэрээний бус үүрэг, өв залгамжлал, олон улсын иргэний эрх зүй

Иргэний хуулийн ерөнхий ангийн (I хэсгийн I-IV дэд хэсэг) хэрэгжилтийн судалгааг Н.Отгончимэг, Э.Золзаяа, Б.Хишигбаатар, М.Түвшинжаргал, С.Нарантунгалаг, Ж.Чиймаа, Б.Лхагвасүрэн, Н.Дариймаа, Т.Болор-Эрдэнэ нарын хуульч, судлаач, мэргэжилтнээс бүрдсэн судалгааны баг гүйцэтгэлээ.

Энэхүү судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”, Ажлын хэсгээс баталсан ““Иргэний хуулийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдлын дүн шинжилгээ, үр дагаврын үнэлгээ” судалгааны удирдамж, тайлангийн загвар”-ыг баримтлан хийсэн.

Иргэний хуулийн I хэсгийн I-IV дэд хэсгээс хэрэгжилтийн дүн шинжилгээ, үнэлгээ хийх шаардлагатай зүйлүүдийг сонгохдоо судлаачдын багийн хурлаар хамтран хэлэлцэж шийдвэрлэсэн болно. Хэрэгжилтийн дүн шинжилгээ, үнэлгээ хийх хуулийн зүйлийг сонгохдоо дараах зарчим баримтлав:

- Хэрэгжилтийн дүн шинжилгээ, үнэлгээ хийхээр хуулийн зүйлийг сонгохдоо хэрэгжилтэд сөрөг үр дагавар ямар нэг хэмжээ, хүрээнд илэрч байгаа гэж үзвэл аль болох сонгох зарчим баримтлах,
- Иргэний хуулийн тухайн зүйлийн хувьд хэрэгжилтэд ямар нэг сөрөг үр дагавар гараагүй хэдий ч сонгож судлах нь цаашид эрх зүйн хөгжил, агуулгын хувьд чухал ач холбогдолтой гэж үзвэл сонгох зарчим баримтлах,
- Судалгааны явцад анх сонгосон хүрээг өргөжүүлэх, эсхүл хасах нөхцөл байдал үүсэж болзошгүйд нээлттэй хандах.

Хуулийн хэрэгжилтийн нөхцөл байдалд дүн шинжилгээ, үнэлгээ хийхдээ тухайн зохицуулалт нь зорилгоо хангаж байгаа эсэх, амжилттай хэрэгжиж байгаа бол эерэг нөлөөллийг илрүүлэх, ололтыг бататган дүгнэх, хүндрэл, бэрхшээл гарч байгаа бол сөрөг нөлөөллийг илрүүлэх, шалтгаан нөхцөлийг тодорхойлох, тухайн зүйл, хэсэг, заалт нь Иргэний болон бусад хуулийн зохицуулалттай зөрчилтэй байгаа эсэх, цаашид зохицуулалтыг боловсронгуй болгох, зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох, шийдлийн хувилбар санал болгох арга зүй баримталлаа.

Судалгааны тайлангийн дотоод бүтэц, хэлбэрийг жигдрүүлж онол ба хууль хэрэглээний практик, зохицуулалт бусад хууль тогтоомжтой нийцэж буй байдал, харьцуулсан шинжилгээ, санал дүгнэлт гэсэн ерөнхий бүтэцтэйгээр боловсруулав.

--oOo--

I ДЭД ХЭСЭГ. ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАА, ХУУЛЬ ТОГТООМЖ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Иргэний хуулиар зохицуулах харилцаа, баримтлах зарчим, иргэний хууль тогтоомжийг дагаж мөрдөх, хэрэглэх, төсөөтэй хэрэглэх, буцаан хэрэглэх, харилцааны обьект, харилцаанд оролцогчийг тодорхойлсон зохицуулалтыг I дэд хэсгийн нэгдүгээр бүлэгт 1-7 дугаар зүйлд хуульчилсан байна. Иргэний эрх зүйгээр зохицуулах харилцаа, баримтлах зарчим, хууль тогтоомжийн хэрэглээний онолын ойлголт болон практикт хэрэглээний зөрүү үүсэж буй эсэх, бусад улс орны ИХ-иар зохицуулж буй харилцаа, хууль хэрэглээний ойлголтын нэгдсэн байдлыг харьцуулан судлахыг зорилго болгож “судалгааны удирдамж, тайлангийн загвар, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу хийж гүйцэтгэлээ.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	
ЗҮЙЛ	**ЗОХИЦУУЛАЛТ**
1 дүгээр зүйл. Хуулийн зорилт	1.1.Энэ хуулийн зорилт нь эрх зүйн этгээдийн хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
	1.2.Иргэний хууль тогтоомж нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдал, өмчийн халдашгүй байдал, гэрээний эрх чөлөө, хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх, иргэний эрх үүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, шүүхээр хамгаалуулах зарчимд үндэслэнэ.
	1.3.Хуульд өөрөөр заагаагүй бол татвар, төсөв, санхүү зэрэг захиргааны хууль тогтоомжоор зохицуулах болон захиргааны талаар нэг этгээд нөгөөдөө захирагдах эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцаанд энэ хууль үйлчлэхгүй.
2 дугаар зүйл. Иргэний хууль тогтоомж	2.1.Иргэний хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.
	2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг дагаж мөрдөнө.
3 дугаар зүйл. Иргэний хууль тогтоомжийг хэрэглэх	3.1.Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн хуулийг шүүх хэрэглэхгүй.
	3.2.Тухайн асуудлаар дотоодын хууль тогтоомж гаргах шаардлагатай гэж олон улсын гэрээнд зааснаас бусад тохиолдолд иргэний эрх зүйн харилцаанд Монгол Улсын олон улсын гэрээг хэрэглэнэ
	3.3.Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуулиас бусад хууль хоорондоо зөрчилдвөл тухайн асуудлыг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэнэ. **Өрсөлдөөний тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3.Өрсөлдөөний тухай хуулийг Иргэний хуулийн 3.3-т заасны дагуу өрсөлдөөний харилцааг илүү нарийвчлан зохицуулсан хууль гэж үзнэ. Хуульчилсан**
	3.4.Хуулийг хүчингүй болгох тухай хуулийг хүчингүй болгосноор өмнө хүчингүй болгосон хуулийн үйлчлэл сэргэхгүй.
	3.5.Хуульд заасан тохиолдолд Засгийн газар энэ хуульд нийцүүлэн гаргасан, иргэний эрх зүйн хэм хэмжээ агуулсан, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актыг хэрэглэж болно. */Энэ хэсгийн "...эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтны..." гэснийг Үндсэн хуулийн цэцийн 2003 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 1 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон/*
	3.6.Хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг зөвхөн хуулийн хэм хэмжээг нөхөн зохицуулсан тохиолдолд хэрэглэнэ.
	3.7.Хуулийг мэдэхгүй буюу буруу ойлгосон нь хуулийг хэрэглэхгүй байх, хуульд заасан хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

4 дүгээр зүйл. Иргэний хуулийг төсөөтэй хэрэглэх	4.1.Иргэний хуульд тухайн харилцааг зохицуулсан хэм хэмжээ байхгүй бол түүнтэй төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийн хэм хэмжээг хэрэглэнэ.
	4.2.Төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийн хэм хэмжээ байхгүй бол тухайн харилцааг иргэний эрх зүйн агуулга, зарчим, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд нийцүүлэн зохицуулна.
	4.3.Тусгай харилцааг тухайлан зохицуулсан хэм хэмжээг бусад харилцаанд төсөөтэй хэрэглэж үл болно.
5 дугаар зүйл. Иргэний хууль тогтоомжийг буцаан хэрэглэх	5.1.Хуульд зааснаас бусад тохиолдолд иргэний хууль тогтоомжийг буцаан хэрэглэхгүй.
	5.2.Шинээр баталсан хууль тогтоомж нь гэрээний нэг буюу хоёр талын эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахаар бол гэрээний нөхцөл хүчин төгөлдөр байна
	5.3.Гэрээний талууд харилцан хүлээн зөвшөөрсөн тохиолдолд өмнө үйлчилж байсан хууль тогтоомжоос илүү тааламжтай нөхцөл олгож байгаа шинээр баталсан хууль тогтоомжийг хэрэглэж болно
6 дугаар зүйл. Иргэний эрх зүйн харилцааны объект	6.1.Хуульд заасан үндэслэл, журмаар иргэний гүйлгээнээс хасагдаагүй, мөнгөөр үнэлж болох, эдийн болон эдийн бус баялаг иргэний эрх зүйн харилцааны объект байна.
	6.2.Эдийн болон эдийн бус эрх, үйлдэл, эс үйлдэхүй, мэдээлэл иргэний эрх зүйн харилцааны объект байж болно.
7 дугаар зүйл. Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч	7.1.Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч нь иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага байна
	7.2.Иргэн гэж иргэний эрх зүйн харилцаанд оролцогч- Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг ойлгоно.
	7.3.Төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болох аймаг, сум, нийслэл, дүүрэг нь иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцоно. */Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан.*

Нэг. Онолын ойлголт

Иргэний эрх зүйн онол нь хувь хүн, хуулийн этгээдийн хоорондын эд хөрөнгөтэй холбоотой харилцааг зохицуулдаг эрх зүйн салбарын суурь зарчмууд, ойлголт, тогтолцооны тухай онолын судалгаа юм.[1] Энэхүү онол нь дэлхий даяарх эрх зүйн тогтолцоонуудын ялгаа, адил төстэй байдал дээр үндэслэж хөгжиж ирсэн бөгөөд тухайн улс орны соёл, эдийн засаг, түүхэн уламжлалтай холбоотойгоор өөр өөрөөр хөгжиж ирсэн. Иргэний эрх зүйн хэмээх нэр томьёо нь эртний Ромын эрх зүйгээс гаралтай ба Ромын иргэд эд хөрөнгөө өмчлөх, эзэмших, эрхтэй гэсэн үзэл, сэтгэлгээ бий болж улмаар тэр нь эрх зүйгээр баталгаажин эрх зүйн системд (JUS CIVIL) буюу Иргэний эрх зүй гэсэн салбар болон үүсэн хөгжсөн байна. [2]

Монгол Улсын хувьд 2002 оны ИХ-ийн системчлэлийг авч үзвэл нийт I-VI хэсгээс бүрдэх ба эдгээрээс уг хуулийн тогтолцоог тод харж болно. Тухайлбал 1/.ерөнхий анги буюу нийтлэг үндэслэлүүд, ИХ-ийн 1-185; 2/.үүргийн эрх зүйн нийтлэг зохицуулалт, ИХ-ийн186-242; 3/.гэрээний эрх зүй, ИХ-ийн 243-486; 4/.гэрээний бус үүрэг, ИХ-ийн 487-514; 5/. өвлөх, ИХ-ийн 515-538; 6/. олон улсын иргэний эрх зүй, ИХ-ийн 539-552 гэсэн хэсгээс бүрдэнэ. МУ-ын ИХ нь ерөнхий ангийн техникийг ашигласан нийтлэг зохицуулалт хэмээх нэгдүгээр бүлэгтээ иргэний эрх зүйн хэлцэл, төлөөлөл, хөөн хэлэлцэх хугацаа зэрэг ерөнхий агуулга бүхий зохицуулалтаас гадна эд юмсын эрх зүйг хамарсан гадаад бүтэцтэй. Энэ хэсэг нь нийт хувийн эрх зүйн түвшинд объект, субъектийг тодорхойлсон, нийтлэг зарчмын шинжтэй

[1] Д.Нарачимэг “Иргэний эрх зүйн үндсэн асуудал” УБ, 1999 он 1-р тал
[2] Б.Баттөмөр “Монгол Улсын иргэний эрх зүй” УБ, 2004 он 8-р тал

хэм хэмжээ агуулж буй нь ИХ-ийг хувийн эрх зүйн үндсэн кодификаци гэж үзэх үндэслэл болдог байна.[3]

Хүснэгт 1. *Дэлхийн улс орнуудын эрх зүйн тогтолцоог харьцуулалт*

Тогтолцоо	Тайлбар	Иргэний эрх зүйн онцлог
Континенталь (Европын эх газрын)	Германы, Францын эрх зүйн уламжлал дээр суурилсан. Хууль нь бичмэл, системчилсэн кодекс хэлбэртэй.	Иргэний хууль нь эрх зүйн системийн гол тулгуур. Онол нь хууль тогтоомжийн тайлбар, системийн дотоод логик дээр төвлөрдөг.
Англо-Саксоны (Common Law)	Англи, АНУ, Канад зэрэг улсад хэрэглэгддэг. Шүүхийн шийдвэр үндсэн эх сурвалж.	Иргэний эрх зүйн онол нь тохиолдлын эрх зүйн прецедент дээр тулгуурладаг. Contract Law, Tort Law гэх мэт салбарлаж хөгжсөн.
Социалист эрх зүйн тогтолцоо	ЗХУ болон социалист орнуудад байсан, одоогоор зарим улсад нөлөөтэй хэвээр.	Иргэний эрх зүйн онол нь төрийн өмч, төлөвлөгөөт эдийн засгийн хүрээнд хөгжсөн. Гэхдээ 1990-ээд оноос хойш зах зээлийн эрх зүйн тогтолцоо руу шилжсэн.
Холимог системүүд	Япон, Өмнөд Солонгос, Швейцар зэрэг оронд Европ ба Англо-Саксоны тогтолцоог хослуулсан.	Жишээ: Япон нь Германы кодексыг хуулбарласан ч англо-саксоны зарим шүүхийн практик, баримт нотолгооны зарчим нэвтрүүлсэн.

Иргэний эрх зүйн онолын гол зарчмууд (дэлхий нийтэд нийтлэг)

- Эрхийн субьектын тэгш байдал
- Гэрээний эрх чөлөө
- Хариуцлагын зарчим (Tort / Delict law)
- Өмчийн эрхийн хамгаалалт
- Сайн санааны зарчим (Good faith)
- Эрхийн хэрэгжилтийн хязгаарлалт (Prescription)

Дэлхийн эрх зүйн тогтолцооны хувьд Монгол Улс нь Континенталь[4] эрх зүйн тогтолцоонд багтдаг бөгөөд Иргэний хуулийн 2002 оны шинэчилсэн найруулга нь Герман улсын, Франц улсын кодексууд болон ОХУ-н хууль зүйн уламжлал дээр суурилсан байдаг. Иргэний эрх зүй нь Монгол Улсын эрх зүйн тогтолцооны бие даасан салбар бөгөөд харилцаанд оролцогчдын хооронд үүссэн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг талуудын эрх тэгш байдалд үндэслэн тэдгээрийн хүсэл зориг болон эд хөрөнгийн бие даасан байдлыг ханган зохицуулж байгаа хэм хэмжээний системчлэгдсэн нийлбэр цогц юм.[5] Эдийн баялагтай холбоотой харилцаа нь эд юмс, түүнийг олж авах, эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбоотойгоор иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүсч байгаа харилцаа бөгөөд энэ нь ямагт эдийн засгийн утгыг агуулж байдгаараа онцлог юм.[6]

“Монгол Улсын болон Гадаадын иргэний хуульд бүтцийн анализ хийх нь” судалгааны тайланд либерал ИХ-иуд нь дотоод агуулгаа формал хэлбэрээр тодорхойлж, иргэний эрх зүйн хууль тогтоомжид нийтдээ тусгалаа олсон эрх зүйн харилцааг иргэний эрх зүйн

[3] Б.Буянхишиг, Хувийн эрх зүйн кодификаци, харьцуулалт, 2021 он.

[4] Ром-Германы эрх зүйн бүл буюу континенталь эрх зүйн тогтолцоо бөгөөд хуулийг кодчилсон байдлаар зохицуулдаг. Энэ бүлд Италийн Иргэний хууль (Codice Civile), Швейцарийн Иргэний хууль (Zivilgesetzbuch – ZGB), Нидерландын Иргэний хууль (Burgerlijk Wetboek), Грек, Австри, Испани, Португал зэрэг улсуудын иргэний хуулиуд хамаарна.

[5] Д.Наранчимэг “Иргэний эрх зүйн үндсэн асуудал” УБ, 1999 он 1-р тал

[6] Б.Баттөмөр “Монгол Улсын иргэний эрх зүй” УБ, 2004 он 8-р тал

зохицуулах зүйл мөн гэж үзэх формал хуулийн техник үйлчилдэг.[7] Харин МУ-ын ИХ-ийн §1.1-д “эрх зүйн этгээдийн хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулна” гэсэн нь нийт нийгмийн харилцаанаас иргэний эрх зүйн харилцааг таслан авч үзэхийг шаардана. Тухайн нийгмийн харилцаа ямар шинжтэй байхыг эрх зүйн түвшинд бүрэн тодорхойлох боломжгүйн улмаас энэ тодорхойлолт өөр хүчин зүйлсийг ашиглахад хүргэх ба үүгээрээ социалист хуулийн техникийн сул талыг өөртөө агуулсан. ИХ нь “хөрөнгийн харилцаа” эсвэл “эдийн болон эдийн бус баялгийн харилцаа” гэсэн үг хэллэгийг ашигласан. Гэхдээ энэ нь ч мөн туйлын тодорхойгүй юм. Социалист ИХ нь бүх эрх зүйн субъект хоорондын хөрөнгийн харилцааг, тухайлбал социалист тогтолцоон дахь бүх иргэн, ААН, байгууллага хоорондын эд хөрөнгийн харилцааг хамарч байв. Харин энэ тодорхойлолт нь 1/. эдийн ба эдийн бус баялаг хүн хооронд эрх зүйн харилцаа үүсэж болохгүй гэсэн үзэл онолд тулгуурласан, эд юмсын эрх зүй дэх өмчлөх эрхийн болон бусад хязгаарлагдмал эрхийн асуудлыг оновчтой шийдвэрлэхэд саад болохуйц байна. Мөн 2/. захирах-захирагдах харилцаан дахь хөрөнгийн харилцаанаас иргэний эрх зүйн харилцааг зааглах ялгахад ихээхэн хүндрэл дагуулах ба баялгийн хуваарилалттай холбоотой хууль тогтоомжид /газар гэх мэт/ ялгавартай зохицуулалт тусгахад бэрхшээл үүсгэж, агуулгаар нь захиргааны эрх зүйд хандуулах зэрэг зөрчилд хүргэж байгаа; 3/. хөдөлмөрийн болон үйлчилгээний салбар энэ тодорхойлолтод хамаарч байгаа эсэхээс үл хамааран тусгаарлах болсон үндэслэл нь тодорхой бус учир дутагдалтай.[8]

Хоёр. Монгол Улсын шүүхийн болон хууль хэрэглээний практик

Иргэний хуулийн эхний хэсэгт иргэний эрх зүйн зохицуулах харилцааг, баримтлах зарчим, үйлчлэх хүрээг тодорхойлжээ. Иргэний хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-т хуулийн зорилт нь эрх зүйн этгээдийн хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцаа 1) эдийн баялаг 2) эдийн бус баялаг гэж тодотгож ангилсан байна. Иргэний эрх зүйн харилцааг ингэж ангилахдаа субьектын хувьд иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, 2022 онд хуулийн өөрчлөлт оруулж төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болох аймаг, сум, нийслэл, дүүрэг нь иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил хамаарахаар зохицуулсан. Гэвч 1)эд хөрөнгийн эрхийн зохицуулалтыг хуульчилсан, амины эрхийн зохицуулалт нарийвчлагдаагүй, 2) зорилтыг тодорхойлсон боловч технологийн эрин үе, хүний эрхэд суурилсан хөгжлийн чиг хандлагатай нийцэхгүй хууль хэрэглээний нэгдмэл ойлголтын зөрүүтэй байдал бий болж байна.

ИХ-д тусгагдсан өөр нэг зөрчилдөөний хэм хэмжээ бол ИХ-ийн 2.1 бөгөөд иргэний эрх зүйн системчлэлийг бүрдүүлж буй гэдэг утгаараа ИХ нь бусад иргэний хууль тогтоомжийн хэмжүүр болох тухай энд заажээ. Энэхүү ИХ-ийн давуу үйлчлэл нь бусад хууль тогтоомж, ялангуяа төр эрх зүйн шинжтэй, тогтолцооны тухай хэм хэмжээгээр зохицуулагдаагүй. Тиймээс практикт тусгай хууль тогтоомж давуу үйлчлэх ерөнхий онолын зарчмыг баримтлах нь элбэг. Тухайлбал хувийн эрх зүйн салбарт Компанийн тухай хууль, оюуны өмчийн тухай хууль тогтоомж зэрэг нийт салбарын системийг бүрдүүлэгч актууд бий. Эдгээр тусгай хууль тогтоомжийг ИХ-д нийцүүлэн шалгах уу эсвэл тусгайлсан агуулга бүхий хууль гэдэг утгаараа ИХ ийн агуулгатай үл нийцэх тохиолдлыг хүлээн зөвшөөрөх үү гэдэг тухайд ИХ-ийн 2.1-д заасан зөрчилдөөний хэм хэмжээ нь эрх зүйн ерөнхий онолын lex specialis derrogat legi generali буюу тусгайлсан зохицуулалт нийтлэг хэм хэмжээнээс давуу үйлчлэх зарчмаас зөрж байгаа талаар (Ph.D) (Ass.Juri.)Б.Буянхишиг дүгнэсэн байдаг.

[7] Petev, Valentin: Sozialistisches Zivilrecht, 1977, S.17.
[8] Монгол Улсын болон Гадаадын иргэний хуульд бүтцийн анализ хийх нь Судалгааны тайлан 2021 он судалгааг гүйцэтгэсэн Б.Буянхишиг. МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, Хууль зүйн ухааны доктор (Ph.D) (Ass.Juri.)

Түүнчлэн ИХ-н 3.3-т заасан “Иргэний хуулиар зохицуулаагүй асуудлыг иргэний эрх зүйн нийтлэг зарчимд нийцүүлэн хэрэглэнэ” гэсэн заалтыг шүүхийн практикт хэрхэн ойлгож, хэрэгжүүлэх нь нэгдсэн аргачлалгүй, зөрүүтэй тайлбарлагдаж байна. Түүнчлэн тусгай хуулиудтай уялдах байдлын тухай асуудал ч тодорхойгүй хэвээр байгаа юм. Тухайлбал, Арилжааны эрх зүйн зохицуулалттай холбоотой тусгай хуулиуд нь Иргэний хуулийн үндсэн зарчмыг гажуудуулах, эсвэл давхцах явдал бий болсон нь хууль хэрэглээний эрэмбэ, логикт сөрөг нөлөө үзүүлж байна. Энэ талаао иргэний эрх зүйн салбарын хуульч, судлаач, эрдэмтэн багш нарын зүгээс 2002 оны ИХ-н шинэчлэл, системчлэл, арилжааны болон худалдааны хууль тусгайлан байх эсэх, ИХ-н зөрчилдөөний хэм хэмжээ, дотоодын тусгайлсан/нарийвчилсан хууль тогтоомжийн хүчин чадлын эрэмбэ, хэрэглээ зэрэгт ихээхэн анхаарал хандуулж, өөр өөрийн байр суурийг илэрхийлж байгаа билээ. Үүнээс дурдвал,

1. **Улсын дээд шүүхийн иргэний хэргийн танхим 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн “арилжааны ерөнхий хууль”-ийн төсөлд удш-ээс 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн албан бичгээр хүргүүлсэн санал:** Арилжааны ерөнхий хууль ба Иргэний хуулийн үйлчлэх эрэмбийг анхаарах шаардлагатай. Төслийн Арилжааны хууль тогтоомжийг хэрэглэх гэсэн 5 дугаар зүйлд арилжааны харилцаанд тус хууль нь илүү нарийвчилсан хууль байхаар заасан байна. Нэгэнт арилжааны харилцааг зохицуулах тусгайлсан хууль тул үйлчлэх эрэмбийн хувьд тэргүүн ээлжид үйлчлэх нь зохистой. Гэвч Иргэний хууль нь анх боловсруулагдахдаа эдийн болон эдийн бус амины харилцааны суурь бөгөөд нарийвчилсан хууль байх үндсэн үзэл баримтлалд тулгуурласан. Энэ агуулгаар Иргэний хуулийн 3.3-т “Үндсэн хууль, энэ хуулиас бусад хууль хоорондоо зөрчилдвөл тухайн асуудлыг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэнэ” гэж заан, Иргэний хууль бусад хуультай зөрчилдвөл тухайн хууль нарийвчилсан эсэхээс үл хамааран эхний эрэмбээр үйлчлэх тэргүүлэх хүчин чадалтай байхыг баталгаажуулсан. Хэрэв Арилжааны ерөнхий хуулийн төслийн 5 дугаар зүйл энэ хэвээр дэмжигдвэл тус зохицуулалтын хүрээнд Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн үндсэн үзэл баримтлал хөндөгдөх нь зайлшгүйг анхаарч, үзэл баримтлалын шинжтэй томоохон өөрчлөлт Иргэний хуульд тусах шаардлагатай байх тул цаг алдалгүй томьёоллын зөв хувилбаруудыг санал болгох нь чухал.
2. **Арилжаа (худалдаа)-ны хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан (2019):** Монгол Улсын ИХ-н хүрээнд аж ахуйн үйл ажиллагааны онцлогт нийцсэн зарим хэм хэмжээг бий болгосныг харуулдаг. Өөрөөр хэлбэл хувийн эрх зүйн ердийн харилцааг зохицуулах нийтлэг зохицуулалт болон аж ахуйн харилцааг зохицуулах тусгай зохицуулалт Иргэний хуульд зэрэгцэн оршиж байна. Монгол Улсын Иргэний хууль нь иргэн хоорондын олон аж ахуй эрхлэгч хоорондын аль аль эрх зүйн харилцааг зохицуулахуйц эрх зүйн хэм хэмжээг өөртөө агуулсан буюу монист загварыг хэрэглэсэн гэж дүгнэж болно. Тиймээс иргэн хоорондын болон аж ахуй эрхлэгч хоорондын эрх зүйн харилцааг зааглан ялгах тодорхой шалгуур шаардлагатай. Монгол Улсын одоогийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд иргэд хоорондын хэлцлийн харилцаа болон аж ахуй эрхлэгч хоорондын хэлцлийн харилцааг ялгамжтайгаар зохицуулахгүй байгааг өмнөх хэсгүүдээс харж болно. Харин үүнийг эх газрын эрх зүйн систем бүхий Герман, Япон, Франц зэрэг улсуудын эрх зүйн зохицуулалтыг авч үзвэл ялгамжтай байдлаар буюу Иргэний хууль, Худалдааны хууль гэсэн бие даасан хуулиудаар зохицуулж байна. Иймд иргэд хоорондын харилцааг аж ахуй эрхлэгчийн харилцаанаас ялган зохицуулахын тулд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Иргэний хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, эсхүл бие даасан Арилжааны хууль /Худалдааны хууль/-ийн төсөл боловсруулах уу гэдэг асуудал үүснэ. Өөрөөр хэлбэл Иргэний хууль нь иргэн, хуулийн этгээдийн хоорондын

нийгмийн суурь харилцааг зохицуулах ерөнхий хууль байх бол Арилжаа /Худалдаа/-ны хуулийн төсөл нь зөвхөн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй субьектүүдэд хамаарах тусгай 52 хуулийн шинжтэй байх нь зохимжтой. Иргэний хууль нь нийгэм дэх иргэн, хуулийн этгээд хоорондын үүсэх гэрээний болон гэрээний бус үүргийн харилцаа, өмчийн харилцааг цогцоор нь зохицуулдаг суурь хууль байх тул тус хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар аж ахуй эрхлэгчийн ялгамжтай зохицуулалтыг бий болгохоос илүүтэй аж ахуй эрхлэгчийн харилцааны онцлогийг агуулсан бие даасан хуулийн төсөл байх нь илүү оновчтой арга зам юм.[9]

3. **Монгол Улсын болон Гадаадын иргэний хуульд бүтцийн анализ хийх нь Судалгааны тайлан (2021) судалгааг гүйцэтгэсэн Б.Буянхишиг. МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, Хууль зүйн ухааны доктор (Ph.D) (Ass.Juri.):** 2002 оны ИХ нь Civil Law нэртэй л болохоос эдийн засгийн харилцааны суурь кодификаци буюу Арилжааны Кодекс гэж тодорхойлон дүгнэсэн байдаг. Тийм учраас энд логикийн хувьд Арилжааны Кодексийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа ИХ-иас Арилжааны Хуулийг таслан баталснаар логикийн хувьд өөр нэртэй боловч эдийн засгийн нэг зорилго бүхий 2 хууль бий болно. Хэдий "иргэний" хууль нэртэй ч хувь этгээдийн эдийн засгийн харилцаанд оролцох, аж ахуйн үйл ажиллагаанд хандсан эрх зүйн зохицуулалтад түлхүү агуулсан, иргэн хувь этгээдийн хамгаалалт дутуу байгаа нь хувийн эрх зүйн харилцааг төгс хамрах анхдагч зорилгодоо хүрээгүй гэж үзэх үндэслэл юм. Энэ шалтгаанаар 2002 оны ИХ-д дүн шинжилгээ хийсний үр дүнд хувийн эрх зүйн цөмийг агуулсан уг хуулийг тусгайлсан кодификацийн аргаар дэлгэрүүлэн зохицуулах нь ИХ-ийн хамрах хүрээ, дэлхий нийтийн сайн жишигт нийцэх, мөн хууль хэрэглээний түвшинд нэгэнт байгуулсан нүсэр системт тогтолцоогоо улам чанаржуулах, цахим орчинд хэрэглэгчийг хамгаалсан өргөн хүрээ бүхий хууль тогтоомж болгон хөгжүүлэх боломжтой хэмээн дүгнэлээ. Туйлын олон зохицуулах зүйл бүхий хувийн эрх зүйн харилцаанд сонгодог кодификацийн аргыг түүний дэвшилтэт хувилбар болох номоор буюу тусгайлсан кодификацийн аргатай хослуулан гэр бүлийн эрх зүй, хэрэглэгчийн гэрээний хамгаалалтыг нэгтгэх нь хувийн эрх зүйн тусгай салбарууд бие даан хөгжих, зохицуулалтыг тухай бүр нь шинэчлэн найруулах боломж олгохоор байна.[10]

4. **Б.Амарсанаа, Монгол Улс, Япон Улсын хууль тогтоомжийн хөгжил: Худалдаа (арилжааны эрх зүй), (2017)**: ИХ-ийн бүтцийг дахин үнэлж, томоохон бүлгүүдийн хоорондын агуулгын тэнцвэрийг хангахын тулд "эд хөрөнгийн эрх", "хувь хүний эрх", "ариун журам, нийгмийн эрх ашгийг хамгаалах" гэсэн чиглэлүүдийг тусгайлан ялгаж, тодорхой ангилал бүхий хэлбэрт оруулах шаардлагатай. [11]Энэ хүрээнд Арилжааны хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчлэлтэй уялдуулан ИХ-ийн хамрах хүрээг өргөтгөж, хүний эрхийн агуулгыг гүнзгийрүүлэн тусгах ёстой.

5. **"Иргэний хуулийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдлын дүн шинжилгээ, үр дагаврын үнэлгээ" сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийн тэмдэглэл 2025.04.14 Улсын Дээд шүүхийн шүүгч Н.Баярмаа:** гэдэг санаагаа хэлсэн заалт. Кодексын шинж чанартай пандектын хэв маягтай хууль байх уу? Өөрөөр хэлбэл энэ дотор бүх юмыг эхнээс нь эхлээд төгсгөлийн энд цэг хүртэл зохицуулдаг хууль байх уу үгүй юү гэдгээ шийдсэн заалт. Яг энэ агуулгаараа 2002 онд гэрээний тусгай төрлүүдийг тэнд нарийвчлан оруулаад тэр үед манайд худалдааны хууль байгаагүй одоо ч байхгүй байгаа. Зүгээр байлгая гэж ярьж байгаа үзэл баримтлалын түвшинд. Энэ худалдааны

[9]Арилжаа (худалдаа)-ны хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан 2019 он
[10] Монгол Улсын болон Гадаадын иргэний хуульд бүтцийн анализ хийх нь Судалгааны тайлан 2021 он судалгааг гүйцэтгэсэн Б.Буянхишиг. МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, Хууль зүйн ухааны доктор (Ph.D) (Ass.Juri.)
[11] Мөн тэнд.

хууль өөрөө бас иргэний хуультай тодорхой тохиолдолд зарим харилцаанууд дээр эн тэнцүү оршиж байгаа шинж байдал гадны орнуудад харагдаж байгаа. Зарим орнууд анхнаасаа худалдааны хууль, иргэний хууль хоёроо цуг явуулж байснаа сүүлдээ нэгтгээд явж байгаа орнууд ч байгаа Голланд зэргийн. Зарим орнууд болохоор анхнаасаа хоёрооро тэр чигээрээ хоёрооро явж байгаа Герман, Франц, Япон гэх мэт. Гэхдээ манайх тухайн үед бол тэгж сонгоогүй юм байна 2002 онд. Гэхдээ одоо худалдааны хууль ороод ирвэл иргэний хууль яах вэ гэдэг асуудал яригдах байх. Бусад жижиг хуулиудын хувьд жишээлбэл, Хөдлөх хөрөнгийн барьцаа, санхүүгийн түрээсийн хууль, өөр бусад нэг хэсэг бас ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах тухай хууль гэдэг ийм жижиг хуулиуд гарч эхэлсэн. Иргэний хууль чинь тухайн харилцааг эхлүүлээд төгсгөл хүртэл нь өөр дээрээ зохицуулна аа. Энэ өөрөө ийм бүтэн кодексын чанартай эх хууль байна аа гэж хэлсэн байсан учраас энэ хууль эхлээд Үндсэн хууль, энэ хууль, тэгээд энэ хуультай өөр хуулиуд зөрчил үүсвэл өөрөөр хэлбэл энэ тусгайгаас ерөнхийгийн зарчмаар явж байгаа биш байхгүй юу. Анализын хувьд энэ анхнаасаа өөрөө тусгай хууль байхгүй юу. Ерөнхий ч хийгээд тусгай ч шинжийг агуулсан хууль. Гэхдээ юмс өөрчлөгддөг. Хэрвээ бид Иргэний хуулийн маань гэрээний тусгай төрлүүд зарим тусгай асуудлууд нь бүрэн гүйцэд зохицуулж чадахгүй байна аа гэж үзэх юм бол тэр хэсгийг нэмж зохицуулж бол болно. Нэмж зохицуулж хууль гаргаж болно. Гэхдээ аягүй болгоомжтой хандахгүй бол Иргэний хууль бусад тусгай хуулиудтай зөрчилдвөл тусгай хуулиа барина гээд явчих юм бол учир дутагдалтай.

6. **“Иргэний хуулийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдлын дүн шинжилгээ, үр дагаврын үнэлгээ” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийн тэмдэглэл 2025.04.14: багш Т.Мэндсайхан:** Иргэний хуулийн 3 дугаар зүйл дээр яах вэ үнэлнэ гээд биччихсэн байна л даа. Тэгэхдээ сая тодорхой сайн яригдсангүй. Би бол энэ 3 дугаар зүйл ялангуяа 3.1, 3.2, 3.3 ч гэдэг юм уу. Энийг одоо нэг бүхэлд нь харахгүй бол хуулийн эрэмбэ дээр Иргэний хууль доторх эрэмбэ нь их тодорхой биш. За тэгээд дараа нь Иргэний хууль чинь бүхэлдээ нөгөө диспозитив гэж ойлгодог хэрнээ диспозитив байдал нь заримдаа харагддаггүй. Одоо тэрийг заавал л императив шинжтэй байдлаар хэрэглэдэг ийм нэг буруу практик яваад байна л даа.
7. Бусад зарим судлаачдын үзэж байгаагаар банк оролцсон гэрээ, маргаантай холбоотой хэргүүд дээр Иргэний хууль, Банкны тухай хууль, Эрүүгийн хуулийн заалтын хооронд хэм хэмжээний зөрчилдөөн үүсч байгаа нь зохицуулалтын цоорхойг харуулж байна. Түүнчлэн үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой асуудлууд дээр бүртгэлийн зохицуулалт[12], ИХ-ийн хэм хэмжээнүүд зөрчилдөх нөхцөл үүсдэг бөгөөд энэ нь зөрчилдөөнийг хэрхэн шийдвэрлэх талаар эрх зүйн тодорхой хэм хэмжээ дутагдаж буйг илтгэнэ.[13]

Хуулийн цахим фортал сайтад 932 хуул бүртгэлттэй нээлттэй байна[14]. Дараах 53 гаруй хууль нь Хууль тогтоомжийн бүрдэл хэсэгт “Иргэний хууль”-г иш татсан байна. Тодруулбал тус хуулиад нь иргэний хууль тогтоомж хэмээх ойлголтод хамаарах буюу иргэний эрх зүйн харилцааг шууд бус агуулгаар зохицуулж байна. Үүнээс гадна зөвхөн Зөрчилдөөний тухай хуульд “Энэхүү хуулийн нь иргэний хуулийн нарийвчилсан хууль ” гэж хуульчилсан байна. Харин бусад хуулиудын хувьд хэрхэн Иргэний хуульд нийцэж буй эсэхэд хууль тус бүр үнэлгээ хийх шаардлагатай. Эвлэрүүлэн зуучлалын тухай (2012), Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай (2018), Цахим гарын үсгийн тухай (2021) Хадгаламж, зээлийн хоршооны тухай (2011), Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн

[12] МУ-ын шинэ ИХШХШЭЗ ба Үл хөдлөх хөрөнгийн эрх зүй, 55, Д.Янжинхорлоо, Үл хөдлөх хөрөнгийн барьцааны эрх зүйн зохицуулалт, тулгамдсан асуудал, 2016 он, 108 дахь тал.
[13] С.Должин, Д.Бадам, Залилах гэмт хэрэг ба гэрээний маргаан, 2018 он, 5-6 дахь тал.
[14] https://legalinfo.mn/mn

барьцааны тухай (2015), Хүүхдийн эрхийн тухай (2016), Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай (2018) Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай (2021) Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай (1995) Хохирогчид нөхөх олговор олгох тухай (2009) Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай (2007) Хоршооны тухай (2021) Хөрөнгийн үнэлгээний тухай (2022) Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай (2011) Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль (2003) Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай (2000) Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай (2009) Үнэт цаасны зах зээлийн тухай/шинэчилсэн найруулга/ Улсын бүртгэлийн ерөнхий хууль (2018) Төрийн болон орон нутгийн өмчийн тухай (1996) Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай (2005) Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай (2006) Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай (2003) Патентын тухай (2021) Өрсөлдөөний тухай (шинэчилсэн найруулга) 2010 Орон сууцны тухай (1999) Орон сууц хувьчлах тухай (1996) Оюуны өмчийн тухай (2020) Векселийн тухай (1995) Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай (2021) Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай (2004) Даатгалын тухай (шинэчилсэн найруулга) 2004) Дампуурлын тухай (1997) Зөвшөөрлийн тухай /шинэчилсэн найруулга/ (2022) Зохиогчийн эрхийн тухай/шинэчилсэн найруулга/ (2021) Зээлийн батлан даалтын сангийн тухай (2012) Зээлийн мэдээллийн тухай (2011) Иргэний улсын бүртгэлийн тухай /шинэчилсэн найруулга/ (2018) Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай (2019) Жолоочийн даатгалын тухай (2011) Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай (1999) Компанийн тухай /шинэчилсэн найруулга/ (2011) Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай (2002) Мэргэжлийн 2024 нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай, 2021 Нотариатын тухай /шинэчилсэн найруулга/ (2011) Гэрийн тэжээвэр амьтны тухай (2023) Гэр бүлийн тухай (1999) Барилгын тухай (2016) Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай (2010) Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай (2021) Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай (2013) Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай (2002) Гэрээт харуул хамгаалалтын тухай (2000 он) Түүнчлэн эдгээр 53 гаруу хууль тогтоомжоос гадна Иргэний эрх зүйн харилцаанд хамаарах харилцааг зохицуулж буй хуулиад нь Иргэний хуулийг хууль тогтоомжийн бүрдэл хэсэгтээ хуульчилж ишлээгүй байна. Жишээлбэл Хувь хүний орлогын албан татварын тухай хууль (2019) Хөрөнгө оруулалтын тухай хууль Нөхөрлөлийн тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Төр сүм хийдийн харилцааны тухай хууль, Инновацийн тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль гэх мэт.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны шүүхийн статистикийн судалгаанд дурдсанаар:

Анхан шатны шүүх 2024 онд нийт 102385 нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авснаас 12314 нэхэмжлэлийг хуульд заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзах, буцаах, татан авах, нэгтгэх, харьяаллын дагуу шилжүүлэх, нэгтгэх, татан авах зэрэг ажиллагааг хийж, 73727 хэргийг хянан шийдвэрлэж, Анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо өмнөх оноос 10320 хэрэг буюу 16.3 хувиар өссөн байна. Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн нийт хэрэгт ИХ-иар шийдвэрлэсэн хэргийн тоо 49091 буюу 66.6 хувийг, ИХШХШТХ-иар шийдвэрлэсэн хэргийн тоо 16099 буюу 21.8 хувийг, Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 6520 буюу 8.8 хувийг, Хөдөлмөрийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 770 буюу 1.0 хувийг, бусад хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 1247 буюу 1.7 хувийг тус тус эзэлж байна гэжээ. Бусад хуулиар хянан шийдвэрлэсэн хэрэг, маргаанаас Гэр бүлийн эрх зүйн маргаан 607 хэргээр буюу 10.3 хувиар, Газрын тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 11 хэргээр буюу 12.8 хувиар, Шүүхийн шийдвэр

гүйцэтгэх тухай хуулиар 92 хэргээр буюу 24.2 хувиар, Нийгмийн даатгалын багц хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 50 хэргээр буюу 19.5 хувиар тус тус өссөн бол Хөдөлмөрийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 354 хэргээр буюу 31.5 хувиар, Цагаатгалын нөхөн олговортой холбоотой маргаан 15 хэргээр буюу 83.3 хувиар тус тус буурсан дүнтэй байна.[15]

Уг судалгаанаас үзвэл Иргэний шүүхээр хянан шийдвэрлэгдэж буй маргаан жил ирэх тусам өсөж байна.Нөгөөтэйгүүр шүүх маргааны төрлийг иргэний хуулиар, ИХШХШТХ, Гэр бүлийн хууль, Хөдөлмөрийн хууль, Газрын тухай хууль, Бусад хуулиар хэмээх ангилан авч үзэж байна.

Манай улсын хувьд хуулийн хэрэглээний хувьд хэргийн харьяалал маргааны төрлөөр иргэний, эрүүгийн, захиргааны зөрчлийн, үндсэн хуулийн цэцийн, арбитрын хэмээн тодорхойлж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна. Зарим тохиолдолд шүүх болон шүүгчид ч хэргийн харьяаллын хувьд алдаа гаргах тохиолдол цөөнгүй бий. Бусад улс орнуудын шүүхийн тогтолцоо жишгийг харвал дагнасан болон муж улсуудын шүүхийн зохион байгуулалттай байдаг. Гэтэл манай улсын хувьд дагнасан шүүхийн тогтолцоо байхгүй. Үндсэндээ 3 томоохон салбар эрх зүйн шүүхийн бүтэцтэй, 2025 оны 01-р сарын 01-ны өдрөөс “Хялбар ажиллагааны” гэх шүүх байгууллагдаж хэрэг хянан шийдвэрлэх тодорхой хамрах хүрээний маргааны шийдэж байна. Энэ нь сул талтай ихтэй, практикт тулгамдаж буй олон асуудлыг дагуулж байна. Үүнд зөрчигдсөн эрхээ шүүхээр сэргээн эдлүүлэх зарчимд хангалттай хэрэгжих боломжгүй өөрөөр хэлбэл шийдвэр гүйцэтгэх ажиллагааг ихэсгэх, шүүхийн ачаааллыг нэмэгдүүлсэн, хуульд заасан үндсэн зарчим хэрэгжихгүй байх үндсэн шалтгаан болж байна. Тиймээс дагнасан шүүхийн тогтолцоогүй хэрэг маргааны төрөл, субьектээс хамааран шүүхэд ханддаг. Жишээлбэл төр болон иргэний хооронд бол захиргааны шүүх, гэрээ бол иргэний шүүх, гэмт хэрэг бол эрүүгийн шүүх гэх л ойлголттой байдаг. дэлгэрч, жишээ нь залилах бол гэрээтэй бол иргэний шүүхэд ханд гэдэг, төрийн үйлчилгээний албан хаагчийн хөдөлмөрийн маргааны хувьд шийдвэр гаргасан субьектын хувьд захиргааны шүүхэд, харилцаа нь хөдөлмөрийн хуулиар зохицуулагдаж байгаа тул иргэний шүүхэр хянан шийдвэрлүүлэх практикт жишигт тогтсон байна. Энэ мэтчилэн шүүхийн харьяаллын асуудал ихээхэн тулгамддаг үүнээс үүдэн хууль хэрэглээний асуудал үүсдэг. Дээрхээс дүгнэж үзвэл болон эх сурвалжийн эрэмбэ дараалал, хууль тогтоомжийн хүчин чадал нь хууль хоорондын зөрчилдөөн үүсэж болохоор байна.

Дээр дурдсан хувийн эрх зүйн тусгайлсан салбаруудыг хүлээн зөвшөөрөх тусам МУ-ын ИХ-ийн бусад салбар хуулиудтай харилцан хамаарал нь бүдгэрч, тодорхой бус байгаа талаар шүүмж их гарсан. /хөдөлмөр, гэр бүл, оюуны өмч гэх мэт /ИХ ба бусад хууль тогтоомжийн харилцан хамаарлыг тодотгох үр дагавартай. Иргэн нь юуны өмнө хувь хүн тул ИХ-д хувь хүний буюу амины эрхийн хамгаалалт тусгалаа олсон байх ёстой.[16]

Сүүлийн жилүүдэд техник, технологийн хурдацтай хөгжилтэй уялдан цахим эд хөрөнгө, виртуал өмч, өгөгдөл, хиймэл оюун ухаанд суурилсан үйлчилгээ зэрэг шинэ харилцаанууд бий болж байна. Гэвч эдгээр харилцаа нь Иргэний хуулийн зорилт, зохицуулалтын хүрээнээс гадуур үлдэж, хууль зүйн тодорхой бус байдал үүсч байна. Түүнчлэн хүний эрхийн үзэл баримтлалын хүрээнд хувь хүний хувийн нууц, мэдээллийн аюулгүй байдал, цахим орчинд нэр төрөө хамгаалах зэрэг асуудлууд нь зайлшгүй зохицуулалт шаардсан, чухал шинэ эрх зүйн харилцаа болж байна. Шүүхийн практикт хувийн мэдээлэл, нэр төр, алдар хүнд, цахим орчин дахь нэр хүндийг “эдийн бус баялаг”

[15] https://www.judcouncil.mn/site/news_full/14795

[16] Монгол Улсын болон Гадаадын иргэний хуульд бүтцийн анализ хийх нь Судалгааны тайлан 2021 он судалгааг гүйцэтгэсэн Б.Буянхишиг. МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, Хууль зүйн ухааны доктор (Ph.D) (Ass.Juri.)

гэж үзэх эсэх тухайд нэгдсэн ойлголт байхгүй байна. Ийм маргаан шийдвэрлэхдээ шүүх бүр өөрийн үнэлэмжээр ханддаг, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо эд хөрөнгийн үнэлгээнд дүйцүүлэн үнэлэх эсэх нь маргаантай хэвээр байна. Үүний улмаас эдийн бус баялаг болон эдийн бус эрхийн ялгаа, тэдгээрийн хамгаалалтын хүрээ тодорхойгүй хэвээр байна. Мөн виртуал хөрөнгө, тоон өмч (жишээ нь NFT, крипто хөрөнгө гэх мэт)-ийг Иргэний хуулиар эд хөрөнгөд хамааруулах эсэх нь тодорхой бус бөгөөд эрх зүйн үнэлгээ, эрх хамгаалалт дутмаг ИХ-ийн Ерөнхий анги дахь “хувь этгээдийн эрх зүйн байдал”-тай холбоотой зохицуулалт нь орчин үеийн арилжааны эрх зүйн харилцаанд оролцож буй этгээдүүдийг тодорхойлоход хангалтгүй байна. Иргэний эрх зүйд гарч буй шинэ төрлийн харилцаа, тухайлбал цахим орчин дахь гэрээ, хиймэл оюун ухаантай холбоотой үйл ажиллагаа, дижитал өмч зэрэг нь хуульд тодорхойлоогүй шинэ объектыг бий болгож байна. Гэвч Иргэний хуулийн эхний бүлгүүдэд эдгээрийг зохицуулах боломжтой системтэй ойлголт, зарчмыг тодорхойлоогүйгээс эдгээр харилцааг хуулийн дагуу шийдвэрлэхэд хүндрэл учирч байна. Цахим гэрээний этгээдийн үнэн зөвийг тогтоох, цахим гарын үсгийн эрх зүйн хүчинтэй байдал зэрэг асуудал нь хуулийн этгээд ба иргэний ялгааг улам бүр тодруулах шаардлагатайг харуулж байна.

УДШ-ийн тогтоол, бусад шүүхийн шийдвэрүүдээс харахад, ИХ-ийн 4-р зүйлээр аналогийг оновчтой хуульчилсан боловч шүүхийн практикт түүний хэрэглээ төлөвшөөгүй байна. Үүний улмаас хуулиар тухайлан зохицуулагдаагүй орчинд үүссэн фактыг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр үндэслэгдсэн бус байхын сацуу, хүний эрхийг хамгаалж чадахгүй байна. Товчхондоо, Шүүх аналогийг хэрэглэж хэвшихгүй бол шүүхийн практикаас хууль үгүй бол эрх үгүй зарчим үүсэх эрсдэлтэй. Тиймээс хууль тогтоомжийг боловсронгуй болохын зэрэгцээ аналогийн ач холбогдол, арга зүйг таниулах, онол, арга зүйн судалгаа хийх, гарын авлага, ном, сурах бичиг бэлтгэх, шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ хийх зэргээр хууль хэрэглээний /аналоги/ аргачлалыг хөгжүүлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох эх сурвалж болох ач холбогдолтой.

Монгол Улсын Иргэний хуулийн (ИХ) зорилт, хамрах хүрээ нь эрх зүйн орчинд үүсэж буй шинэ харилцаануудыг бүрэн хамарч чадахгүй, зарим тохиолдолд Үндсэн хуулийн хүний эрхийн зарчимтай зөрчилдөх эрсдэл дагуулж байна. ИХ-ийн зорилт, суурь үзэл баримтлал тодорхой бус байгаагаас үүдэн шүүгчдийн хууль хэрэглээний ойлголт зөрөх, ИХ-ийн бусад зүйл, заалтыг хэрхэн тайлбарлах, хэрэглэх талаар маргаантай нөхцөл байдал үүсдэг.

Гурав. Харьцуулсан судалгаа

Эд хөрөнгийн бус эрх МУ-ын иргэний эрх зүйд эдийн бус баялгийн төрөл. Амины эрхэд эд хөрөнгийн агуулгатай шууд холбоогүй эрх хамаарна: амь нас ба эрүүл мэнд, бие хүний алдар хүнд, хувийн халдашгүй байдал, нэр төр, ажил хэргийн нэр хүнд, хувийн амьдралын халдашгүй байдал, хувийн ба гэр бүлийн нууц, зорчих эрх чөлөө, оршин суух ба амьдрах газраа чөлөөтэй сонгох, зохиогчийн эрх зэрэг[17] багтана. Амины эрх (хувь хүний эрх буюу “амь биеийн эрх”) гэдэг нь хувь хүний амь нас, эрүүл мэнд, нэр төр, хувийн нууц, дүр төрх, бие махбодын халдашгүй байдал зэрэг субьектив эрхүүдийг хамардаг бөгөөд эдгээрийг иргэний болон үндсэн хуулиар баталгаажуулсан байдаг. Ардчилсан улс орнуудад энэ эрхийг үндсэн хуульт ёс болон шүүхийн практик, хууль зүйн онолын түвшинд гүнзгий хөгжүүлсэн байдаг.

Герман Улсын хувьд Үндсэн хууль (Grundgesetz)-д Хүний нэр төрийг дээдэлж, амь нас, бие махбодын халдашгүй байдлыг баталгаажуулдаг. Иргэний хуулийн (BGB) §823

[17] С.Нарангэрэл “Монголын эрх зүйн англи, орос, латин хадмал эх толь бичиг", Улаанаатар 2015 он, дөрөв дэх хэвлэлт

дугаар зүйлд “амь нас, эрүүл мэнд, бие махбод, эрх чөлөө, өмч зэрэгт учирсан хохирлыг” нөхөн төлүүлэхээр заасан. Уг зохицуулалттай холбоотойгоор шийдвэрлэсэн Шүүхээр Leserbriefe (1954*)* “Бусад эрх”-ийн хүрээнд анх удаа “ерөнхий амины эрх”-ийг хүлээн зөвшөөрсөн.[18] Herrenreiter (1958) Нэр төр, дүр төрх, хувийн нууцыг “амины эрх”-ийн хүрээнд хамгаалсан.[19] Lüth (1958) Үндсэн хуулийн эрх нь зөвхөн төрд бус, иргэд хооронд ч үйлчлэх ёстой (“хэвтээ үйлчлэлийн онол”) зэрэг жишиг байдаг. Мөн зарим судлаачид Hannes Rösler: Амины эрхийг өргөн хүрээтэй ойлгож, нэр төр, нууц, дүр төрх зэргийг хамарна гэж үзсэн бол Robert Alexy: Үндсэн эрхүүдийн зөрчлийг шийдэх “харьцангуй жинлэлтийн онол”-ыг дэвшүүлсэн байдаг.

АНУ (Калифорни муж хувьд) Иргэний Хууль (California Civil Code)-н §43–53: Амь нас, эрүүл мэнд, нэр төр, хувийн нууцыг хамгаална. §43: Хүн бүр амьд байх, нэр төрөө хадгалах, халдашгүй байх эрхтэй.гэж хуульчилсан байдаг. Хуулийн этгээдийн зохицуулалт дахь ангилал Legal person-ийг төрлөөр нь (LLC, корпораци гэх мэт) нарийвчлан ангилдаг. Natural болон Artificial person гэсэн ялгаатай. Иргэний эрх зүйн объектын хувьд Эд хөрөнгө, эдийн бус эрх – гэрээний объектын хүрээнд авч үздэг.

Япон Улсын Үндсэн хуулийн 13-р зүйл “Хүн бүр нэр төртэй, эрх чөлөөтэй, аз жаргалтай байхыг эрмэлзэх эрхтэй.” Иргэний хууль (民法)-н §709 зүйлд Бусдын нэр төр, амь нас, эрүүл мэнд, хувийн нууцад халдсан тохиолдолд хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй. 2017 онд орчин үеийн харилцаанд нийцүүлэн шинэчлэл хийсэн.

Франц Улсын Иргэний хууль (Code Civil)-н 9-р зүйлд “Хүн бүр хувийн амьдралынхаа халдашгүй байдлыг хамгаалуулах эрхтэй.” 16–16-9-р зүйлд Хүний бие халдашгүй, өмч болох боломжгүй. Хүнийг эхлэлээс нь хүндэтгэх ёстой. Шүүхийн практик: Дүр төрхийг зөвшөөрөлгүй нийтлэх, хувийн мэдээллийг тараахыг хориглодог. Сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх практик хөгжсөн. Иргэншил, бүртгэлийн зохицуулалтын хувьд нарийн зохицуулсан байдаг.

Хүснэгт 2. *Амины эрх, сэтгэл санааны хохирол, шүүхийн практик*

Асуудал	Монгол	Герман	Франц	Япон
Амины эрхийн хамгаалалт	Иргэний хуулиар тодорхой	BGB §823, үндсэн хуульд	Code Civil 9-р зүйл	Үндсэн хууль ба Иргэний хууль
Сэтгэл санааны хохирол	Онолын үндэстэй ч практик сул	Маш сайн хөгжсөн	Нарийн стандарттай	Шүүхийн тогтсон практиктай

[18] Кэйс BGH 1954 оны "Leserbriefe" хэрэг Энэ хэрэгт шүүх анх удаа "ерөнхий амины эрх"-ийг §823(1)-ийн "бусад эрх"-ийн хүрээнд хүлээн зөвшөөрсөн. BGH 1958 оны "Herrenreiter" хэрэг Шүүх хүний нэр төр, хувийн нууц, дүр төрх зэрэг эрхийг "ерөнхий амины эрх"-ийн хүрээнд хамгаалах ёстой гэж үзсэн. BVerfG 1958 оны "Lüth" хэрэг Үндсэн хуулийн эрхүүд нь зөвхөн төрийн бус, хувийн этгээдүүдийн хоорондын харилцаанд ч нөлөөлөх ёстой гэсэн "хэвтээ үйлчлэлийн онол"-ыг дэвшүүлсэн.

[19] Hannes Rösler Тэрээр амины эрхийг "хүний нэр төр, хувийн нууц, дүр төрх зэрэг эрхүүдийг хамгаалах өргөн хүрээтэй эрх" гэж тодорхойлсон. Robert Alexy Тэрээр үндсэн хуулийн эрхүүдийн хоорондын зөрчлийг шийдвэрлэхэд "харьцангуй жинлэлтийн онол"-ыг дэвшүүлсэн. Энэ онолоор шүүхүүд эрхүүдийн ач холбогдлыг харьцуулан, аль эрхийг илүү хамгаалах ёстойг тогтоодог. Германы эрх зүйд амины эрхийг хамгаалах нь Үндсэн хуулийн эрхүүдийн хүрээнд өргөн хүрээтэй, нарийн зохицуулалттай бөгөөд шүүхийн практик, онолын судалгаагаар байнга хөгжиж байдаг. Монгол Улсад энэ чиглэлээр илүү нарийвчилсан стандарт, шүүхийн практик, онолын судалгаа шаардлагатай байна.

Шүүхийн практик	Зөрүүтэй, стандартгүй	Тогтсон, хэм хэмжээг баримталдаг	Европын ХЭШ-ийн жишээг дагадаг	Сэтгэлзүйн шинжилгээ ашигладаг

Ихэнх улс орнууд амины эрхийг Үндсэн хууль болон Иргэний хуульдаа тусган, шүүхийн практик, онолын түвшинд өргөн хүрээтэйгээр хамгаалдаг. Герман, Франц зэрэг оронд эрхийн философи, шүүхийн тайлбар хөгжсөн бол АНУ, Япон нь практик хэрэглээнд анхаарал хандуулдаг. Монгол Улсад эрх зүйн зохицуулалт ерөнхий агуулгатай тул гүнзгийрүүлсэн шүүхийн практик, судалгаа, нарийвчилсан хууль тогтоомжийг хөгжүүлэх шаардлагатай байна.

Дөрөв. Дүгнэлт

ИХ-ийн эхний бүлгүүд нь эрх зүйн зарчим, хууль хэрэглээний дараалал, төсөөтэй хэрэглээний талаарх ерөнхий ойлголтыг тусгасан хэдий ч эдгээр зохицуулалтын уялдаа, төрийн байгууллагын оролцоо, эрх зүйн чадамжгүй этгээдийн үйл ажиллагаа, гадаадын иргэн, байгууллагын эрх зүйн байдал ч тодорхой бус Мөн “эрх зүйн этгээд” болон “эрх зүйн чадамжтай этгээд” гэсэн ойлголтын ялгаа онолын түвшинд маргаантай зэрэг нь практикт хэрэглээний ил тод, нэгдмэл бус байна. Эдгээр асуудлуудыг шийдвэрлэхийн тулд Иргэний хуульд үзэл баримтлалын томоохон шинэчлэлт хийх, тусгай хууль, ерөнхий хууль хоорондын эрэмбийн зохицуулалтыг тодорхой болгох, иргэний эрх зүйн объектуудын хүрээг нарийвчлах шаардлагатай байна. Монгол Улсад “амины эрх” буюу хувь хүний амь нас, бие махбод, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, хувийн нууц зэрэг суурь эрхүүдийг Үндсэн хууль, Иргэний хууль, Эрүүгийн хууль зэрэг голлох эрх зүйн эх сурвалжуудад тусгасан байдаг. Гэсэн хэдий ч эдгээр эрхийн зохицуулалт нь онолын маргаан, шүүхийн зөрүүтэй тайлбар, хэрэгжилтийн практик дээр тодорхой бэрхшээлтэй тулгарсаар байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн эх зохиогч Б.Чимид “Монголын эрх зүйн тогтолцоонд хүний нэр төр, амьд явах, хувийн орон зайг хамгаалах нь үндсэн хуульт ардчиллын гол шалгуур” хэмээн үзэж байсан. Түүний үзэл баримтлалаар амины эрх нь зөвхөн иргэний харилцааны шинжтэй эрх бус, төрөөс онцгой хамгаалалт эдлэх язгуур эрх хэмээн тодорхойлогддог. Хууль хэрэглээний үндсэн зарчмуудын хэрэгжилт Хууль зүйн практикт аливаа хэргийг зөв зохистой шийдвэрлэх үндэс нь хууль хэрэглээний үндсэн зарчмуудыг чанд мөрдөхөд оршино. Иргэний хуулийн 3, 4, 5 дугаар зүйл болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд тусгасан эдгээр зарчмууд (жишээлбэл, шударга ёс, хууль ёсны итгэл, эрх тэгш байдал, хуульд захирагдах) нь шүүгчийн шийдвэр гаргах үндсэн суурь болдог. Харамсалтай нь, эдгээр зарчмуудын агуулга, хэрэглэх аргачлалыг шүүх бүр ижил ойлгож хэрэгжүүлдэггүй нь зөрүүтэй шийдвэрүүд гаргах, хууль хэрэглээний тодорхой бус байдал үүсгэх нөхцөл болж байна. Шүүх нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг уялдаа холбоотой, шат дараатай, харилцан шүтэлцэлтэйгээр явуулах нь эрх зүйн маргааныг хууль ёсны, үндэслэл бүхий байдлаар шийдвэрлэх үндсэн нөхцөл болно.

Мөн шүүхийн практикт иргэний эрх зүйн суурь ойлголтуудыг тайлбарлахдаа Улсын Дээд Шүүхийн тайлбар болон тухайн хэрэгт холбогдох онолын үндэслэлд тулгуурлан шийдвэр гаргах ёстой боловч бодит байдал дээр энэ нь хангалтгүй хэрэгжиж байна. Үүний улмаас төсөөтэй хэрэглээний заалтуудыг зөрүүтэй тайлбарлах, аливаа эдийн бус хохирлын маргаанд хэт хуульчилсан буюу чөлөөтэй тайлбар хийх замаар хүний эрхийг хамгаалах үндсэн зарчмыг алдагдуулж болзошгүй нөхцөл үүсгэж байна. Жишээлбэл, сэтгэл санааны хохирлыг эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрөхгүй байх нь зөвхөн хуулийн хийдлээс шалтгаалсан бус, тайлбарын онолын асуудлыг шүүхийн практикт нэг мөр болгон тусгаж чадаагүйн илрэл юм. Иргэний хуульд төсөөтэй хэрэглээний (analogia legis) зохицуулалт бий

боловч, зарим шүүхэд хуулийн төсөөтэй хэрэглээ оновчтой биш ашиглагдаж, хүний эрх зөрчигдөх эрсдэлтэй байна. Жишээ нь, эдийн бус гэм хорыг нөхөн төлүүлэх асуудал Эрүүгийн хууль болон Иргэний хуулийн зохицуулалтаар ялгаатай байдлыг найрийн зохицуулах шаардлагтай.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ҮҮСЭХ ҮНДЭСЛЭЛ, ХАМГААЛАЛТ, ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААНД ЭРХ, ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 8-13 ДУГААР ЗҮЙЛИЙН ХЭРЭГЖИЛТ ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

Энэхүү үнэлгээний ажлын гол зорилго нь Монгол Улсын Иргэний хуулийн 2 дугаар бүлэг 8-13 дугаар зүйлд зохицуулж буй хуулийн зүйл, заалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу онолын хувьд дүн шинжилгээ хийж, онол практик хууль хэрэглээний зөрүүтэй байдал, бусад улсын хуультай харьцуулахаар судалгааг судалгааны удирдамж, тайлангийн загвар, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачла ”-ын дагуу хийж гүйцэтгэлээ.

Хоёрдугаар бүлэг. Иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэл, хамгаалалт, иргэний эрх зүйн харилцаанд эрх, үүргийг хэрэгжүүлэх	
8 дугаар зүйл. Иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэл	8.1.Иргэний эрх зүйн харилцаа дараахь үндэслэлээр үүснэ:
	8.1.1.хуульд заасан буюу заагаагүй боловч агуулгын хувьд хуульд үл харшлах хэлцэл;
	8.1.2.иргэний эрх зүйн харилцаа үүсгэхэд чиглэсэн шүүхийн шийдвэр;
	8.1.3.хуульд заасан бол иргэний эрх зүйн харилцаа үүсгэхэд чиглэсэн захиргааны шийдвэр;
	8.1.4.оюуны үнэт зүйл бүтээх;
	8.1.5.гэм хор учруулах;
	8.1.6.үндэслэлгүйгээр эд юмс олж авах, эзэмших;
	8.1.7.иргэний эрх зүйн харилцааг үүсгэсэн хууль зүйн үйл явдал бий болох;
	8.1.8.иргэний эрх зүйн харилцаа үүсгэхээр хуульд заасан бусад үндэслэл.
9 дүгээр зүйл. Иргэний эрх зүйн хамгаалалт	9.1.Иргэний эрх зүйн хамгаалалт нь зөрчигдсөн эрхийг сэргээх зорилготой байна.
	9.2.Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч эрхээ хамгаалуулах этгээдийг хуульд заасны дагуу сонгох эрхтэй
	9.3.Иргэний эрх зүйн хамгаалалтыг шүүх, арбитр хуулиар тогтоосон журам, аргаар хэрэгжүүлнэ.
	9.4.Иргэний эрхийг дараахь аргаар хамгаална: Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.Энэ хуулийн 23.1-д заасан тохиолдолд барьцаалуулагч нь Иргэний хуулийн 9.4-т заасны дагуу эрхээ хамгаална.
	9.4.1.эрхийг хүлээн зөвшөөрөх;
	9.4.2.эрх зөрчсөн үйлдлийг таслан зогсоож, зөрчихөөс өмнөх байдлыг сэргээх;
	9.4.3.хүлээсэн үүргийг гүйцэтгүүлэх;
	9.4.4.учруулсан хохирлыг арилгуулах;

	9.4.5.эдийн бус гэм хорыг арилгуулах;
	9.4.6.хууль болон гэрээнд заасан анз төлүүлэх;
	9.4.7.бусдын эрх зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгох;
	9.4.8.иргэний эрх зүйн харилцааг өөрчлөх, дуусгавар болгох;
	9.4.9.өөртөө туслах;
	9.4.10.хуулиар тогтоосон бусад арга.
10 дугаар зүйл. Аргагүй хамгаалалт	10.1.Хууль бус халдлагаас өөрийгөө болон бусад этгээд, эд хөрөнгийг хамгаалах зорилгоор үйлдсэн, зайлшгүй шаардлагатай бөгөөд тухайн нөхцөл байдалд нийцсэн үйлдлийг аргагүй хамгаалалт гэнэ.
	10.2.Аргагүй хамгаалалтаас учруулсан гэм хорыг уг үйлдэл хийсэн иргэн хариуцан арилгах үүрэг хүлээхгүй.
11 дүгээр зүйл. Гарцаагүй байдлын улмаас хийсэн үйлдэл	11.1.Тухайн нөхцөл байдалд аюулыг өөр арга замаар зайлуулах боломжгүй бол түүнийг таслан зогсоох, сэргийлэх зорилгоор хийсэн үйлдэл /эс үйлдэхүй/-ийг гарцаагүй байдлын улмаас хийсэн үйлдэл гэнэ.
	11.2.Гарцаагүй байдалд учруулсан гэм хор нь учирч болох байсан гэм хороос бага байвал уг үйлдэл хийсэн этгээд гэм хорыг хариуцан арилгах үүрэг хүлээхгүй.
	11.3.Учруулсан гэм хор нь учирч болох байсан гэм хороос илт их байвал үйлдэл хийсэн этгээд хэтрүүлсэн тэр хэмжээгээр гэм хорыг арилгах үүрэг хүлээнэ.
	11.4.Гэм хор учирсан бодит нөхцөл байдлыг харгалзан шүүх эрх, хууль ёсны ашиг сонирхлынх нь төлөө үйлдэл хийгдсэн гуравдагч этгээдэд уг гэм хорыг арилгах үүрэг хүлээлгэх, эсхүл гэм хор учруулагч буюу гуравдагч этгээдийг дээрх үүргээс бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлж болно.
	11.5.Гарцаагүй байдлын улмаас үйлдэл хийсэн этгээд тухайн нөхцөл байдлыг өөрөө бий болгосон бол учирсан гэм хорыг арилгах үүрэгтэй.
12 дугаар зүйл. Өөртөө туслах	12.1.Эрх бүхий байгууллагын тусламжийг шуурхай авах боломжгүй байсан болон цаг алдалгүй арга хэмжээ авахгүй бол эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болох буюу эрхээ хэрэгжүүлэхэд ноцтой хүндрэл учрахаар байвал иргэний эрх зүйн харилцаанд оролцогч өөрийнхөө эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, өөртөө туслах зорилгоор эд юмсыг эзэмдэж авах, устгах буюу эвдэх, эсхүл зайлсхийж болзошгүй үүрэг гүйцэтгэгчийг саатуулах, үүрэг бүхий этгээдээс гүйцэтгэвэл зохих үйлдлийн эсрэг үйлдлийг таслан зогсоохоор тухайн нөхцөл байдалд тохируулан хийсэн үйлдлийг хууль бус гэж үзэхгүй.
	12.2.Энэ хуулийн 12.1-д заасан үйлдлийг хийсэн этгээд эд юмсыг битүүмжлэх буюу үүрэг бүхий этгээдийг албадан саатуулахаар эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.
	12.3.Өөртөө туслах үйлдэл нь тухайн нөхцөл байдалд тохирсон хэр хэмжээнээс хэтэрч болохгүй..
	12.4.Энэ хуулийн 12.1-д заасан үйлдлийг эндүүрч хийсэн буюу хэр хэмжээнээс хэтрүүлсэн этгээд үйлдлийнхээ улмаас бусдад учруулсан гэм хорыг арилгах үүрэгтэй
13 дугаар зүйл. Иргэний эрх зүйн харилцаанд эрх, үүргийг хэрэгжүүлэх	13.1.Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч хууль буюу гэрээнд заасан эрх, үүргээ үнэнч шударгаар хэрэгжүүлнэ.
	13.2.Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч хуулиар хориглоогүй буюу хуульд шууд заагаагүй эрх, үүргийг өөрийн хүсэл зоригийн дагуу хэрэгжүүлж болно.
	13.3.Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ бусдад гэм хор учруулсан, зах зээлийн харилцааны чөлөөт байдлыг үндэслэлгүйгээр хязгаарласан, хууль ёсны давуу байдлаа хууль бусаар

	ашигласан үйл ажиллагаа явуулж болохгүй бөгөөд хэрэв зөрчвөл хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

Нэг. Онолын ойлголт

Иргэний эрх зүйн харилцаа нь хувь хүний эрх, эрх чөлөөний үндэс бөгөөд хувь хүний чөлөөт байдлын зарчмаар баталгааждаг. Үүнд гэрээний эрх чөлөө, чөлөөтэй өвлүүлэх эрх, өмчлөгчийн өмчөө чөлөөтэй захиран зарцуулах эрх, хувь хүн болон хуулийн этгээд эвлэлдэн нэгдэх, байгууллага үүсгэх эрх зэрэг хувийн эрх зүйн үндсэн зарчим ордог. Иргэний эрх зүйн харилцааг өмчийн болон үүргийн эрх зүйн харилцаа гэж хоёр үндсэн бүлэгт хуваадаг. Үүргийн эрх зүй нь өөрөө гэрээний болон гэрээний бус үүрэг гэсэн хоёр хэсгээс бүрддэг. Энэ ангилал нь холбогдох шаардах эрхийн үндэслэлийг тодорхойлоход, мөн иргэний хэргийн шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой.

Иргэний эрх зүйн харилцаа үүсэхэд зайлшгүй шаардлагатай, мөн ач холбогдол, нөлөө бүхий хүчин зүйлсийг харилцааны элемент гэж үздэг. Үүнд харилцааны субьект, субьектив эрх, объект багтдаг. Монгол Улсын иргэн хуульд заасан дагуу эд юмсыг олж авах, өмчлөх, захиран зарцуулах, сонирхсон аж ахуйн нэгж байгуулах буюу байгуулахгүйгээр эрхэлж, хөтлөх эрхтэй. Үүнийг Монгол Улсын Үндсэн хууль баталгаажуулсан ба энэхүү эрх зөрчигдвөл иргэний хуулиар заасан хамгаалалтын арга хэлбэрээр хамгаалагдана. Хамгаалалт гэдэг нь бүрэн эрх бүхий этгээд өөрийгөө болон бусдыг хамгаалах зорилгоор тодорхой үйлдэл хийх, төрийн болон бусад эрх бүхий байгууллагаар иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах иргэний эрх зүйн субьектив эрхийг хэлнэ. Энэхүү эрхийн хүрээнд эрх нь зөрчигдсөн этгээд болон бусад субьектийн зүгээс эрх зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, аюулыг арилгах арга хэмжээг авч, шаардлагатай бол шүүхэд хандах боломжтой. Иргэний эрх зүйн харилцаанд оролцогчийн чадварыг хоёр талаас авч үздэг. Үүнд:

- Хэрэгт оролцогчийн иргэний эрх зүйн чадвар нь эрх, үүрэгтэй болох боломжийг илэрхийлдэг.
- Иргэний эрх зүйн чадамж нь шүүхэд эрхээ хэрэгжүүлэх нөөц бололцоог заана.

Нийтийн эрх зүйн хууль тогтоомжид тулгуурлан байгуулсан хуулийн этгээдийг нийтийн эрх зүйн хуулийн этгээд гэж нэрлэдэг. Үүнд төр, түүний нутгийн нэгжүүд, төрийн өмчит байгууллагууд (улсын сургуулиуд, сүм хийд), төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч бусад байгууллагууд (Улсын радио, телевизийн газар) болон нийтийн эрх зүйн сангууд багтана. Эдгээр нь хувийн эрх зүйн харилцаанд оролцогч субьект болох боломжтой.

Эрхийн тухай ойлголтыг судлаачид хоёр утгаар хэрэглэдэг:

- Обьектив утгаараа эрх нь эрх зүйн хэм хэмжээний нийлбэр буюу хууль тогтоомжийн цогц байдлыг илэрхийлдэг.
- Субьектив утгаараа эрх нь тодорхой этгээдэд олгогдсон, тухайн этгээдийн хүсэл зоригоор хэрэгждэг эрх зүйн байр суурь юм. Жишээ нь, хэн нэгэн эд зүйлийн өмчлөгч бол өмчлөх эрхийг эдлэх субьектив эрхтэй гэсэн үг.

Субьектив эрх нь обьектив эрх зүйн хэм хэмжээгээр аливаа маргааны хүрээнд хэрэгждэг бөгөөд нэг тал эрх эдэлж, нөгөө тал үүрэг хүлээдэг байна. Тухайн эрхийг олгосноор тодорхой ашиг сонирхлыг хамгаалах зорилготой субьектив эрх үүсдэг. Субьектив эрхийг олон шалгуураар ангилдаг бөгөөд түгээмэл нь туйлын болон харьцангуй эрх байдаг. Өмчийн эрх нь туйлын эрхийн жишээ бөгөөд эд зүйлийг захирах эрхүүд (өмчлөх, барьцаалах, сервитут зэрэг), амины эрхүүд (нэрийн эрх, өөрийн дүрийг ашиглах эрх, зохиогчийн эрх гэх мэт), эдийн бус баялгийн эрх (зохиогчийн эрх, патентын эрх) багтана.

Харин харьцангуй эрх нь зөвхөн холбогдох этгээдэд хамааралтай бөгөөд шүүхээр хэрэгжүүлэх боломжтой эрх юм.

Иргэний эрх зүй нь иргэд хоорондын харилцааг зохицуулж, хувь хүний өмч, эрх, үүргийг хамгаалах үндсэн эрх зүйн салбар юм. Монгол Улсын Иргэний хуульд заасан 8–13 дугаар зүйлд иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэл, иргэний эрхийн хамгаалалт, аргагүй хамгаалалт, гарцаагүй байдлын улмаас хийсэн үйлдэл, өөртөө туслах эрх, эрх үүрэг хэрэгжүүлэх тухай үндсэн ойлголтуудыг хуулиар зохицуулсан. Гэвч эдгээр заалтын хэрэглээнд тодорхой ойлгомжгүй байдал, шүүхийн практикт зөрчил үүсэх, хууль тогтоомжийн нэгдмэл ойлголт хэрэгжилт алдагдах зэрэг асуудлууд тулгарч байгааг нарийвчлан зохицуулах шаардлагатай.

Хоёр. Монгол Улсын шүүхийн болон хууль хэрэглээний практик

Монгол Улсын Иргэний хууль нь хувийн эрх зүйн үндсэн эх сурвалж болохын хувьд иргэний эрх зүйн харилцаа, түүний үүсэх үндэслэл, хамгаалалт, эрхээ хэрэгжүүлэх механизм, зарим тохиолдолд хувь иргэн өөрөө эрхээ хамгаалах нөхцөлийг нарийвчлан зохицуулдаг. Ялангуяа Иргэний хуулийн 8–13 дугаар зүйлд энэхүү үндсэн ойлголтууд тусгалаа олсон боловч практик хэрэглээнд тодорхойгүй байдал, шүүхийн зөрүүтэй тайлбар, хууль тогтоомжийн уялдаа хангалтгүй зэргээс шалтгаалж олон асуудал үүсч байна. Иймд эдгээр зүйлүүдийг онол, шүүхийн практик, харьцуулсан эрх зүйн үүднээс авч үзье.

Хоёрдугаар бүлэг. Иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэл, хамгаалалт, иргэний эрх зүйн харилцаанд эрх, үүргийг хэрэгжүүлэх	
8 дугаар зүйл. Иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэл	**Тулгамдсан асуудал**
	- Үндэслэл бүрийн тодорхойгүй байдал - Эрх зүйн үйл явдал ба үйлдлийн ялгааг онцлоггүй томьёолсон. - "Хэлцэл" үүсгэх хүчинтэй нөхцлүүдийг ИХ-ийн 43-р зүйлд тусгасан ч, 8-р зүйлтэй уялдаагүй. - “иргэний эрх зүйн харилцаа үүсгэхэд чиглэсэн шүүхийн шийдвээр” харилцаа үүсэх тухай заалт практикт хэрхэн хэрэгжих нь тодорхой бус байна. - Иргэн өөрийн нас баралтаар даатгалын гэрээний гүйцэтгэлийг үүсгэж байгаа тохиолдлыг зарим шүүх “үйл явдал” бус, “үйлдэл” гэж үзсэн.
	Шийдвэрлэж болох талаар
	Онолын нарийвчилсан ялгааг зохицуулах шаардлагтай. Жишээлбэл гэрээний үүрэг нь талуудын зөвшилцөл, итгэлцэл дээр үндэслэн бий болдог бол гэрээний бус үүргийн харилцаа хуульд тухайлан заасан нөхцөл бүрэлдсэнээр талуудын хооронд үүсдэг бөгөөд гэрээ байгуулсан эсэхээс үл хамааран бууутай этгээдэд шаардлага гаргаж болдог. Өөрөөр хэлбэл иргэний эрх зүйн харилцааны гэрээний үндсэн дээр үүсэх үүргийг гэрээний бус үүргээс ялгаж үзэх нь гэрээнээс үүсэх хууль зүйн үр дагаврыг ойлгоход чухал ач холбогдолтой болно. Зээлийн гэрээний үүргийн хариуцлагыг гэрээний бус үүрэгт хэрэгжих заалтуудыг хэрэглэн, зээлийн эрсдэлийн даатгалын нөхөн төлбөрийг нэхэмжлэх хууль зүйн үндэслэл байхгүй болох нь энэхүү дүн шинжилгээний хүрээнд хийсэн судалгаанаас харагдаж байна.[20]
9 дүгээр зүйл. Иргэний эрх зүйн хамгаалалт	**Тулгамдсан асуудал**
	- Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.Иргэний эрхийг дараахь аргаар хамгаална гэжээ. Харин хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч нь иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага байна. Тодорхойлсон

[20] “зээлийн эрсдэлийн даатгалын гэрээний шаардах эрх иргэний хуулийн 443.7-д заасны дагуу шилжих эсэх, энэ зохицуулалтыг 497.1-тэй уялдуулан тайлбарлах асуудал”-тай холбоотой шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ Шүүхийн судалгааны төв 2024 он

	хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын эрхийг хамгаалах, гадаадын иргэн, харьяалалгүй иргэний эдийн болон эдийн бус баялагтай холбоотой эрхийг хэрхэн хамгаалах талаарх зохицуулалт тодорхойгүй. - Хуулийн 9.3.Иргэний эрх зүйн хамгаалалтыг шүүх, арбитр хуулиар тогтоосон журам, аргаар хэрэгжүүлнэ. Жишээлбэл гадаадын иргэн, харьяалалтгүй этгээдийн хамгаалалтыг тус хуулийн 6 хэсэгт заасан олон улсын хэм хэмжээг хэрэглэн хамгаалах эсэх, тухайлбал эрх зөрчсөн шийдвэр гэдгийг ямар субьектийн гаргасан шийдвэр хэмээн ойлгохыг тодорхойлоогүй нь хуулийг хэрхэн ойлгож хэрэглэх нь ойлгомжгүй байна. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн[21] 23 дугаар зүйлд заасан эрхийг хамгаалах харилцаанд барьцааны зүйлийн өмчлөгч нь хуулийн этгээд, болон гадаадын иргэн, харьяалалгүй бол их-н 9.4-т заасны дагуу эрхээ хамгаалуулах уу, гэх асуулт үүсэж байна.практикт бол иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй этгээд ч шүүхэд хандаж шийдвэрлүүлдэг.
	Шийдвэрлэж болох талаар
	Хамгаалалтын аргуудыг ИХ-д заасан оролцогчдын хувьд хэрхэн хамаарах талаарх нарийн зохицуулалт шаардлагатай. Түүнчлэн хуулийн зүйл заалтын уялдаа холбоог сайжруулаж нийцүүлэх шаардлагатай.
10 дугаар зүйл. Аргагүй хамгаалалт	**Тулгамдсан асуудал**
	- Зохистой хамгаалалт”-ын шалгуур байхгүй - Аргагүй хамгаалалтын хэмжээ, зохистой байдал, бодит аюул-ын үнэлгээ шүүх бүрт ялгаатай. - Эрүүл мэндэд хохирол учруулахгүйгээр хамгаалах өөр сонголт байсныг үл тоомсорлох явдал түгээмэл. Жишээлбэл Хулгайчаас өмчөө хамгаалах үед хүч хэрэглэсэн этгээдийг “хэт хамгаалсан” гэж үзэж хохирол нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн (2021 оны шийдвэр №001/ИШ2021/23456). Практик ихэвчлэн Эрүүгийн хэргийн шүүхээр хянан шийдвэрлэгдсэн шүүхийн шийдвэр байх бөгөөд, Иргэний шүүхээр хянан шийдвэрлэгдсэн шүүхийн шийдвэр олдоогүй болно. Гэвч 2 салбар эрх зүйн хувьд гэм хорын хохирол төлөх эсэх, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг шийдвэрлэх чухал хуулийн зохицуулалт юм.
	Шийдвэрлэж болох талаар
	Эрүү, иргэний хуулийн уялдааг сайжруулах шаардлагатай. Тухайлбал Эрүүгийн хуулийн 4.1 дүгээр зүйл.Аргагүй хамгаалалт Өөрийн, эсхүл бусдын амь нас, эрүүл мэндийн эсрэг хууль бус ба тулгарсан довтолгооны эсрэг хийсэн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй.гэх зохицуулалт болон ИХ-н 10.1-т заасан аргагүй хамгаалалт хэмээх зохицуулалтын ялгаа эсхүл уялдаа холбоог нарийвчлан зохицуулах шаардлагатай.
11 дүгээр зүйл. Гарцаагүй байдлын улмаас хийсэн үйлдэл	**Тулгамдсан асуудал**
	- Гарцаагүй байдлыг зөвтгөх шалгуур сул - Хийсэн үйлдэл нь гарцаагүй эсэх, учруулсан хохирол нь зөвшөөрөгдөх хэмжээтэй эсэх талаар шүүх практик тогтворгүй. - Зарим шүүх "гарцаагүй байдал"–ыг өөрийн хариуцлагаас бултах арга гэж үзэх хандлагатай. Жишээлбэл Хүний эрх болон Амьтны эрхийн талаарх маргаан гардаг. Шийдвэрийн дугаар он сар: Говь-алтай аймаг дахь сум дундын анхан шатны шүүх /иргэний хэрэг/ийн шийдвэр 2021 оны 04 сарын 14 өдөр Дугаар 133/ШШ2021/00173 Нэхэмжлэлийн шаардлага**:** Амьтны аймагт учруулсан хохиролд 22,400,000 Т гаргуулж, Говь-Алтай аймгийн Т сумын Засаг даргын Тамгын газарт олгуулах тухай иргэний хэрэг. Шүүх шийдвэрлэхдээ ИХ-н 11.1 Гарцаагүй байдлыг зохицуулалтыг

[21] Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль 2009 он

	баримталсан. үний амь бие, эрүүл мэндийн үнэ, цэнийг амьтны үнэтэй харьцуулах боломжгүй тул хариуцагч Д.Д-гийн дүү У.А-т учирч болох байсан хохирол, үр дагаврыг цоохор ирвэсийг алсны улмаас амьтны аймаг учруулсан хохиролтой харьцуулан дүгнэх боломжгүй нь хуульд нийцэж байна.
	Шийдвэрлэх болох талаар
	“Бага хохирол – их хохирол”-ын харьцуулалт оновчтой болгох шаардлагатай. Жишээлбэл Эрүүгийн хуульд[22] эрүүгийн хуульд хохирол, хор уршгийн хэмжээг тодорхойлсон байдаг. Үүний улмаас мөн хохирол нь Гэмт хэргийн бүрэлдэхүүнээс хамаарч эрүүгийн хуульд заасан хохирол үүсээгүй бол зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэх ч боломжтой.
12 дугаар зүйл. Өөртөө туслах	**Шийдвэрлэх талаар**
	- харилцан хамаарлыг тодорхойлох Өөртөө туслах эрх хязгаарлагдмал. - Иргэн өөрийн хүчээр эрхээ хамгаалах эрх нь эрүү болон захиргааны хууль зөрчих эрсдэлтэй. - Хуульд заасан “боломжгүй нөхцөл”–ийг тайлбарлах практик байхгүй. Жишээлбэл Түрээсийн байрнаас хөөгдсөн иргэн “өөрийн хүчээр” хүлээлгэн өгөхгүй байх үйлдлийг шүүх “өөртөө туслах биш, зөрчил” гэж үзсэн. Жишээлбэл “хэр хэмжээнээс хэтрүүлсэн” хэрхэн үнэлж тогтоох тухай тодорхойгүй. Шүүхийн болон маргааны төрлөөс хамаарч үнэлэмж өөрчлөгдөх боломжтой. “Х ш” ХХК нь тухайн газар дээрх үл хөдлөх хөрөнгүүдийн хууль ёсны өмчлөгч болохынхоо хувьд, мөн 650 гаруй худалдаа эрхлэгчдийн аж ахуйн үйл ажиллагааг хэвийн нөхцөлөөр хангаж байх хариуцлагыг хүлээж буй иргэний эрх зүйн оролцогч этгээдийн хувьд Иргэний хуульд зааснаар өөртөө туслах аргыг хэрэгжүүлж Э.Гын хууль бус барилга угсралтын ажлын түрэмгийлэл, хүчирхийллээс хамгаалан шөнийн 22 цагаас үүрийн 03 цаг хүртэл хугацаанд хаалтыг хэрэглэж байсан нь хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл болохгүйн зэрэгцээ, тулгарсан аюулд нийцүүлэн авсан арга хэмжээ юм. Тодруулбал Иргэний хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т “Иргэний эрх зүйн хамгаалалтыг шүүх, арбитр хуулиар тогтоосон журам, аргаар хэрэгжүүлнэ”, 9.4-т “Иргэний эрхийг дараахь аргаар хамгаална”, 9.4.9-т “өөртөө туслах”, 12 дугаар зүйлийн 12.1-д “Эрх бүхий байгууллагын тусламжийг шуурхай авах боломжгүй байсан болон цаг алдалгүй арга хэмжээ авахгүй бол эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болох буюу эрхээ хэрэгжүүлэхэд ноцтой хүндрэл учрахаар байвал иргэний эрх зүйн харилцаанд оролцогч өөрийнхөө эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, өөртөө туслах зорилгоор эд юмсыг эзэмдэж авах, устгах буюу эвдэх, эсхүл зайлсхийж болзошгүй үүрэг гүйцэтгэгчийг саатуулах, үүрэг бүхий этгээдээс гүйцэтгэвэл зохих үйлдлийн эсрэг үйлдлийг таслан зогсоохоор тухайн нөхцөл байдалд тохируулан хийсэн үйлдлийг хууль бус гэж үзэхгүй” гэж тодорхой заажээ. Гэтэл “Х ш” ХХК-ийн дээрх арга хэмжээг Газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т “газар эзэмших” гэж газрыг гэрээнд заасан зориулалт, нөхцөл, болзлын дагуу хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг; түүнчлэн 3.1.4-т “газар ашиглах” гэж хуулиар зөвшөөрсөн хүрээнд газар өмчлөгч, эзэмшигчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу газрын аль нэг ашигтай чанарыг нь гаргаж хэрэглэхийг ойлгоно гэж заасан ухагдахуунаар тайлбарлаж зөвшөөрөлгүйгээр “газрын аль нэг ашигтай чанарыг гаргаж хэрэглэсэн” буюу ашигласан хэмээн дүгнэж байгаа нь бодит байдалд нийцээгүй гэж бодож байгаа юм.[23]

[22] 2.5 дугаар зүйл.Гэмт хэргийн хохирол, хор уршиг

4.Энэ хуульд заасан дараах хохирлын хэмжээг доор дурдсанаар ойлгоно:

4.1."их хэмжээний хохирол" гэж тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг;

4.2."үлэмж хэмжээний хохирол" гэж арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг;

4.3."бага хэмжээний хохирол" гэж гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс доош хэмжээг.

[23]Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал 2020 оны 06 сарын 11 өдөр Дугаар 221/МА2020/0382

	ИХ-н 215 дугаар зүйлд заасан үүргийн гүйцэтгэлийг саатуулах эрхийн зохицуулалт
	Шийдвэрлэж болох талаар
	Нарийчлан зохицуулалт шаардлагтай.
13 дугаар зүйл. Иргэний эрх зүйн харилцаанд эрх, үүргийг хэрэгжүүлэх	**Тулгамдсан асуудал**
	Эрхээ эдлээгүй этгээдийг хамгаалахгүй Зарим иргэн эрхээ хэрэгжүүлээгүйгээс болж үр дагаврыг хүлээн зөвшөөрсөн гэж шүүх дүгнэдэг нь зарим тохиолдолд шударга бус нөхцөл байдалд хүргэдэг. Хуулийн мэдлэггүй байх, эрхээ хэрхэн хэрэгжүүлэхээ мэдэхгүй байх тохиолдолд хамгаалах механизм дутагдалтай. Жишээлбэл Иргэн хуулийн этгээдийн зүгээс хууль бус торгууль авсныг хожуу мэдсэн ч “хугацаа өнгөрсөн” гэх үндэслэлээр гомдлыг хэрэгсэхгүй болгох тохиолдол бий.
	Шийдвэрлээ болох талаар
	Иргэний эрх мэдлийн түвшинд тэнцвэр хэрэгтэй буюу нарийчлан зохицуулалт шаардлагтай.

Шүүхийн шийдвэрлэлтийн талаарх кэйсийг авч үзье.

Кэйс 1 Дахин сэргээх боломжгүй эрүүл мэндийн хохирол учирсантай холбоотой сэтгэл санааны хохирол

Тогтоолын нэр, дугаар: *Нэхэмжлэлийн шаардлага: Иргэн С нь “А” эмнэлгээс сэтгэл санааны хохиролд 50,000,000, эд хөрөнгийн хохиролд 31,098,432, нийт 81,098,432 төгрөг шаардан нэхэмжлэл гаргажээ.*

Шийдвэрлэсэн байдал:

Анхан шатны шүүхээс С-ийн эд хөрөнгийн хохиролд 18,452,502, харин сэтгэл санааны хохиролд 10,000,000, нийт 28,452,502 төгрөгийг “А” эмнэлгээс гаргуулан нэхэмжлэгчид олгохоор шийдвэрлэжээ.

Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээжээ. Харин УДШ-ээс анхан болон давж заалдах шүүх хууль хэрэглээний алдаа гаргасан байна гэж үзэн өөрчлөлт оруулжээ. Уг өөрчлөлтөөр анхан болон давж заалдах шатны шүүхээс сэтгэл санааны хохиролд 10,000,000 төгрөг олгосныг хангахгүй орхисон байна. Гэхдээ нэхэмжлэгчийн эд хөрөнгөд учирсан зарим хохирлыг үнэлээгүй байна гэж үзэн, эд хөрөнгөд учирсан хохиролд 10,000,000 төгрөг олгуулахаар ханган шийдвэрлэжээ.

(Сэтгэл санааны хохирлын тухайд): “Нэхэмжлэлийн шаардлагын нэг болох сэтгэл, санааны хохирол буюу нэхэмжлэгчид хариуцагчийн үйлдлийн улмаас сэтгэл санааны хохирол учирсан гэж үзэх үндэслэлтэй бөгөөд Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.1-д зааснаар хохирогч эдийн бус гэм хорыг арилгуулахаар шаардах эрхтэй боловч мөн зүйлийн 230.2-т “гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө” гэж заасан. Мөн хуулийн эдийн бус гэм хорыг арилгах тухай 511 дүгээр зүйлд сэтгэл санааны хохирлыг арилгах асуудал зохицуулагдаагүй тул нэхэмжлэлийн шаардлагын энэ хэсгийг хангах үндэслэлгүй юм. Иймээс сэтгэл, санааны хохиролд 10,000,000 төгрөг гаргасан шүүхийн шийдвэрийн үндэслэл хуульд нийцээгүй хэдий ч уг 10,000,000 төгрөгийн хэмжээнд нэхэмжлэлийн шаардлагын нөгөө нэг хэсэг болох нэхэмжлэгчийн эд хөрөнгөд учирсан гэм хорын шаардлагаас хэрэгсэхгүй болгосон хэсгээс дүйцүүлэн хангах нь зүйтэй”.

Кэйс 2 Хууль бусаар цагдан хоригдсонтой холбоотой сэтгэл санааны хохирол:

Тогтоолын нэр, дугаар: *УДШ-ийн 2018 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 169 дүгээр тогтоол.*

Нэхэмжлэлийн шаардлага: *И, Э нар гэмт хэрэг үйлдээгүй болох нь тогтоогджээ. Иймхүү И, Э нар гэмт хэрэгт сэжиглэгдэн шалгагдсан, таслан сэргийлэх, цагдан хорих арга хэмжээ авхуулсан, ял сонссон зэрэг төрийн байгууллага, албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр Иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргажээ. Нэхэмжлэлдээ эд хөрөнгөд учирсан хохирол 8,995,300 төгрөг, сэтгэл санаанд учирсан хохирол 18,507,000 төгрөг гэж тодорхойлсон байна.*

Шийдвэрлэсэн байдал: *УДШ-ээс нэхэмжлэгч Э, И нарын сэтгэл санааны хохирлыг ханган шийдвэрлэсэн анхан болон давж заалдах шатны шийдвэрийг үнэлэхдээ хууль буруу хэрэглэсэн гэж үзжээ. Ингэхдээ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1 болон 45.4 дүгээр зүйл нь Иргэний хуулийн 230.2-т заасан "хуульд тусгайлан заасан" гэдэгтэй нийцэхгүй гэж үзжээ. Учир нь Дээд шүүх "хуульд тусгайлан заасан" гэдгийг "Иргэний хуульд тусгайлан заасан" гэж ойлгоно гэж тайлбарласан байна. "Хуульд" гэдгийг "Иргэний хуульд" гэж ойлгоно гэсэн УДШ-ийн тайлбар нь хууль тогтоогчийн байр суурьтай зөрчилдөнө.*

Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4, мөн хуулийн 511 дүгээр зүйлийг төсөөтэй хэрэглэж, нэхэмжлэгчдийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд сэтгэл санааны хохиролд 18,507,000 төгрөг нэхэмжилснийг хангаж, нийт 24,988,500 төгрөгийг төрөөс гаргуулан нэхэмжлэгчдэд олгох нь зүйтэй гэж шийдвэрлэжээ. Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээжээ. Хариуцагч уг шийдвэрийг эс зөвшөөрч УДШ-д гомдол гаргажээ. УДШ анхан болон давж заалдах шатны шүүх Иргэний хуулийн хэрэглэвэл зохих зүйл, заалтыг хэрэглээгүй, зарим зохицуулалтыг буруу тайлбарлан хэрэглэсэн, улмаар нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангахдаа эрх зүйн хувьд алдаатай дүгнэлт хийсэн гэж үзэн магадлалд 50 дараах өөрчлөлт оруулжээ. УДШ-ээс нэхэмжлэгчдэд сэтгэл санааны хохиролд нөхөн төлбөр олгохоос татгалзсан боловч сэтгэл санааны хохиролд нэхэмжилсэн зарим шаардлага нь эд хөрөнгийн хохирлын шинжтэй гэж үзэн нэхэмжлэлээс 11,812,800 төгрөгийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож, үлдэх 15,689,500 төгрөгийг Засгийн газрын сангаас гаргуулахаар шийдвэрлэжээ.

Кэйс 3 Урт хугацааны турш таслан сэргийлэх арга хэмжээ авхуулсан, сэжигтнээр татагдсантай холбоотой сэтгэл санааны хохирол:

Тогтоолын нэр, дугаар: *УДШ-ийн 2018 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 001/ХТ2018/01759 дүгээр тогтоол*

Шийдвэрлэсэн байдал: *Анхан шатны шүүхээс Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.1, 230.2, 497 дугаар зүйлийн 497.1, 498 дугаар зүйлийн 498.4, Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7-д тус 54 тус заасныг бариимтлан Монгол Улсын Засгийн газрын нөөцийн сангаас Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтны хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохиролд 73,218 төгрөг, эдийн бус хохиролд 50,000,000 төгрөг гаргуулан нэхэмжлэгч О-д олгохоор шийдвэрлэжээ. Давж заалдах шатны шүүх Иргэний хуулийн*

230 дугаар зүйлийн 230.2, 498 дугаар зүйлийн 498.4-т заасныг бариmтлан Монгол Улсын Засгийн газрын нөөц сангаас 960,000 төгрөгийг нэхэмжлэгч О-д олгож, харин сэтгэл санааны хохирлын шаардлагыг хангахаас татгалзсан байна. О уг магадлалд сэтгэл санааны хохиролд 50,000,000 төгрөг нэмж гаргуулахаар өөрчлөлт оруулж өгнө үү хэмээн УДШ-д гомдол гаргажээ. УДШ-ээс давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээжээ. Өөрөөр хэлбэл, О сэтгэл санааны хохиролд 50,000,000 төгрөг, эдийн хохиролд 73,218 төгрөгийг төрийн сангаас гаргуулж авах эрхтэй болсон байна.

(Сэтгэл санааны хохирлын тухайд): "Нэгэнт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар "...эд хөрөнгийн бус хохирол, сэтгэл санаанд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэл" гаргах эрхийг нэхэмжлэгчид олгосон байхад зөвхөн Иргэний хуульд тусгайлсан зохицуулалт байхгүй гэсэн үндэслэл зааж хүсэлтийг хэрэгсэхгүй болгох нь Иргэний хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2-т заасан "...иргэний эрх үүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, шүүхээр хамгаалуулах зарчим"-д нийцэхгүй. Иймээс нэхэмжлэгч О нь 134 хоног цагдан хоригдсон, 21 жилийн турш сэжигтэн, яллагдагч байсан, 21 жил таслан сэргийлэх арга хэмжээтэй байсан нь хэрэгт авагдсан бариmтаар тогтоогдож байх тул Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийг төсөөтэй хэрэглэж, 230 дугаар зүйлийн 230.2-т зааснаар нэхэмжлэгчид учирсан хохирлыг гаргуулах нь Иргэний хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т нийцнэ".

Кэйс 4 Хөнгөн гэмтэл учирсантай холбоотой сэтгэл санааны хохирол

Тогтоолын нэр, дугаар: *УДШ-ийн 2019 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 692 дугаартай тогтоол*

Шийдвэрлэсэн байдал: *2018 оны 2 дугаар сарын 14-ний өдөр иргэн М авто машин жолоодож явахдаа туслах замын гарцаар гарч байсан иргэн Б-г мөргөж эрүүл мэндэд нь хөнгөн гэмтэл учруулжээ. Б-гийн биед зүүн мөрний шөрмөсний сэмрэлт, зүүн мөр, түнхний үеийн зөөлөн эдийн няцрал, цус хуралт учирсан нь тогтоогдсон ба эмчилгээний төлбөрт 776,500, рашаан сувиллын зардалд 667,200, олох байсан орлогод 4,800,000, сэтгэл 1 57 санааны хохиролд 2,000,000 төгрөг тус тус, нийт 8,243,700 төгрөг нэхэмжилжээ. Тус хэргийн хувьд хохирогч зам тээврийн ослын улмаас хөнгөн гэмтсэн бөгөөд үүнтэй холбогдуулан сэтгэл санааны хохирол нэхэмжилснийг анхан шатны шүүх зарим хэсгийг нь хангасан ч дээд шатны шүүхүүд Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т заасан "хуульд тусгайлан заасан" тохиолдолд л эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлнэ гэсэнтэй нийцээгүй гэж үзэн сэтгэл санааны хохиролтой холбоотой шаардлагыг бүхэлд нь хангахаас татгалзсан байна. Уг үндэслэлийг буруутгах боломжгүй юм. Учир нь Иргэний хуульд тусгайлан заасан нь "нэр төр, алдар хүндэд учруулсан гэм хор", бусад хуульд тусгайлан заасан нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан "эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эрх бүхий албан тушаалтны хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан гэм хор", түүнчлэн Гэр бүлийн тухай хуульд заасан тохиолдол юм. Өөрөөр хэлбэл, бусдын эрүүл мэндэд учруулсан хохирлоос үүдэх сэтгэл санааны хохирлын талаар тусгайлсан зохицуулалт байхгүй. Анхан шатны шүүхээс Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.1, 497 дугаар зүйлийн 497.1, 505 дугаар зүйлийн 505.1, 511 дүгээр зүйлийн 511.2 дахь хэсэгт заасныг бариmтлан М-ээс эд хөрөнгийн хохиролд 776,500, сэтгэл санааны хохиролд 1,000,000 төгрөг тус тус, нийт 1,776,000 төгрөг гаргуулан Б-д олгож шийдвэрлэжээ. Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх нэхэмжлэгч Б-д эмчилгээний зардалд 776,500 төгрөг гаргуулан олгож, нэхэмжлэлийн үлдэх*

шаардлагыг хангахаас татгалзжээ. УДШ давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээх нь зүйтэй гэж шийдвэрлэсэн байна.

Кэйс 5 Эрүүгийн хэрэгийн шүүхэд сэтгэл санааны хохирол шийдвэрлэсэн талаар

Тогтоолын нэр, дугаар: *УДШ-ийн 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 238 дугаартай тогтоол*

Нэхэмжлэлийн шаардлага: *Тус эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх явцад хохирогч болох талийгаачийн төрсөн эх шүүгдэгчдээс оршуулгын зардалд 4,646,839 төгрөг нэхэмжилжээ. Өөр ямар нэг хохирлын нөхөн төлбөр нэхэмжлээгүй байна.*

Шийдвэрлэсэн байдал: *Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс А1, А2 нарыг санаатайгаар хүн алах гэмт хэргийг хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байгааг мэдсээр байж онц харгис хэрцгий аргаар бүлэглэн үйлдсэн, бусдыг байнга зодох буюу тарчлаах гэмт хэрэг бүлэглэн үйлдсэн гэм буруутай гэж үзэн А2-ыг 23 жил, А1-ийг 20 жил хорих ял эдлүүлэх, Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 508 дугаар зүйлийн 508.1 дэх хэсгийг үндэслэн А2-оос 2,324,420 төгрөг, А1-ээс 2,324,420 төгрөгийг тус тус гаргуулан, хохирогчийн хууль ёсны төлөөлөгч С (хохирогчийн төрсөн эх)-д олгуулахаар шийдвэрлэжээ. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээжээ. Дээд шүүхээс А2-т 18 жил, А1-д 13 жил хорих ял оногдуулах, Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 508 дугаар зүйлийн 508.1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч А1, А2 нараас хувь тэнцүүлэн 50,000,000 (тавин сая) төгрөг гаргуулж хохирогчийн хууль ёсны төлөөлөгч С-д олгохоор шийдвэрлэжээ А1 (хохирогчийн төрсөн эцэг), А2 (хохирогчийн хойд эх) нар бүлэглэн 2014 оны 10 дугаар сарын 2-ноос 2015 оны 2 дугаар сарын 14-ний өдөр хүртэлх хугацаанд Х (3 нас 11 сартай, охин)-д арцыг арвайн будаатай хольж хүчээр идүүлэх, суран бүсний арлаар зодох зэргээр байнга зодож тарчлаадаг байсан ба 2015 оны 2 дугаар сарын 15-ны өдөр өмдөндөө баалаа, үгэнд орсонгүй гэж Х-г биеэ хамгаалж чадахгүйг мэдсээр байж, онц харгис хэрцгий аргаар зодож санаатайгаар амь насыг нь бусниулжээ. Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 508 дугаар зүйлийн 508.1 дэх хэсгийг үндэслэн А2-оос 2,324,420 төгрөг, А1-ээс 2,324,420 төгрөгийг тус тус гаргуулан, хохирогчийн хууль ёсны төлөөлөгч С (хохирогчийн төрсөн эх)-д олгуулахаар шийдвэрлэжээ. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээжээ. Дээд шүүхээс А2-т 18 жил, А1-д 13 жил хорих ял оногдуулах, Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 508 дугаар зүйлийн 508.1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч А1, А2 нараас хувь тэнцүүлэн 50,000,000 (тавин сая) төгрөг гаргуулж хохирогчийн хууль ёсны төлөөлөгч С-д олгохоор шийдвэрлэжээ.*

Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлд гэмт хэргийн хохирол, хор уршгийн хэмжээг тодорхойлохдоо 50,000 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 50,000,000 төгрөгийг их хэмжээний хохирлын доод хэмжээ болгон хуульчилсан зэрэг жишиг болох нөхцөл байдлуудыг харгалзан үзэж шүүгдэгч А1, А2 нараас хувь тэнцүүлэн 50,000,000 төгрөг гаргуулан хохирогчийн хууль ёсны төлөөлөгч С-д олгуулахаар шийдвэрлэсэн болно" Харин сэтгэл санааны хохирол гэж 50,000,000 төгрөг эсхүл түүнээс илүү үнийн дүн бүхий нэхэмжлэл гаргаагүй байхад шүүхээс дур мэдэн хохирогчид нөхөн төлбөрийг гэм хор учруулагчдаас гаргахаар шийдвэрлэжээ. Хэдийгээр энэхүү шүүхийн шийдвэрт дээр дурдсан шүүмжлэл дагуулахуйц зүйлс тусгагдсан байх боловч шүүхийн байр суурь хүний амь насыг бусниулсан хэрэгт сэтгэл санааны хохирол тусгайлсан зохицуулалт байхгүй ч хууль тайлбарлах замаар хүлээн зөвшөөрч, түүгээр ч үл барам нөхөн төлбөрийн хэмжээг

тооцоолохдоо тухайн гэмт хэргийн харьяалагдах төрлийн материаллаг шинжээр дүйцүүлнэ гэж үзсэн нь тодорхой юм.

Анхан болон давж заалдах шатны шүүх нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангахдаа Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.1-д заасан зохицуулалтыг тухайн маргаанд төсөөтэй хэрэглэсэн нь алдаатай болжээ. Иргэний хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д зааснаар Иргэний хуульд тухайн харилцааг зохицуулсан хэм хэмжээ байхгүй бол түүнтэй төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийн хэм хэмжээг хэрэглэх боловч мөн зүйлийн 4.3-т зааснаар тусгай харилцааг тухайлан зохицуулсан хэм хэмжээг бусад харилцаанд төсөөтэй хэрэглэж үл болно. Сэтгэл санаанд учирсан гэм хор болон нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд гутаагдсанаас учирсан гэм хор нь эдийн бус гэх төрөлд хамаарах боловч агуулга, хэлбэрийн хувьд ялгаатай тул эдгээр харилцаанд эрх зүйн нэг хэм хэмжээг төсөөтэй хэрэглэх боломжгүй гэж үзжээ.

Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-д “Зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлүүлнэ” гэж заасан нь эдийн бус гэм хорын нөхөн төлбөрт тавигдах хязгаарлалтыг илтгэнэ. Монгол Улсын Иргэний хуульд шаардлагатай нөхцөл бүрдсэн тохиолдолд гэрээний харилцааг үндэслэл болгохгүйгээр эдийн бус гэм хорын нөхөн төлбөрийг хэрэгжүүлэх зохицуулалт бий. Иргэний хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэлийг тодорхойлсон бөгөөд 8.1.5-д “Гэм хор учруулах” гэсэн үндэслэл багтсан байна. Мөн 9 дүгээр зүйлийн 9.4-т иргэний эрхийг хамгаалах аргуудыг зааж, 9.4.5-д “Эдийн бус гэм хорыг арилгуулах” тухай тусгасан байдаг. Харин 228 дугаар зүйлийн 228.1-д “Гэм хорыг арилгах үүрэг бүхий этгээд нөгөө талын зөрчигдсөн эрхийг гэм хор учруулахаас өмнөх байдалд сэргээх үүрэгтэй. Хэрэв эрхийг сэргээх боломжгүй буюу харьцангуй өндөр зардал гарвал мөнгөөр нөхөн төлж болно” гэж заасан. Түүнчлэн 230 дугаар зүйлийн 230.1-д “Эдийн бус гэм хорыг арилгуулахаар хохирогч шаардах эрхтэй” гэж тодорхойлсон бол 230.2-д зөвхөн хуульд тусгайлан заасан нөхцөлд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө гэдгийг хязгаарласан. Иргэний хуулийн бусад холбогдох заалтуудад, тухайлбал 497 дугаар зүйлийн 497.1-д “Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд санаатай буюу болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй”, 511 дугаар зүйлийн 511.1, 511.2-т бусдын нэр төр, алдар хүндийг гутаасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах талаар нарийвчилсан зохицуулалт бий. Гэсэн хэдий ч Иргэний хуулийн үзэл баримтлал, зохицуулалтаас үзэхэд эдийн бус гэм хорын ойлголтод зөвхөн бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд багтаж байгаа нь анхаарал татна. Мөн бие махбод, эрүүл мэнд, эд хөрөнгөд учруулсан хохирлын улмаас үүссэн сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр хэрхэн нөхөн төлүүлэх тухай зохицуулалт учир дутагдалтай байна.

Гурав. Харьцуулсан судалгаа

Хүснэгт 3. *Харьцуулалт*

Улс	Аргагүй хамгаалалт (Self-defense)	Гарцаагүй байдал (Necessity)	Өөртөө туслах эрх (Self-help)
Герман	Германын Иргэний хууль (BGB) аргагүй хамгаалалт, гарцаагүй байдлыг нарийвчлан зохицуулдаг. “Нэн даруй хариу арга хэмжээ авах” боломжийг олгодог бөгөөд эдгээр нь эрүүгийн болон иргэний хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болдог.	Зөвхөн хүний амь, эрүүл мэндэд заналхийлсэн үед зөвшөөрөгддөг.	Хязгаарлагдмал бөгөөд хуульд нарийн заасан байдаг.

Франц	Францын Иргэний хуульд аргагүй хамгаалалт, гарцаагүй байдлын ойлголтууд шүүхийн практикт өргөн хэрэглэгддэг. Үүнийг хууль зөрчсөн үйлдлийг зөвтгөх үндэслэл болгон ашигладаг.	Үйлдэл нь шударга, зохистой байх ёстой.	Маш онцгой нөхцөлд зөвшөөрөгддөг.
Япон	Бодит аюул заналхийлэл байх шаардлагатай.	Үр дагавар нь бага байх тохиолдолд зөвтгөдөг.	Хуульд тодорхой зохицуулалтгүй.
АНУ (Калифорни)	“Stand your ground” гэсэн үзэл давамгайлдаг. Өөрийгөө болон бусдыг хамгаалах эрхийг зөвшөөрдөг. Гэхдээ зайлшгүй, бодит аюул заналхийлэлтэй нөхцөлд зохистой хүч хэрэглэсэн байх шаардлагатай.	Зайлшгүй нөхцөлд хууль зөрчихөөс өөр аргагүй байдалд орсон тохиолдолд хэрэглэгддэг. Жишээ нь онцгой байдалд бусдын өмчид хохирол учруулах.[24]	Иргэн өөрийн өмчийг хамгаалах эрхтэй.

Дөрөв. Дүгнэлт

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн дөрөвдүгээр бүлэгт гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлыг хуульчилсан бөгөөд үүнд 4.1 дүгээр зүйлд аргагүй хамгаалалтын зохицуулалт тусгагдсан байдаг. Тухайлбал, 4.1.1-д “Өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндэд тулгарсан хууль бус довтолгооны эсрэг хийсэн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй” гэж заасан байна. Хуулинд хүн мэргэжил, тусгай бэлтгэл, албан байдал, довтолгооноос зайлсхийх эсвэл бусдаас тусламж авах боломжтой байсан эсэхээс үл хамааран аргагүй хамгаалалт хийх эрхтэй гэж хуульчилсан нь эрүүгийн хянан шийдвэрлэх ажиллагаанд цагаатгагдсан болон шийтгэх тогтоол гаргах үндэс болж байгаа хэд хэдэн тохиолдол бий. Гэвч Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд аргагүй хамгаалалтын зохицуулалттай холбоотой жигд шүүхийн практик бүрдээгүй, Иргэний хуулийн 8–13 дугаар зүйлд заасан суурь зарчмууд нь практикт тодорхойгүй байдлаас шалтгаалсан зөрчил, ялгаатай тайлбаруудыг төрүүлж байна. Мөн зарим зохицуулалт эрүүгийн болон захиргааны хуулийн заалтуудтай давхцаж, уялдаа холбоогүй нь хуулийн хэрэглээнд хүндрэл үүсгэж байна.

Хувь хүний эрхийн зөрчил гэм хорын эрх зүйн бүрэлдэхүүнийг хангаж байж эрхийн хамгаалалт амжилттай хэрэгжих боломжтой юм. Тиймээс Иргэний хуулийн ерөнхий ангид тусгагдсан хувь этгээдийн эрх хамгаалалт болон гэм хорын эрх зүйн шаардах эрхийн хоорондын уялдааг системийн өнцгөөс тодорхойлох шаардлага байна. Хувь хүний эрхийн зөрчлийг хамгаалах үйл явц нь аргагүй хамгаалалт хэрэгжээгүй тохиолдолд гэм хорын эрх зүйн шаардах эрхийн бүрэлдэхүүнд ихээхэн хамааралтай байдаг. Иймээс гэм хорын эрх зүйн хамгаалалт нь хууль зүйн системийн хувьд ерөнхий ангийн хувь этгээдийн хамгаалалтын үргэлжлэл бөгөөд энэ хоёр зохицуулалт зарчмын хувьд нягт уялдаатай байна. Тиймээс Иргэний хуулийн 21, 27 дугаар зүйлд заасан хамгаалалтыг системийн нэг хэсэг гэж үзэж, эдгээрийг хамтад нь зохицуулах нь оновчтой гэж үзнэ. Учир нь хувь хүний эрхийг хамгаалах зарчим нь гэм хорын эрх зүйн хамгаалалтыг зайлшгүй шаарддаг бөгөөд эдгээр нь хүний амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд зэрэг амины эрхийг хамгаалах үндсэн хүрээг бүрдүүлдэг.

Монгол Улсын Иргэний хуульд эдийн бус, сэтгэл санааны хохирлыг арилгах зохицуулалт хангалтгүй байгаагаас хувь этгээдийн амины эрхийг бүрэн хамгаалах боломж хязгаарлагдмал байна. Тухайлбал, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг

[24] www.justia.com

хамгаалах амины эрхийн зохицуулалттай боловч хууль хэрэглээний нэгдмэл ойлголтгүй улмаас энэ хүрээнд сэтгэл санааны болон эдийн бус хохирлыг барагдуулах эрх зүйн зохицуулалт хангалтгүй хэвээр байна.

Мөн хувь хүний амины эрх нь зөвхөн нэр төр, алдар хүндээр хязгаарлагдахгүй бөгөөд хувийн нууц, эмнэлгийн түүх, зэрэг нууц мэдээллүүд нь эд хөрөнгө, бусад эрхтэй адил хамгаалалтад орох ёстой үнэт зүйлс юм. Манай улсын хувьд Эрүүгийн хуулийн [25]тусгай ангийн арван гуравдугаар бүлэгт "хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг"-т 13.8, 13.10, 13.11, 13.14 дүгээр зүйлүүдэд хуульчлан зохицуулж энэ төрлийн гэмт хэргийг эрүүгийн хэргийн шүүх шийдвэрлэн хуульд заасан ялыг оногдуулж байна. Иймд эдгээр эрхийг Иргэний хуульд "бусад эрх" гэсэн тодорхойгүй нэр томьёонд хамаатуулан системтэйгээр хамгаалах шаардлага үүсэж байна. Үүнээс гадна Иргэний хуулийн 230 дугаар зүйлд "эдийн бус гэм хорыг зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөөр нөхөн төлнө" гэж зааснаар иргэдэд бодитоор учирсан сэтгэл санааны хохирлын нэг хэсгийг бүрэн нөхөн гаргуулах боломжгүй нөхцөл байдал үүсэж байна. Энэ асуудлыг гадаад жишээгээр жишээ авахад, жишээлбэл Португалийн Иргэний хуульд хувь хүний эрхийг бүхэлд нь, насан эцэс хүртэл хамгаалах нарийвчилсан зохицуулалттай байдаг. Монгол Улсын ИХ-н өнөөгийн эрх зүйн зохицуулалт нь хувь хүний амины эрх, тэр дундаа эдийн бус болон сэтгэл санааны хохирлыг бүрэн хамгаалахад дутмаг бөгөөд үүнийг хууль тогтоомж, шүүхийн практикийн уялдааг сайжруулан системтэйгээр зохицуулах шаардлагатай гэж үзэж байна. Энэхүү өөрчлөлт нь хувь хүний эрхийн хамгаалалтыг бэхжүүлж, хохирлын эрх зүйн тэнцвэрт байдлыг хангах, эрхийн хамгаалалтын системийг боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой юм.

II ДЭД ХЭСЭГ. ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААНД ОРОЛЦОГЧИД 14-24 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН ХЭРЭГЖИЛТ ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ИРГЭН

Энэхүү үнэлгээний ажлын гол зорилго нь Монгол Улсын Иргэний хуулийн 3 дугаар бүлэг 14-24 дүгээр зүйлд зохицуулж буй хуулийн зүйл, заалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу онолын увьд дүн шинжилгээ хийж, хуулийн хэрэглээний болон бусад улс орны хуультай харьцуулан судалгааг судалгааны удирдамж, тайлангийн загвар, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу хийж гүйцэтгэлээ.

14 дүгээр зүйл. Иргэний эрх зүйн чадвар	14.1.Иргэний эрх зүйн чадвар нь иргэнийг төрсөн үеэс эхэлж нас барснаар дуусгавар болно.
	14.2.Иргэний эрх зүйн чадварыг хязгаарлахыг хориглоно.
15 дугаар зүйл. Иргэний эрх зүйн бүрэн чадамж	15.1.Иргэний эрх зүйн бүрэн чадамж буюу иргэн өөрийн үйлдлээр өөртөө эрх олж авах, үүрэг бий болгох чадвар насанд хүрснээр буюу 18 наснаас бий болно.
	15.2.Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүх 16-аас 18 хүртэлх насны иргэнийг, түүний хүсэлт, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр иргэний эрх зүйн бүрэн чадамжтай гэж тооцож болно.
	15.3.Иргэний эрх зүйн бүрэн чадамжтай гэж тооцсон шүүхийн шийдвэрийг зохих үндэслэл байвал сонирхогч этгээдийн хүсэлтээр шүүх хүчингүй болгож болно.
	16.1.Насанд хүрээгүй буюу 14-өөс 18 хүртэлх насны этгээд иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай байна.

[25] https://legalinfo.mn/mn/detail/11634

16 дугаар зүйл. Иргэний эрх зүйн бүрэн бус чадамж	**Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5."мэдээллийн эзэн" гэж энэ хуулийн 4.1.11-д заасан мэдээллээр тодорхойлогдож байгаа хүнийг, Иргэний хуулийн 17, 18, 19 дүгээр зүйлд заасан, хуульд өөрөөр заагаагүй бол мөн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэн бол түүний хууль ёсны төлөөлөгчийг;**
	16.2.Насанд хүрээгүй иргэн хуулиар зөвшөөрснөөс бусад хэлцлийг хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, харгалзан дэмжигч/-ийн бичгээр олгосон зөвшөөрлийн үндсэн дээр хийнэ.
	16.3.Насанд хүрээгүй иргэн хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр дараахь эрхээ бие даан хэрэгжүүлж болно: 16.3.1.өөрийн хөдөлмөрийн хөлс, оюутны тэтгэлэг, тэдгээртэй адилтгах бусад орлого, тэдэнд өөрийн үзэмжээр захиран зарцуулахад нь зориулж шилжүүлсэн эд хөрөнгийг захиран зарцуулах; 16.3.2.өөртөө хохиролгүй бөгөөд хиймэгц биелэх ахуйн чанартай хэлцэл хийх; 16.3.3.энэ хуулийн 16.3.1-д заасан орлогыг банк, зээлийн байгууллагад хадгалуулах. **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3.Иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай этгээд Иргэний хуулийн 16.3-т заасан үндэслэлээр иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд бие даан оролцож болно.**
	16.4. 16-аас 18 хүртэлх насны иргэн хоршооны гишүүн байж болно.
17 дугаар зүйл. Иргэний эрх зүйн зарим чадамж	17.1. 7-гоос 14 хүртэлх насны этгээд иргэний эрх зүйн зарим чадамжтай байна. **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5."мэдээллийн эзэн" гэж энэ хуулийн 4.1.11-д заасан мэдээллээр тодорхойлогдож байгаа хүнийг, Иргэний хуулийн 17, 18, 19 дүгээр зүйлд заасан, хуульд өөрөөр заагаагүй бол мөн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэн бол түүний хууль ёсны төлөөлөгчийг;**
	17.2. 7-гоос 14 хүртэлх насны этгээдийн хийсэн өөртөө хохиролгүй бөгөөд хиймэгц биелэх, ахуйн чанартай жижиг хэлцлээс бусад хэлцлийг тэдгээрийн нэрийн өмнөөс хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч/ хийнэ. **Гэр бүлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.4.сэтгэцийн өвчний улмаас шүүхээс иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй гэж тооцогдсон хүн.**
18 дугаар зүйл. Иргэний эрх зүйн чадамжгүй иргэн	18.1. 7 хүртэлх насны этгээд иргэний эрх зүйн чадамжгүй байна.
	18.2.Сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон этгээдийг шүүх иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцож, түүнд асран хамгаалалт тогтооно
	18.3.Иргэний эрх зүйн чадамжгүй этгээдийн нэрийн өмнөөс түүний хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч/ хэлцэл хийнэ.
	18.4.Иргэний эрх зүйн чадамжгүйд тооцох үндэслэл болсон нөхцөл байдал үгүй болсон тохиолдолд шүүх тухайн этгээдийг иргэний эрх зүйн чадамжгүйд тооцсон шийдвэрийг хүчингүй болгоно.
19 дүгээр зүйл. Иргэний эрх зүйн чадамжийг хязгаарлах	19.1.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэж, гэр бүлээ эдийн засгийн талаар хүнд байдалд оруулсан насанд хүрсэн этгээдийн иргэний эрх зүйн чадамжийг сонирхогч этгээдийн хүсэлтээр, шүүх хуулиар тогтоосон журмаар хязгаарлаж, харгалзан дэмжигч томилж болно. **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5."мэдээллийн эзэн" гэж энэ хуулийн 4.1.11-д заасан мэдээллээр тодорхойлогдож байгаа хүнийг, Иргэний хуулийн 17, 18, 19 дүгээр зүйлд заасан, хуульд өөрөөр заагаагүй бол мөн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэн бол түүний хууль ёсны төлөөлөгчийг**

	19.2.Иргэний эрх зүйн чадамжийг хэлцэл хийх замаар хязгаарлахыг хориглоно.
	19.3.Иргэний эрх зүйн чадамж нь хязгаарлагдсан этгээд хязгаарлагдаагүй чадамжийнхаа хүрээнд, харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр хэлцэл хийж болно.
	19.4.Иргэний эрх зүйн чадамжийг хязгаарлах үндэслэл болсон нөхцөл байдал үгүй болсон бол тухайн этгээдэд тогтоосон хязгаарлалтыг шүүх хүчингүй болгож, харгалзан дэмжигчийг үүргээс нь чөлөөлнө.
20 дугаар зүйл. Иргэний нэр	20.1.Иргэн өөрийн нэртэй байна.
	20.2.Иргэний нэрийг бүртгэх, өөрчлөх журмыг хуулиар тогтооно.
	20.3.Иргэний нэрийг эрх бүхий байгууллагад бүртгүүлнэ. Иргэний эрх, үүргийг иргэн өөрийн нэрээр олж авч хэрэгжүүлнэ. Гагцхүү хуульд заасан нөхцөл, журмын дагуу зохиомол нэр хэрэглэж болно.
	20.4.Иргэн нэрээ өөрчилсөн нь түүний өмнөх нэрээр олж авсан эрх, хүлээсэн үүргийг өөрчлөх буюу дуусгавар болгох үндэслэл болохгүй.
	20.5.Нэрээ өөрчилсөн этгээд үүрэг гүйцэтгүүлэгч болон үүрэг гүйцэтгэгчид энэ тухай мэдэгдэх үүрэгтэй бөгөөд энэ үүргээ биелүүлээгүйгээс гарсан үр дагаврыг хариуцна.
21 дүгээр зүйл. Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах	21.1.Иргэний нэрийг хууль бусаар ашиглахыг хориглоно.
	21.2.Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл, эсхүл өөр хэлбэр, хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ.
	21.3.Бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс бусдын нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бол энэ хуулийн 21.2-т заасан журмаар няцаах үүрэг хүлээнэ.
	21.4.Хуулиар тогтоосон хувийн нууцад хамааралтай мэдээг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр тарааснаас гэм хор учирсан гэж үзвэл иргэн уг гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй.
	21.5.Иргэний дүрсийг гэрэл зураг, кино, дүрс бичлэгийн хальс, хөрөг зураг болон бусад хэлбэрээр өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлсэн, олон нийтэд үзүүлснээс гэм хор учирсан гэж үзвэл тухайн этгээд гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй. 21.6.Иргэний нийгэмд эзлэ
	21.6.Иргэний нийгэмд эзлэх байр суурьтай холбогдуулан түүнийг сурталчлах зорилгоор болон сургалт, эрдэм шинжилгээний ажил, ажил хэргийн хүрээнд олон нийтийг хамарсан үйл ажиллагааны явцад уг этгээдийг дүрсэлсэн, эсхүл тухайн этгээд өөрийгөө дүрслүүлсний төлөө хөлс, шан харамж авсан бол түүний зөвшөөрөл шаардагдахгүй.
	21.7.Нас барсан этгээдийн нэр, нэр төр, алдар хүндийг гутаасан, эсхүл түүний хувийн нууцтай холбоотой мэдээг энэ хуулийн 520 дугаар зүйлд заасан өвлөгчийн зөвшөөрөлгүйгээр олон нийтэд тараасан бол энэ зүйлд заасан журам нэгэн адил үйлчилнэ.
	21.8.Энэ хуулийн 21.7-д заасан тохиолдолд учирсан гэм хорыг эдийн хэлбэрээр нөхөн төлүүлэхийг шаардах эрхгүй.
	21.9.Энэ зүйлд заасан эрхийг зөрчсөн этгээд бусдад учруулсан гэм хорыг хохирогч буюу сонирхогч этгээдэд энэ хуулийн 497, 511 дүгээр зүйлд заасан журмын дагуу арилгана.
	22.1.Иргэний оршин суугаа газрыг хуулийн дагуу түүний харьяалагдан бүртгүүлсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр тодорхойлно.

22 дугаар зүйл. Иргэний оршин суугаа газар	22.2.Иргэн бүртгүүлсэн газраа байнга оршин суудаггүй бол гол төлөв амьдран суудаг, эсхүл тухайн этгээдийн эд хөрөнгийн дийлэнх хэсэг байгаа газрыг түүний оршин суугаа газар гэж тодорхойлж болно.
	22.3.Бусдын асран хамгаалалтад байгаа этгээдийн оршин суугаа газрыг тэдгээрийн эцэг, эх, асран хамгаалагчийн оршин суугаа газраар тодорхойлно.
23 дугаар зүйл. Иргэнийг сураггүй алга болсонд тооцох	23.1.Оршин суугаа газраасаа алга болсноос хойш хоёр жилийн хугацаанд хаана байгаа нь мэдэгдэхгүй, сураг чимээгүй болсон иргэнийг сонирхогч этгээдийн хүсэлтээр, шүүх сураггүй алга болсонд тооцож болно.
	23.2.Сураггүй алга болсонд тооцогдсон этгээдийн эд хөрөнгөд шүүхээс эрхлэн хамгаалалт тогтоох бөгөөд тухайн этгээдийн асрамжид байсан хүмүүсийг тэжээн тэтгэх, хуулиар тогтоосон журмын дагуу татвар, хураамж төлөх, бусдын өмнө хүлээсэн үүргийн дагуу өр төлбөрийг төлж барагдуулах зэрэг хууль ёсоор гүйцэтгэвэл зохих үүргийг уг эд хөрөнгөөс гүйцэтгэнэ.
	23.3.Сураггүй алга болсонд тооцогдсон этгээдийн байгаа газар нь тогтоогдсон, тухайн этгээд эргэж ирсэн тохиолдолд шүүх шийдвэрээ хүчингүй болгож, эд хөрөнгөд нь тогтоосон эрхлэн хамгаалалтыг зогсооно.
	23.4.Эргэж ирсэн этгээд нь сураггүй алга болсонд тооцогдсоноос хойш энэ хуулийн 23.2-т зааснаас өөр үндэслэлээр бусдад үнэ төлбөргүй шилжсэн бөгөөд бэлэн байгаа эд хөрөнгөө буцаан авахаар шаардах эрхтэй. Уг эд хөрөнгийг аж ахуйн зориулалтаар ашигласны үр дүнд олсон ашгийг нөхөн төлүүлэхээр шаардах эрхгүй.
	23.5.Сураггүй алга болсонд тооцогдсон этгээдийн эд хөрөнгийг эрхлэн хамгаалагч нь бусдад худалдсан бол түүний үнийг, үрэгдүүлсэн, дутаасан, гэмтээсэн бол шүүх гэм буруугийн шинж байдлыг харгалзан уг эд хөрөнгийн үнийг бүрэн буюу хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэж болно.
	23.6.Сураггүй алга болсонд тооцогдсон этгээд эргэж ирсэн бол эд хөрөнгийг эрхлэн хамгаалагч нь уг эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалттай холбогдон гарсан зардал, хохирлоо төлүүлэхээр шаардах эрхтэй.
24 дүгээр зүйл. Иргэнийг нас барсан гэж зарлах	24.1.Иргэн оршин суугаа газраасаа алга болсноос хойш таван жилийн хугацаанд хаана байгаа нь мэдэгдэхгүй сураг чимээгүй болсон, эсхүл амь үрэгдэж болох нөхцөл байдалд алга болсноос хойш нэг жилийн турш амьд байгаа эсэх нь мэдэгдэхгүй байгаа бол сонирхогч этгээдийн хүсэлтээр шүүх түүнийг нас барсан гэж зарлаж болно. **Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.Энэ зүйлийн нөхөх олговрыг нэхэмжлэх эрхтэй этгээд энэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш нэхэмжлэлийн бүрдүүлбэрээ хангаж байх хугацаандаа, эсхүл шүүхэд нэхэмжлэлээ гаргасны дараа нас барсан бол түүний эрх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 30 дугаар зүйл, Иргэний хуулийн 24, 515, 518 дугаар зүйлд заасны дагуу хууль ёсны буюу гэрээслэлээр өв залгамжлагчид шилжинэ.** **/Энэ хэсгийг 1999 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн, энэ хэсэгт 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/**
	24.2.Байлдааны ажиллагаанд оролцож яваад сураггүй алга болсон этгээдийг уг ажиллагаа дууссан өдрөөс хойш хоёр жил өнгөрсний дараа шүүхээс нас барсан гэж зарлаж болно.
	24.3.Иргэнийг нас барсанд тооцсон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрийг уг этгээдийн нас барсан өдөр гэж үзнэ.
	24.4.Амь үрэгдэж болох нөхцөл байдалд алга болсон иргэнийг нас барсан гэж зарласан бол шүүх түүний нас барсан байж болох өдрийг уг этгээдийн нас барсан өдөр гэж тооцож болно.
	24.5.Нас барсан гэж зарлагдсан этгээдийн хөрөнгийг өвийн журмаар бусдад шилжүүлнэ.

	24.6.Нас барсан гэж зарлагдсан этгээд эргэж ирэх буюу байгаа газар нь тогтоогдсон бол шүүх урьд гаргасан шийдвэрийг хүчингүй болгоно.
	24.7.Нас барсан гэж зарлагдаад эргэж ирсэн этгээд өвлөх болон бусад хэлбэрээр бусдад үнэ төлбөргүй шилжсэн бэлэн байгаа эд хөрөнгөө буцаан авахаар шаардах эрхтэй. Энэ журмаар төрийн өмчлөлд шилжсэн эд хөрөнгийг өмчлөгчид буцаан олгох боломжгүй бол үнийг нь нөхөн төлнө.
	24.8.Нас барсан гэж зарласан шүүхийн шийдвэр хүчингүй болсон нь тухайн этгээдийн эхнэр, нөхрийн шинээр гэрлэсэн гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох үндэслэл болохгүй.

Нэг. Онолын ойлголт

Иргэн нь төрсөн цагаасаа эхлэн эрх зүйн харилцааны субъект болох үндсэн чадвар[26] буюу иргэний эрх зүйн чадвартай болно. Энэ чадвар нь эрх эдлэх, үүрэг хүлээх хууль ёсны боломжийг илэрхийлдэг бөгөөд амьд ахуй хугацаанд хүчин төгөлдөр оршин тогтноно. Эрх зүйн чадвараас гадна тухайн иргэн эрх зүйн үйлдэл хийх, өөрийн нэрийн өмнөөс гэрээ байгуулах, үүрэг хүлээх иргэний эрх зүйн чадамж-тай байх ёстой. Чадамж нь хүний сэтгэцийн байдал, нас зэрэг нөхцөлөөс хамаарч дараах байдлаар ангилагддаг. Нэгдүгээрт, бүрэн чадамж нь 18 нас хүрсэн, сэтгэцийн хувьд эрүүл иргэнд хамаарна. Энэ тохиолдолд иргэн эрх зүйн аливаа харилцаанд бие даан оролцож, гэрээ хэлцэл байгуулах, өмч эзэмших зэрэг бүх эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Хоёрдугаарт, бүрэн бус чадамж нь 7-оос дээш насны хүүхдүүдэд хамаарах бөгөөд тэд өдөр тутмын жижиг хэрэгцээтэй гэрээ хийхээс бусад тохиолдолд хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрлөөр эрх зүйн үйлдэл хийнэ. Гуравдугаарт, зөвхөн зарим эрх зүйн чадамжтай иргэн нь (ихэвчлэн 14-18 насны өсвөр насныхан) хуульд заасан тодорхой харилцаанд бие даан оролцох боломжтой байдаг. Жишээлбэл өөрийн орлогоор жижиг худалдан авалт хийх зэрэг. Харин эрх зүйн чадамжгүй иргэн нь сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй, өөрийгөө хянах чадваргүй хүнийг хэлэх ба шүүхийн шийдвэрээр чадамжгүйд тооцож, асран хамгаалагч томилдог. Ийм иргэний өмнөөс аливаа эрх зүйн үйлдлийг зөвхөн төлөөлөгч гүйцэтгэнэ. Иргэний чадамжийг хуулиар хязгаарлах боломжтой. Хэрэв иргэн архины хэтрүүлэл, мансууруулах бодисын нөлөөнд орж, өөрийгөө болон эд хөрөнгөө зохицуулах чадваргүй болсон бол шүүх түүнийг хязгаарлагдмал чадамжтайд тооцож, хууль ёсны төлөөлөгч томилно.

Иргэн нь нийгмийн харилцаанд өөрийн нэрээр оролцдог бөгөөд нэр нь тухайн хүний овог, нэрийг хамарна. Иргэн өөрийн нэрийг сонгох, өөрчлөх эрхтэй. Үүнтэй уялдан иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд нь хуулиар хамгаалагдана. Хэн нэгэн этгээд эдгээрийг гүтгэх, гутаах, нэр хүндэд халдах үйлдэл хийсэн бол хуульд заасан журмаар хариуцлага хүлээдэг. Мөн иргэн оршин суугаа газартай байх үүрэгтэй бөгөөд энэ нь түүний байнга амьдардаг хууль ёсны хаяг юм. Оршин суугаа газар нь шүүхийн мэдэгдэл, захидал харилцаа, хууль хэрэглэх нутаг дэвсгэрийг тогтооход чухал ач холбогдолтой. Зарим тохиолдолд иргэн тодорхой хугацаанд сураггүй болсон бол шүүхээс сураггүй алга болсонд тооцох шийдвэр гаргаж болно. Энэ нь ердийн нөхцөлд 2 жилийн хугацаагаар тооцогддог бөгөөд тухайн хүний өмч хөрөнгийн эрхийг хамгаалах зорилготой. Цаашлаад, хэрэв тухайн иргэн амь насанд аюултай нөхцөл байдалд орсон ба 6 сар, эсвэл сураггүй болсноос хойш 5 жилийн хугацаа өнгөрсөн бол шүүх нас барсан гэж зарлах шийдвэр гаргаж болно. Энэ шийдвэр нь өв залгамжлалын эрх зүйн харилцааг үүсгэх эрх зүйн үр дагавартай.

МУ-ын ИХ-д 15-с “иргэний эрх зүйн чадвар” гэсэн нэр томьёог ашигласан нь хувийн эрх зүйн салбарын бүх эрхүүдийг бүх хүн тэгш хүртэх бодит боломж хязгаарлагдмал учир тусгай эрх зүйн чадвар байх боломжтой.[27] Иргэний эрх зүйн чадвар гэдэгт хувийн эрх зүйн

[26] Ч.Нямсүрэн, Эрх зүйн онол, 2010 он

[27]Ч.Нямсүрэн, Эрх зүйн онол, 2010 он, Palandt, Bürgerliches Gesetzbuch, 64. Aufl., 2005, S.9

салбарт эрх эдэлж, үүрэг хүлээх боломжийг ойлгож байсан хэмээн өрөөсгөл тайлбарт хүргэж байна.[28] Хувь хүний салшгүй эрх болон туйлын бусад эрх гэм хорын эрх зүйгээр хамгаалагдана гэх Германы хуульчдын хандлага нь зөрчигдсөн эрхийг сэргээх нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлоход нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл туйлын эрхийг зөрчсөнөөр шууд буюу бодит хохирлыг арилгах үндсэн чиг тогтсон бөгөөд дамжмал шинжтэй, цэвэр эдийн засгийн агуулгатай хохирлыг арилгах нь туйлын эрхийн хамгаалалттай уялдахгүй гэж үзэх шүүхийн практик тогтжээ. Харин Франц Улсын гэм хорын эрх зүй дэх хамгаалагдах зүйл, эрхийн нээлттэй байдал нь хохирлын хэмжээг тогтооход Герман Улсаас өөр практик тогтох үндэслэл болсон. Ийнхүү эх газрын эрх зүйн бүлийн голлох хоёр улсын ялгаатай шүүхийн практик гэм хорын эрх зүйн хамгаалах зүйлийн хүрээг хэрхэн тогтоосноос ихээхэн хамаарчээ.[29]

БНСУ-н ИХ-ийн 18.2. Сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон этгээдийг шүүх иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцож, түүнд асран хамгаалалт тогтооно. [30]

Кэйс 1 Эхнэр, нөхөр хоёрын сэтгэцийн эмгэгийн улмаас гэр бүл цуцлуулах, нөхрөө асран хамгаалах тухай гомдол

Үйлчлүүлэгч нөхөр нь хуулийн фирмд хандаж, сэтгэцийн хүнд өвчтэй, хүнд эмчилгээ хийлгэсний улмаас эхнэр сэтгэцийн өвчтэй гэсэн үндэслэлээр гэрлэлтээ цуцлуулах өргөдөл гаргасан. Эхний шүүх хурлаар эхнэрийн эд хөрөнгө хуваах хүсэлтийг хэрэгсэхгүй болгож, асран хамгаалах, хүүхдийн тэтгэлэг олгох тухай шийдвэр гаргасан. Үйлчлүүлэгч болон түүний эхнэр 17 жил эв найртай амьдарсан. Эхнэрийн сэтгэцийн эмгэг гэрлэхээс өмнө үүссэн, сэтгэцийн эмгэгийн зэрэг нь маш хүнд тул эдгэрэхэд хэцүү, үүнийг тэвчихэд хэт их дарамт учруулж байна гэж няцаасан. Дээд шүүхээс сэтгэцийн эмгэг эдгэшгүй өвчнөөр өвчилсөн бол энэ нь шүүхээр гэрлэлтээ цуцлуулах үндэслэл болно гэж үзсэн байна.

Кэйс 2 Сэтгэцийн эмнэлэгт албадан хэвтүүлэх хүсэлт гаргах, эмнэлгээс гаргуулах хүсэлт

Хоёр асран хамгаалагчийн зөвшөөрөл, хоёр ба түүнээс дээш сэтгэцийн эмчийн оноштойгоор өвчтөнийг албадан хэвтүүлж болно. Нөхөр нь эхнэрээ сэтгэцийн өвчтэй гэж буруутган, сэтгэцийн эмнэлэгт албадан саатуулсан кейсүүд байдаг байна. Эхнэр юм уу нөхөр нь сэтгэцийн өвчтэй бол түүний хууль ёсны асран хамгаалагч түүний нөхөр эхнэр, хадмууд нь байна. Өмгөөлөгчийн няцаалт үйлчлүүлэгч сэтгэцийн түүхгүй, өдөр тутмын тайван амьдралаар амьдарч байгааг онцолсон, ажил олгогч компани, дарга нь ямар ч асуудалгүй ажиллаж байсан гэдгийг гэрчилсэн.

Хариуцлагын чадвар мөн гэм хорын чадвар гэж нэрлэдэг. Асран хамгаалалт нь Солонгос Улсад ихэвчлэн гэр бүлийн шүүхийн маргаан болж байна

БНСУ-д Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, сэтгэцийн өвчтэй хүмүүсийн халамжийн үйлчилгээг дэмжих тухай хууль хэрэгждэг. Энэ хуулиар болон иргэний хуулиар сэтгэцийн өвчтэй хүн өөр бусдад хохирол учруулж, нөхөн төлбөр төлөхгүй бол түүнд хяналт тавих

[28] Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн удиртгал, 2014 он, 2 дахь хэвлэл, 44 дэх тал.
[29] Н.Баярмаа, Улсын дээд шүүхийн шүүгч “Гэм хорын эрх зүйн талаарх зарим эргэцүүлэл: эдийн ба эдийн бус хохирол” 2025 он
[30] https://law.go.kr/lsSc.do?section=&menuId=1&subMenuId=15&tabMenuId=81&eventGubun=060101&query=%EB%AF%BC%EB%B2%95#undefined 민법

үүрэгтэй этгээд хохирлыг нөхөн төлөх зохицуулалттай. Шизофрени өвчтэй хүн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хууль ёсны шийтгэл гэхээсээ илүү эмчилгээний арга барил хэрэгтэй. Өвчтөнүүд эмчилгээ хийлгэж, шинж тэмдгүүдээ арилгахад нь туслах орчинг бүрдүүлэх нь чухал юм. Эмчилгээг ихэвчлэн шүүхээс тушаадаг бөгөөд энэ нь өвчтөнүүдийг нийгэмд эргэн ороход нь тусалдаг байна.

Шизофрени өвчтэй хүмүүсийн гэмт хэргийн шалтгаан Шизофрени өвчтэй хүмүүс гэмт хэрэг үйлдэж болох гол шалтгаануудын зарим нь: Шизофрени өвчний сөрөг шинж тэмдэг эсвэл танин мэдэхүйн чадвар буурах нь бодит байдлын талаарх дүгнэлтийг гажуудуулж, нийгмийн хэм хэмжээ, хууль эрх зүйн стандартыг ойлгоход хэцүү болгодог. Шизофрени өвчтэй зарим хүмүүс шинж тэмдгийг арилгахын тулд эмэнд найдаж болно, эсвэл мансууруулах бодис хэрэглэсний улмаас шинж тэмдгүүд нь улам дордож, хүчирхийллийн зан үйлд хүргэдэг. Тус өвчнийг эмчлэхээ больсон эсвэл тогтмол бус эмчилгээ хийвэл таны шинж тэмдгүүд улам дордож, нийгмийн зөрчилдөөн үүсгэж, гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг нэмэгдүүлдэг. Шизофрени өвчтэй хүмүүс гэмт хэрэг үйлдэх гол шалтгаануудын нэг нь зохих эмчилгээ, тусламж үйлчилгээ дутмаг байдаг. Сэтгэцийн өвчтэй хүмүүст тогтмол эмчилгээ, эмийн эмчилгээ чухал байдаг бөгөөд энэ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд тусалдаг. Шизофрени өвчтэй хүмүүст зөвхөн эмчилгээ төдийгүй нийгмийн дэмжлэг хэрэгтэй. Гэр бүлийн дэмжлэг, нийгмийн үйлчилгээ, нөхөн сэргээх хөтөлбөрүүд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Хоёр. Монгол Улсын шүүхийн болон хууль хэрэглээний практик

МУ-н хувьд ИХ-д заасны дагуу ИХШХШтХ-д заасан сонирхогч этгээдийн хүсэлтийн дагуу эрх зүйн чадамжийн хязгаарлалтыг шүүхээс тогтоодог. 2025 оны 02 сарын 20-ны өдрийн 192/ШШ2025/01492 дугаартай Баянгол, Хан-уул, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн *Сэтгэцийн өвчний улмаас хүнийг эрх зүйн чадамжгүй болон хязгаарлагдмал чадамжтай гэж тооцох* шийдвэр[31] 2025 оны 01 сарын 22 өдрийн 192/ШШ2025/00506 дугаартай Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн *Сэтгэцийн өвчний улмаас хүнийг эрх зүйн чадамжгүй болон хязгаарлагдмал чадамжтай гэж тооцох* нэхэмжлэгчийн татгалзлыг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай шүүхийн шийдвэр[32]

Иргэний нэрийг хууль бусаар ашиглах нь тухайн хүний эрхийг зөрчиж, нэр хүндийг гутаах аюултай. Энэ нь хүний бүрэн эрхийн асуудал бөгөөд хууль бусаар ашиглахыг хориглодог. Нэр хүндийг зөрчсөн этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэх, нэр хүндийг сэргээх боломжийг эрх зүйн дагуу хангах шаардлагатай. Иргэний хуулийн 21.1 дүгээр зүйл-д зааснаар иргэний нэрийг хууль бусаар ашиглахыг хориглоно гэсэн зохицуулалт нь хүний нэрийг зөвшөөрөлгүй ашиглах, түүнчлэн нэрийн эдийн засгийн ашиг, сурталчилгаа, олон нийтийн танилцуулах зорилгоор хууль бусаар ашиглахыг хориглоно гэсэн утгатай. Энэ нь нэрний эрх зүйн хамгаалалт болон хүний нэр хүндийг хамгаалах зорилготой. Хууль бусаар, зөвшөөрөлгүйгээр танихгүй хүн таны нэрийг ашиглан худал мэдээлэл тараах буюу таны нэрээр сөрөг сурталчилгаа хийх**.** Энэ нь таны нэр хүндийг гэмтээж, хууль зөрчсөн үйлдэл болно. Нэр хүндтэй, танигдсан хүний нэрийг ашиглан тэр хүний сурталчилгаанд оролцох эсвэл зөвшөөрөлгүйгээр бизнесийн зорилгоор ашиглах. Иргэний нэрийг ашиглан банкны хуурамч бүртгэл үүсгэх эсвэл нэр хүндийг нь ашиглан бусдад санхүүгийн хохирол учруулах зэрэг хууль зөрчсөн хэрэг ихээхэн байна. Үүнийг практикт иргэний хэрэг үү, эрүүгийн гэмт хэрэг үү гэх харьяаллын асуудал үүсдэг.

Эд хөрөнгийн бус амины харилцаа нь эдийн бус харилцаанд хамаарах дараагийн төрлийн харилцаа нь тухайн хүний хувийн байдалтай салшгүй холбогдох эдийн бус эрх, эрх

[31] https://shuukh.mn/single_case/178889?daterange=2024-01-01%20-%202025-03-31&id=1&court_cat=1&bb=1
[32] https://shuukh.mn/single_case/177526?daterange=2024-01-01%20-%202025-03-31&id=1&court_cat=1&bb=1

чөлөөтэй холбоотой үүсэх амины эрхийн харилцаа юм. Энэхүү амины эрхийн харилцаанд “нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд”, “хувийн ашиг сонирхол” “хувийн амьдрал, захидал харилцааны нууц” зэрэг амин хувийн ашиг сонирхолтой холбогдох харилцаа багтдаг. Хэдийгээр уг харилцаа нь мөнгөн “эквивалент” шинж байхгүй буюу илэрхий эдийн засгийн агуулгагүй боловч өөрийн гэсэн үнэ цэнтэй байдаг. Эдгээр нь субъектээс салшгүй шинжтэй байдаг учраас“амины” гэж нэрлэгддэг.[33]

Тоон мэдээллээс үзвэл Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4-т “Хуулиар тогтоосон хувийн нууцад хамааралтай мэдээг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр тарааснаас гэм хор учирсан гэж үзвэл иргэн уг гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй”, мөн зүйлийн 21.5-д “Иргэний дүрсийг гэрэл зураг, кино, дүрс бичлэгийн хальс хөрөг зураг болон бусад хэлбэрээр өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлсэн, олон нийтэд үзүүлснээс гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй.” Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан буюу https://shuukh.mn// -д 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд Иргэний хуулийн 511 дүгээр зүйлд заасан “эдийн бус гэмт хорыг арилга /нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан/” шийдвэрлэсэн нийт 242 шүүхийн шийдвэрийн байна. Үүнээс үзвэл дийлэнх маргаан нь цахим орчинд олон нийтийн мэдээллийн цахим сүлжээнд /Facebook, twitter мэдээллийн сайт, телевиз, ажлын байр, ажлын байранд, ор үндэслэлгүйгээр хуулийн байгууллагаар шалгуулах гэх мэт/ маргаан байх бөгөөд шүүхийн практикт Эдийн бус гэм хор арилгах /нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан/ маргаан нь талуудын үндэслэл тайлбараа нотолж, няцааж буй талуудын гаргаж, цуглуулж өгсөн нотлох баримтын хүрээнд хэргийн хянан шийдвэрлэж буй нь ажиглагдаж байна.

Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан буюу https://shuukh.mn// -д 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргээр зүйлчилж шийдвэрлэсэн нийт 141 шүүхийн шийдвэрийн байна. Үүнээс уг төрлийн гэмт хэргийн дийлэнх нь цахим орчинд олон нийтийн мэдээллийн цахим сүлжээнд /Facebook, twitter мэдээллийн сайт, телевиз/ үйлдэгджээ. Шүүхийн практикт бусдын нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг цахим орчинд тараасан тохиолдлыг гэмт хэрэгт тооцож, ял шийтгэл оногдуулан шийдвэрлэж байна. Дүн шинжилгээ хийсэн шүүхийн шийдвэрээс үзвэл 90 орчим хувь нь эрүүгийн хариуцлага хүлээлгэн шийдвэрлэсэн байна.

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргийн тухай өргөдөл, гомдол хүлээн авах, шалгах, шийдвэрлэхдээ Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан журмаар шийдвэрлэгдэх иргэний маргааны шинжтэй бол энэ төрлийн өргөдөл, гомдлыг хүлээн авахгүй байх, уг асуудлаар үүсгэсэн эрүүгийн хэргийг шууд хэрэгсэхгүй болгож байх, цаашид хууль хэрэглээний хувьд Эрүүгийн хуульд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэрэг, Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан журмаар шийдвэрлэгдэх хэрэг маргааныг зөв ялган зүйлчлэх, иргэний шинжтэй маргааныг эрүүгийн журмаар шалгахгүй байх, эрүүгийн хариуцлагад татахгүй байх шаардлагатай. Мөн хууль хоорондын ялгаа болох мэдээ, мэдээллийн ялгаатай байдлыг хууль зүйн хувьд тайлбарлан хэрэг маргааныг хянан шийдвэрлэж шүүхийн шийдвэрийг гаргаж чадаагүй байна. Жишээлбэл иргэний хэргийн шүүхийн шийдвэрт иргэний хуулийн 21.2-т заасан “мэдээ” гэх үг ороогүй “мэдээлэл” гэж бичигдэж тайлбарлагдсан байна.

Иргэний хуулийн 22 дугаар зүйл нь иргэний оршин суугаа газартай холбоотой асуудлыг зохицуулдаг бөгөөд тухайн хүний эрх зүйн харилцаанд оролцох, зарим үүргийг биелүүлэх, хууль ёсны мэдэгдэл хүлээн авах зэрэгт чухал үүрэг гүйцэтгэдэг. Хот суурин газрын хүн амын нүүдэл, түр оршин суух үзэгдэл нэмэгдсэнтэй холбоотойгоор зарим иргэд

[33] Ж.Оюунтунгалаг. Иргэний эрх зүй I., Ерөнхий анги, УБ., 2020 он 30-31 дэх тал.

байнгын бүртгэлгүй, түр байрлаж буй хаягаа оршин суугаа газраа болгож бүртгүүлдэггүй. Энэ нь шүүхийн нэхэмжлэл, нотариатын мэдэгдэл, гэрээний хэрэгжилт зэрэгт хүндрэл учруулдаг. Зарим этгээд өр төлбөрөөс зугтах, эсвэл хууль зөрчсөн үйлдлээс зугтах зорилгоор оршин суугаа газраа бүртгүүлдэггүй. Ингэснээр тэдгээр хүмүүст шүүхийн зар, захиргааны шийдвэр хүргэх боломжгүй болдог. ИХШХШтХ-н 77,6, 14.5, 133.1.9, 80.1.6, 155.1-т заасан зохицуулалттай боловч шүүхийн практикт тулгамдаж буй асуудлын хүрээнд хариуцагч хаягтай байхгүй улмаас, нэхэмжлэгчид цаг хугацааны болон эдийн засгийн хувьд хохиролтой, нөгөөтэйгүүр шүүхийн ачаалал нэмэгдэж, цагдаагийн байгууллагын оролцоо хангалтгүй байна.

Иргэний хэрэг ИХ-н 21.2	**Эрүүгийн хэрэг ЭХ-н 13,14**
Эдийн бус гэм хориг арилгах /нэр төр, алдар хүнд, ажил Хэргийн нэр хүндийг гутаасан/	**Иргэн “с.м”ийн “худал мэдээлэл тараах” гэмт хэрэг**
Шүүх: Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх **Шүүхийн шийдвэрийн он сар дугаар:** 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 210/МА2022/01340 дугаар магадлал. **Товч агуулга:** Иргэн А нь хариуцагч Ж, Л нарт холбогдуулан нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг сэргээлгэх, мэдээ тараасан хэлбэр, хэрэгслээр няцаалт хийхийг даалгах, эдийн бус гэм хорын хохиролд 50,000,000 төгрөг гаргуулах, цаашид нэр төрд халдсан үйлдэл гаргахгүй байхыг даалгах тухай нэхэмжлэл гаргасан. Хариуцагч Ж, Л нар нь нэхэмжлэлийг эс зөвшөөрч “иргэн А-тай холбоотой хэвлэмэл хуудас тараасан нь үнэн, гэхдээ энэ нь түүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдсан мэдээлэл агуулаагүй” гэж тайлбарлажээ.	**Шүүх**: Төв аймаг дахь сум дундын анхан шатны шүүх /эрүүгийн хэрэг/ийн шийтгэх тогтоол **Шүүхийн шийдвэрийн дугаар:** 2024 оны 03 сарын 11 өдөр, Дугаар 2024/ШЦТ/88 **Холбогдсон хэргийн талаар:** Яллагдагч С.М нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан” гэмт хэрэгт холбогджээ. Эрүүгийн дугаартай хэрэгт гэмт хэрэгт хамааралтай, ач холбогдолтой гэж цуглуулж, бэхжүүлж авсан бичгийн нотлох баримтуудаас шүүгдэгч С.Мын 2023 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр "Лүн сумын 2 дугаар багийн нутаг гэх газарт үйл ажиллагаа явуулдаг ХХК нь махаа газар чирч оруулдаг, махаа бүтээлгээр бүтээдэггүй, ...Лүн сумын тамгын газраас ХХК-д 8-9 га газар илүү өгсөн, ХХК- д ажиллаж байсан хүнийг зодож цохиод алсан, тархи нь газраар гоожоод хар уутанд хийгээд бордоо хийсэн. Лүн сумын иргэдийг хөөдөг..." гэх агуулга бүхий зүйл ярьж live бичлэг хийж өөрийн Иргэдийн төлөөлөгч Ц.М; нэртэй цахим фэйсбүүк хаягт байршуулан олон нийтэд түгээж хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан, илт худал мэдээллийг тараасан хэрэгт холбогджээ. Шүүх шүүгдэгч С.Мыг долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 700.000 /долоон зуун мянга/ төгрөгийн торгох ялаар тогтоож шийдвэрлэлээ.
Дүн шинжилгээ: Анхан шатны шүүх нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Тус шийдвэрийг нэхэмжлэгчийн өмгөөлөгч эс зөвшөөрч давж заалдах гомдол гаргасан. Хариуцагч Ж, Л нар нь 2019.10.27-ны өдөр Монголын Хуульчдын холбооны 4-р Их хурлын завсарлагаанаар “иргэн А, Б нар нь хуйвалдан, хууль бусаар өвлөх эрхийн гэрчилгээ олгосон, ийм хариуцлагагүй, шударга бус хуулиа мэддэггүй, ёс зүйн наад захын шаардлага хангахгүй этгээд тус холбооны зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж байна” гэх агуулга бүхий мэдээлэлтэй хэвлэмэл хуудсыг хурлын төлөөлөгчдөд тараажээ. Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасантай холбоотой	**Дүн шинжилгээ:** Шүүгдэгч С.М нь гэм буруу болон хэргийн зүйлчлэлийн талаар маргадаггүй бөгөөд түүний гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн мэдүүлэг нь гэмт хэргийн талаар амаар болон холбоо, мэдээллийн хэрэгслээр гаргасан гомдол, мэдээллийг хүлээн авсан тухай тэмдэглэл, шинжээчийн дүгнэлт, хохирогч, гэрчүүдийн мэдүүлэг болон бусад бичгийн нотлох баримтаар давхар нотлогдож байх тул дээрх нотлох баримтуудыг шийтгэх тогтоолын үндэслэл болгон шийдвэрлэлээ. Шүүгдэгч С.Мын холбогдсон тухайн гэмт хэрэг нь энэ хуулийн тусгай ангийн Арван гуравдугаар бүлэгт заасан “Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг” гэмт хэрэгт хамаарах бөгөөд энэ бүлэгт заасан

маргаанд мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотлох үүрэг хүлээдэг ба хариуцагч Ж, Л нар нь дээрх агуулга бүхий мэдээний үнэн, зөвийг нотолж чадаагүй байна. Өөрөөр хэлбэл, хариуцагч Ж, Л нар нь иргэн А-ийн талаар өөрийн санал бодлоо илэрхийлэх эрх нь нээлттэй боловч тэдгээрийн үзэл бодол, сэтгэгдлээ илэрхийлж буй хэлбэр нь бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан агуулгатай байх учиргүй юм. Давж заалдах шатны шүүх хариуцагч Ж, Л нарыг иргэн А-ийн талаар Монголын Хуульчдын холбооны 4 дүгээр Их хурлын төлөөлөгчдөд тараасан мэдээнийхээ үнэн зөвийг нотолж чадаагүй гэж дүгнэн, иргэн А-ийн нэр төрийг сэргээж, нэхэмжлэлийг энэ хэсгээр хангаж, Монголын Хуульчдын холбооны албан ёсны цахим хуудсаар няцаалт хийхийг хариуцагч Ж, Л нарт даалгаж, нэхэмжлэлээс үлдэх хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Энэхүү шийдвэрээс үзвэл Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасантай холбоотой маргаанд мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотлох үүрэг хүлээдэг.	гэмт хэргүүдэд хүний халдашгүй байх эрхийг хуулиар хамгаалж өгсөн ба тухайн эрх нь зөрчигдсөн, хохирол, хор уршиг учирсныг гэмт хэрэгт тооцохоор тусгайлан заасан ба эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилж өгсөн. Илт худал мэдээлэл гэдэг нь “огт үндэслэлгүй, худал хуурмаг мэдээлэл баримтыг” ойлгодог. Түүнчлэн хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн энр хүндийн талаар энэ үнэлэмжийг илт худал мэдээллээр олон нийтэд гутаан доромжилсон, унагасан, халдсан үйлдлийг ойлгоно гэж үзжээ. Эрүүгийн хуулийн 13 дугаар бүлэг бол “Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг”-ийг хуульчилсан. Гэтэл хуулийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.”гэж зааснаас үзвэл хуулийн этгээдийн нэр хүндийг хуульчилсан нь хууль тогтоомжийн тухай хуулиар зөрчилтэй байна. Тодруулбал Монгол Улсын Үндсэн хуульд халдашгүй чөлөөтэй байх нэр төр, алдар хүнд халдашгүй чөлөөтэй байх эрхийг Монгол Улсын иргэнд баталгаатай эдэлнэ гэж баталгаажуулсан. Субьектийн хувьд ялгаатай атал хууль тогтоож түүний харгалзан үзээгүй байна. Үүнтэй адил эрүүгийн хэргийн шүүх хуулийн этгээдийн нэр төрд халдсан хэрэг маргааны хянан шийдвэрлэж эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шүүхийн шийдвэр байна.

Үндсэндээ бүх эрх зүйн чадвар бүхий этгээд иргэний эрх зүйн харилцааны субъект байх бололцоотой, мөн энэ нь ямар ч нөхцөлд хязгаарлагдахгүй байх нь ямагт эрх зүйн субъект болдог хувь хүний төрөлхийн шинжтэй холбоотой. Тэрээр иргэний гүйлгээнд буюу хэлцэл суурьтай эрх зүйн харилцаанд, тухайлбал үүргийн эрх зүй, хэлцлийн үндсэн дээр үүсэх эд юмсын эрх зүйн болон худалдааны эрх зүйн харилцаанд бүх хувь этгээд оролцох, бүх эрх зүйн институтийг ашиглах боломжтой. Тиймээс ИХ-д хувь этгээдийн чадвар нь ҮХ-ийн адил нийтлэг эрх зүйн чадварт суурилна.

Эрхийн хамгаалалт. Онолын хувьд хувь этгээдийн эрх зүйн байдлыг 1/. эрх зүйн этгээдийн тухай зохицуулалт, 2/. хувь этгээдийн эрхийн тухай гэсэн хоёр хэсэгт хуваж зохицуулдаг. “Хувь хүн” гэсэн ерөнхий нэр томьёо нь эрх зүйн харилцааны субъект байх боломжийг илтгэнэ. Эрх зүйн чадвар болон хувь хүнтэй холбоотой эрх зүйн хамгаалалтыг адилтгаж хэрэглэвэл эрх зүйн ухагдахууны мөн чанарт харш;[34] хувь хүний үнэ цэнийг илтгэдэг эрх зүйн чадвар хэмээх ухагдахуун бүхий хэсэг нь хамгаалалтаа нэгэн зэрэг агуулах боломжгүй гэж үздэг[35]. Хувь хүн нь амьдралынхаа туршид өөрийгөө хөгжүүлэн төгөлдөржүүлж, бусдаас тодорхой үнэлэмж олж авах ба эндээс тухайн хүний хувь шинжийн талаарх үзэл баримтлал үүсэж хөгжсөн. Жишээ Францын иргэний эрх зүйн онолд хувь хүний

[34] Zweigert\ Kötz: Einführung in die Rechtsvergleichung, 3. Aufl., 1996, S.98
[35] Zweigert\ Kötz: Einführung in die Rechtsvergleichung, 3. Aufl., 1996, S.84

эрхүүдийг эрх зүйн хамгаалалтын хүрээнд тусгаарлан зохицуулсан. Энэ аргачлал нь кодификацийн онолд хувь хүний эрх зүйн байдлыг хамгаалалтаас нь тусгаарлах ойлголтыг бий болжээ[36]. МУ-ын ИХ-ийн §§21, 27-д амины эрхийн хамгаалалтыг хувь хүний эрх зүйн байдалд хамаатуулан зохицуулсан байгаа нь хувь этгээдийн байдал ба хамгаалалтыг нэгтгэсэн үйлдэл юм.

Шүүхийн практикт ИХ-ийн §21 нь нэр төр, ажил хэргийн нэр хүнд, алдар хүндэд х халдсан нөхцөлд холбогдох эрхийг сэргээх шаардах эрх болдог. УДШ-ээс зохион байгуулсан “Эдийн бус баялгийн хохирлыг арилгах зарим асуудал сэдэвт” бага хурлаар ИХ-ийн §511-ийг практикт бие даасан шаардах эрхийн түвшинд хэрэглэж байгаа тухай тэмдэглэсэн. Ийнхүү иргэний эрх зүйн салбарт хүний нэр төр, алдар хүндийн эрхийг ИХ-ийн §§497, 21, 511 хамгаалж буй боловч эдийн бус гэм хорыг арилгах арга зам хангалтгүй гэсэн дүгнэлтэд хүрэхээр байгаа[37], энэ нь хувь этгээдийг эрхийг хамгаалах үндсэн зарчимд үл нийцэх үр дүн юм. Тухайлбал ИХ-ийн §§230, 511-ийн хүрээнд сэтгэл санааны хохирлыг үнэлэх асуудал хангалтгүй байгаа бөгөөд системийн хувьд дутуу болох нь хэд хэдэн судалгаагаар нотлогдсон.[38]

Хуулийн хүрээнд системийн тайлбар хийж үзвэл ИХ-ийн §511-ийн үндсэн зорилго нь нэр хүнд, ажил хэргийн нэр хүндэд холбоотой худал мэдээлэл тараах нөхцөлд зөрчил нотлох баримтаар нотлогдохгүй бол хариуцагч эд хөрөнгийн хохирлоос гадна эдийн бус хохирлыг мөнгөөр нөхөн төлүүлэхэд чиглэсэн punitive damage[39] олгох зохицуулалт мэт харагдаж байна. Нэхэмжлэгч шүүхэд нэхэмжлэлээ гаргахдаа түүний нэр хүндэд халдсан баримтат үйл явцыг нэхэмжлэлдээ тодорхой хэлбэрээр бичиж, дурдах ба үүндээ учирсан хохирол, мэдээ тараасан арга хэрэгсэл зэргийг тусгаж, ингэснээр л шүүх уг хэргийг авч хянан хэлэлцэх нь ойлгомжтой. Харин процессын явцад хариуцагч гол нотолгооны үүргийг хүлээх нь шударга, нотлох баримт хуваарилалтын хувьд хариуцагчид гол ачааг үүрүүлсэн нь оновчтой. Гэхдээ энд нотлох баримт хуваарилалтыг чухалчлахаас илүүтэйгээр ямар нөхцөлд “нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд” халдсан гэж үзэх тухай үндсэн шалгуурыг тодотгох асуудал гарна.

Түүнчлэн Монгол Улсын ИХ-н 22 дугаар зүйл нь иргэний оршин суугаа газрын тухай эрх зүйн харилцааг зохицуулдаг. Энэхүү зохицуулалт нь иргэний хууль ёсны мэдэгдэл хүлээн авах, зарим үүргийг биелүүлэх, шүүхийн нэхэмжлэл хүлээж авах зэрэгт чухал ач холбогдолтой. Гэвч хот суурин газрын хүн амын шилжилт хөдөлгөөн, түр оршин суух байдал нэмэгдсэнтэй холбоотойгоор иргэд байнгын хаягаа бүртгүүлэхгүй байх тохиолдол ихэссэн. Үүнээс үүдэн шүүхийн мэдэгдэл, нотариатын зар, гэрээний хэрэгжилттэй холбоотой хүндрэл үүсч, хариуцагчийн оршин суугаа газар тодорхойгүй болсноор шүүхэд хандсан нэхэмжлэгчид эдийн засгийн болон цаг хугацааны хувьд хохирол амсах, улмаар шүүхийн ачаалал нэмэгдэх зэрэг сөрөг үр дагавар гарсаар байна. Энэ асуудал нь Иргэний хэргийн

---

[36] Zweigert\ Kötz:Einführung in die Rechtsvergleichung, 3. Aufl., 1996, S.318.

[37] Д.Ганхүрэл, МУ-д сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэх эрхийг хүлээн зөвшөөрсөн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2019 оны №3, 32 (40) дахь тал. ДШ: “Эдийн бус баялгийн хохирлыг арилгах зарим асуудал сэдэвт” бага хурлын эмхэтгэл, 2014 он, 33 дахь тал.

[38] Ш.Сүхбаатар, Хүний нэр төр, алдар хүндийн эрх зүйн хамгаалалт, 2012 он, 135-136 дахь тал; Э.Отгонзул, Эдийн бус хохирол, түүнийг арилгах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь сэдэвт бакалаврын дипломын ажил, МУИС-ийн ХЗС, 2011 он, 30 дахь тал;

[39] “Punitive damage” буюу шийтгэл хэлбэрээр ногдуулах нөхөн төлбөр нь АНУ-д XIX зуунаас хойш Иргэний эрх зүйн нэг хэсэг болон хөгжсөөр байна. Анхандаа “Punitive damage” нь эрүүгийн эрх зүйд хамааруулж байсан ба нэмэгдэл шийтгэлийн хувиар хэрэглэгдэж байсан. “Punitive damage”-ийн үндсэн зорилго нь бусдын санаатай болон илт болгоомжгүй үйлдлийн улмаас бий болсон бие махбодын болон сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлж, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршдог бөгөөд “нийгмийн болон хувь хүний ашиг сонирхлын онол” дээр суурилдаг байна. Англо-саксоны эрх зүйд “punitive damage” олгох асуудлыг хязгаарлаж эхэлсэн хандлагатай байгаа ба АНУ-ын зарим муж "punitive damage"-ийн дээд хэмжээг тогтоож өгсөн байдаг байна.

шүүхийн хянан шийдвэрлэх тухай хуулийн 77.6, 14.5, 133.1.9, 80.1.6, 155.1 зүйлүүдэд тусгалаа олсон боловч практикт шийдэгдээгүй хэвээр байна.

Гурав. Харьцуулсан судалгаа

Герман улсын ИХ нь логик бүтэцтэй бөгөөд Analogie буюу төстэй зохицуулалтыг өргөн хэрэглэдэг. Шүүхийн хууль тайлбарлал нь чухал үүрэгтэй (Zimmermann, 1996). “Schikaneverbot” буюу эрхээ хэт зовоох зорилгоор хэрэглэхийг хориглох зарчим §226 BGB-д заагдсан (Palandt, 2017). Иргэний хуулийн анхны бүлэгт хувь этгээдийг иргэн, хэрэглэгч, аж ахуй эрхлэгч гэж ангилдаг (Münchener Kommentar zum BGB, 2021) Эрх зүйн зохицуулалт нь Иргэний хуулийн эхэнд хувь этгээдийн иргэн, хэрэглэгч, аж ахуй эрхлэгч гэсэн ангилалтай. Герман BGB нь логик бүтэцтэй, аналитик тайлбар маш өргөн хэрэглэгддэг. Хувь этгээдийн эрхийн хамгаалалт: Гэм хорын эрх зүйн зохицуулалттай.

- Хууль хэрэглээ ба тайлбар: Аналоги буюу төстэй зохицуулалтыг хэрэглэдэг, мөн шүүхийн хууль тайлбарлал чухал.
- Эрхийн хэрэгжилтийн хязгаар: “Schikaneverbot” буюу эрхээ хэт зовоох зорилгоор хэрэглэхийг хориглодог.

Франц Улсын Иргэний кодекс (Code Civil) дахь personalité ойлголт нь хувь хүний эрх зүйн чадварыг амины эрхээс тодорхой тусгаарласан байдаг (Cornu, 2004). Абьюс дэ дроа (abus de droit) буюу эрхээ зүй бус ашиглахыг шүүхийн практикт 1915 оны Cass. civ. шийдвэрээр баталсан (Mazeaud, 2010). Хууль тайлбарлахдаа literal, systematic, teleological гэсэн дарааллаар хэрэглэдэг (Carbonnier, 1999).

- Эрх зүйн зохицуулалт: Эрх зүйн чадварын нийтлэг ойлголт буюу personalité-т тулгуурладаг. Хувь хүний эрх зүйн чадварыг амины эрхээс эрс тусгаарладаг.
- Хувь этгээдийн эрхийн хамгаалалт: (abus de droit) буюу эрхээ зүй бус ашиглахыг хориглодог.
- Хууль хэрэглээ ба тайлбар: Literal interpretation, systematic interpretation, teleological гэх дарааллаар тайлбарладаг. Кодификацид тулгуурладаг боловч шүүхийн практик чухал үүрэгтэй.
- Эрхийн хэрэгжилтийн хязгаар: Эрхийн зүй бус хэрэглээг хориглодог жишиг шүүхийн шийдвэрүүдэд тусгалаа олсон.

Японы Улсын Иргэний хууль нь Герман болон Францын эрх зүйн системийн холимог бөгөөд хууль тогтоогчийн зорилго, шударга байдлыг онцолсон тайлбарлах аргачлалтай (Takeuchi, 2015). Эрхийн зохисгүй хэрэглээг Minpō Art.1(3) нь хязгаарладаг (Japanese Civil Code, 2023). Аналоги болон телеологийн хосолсон тайлбарлалыг хэрэглэх нь Японы эрх зүйн онцлог (Sakurai, 2018).

- Эрх зүйн зохицуулалт**:** Герман болон Францын эрх зүйн системийн холимог. Иргэний хуулийн зохицуулалтыг логик бүтэцтэй бөгөөд ёс суртахуун, шударга байдлыг онцолдог.
- Хувь этгээдийн эрхийн хамгаалалт: Эрхийн хэрэгжилтийн зохисгүй байдлыг хуульд тодорхой хязгаарладаг.
- Хууль хэрэглээ ба тайлбар**:** Хууль тогтоогчийн зорилго болон шударга байдлыг үндэслэн тайлбарлана. Герман, Францын тайлбарлалтын аргачлалыг хослуулсан.
- Эрхийн хэрэгжилтийн хязгаар**:** Эрхийн зохисгүй хэрэглээг хуулиар хязгаарласан.

Хувь этгээдийн эрх зүйн байдлыг зохицуулах чиглэлээр Монгол Улсын ИХ нь эрх зүйн чадвар, нэр, оршин суугаа газар зэрэг суурь ойлголтыг зохицуулсан хэдий ч эдгээр нь

зарим талаараа онолын хувьд оновчтой бус тодорхойлогдсон, гүйцэтгэлгүй, практикт нэгдсэн ойлголтгүй хэрэглэгдэж байгаа нь харагдаж байна. Харьцуулсан судалгаагаар Герман, Франц, Япон зэрэг улсууд хувь этгээдийн эрхийн хамгаалалтыг илүү нарийвчилсан, системтэйгээр зохицуулж, шүүхийн практикт ашиглаж буй analogie, teleological interpretation зэрэг хууль тайлбарлах аргачлал нь тухайн орны хууль зүйн тогтолцоонд оновчтой нийцсэн байна.

Монгол Улсад хувь хүний нэрийг хууль бусаар ашиглах, оршин суугаа хаягтай холбоотойгоор үүсэж буй шүүхийн асуудлууд нь Иргэний хуулийн 21, 22-ыг бодит амьдралд хэрэглэхэд эрх зүйн зохицуулалт, нотлох баримтын тогтолцоо, хариуцлагын механизм хангалтгүй байгааг харуулж байна. Мөн сэтгэл санааны хохирлыг үнэлэх, нэр төрийн эрхийг сэргээх, эдийн бус гэм хорыг барагдуулах зэрэг асуудалд ИХ-ийн 511, 230 зэргийг хэрэглэхдээ шүүхийн шийдвэрүүд нэгдмэл бус, үнэлгээний шалгуур тодорхойгүй байдал ажиглагдаж байна.

- Эрх зүйн чадварын ойлголтыг системчлэлийн хувьд Иргэний хуульд заасан хувь этгээдийн эрх зүйн байдлыг Франц, Германы жишгээр "бие даасан эрх зүйн субъект" гэдэг онолын үндэслэлтэйгээр гүнзгийрүүлж, хамгаалалт болон чадварын асуудлыг тусгаарлан авч үзэх нь оновчтой.
- Эдийн бус хохирлыг үнэлэх шалгуурыг тодорхой болгох §511, §230-д үндэслэн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдсан тохиолдолд шүүхээр ямар нөхцөлд эдийн бус гэм хорыг барагдуулах вэ гэдгийг илүү тодорхой болгох хууль зүйн тайлбар, журам шаардлагатай байна.
- Нотлох баримтын хуваарилалт, тайлбарын аргачлалыг боловсронгуй болгох Нэр төрийн хэрэгт нотолгооны үүргийг зөвхөн нэхэмжлэгчид хүлээлгэх биш, хариуцагчийн оролцоог өндөржүүлэх, Герман улсын “Schikaneverbot”, Францын “abus de droit” зарчмуудын жишгээр эрхийг зүй бус хэрэглэхээс сэргийлэх зохицуулалт нэвтрүүлэх хэрэгтэй.
- Хууль тайлбарлах аргачлалд нэгдмэл үзэл баримтлал бий болгох Шүүхийн практикт analogie, teleological interpretation зэрэг хосолсон тайлбарын аргачлалыг нэвтрүүлж, Үндсэн хуулийн үнэт зүйлстэй нийцүүлсэн системтэй хэрэглээ шаардлагатай.
- Оршин суугаа газрын зохицуулалтыг шинэчлэх буюу түр оршин суугчдын эрх зүйн хариуцлагыг тодорхой болгож, шүүх, захиргааны байгууллагуудтай мэдээлэл солилцох, хаягийн бүртгэлийн үнэн зөв, хууль ёсны байдлыг хангах эрх зүйн орчныг бий болгох нь зүйтэй.

Дөрөв. Дүгнэлт

ИХ нь “иргэний” гэх нэрийн дор хувь этгээдийн эдийн засгийн харилцаанд оролцох эрх зүйн зохицуулалтад түлхүү анхаарал хандуулсан тул хувь хүний амины эрх, хувь хүний эрх зүйн хамгаалалт харьцангуй дутмаг байгаагийн улмаас хувийн эрх зүйн харилцааг бүрэн хамрах үндсэн зорилгодоо бүрэн хүрч чадаагүй байна. Энэ нь 2002 онд хийгдсэн ИХ-д дүн шинжилгээний үр дүнд тодорхойлогдсон бөгөөд үүний дагуу хувийн эрх зүйн цөмийг илүү нарийвчлан, тусгайлсан аргаар зохицуулах шаардлага бий болсон гэж үзэж байна. Жишээлбэл иргэний оршин суугаа газар нь эрх зүйн хувьд чухал ач холбогдолтой. Үүнийг бүртгүүлэх, үнэн зөв мэдээлэл өгөх нь шүүхийн шийдвэр гаргах, гэрээний хэрэгжилт, төрийн үйлчилгээ авах, хариуцлага хүлээлгэх зэрэг олон талын ач холбогдолтой. Үүнийг хуульчид, шүүх, иргэд бүгд ойлгож, анхаарах хэрэгтэй. Иргэний хуулийн бүтцийн анализ нь “хувь этгээд” гэсэн ойлголтыг боловсронгуй болгож, түүнд иргэнийг хэрэглэгч болон аж ахуй эрхлэгчийн үүрэг гүйцэтгэж буй бодит байдлыг тусгах, мөн дижитал орчны хэрэглэгчийн эрх зүйн асуудлыг цаашдын бүлгүүдэд тусгах шаардлагыг тодотгож байна. Эдгээр өөрчлөлтүүд

нь хууль тогтоомжийн системийн уялдаа холбоо, хэрэглээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй юм. Мөн эд юмсын эрх зүйг объектын ерөнхий зохицуулалтаас тусгаарлан нарийвчлан зохицуулах, үүний зэрэгцээ Иргэний хууль, олон улсын хувийн эрх зүй болон бусад материаллаг хууль хоорондын зөрчилдөөнийг зохистой шийдвэрлэхэд шаардлагатай хууль зүйн хэм хэмжээг тодорхой болгох, цахим орчинд Иргэний хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг Хууль хэрэгжүүлэх тухай хуульд төвлөрүүлэн зохицуулах шаардлага тулгарч байна.

Мөн Иргэний хуулийн 21 дүгээр зүйлд заасан “гутаасан мэдээ” нь “худал мэдээлэл” болон “үнэн мэдээлэл”-ийг давхар агуулдаг. Иргэний хуулийн 21.3-т бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс нэр төрийг гутаасан бол няцаах үүрэг хүлээхээр зохицуулсан. Иргэний хуулиар зохицуулж буй гутаасан мэдээ буюу бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс нэр төрийг гутаасан бол уг асуудал нь Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэрэгт тооцогдох эсэх нь тодорхойгүй байна. Эдгээр эрх зүйн актууд нь худал мэдээ тараах, бусдын нэр төрд халдаж гүтгэн доромжлох сөрөг үйлдлийг зохицуулах үндэс суурийг тавьсан гэж үзэх үндэстэй. Хэдий тийм боловч нэг талаар хууль тогтоомжийн хэрэгжилтэд анхаарах, нөгөө талаар цаг үеийн техник технологийн хурдтай өөрчлөлт, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан, түүнчлэн олон улсын жишиг, чиг хандлагатай нийцүүлэн “угтах бодлого”-ыг баримтлан үндэсний хууль, тогтоомжоо нийцүүлэн боловсруулах шаардлага тулгарч байна.

Эрүүгийн болон Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад сэтгэл санааны эдийн бус гэмт хорын зохицуулалтын хэрэглэх хуулийн хэрэглээний нэгдмэл ойлголтыг бий болгох үүднээс салбар эрх зүйн уялдаа холбоо зохицуулж буй харилцааг тодотгох шаардлагатай байна.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Монгол Улсын Иргэний хуулийн 1-24 дугаар зүйлд Герман, Япон системийн логик бүтэц, Францын ёс суртахуун ба нийтийн дэг журам, АНУ-ын эрх чөлөөт харилцаа, мөн шүүхийн тайлбарлагдсан жишгийн онцлог шинж чанарыг тусган өгсөн нь уг хуулийн эрх зүйн үндсийг олон талын уламжлалаар баяжуулсан байна. “Сайн санаа, шударга байдал, эрхийн зохистой хэрэглээ” зэрэг үндсэн зарчмууд нь бүх улсад нийтлэг бөгөөд Монгол Улсын Иргэний хууль илүү зарчимч, уян хатан тайлбарлагдах боломжтой байна.

Иргэний хуулийн 1–24 дүгээр зүйлүүд нь эрх зүйн тогтолцооны үндэс суурийг бүрдүүлж байгаа ч тэдгээрийн зохицуулалт онол, практикийн хувьд нэгдмэл бус, тодорхой бус байдалтай байсаар байна. Хууль хэрэглээний логик, зарчмын хэрэгжилт, объектын ангилал, төсөөтэй хэрэглээ, шүүхийн тайлбарын уялдаа зэрэг асуудалд цогц шинэчлэл хэрэгтэй. Үндсэн ойлголтуудыг тодруулж, шинэ төрлийн эрх зүйн харилцаанд нийцсэн зохицуулалтыг бий болгохгүйгээр эрх зүйн тогтвортой байдлыг хангаж чадахгүй юм.

Иймд Иргэний хуулийн эрх зүйн зохицуулалтыг дэлхийн сайн жишиг, орчин үеийн хэрэгцээнд нийцүүлэн шинэчлэх, эрх зүйн хэм хэмжээг тодорхой болгож, хууль хэрэглэх практикийг уялдуулан хөгжүүлэх нь Монголын эрх зүйн тогтолцооны хөгжилд чухал түлхэц болно гэж дүгнэж байна. Тиймээс Иргэний болон Арилжааны хуулийн ялгаатай байдлыг тодотгох, Иргэний болон Эрүүгийн хуулийн зохицуулалтын уялдаа холбоог хангаж зохицуулалтыг тодорхой болгож практикд нэгдмэл байдлаар хэрэглэх жишиг тогтоох, жишээ нь ИХ-н 10.1 ба ЭХ-н 4.1.1, ИХ-н 21.2 ба ЭХ-н 13.14, ЭХ-н гэмт хэргийн хохирол хор уршиг, ИХ-н эдийн бус гэм хорыг арилгах зохицуулалтын хэрэглээний зөрүүг арилгах, ИХ-н хүчин чадал бусад тусгайлсан хуулиас дээгүүр байх ба тусгайлсан хуулийг ИХ-нд нийцүүлэн зохицуулах харилцааг нарийвчлан тодорхойлох хэрэгтэй. Үүний тулд ИХ-г бүхэлд нь өөрчлөхөөс илүүтэй одоо байгаа хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах нэмэлт өөрчлөлт оруулах нь зөв хэмээн судлаачийн зүгээс дүгнэлээ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХУУЛИЙН ЭТГЭЭД

Энэхүү үнэлгээний зорилго нь Иргэний хуулийн Дөрөвдүгээр бүлэг буюу Хуулийн этгээдийн эрх зүйн харилцааг зохицуулж буй хуулийн зүйл, заалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, тухайн зохицуулалт нь зорилгоо хангаж байгаа эсэх, үр нөлөөг тооцох, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, эерэг нөлөөллийг илрүүлэх, ололтыг бататган дүгнэх бөгөөд улмаар хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн орчныг сайжруулах, мөн хуулийг ойлгомжтой хэрэглэхэд оршино. Судалгааг судалгааны удирдамж, тайлангийн загварын дагуу дараах бүтэцтэй хийлээ.

1. Хууль хэрэглээний практик болон бусад эрх зүйн зохицуулалттай зөрчилдөж байгаа эсэх;
2. Статистик тоон мэдээ;
3. Харьцуулсан судалгаа (ИХ-ийн 33 дугаар зүйл “Хуулийн этгээдийн төрөл”);
4. Дүгнэлт;
5. Ашигласан материал.

Нэг. Хууль хэрэглээний практик болон бусад эрх зүйн зохицуулалттай нийцэж байгаа эсэх

Үнэлгээ хийх зүйл
25 дугаар зүйл.Хуулийн этгээд 25.1.Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаварыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ. 25.2.Хуулийн этгээд нь ашиг олох зорилготой ашгийн төлөө, хууль буюу дүрэмд заасан зорилготой, ашгийн төлөө бус байж болно. 25.3.Хуулийн этгээд нь нийтийн, хувийн, холимог өмчийн байна. 25.4.Хуульд өөрөөр заагаагүй бол хэд хэдэн хуулийн этгээд нь үйл ажиллагаагаа зохицуулах зорилгоор нэгдэж болох бөгөөд нэгдлийн оролцогчид хуулийн этгээдийн эрхээ хадгална. 25.5.Хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

Иргэний хуулийн энэхүү зохицуулалтын дагуу тухайлсан хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг зохицуулсан хуулийн заалтыг баримтлан Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу бүртгэл хөтлөх үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Хуулийн энэхүү зохицуулалт тодорхой түвшинд үүргээ гүйцэтгэж байна гэж үзэж байна.

Иргэний хуулийн зохицуулалтын агуулгаас үзэхэд хуулийн этгээд нь ашгийн төлөө, ашгийн төлөө бус гэсэн 2 төрөлтэй байх боловч энэ 2 төрлийг тодорхойлж зохицуулаагүй буюу 25.2 дахь хэсэгт ашгийн төлөө бус байж болно хэмээн алтернатив байдлаар томьёолсон. Иймээс хуулийн этгээд төрлийн хувьд ашгийн, ашгийн бус гэсэн 2 төрөлтэй байна гэж тодорхой заах шаардлагатай байна.

Хуулийн этгээд нь нийтийн, хувийн, холимог өмчтэй гэж заасан боловч шашны байгууллагын өмчийн асуудал тодорхой зохицуулалтгүй байна. Тухайлбал, олон зуун

жилийн түүхтэй, шашны үйл ажиллагаа эрхэлж буй Гандантэгчилэн хийд, Дашчойлон хийд, Дамбадаржаа гэх мэт хийдийн өмчийн асуудал тодорхойгүй. Энэ асуудлыг тодорхой болгох шаардлагатай.

Хуулийн 25.4 дэх хэсэг ойлгомжгүй. Иргэний хуулийн 31.3-т заасан нэгтгэх, Компанийн тухай хуулийн 18.3-т заасан нэгтгэхийг ойлгох юм уу, эсвэл Компанийн тухай хуулийн 6.14-т заасан нэгдлийг ойлгох эсэх нь эргэлзээтэй байна. Эсвэл энэ нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4.1.19-т заасан түншлэл үү гэдгийг зохицуулалтыг ойлгомжтой болгох замаар шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж байна.

Хуулийн 25.5-д зааснаар Улсын Их Хурлаас Нөхөрлөлийн тухай, Компанийн тухай, Хоршооны тухай хуулиудыг баталсан. Харин холбоо, сангийн эрх зүйн байдлыг тодорхойлсон бие даасан хуулийг батлаагүй байна.

Иргэний хуулийн 4.1, 4.2-т хуулийг төсөөтэй хэрэглэхээр зохицуулсан боловч бүтэц, удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн хариуцлага өөр өөр онцлогтой хуулийн этгээдүүдийг адилтгаж, нэг хуулиар зохицуулж улсын бүртгэлд бүртгэхэд хүндрэл, бэрхшээл гардаг. Маргаан үүсч, улмаар иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөх, бүртгэл хүчингүй болох, шүүх, хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх зэрэг эрсдэлийг практикт үүсгэж байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд “7.1.3.холбоо /төрийн бус байгууллага/” гэж Төрийн бус байгууллагын тухай хуулиар зохицуулсан ТББ-ыг ИХ-ийн 36.1-д заасан холбоотой адилтгаж ойлгож болохоор хаалтад зэрэгцүүлэн тусгасан байгаа нь нэр томьёоны хувьд ч, ойлголтын хувьд ч зөрүүтэй байгааг цаашид залруулах шаардлагатай.

Үнэлгээ хийх зүйл
26 дугаар зүйл.Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар 26.1.Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсч, хуульд заасан журмын дагуу татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болно.

Энэ заалт нь хуулийн этгээдийг зөвхөн татан буугдсанаар улсын бүртгэлээс хасагдана гэж ойлгогдохоор байгаа бол хуулийн этгээдийн улсын бүртгэлд дараах үндэслэлээр хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасаж бүртгэдэг. Үүнд:

1. тухайн хуулийн этгээдийн эрх бүхий этгээдийн шийдвэр;
2. дампуурсанд тооцсонд болон татан буулгах тухай гарсан шүүхийн шийдвэр;
3. хуулиар эрх олгогдсон байгууллагын шийдвэр гарсан; (тухайлбал, Банкны тухай хуулийн 68.1, 68.2-т заасан)
4. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 26.1 дэх хэсэгт зааснаар Сангийн яамны саналыг үндэслэн тус тус хасдаг.

Иймд тус хэсгийн “<u>татан буугдаж</u>” гэснийг бусад хуулийн зохицуулалттай нийцүүлэх шаардлагатай байна.

Үнэлгээ хийх зүйл
26.2.Хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх, бүртгэлээс хасах журмыг хуулиар тогтооно.

Хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасах асуудлыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 25, 26 дугаар зүйлээр зохицуулсан боловч ямар үндэслэлээр, хэрхэн хасах, түүнчлэн сэргээх тохиолдолд үндэслэл, журам ямар байх талаарх зохицуулалт байхгүй учир бүртгэлээс хасах, сэргээх зохицуулалтыг тус хуульд, эсхүл Иргэний хуульд илүү нарийвчилсан байдлаар тусгах шаардлагатай байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу улсын бүртгэлийн байгууллагаас 2023 оны 08 дугаар сарын 08-ны өдөр санхүүгийн тайлангаа найм ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй, харилцагч санхүүгийн байгууллагад илгээж баталгаажуулаагүй, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон өр, төлбөргүй үндэслэлээр 34377 хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хассан. Үүнээс хойш өнөөдрийг хүртэл нөхөж тайлангаа гарган, үйл ажиллагаа явуулах хүсэлт гаргасан, татварын өр төлбөртэй зэрэг шалтгаанаар 1028 хуулийн этгээдийн улсын бүртгэлийг сэргээсэн.

Үнэлгээ хийх зүйл
26.3.Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар хуульд заасан журмаар байгуулагдсанаар үүсч, татан буугдсанаар дуусгавар болох бөгөөд иргэний эрх зүйн харилцаанд бусад оролцогчтой адил тэгш эрхтэй оролцоно.

Энэ заалтын нийтийн эрх зүйн этгээд гэдэг нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7.1.7-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдтэй ижил эсэх, нийтийн эрх зүйн хуулийн этгээд гэж ямар хуулийн этгээдийг хэлэх тухай тодорхой зохицуулалт Иргэний хуульд тусгагдаагүй байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд нийтийн эрх зүйн хуулийн этгээд хэлбэрээр

- Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо;
- Монголбанк;
- Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт;
- Монголын өмгөөлөгчдийн холбоо;
- Монголын телевизүүдийн холбоо;
- Монголын үндэсний олон нийтийн радио телевиз;
- Монголын хуульчдын холбоо;
- Нотариатын танхим;
- Нутгийн удирдлагын төлөөллийн байгууллага;
- Хүннү хот гэсэн 10 хуулийн этгээд бүртгэлтэй байна.

Эдгээрийн дийлэнх нь нийтийн эрх зүйн этгээд болохыг салбар хуулиар тодорхойлсон байна.

Үнэлгээ хийх зүйл
26.4. Хуулийн этгээд удирдах байгууллагаараа дамжуулан иргэний эрх зүйн харилцаанд оролцоно.

Удирдах байгууллага гэдэгт төлөөлөн удирдах зөвлөл, удирдах зөвлөл, тэргүүлэгчдийн зөвлөл, хувьцаа эзэмшигчдийн хурал, бүх гишүүдийн хурал гэж ойлгож, хэрэглэх асуудал түгээмэл байдаг. Гэвч бодит байдалд хуулийн этгээд гүйцэтгэх удирдлагаараа дамжуулж иргэний эрх зүйн харилцаанд оролцож байна. Удирдах байгууллагагүй хуулийн этгээд /нэг гишүүнтэй ХХК/ ч байна.

Иймд “Удирдах байгууллага” гэдгийг эрх бүхий этгээд гэж томьёолох нь зүйтэй.

Үнэлгээ хийх зүйл
26.5.Хуулийн этгээдийн удирдах байгууллагын эрх зүйн байдлыг хууль буюу үүсгэн байгуулах баримт бичгээр тодорхойлно.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4.1.5-д үүсгэн байгуулах баримт бичиг" гэж эрх бүхий этгээдээс гаргасан хуулийн этгээд байгуулах шийдвэр, хуулийн этгээдийн дүрэм, хуульд заасан тохиолдолд үүсгэн байгуулах гэрээг ойлгоно гэж заасан. Үүсгэн байгуулах баримт бичиг гэсэн ойлголт нь зөвхөн шинээр байгуулж байгаа тохиолдолд үйлдэж буй баримт бичиг гэж ойлгогдохоор байгаа тул нэр томьёог үндсэн баримт бичиг гэж өөрчлөх саналтай байна.

Үнэлгээ хийх зүйл
26.6.Ашгийн төлөө бус хуулийн этгээд өөрийн дүрэм болон үүсгэн байгуулсан бусад баримт бичигт заасан зорилгод нийцэх үйл ажиллагаа явуулна. 26.7.Ашгийн төлөө хуулийн этгээд нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлаагүй аливаа үйл ажиллагаа эрхлэх эрхтэй. 26.8.Хуулийн этгээд хуульд заасан зарим үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ. Үйл ажиллагааг эрхлэх эрх зөвшөөрөл авсан өдрөөс үүснэ. 26.9.Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадварыг гагцхүү хуульд заасан үндэслэл, журмаар хязгаарлана.

Дээрх хэсгүүд дэх зохицуулалт нь хуулийн зорилгодоо нийцэж байна.

Үнэлгээ хийх зүйл
27 дугаар зүйл.Хуулийн этгээдийн нэр 27.1.Хуулийн этгээд өөрийн нэртэй байна. Хуулийн этгээдийн нэр нь түүний зохион байгуулалт, эрх зүйн хэлбэрийг тусгасан байна.

Энэ хэсгийг “Хуулийн этгээд өөрийн нэртэй байна. Хуулийн этгээдийн нэрийн хойно түүний зохион байгуулалт байгуулалт, эрх зүйн хэлбэрийг хамт хэрэглэнэ.” гэж өөрчилбөл бодит байдалд практик хэрэглээнд тохирно.

Үнэлгээ хийх зүйл
27.2. Хуульд заасан бол хуулийн этгээдийн төрлийг заасан нэртэй байна.

Иргэний хуулийн 33 дугаар зүйлд зааснаар хуулийн этгээд нь ашгийн төлөө, ашгийн төлөө бус гэсэн төрөлтэй байх ба энэ 2 төрлийг хуулийн этгээдийн нэрд оролцуулах боломжгүй юм. Иймээс Хуулийн этгээдийн төрөл, хэлбэр /эрх зүйн хэлбэр, зохион байгуулалтын хэлбэр/ гэсэн ойлголтуудыг тодорхой болгох хэрэгцээ шаардлага байна.

Үнэлгээ хийх зүйл

27.3.Хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан буюу бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй байж болохгүй.

Ижил, төсөөтэй байж болохгүй гэдэг нь маргаан их дагуулж байна. Энэ харилцааг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах журмаар зохицуулж байгаа боловч асуудлыг бүрэн шийдвэрлэж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл, ижил гэж ямар тохиолдлыг, төсөөтэй гэж ямар тохиолдлыг ойлгох талаар хуулийн тодорхой заалт, тайлбар байдаггүй учир хуулийн этгээдийн нэртэй холбоотой маргааныг шүүх өөр өөрөөр шийдвэрлэх тохиолдол байна.

Үнэлгээ хийх зүйл
27.4.Хуулийн этгээдийн нэрийг бусад этгээд хууль бусаар ашиглахыг хориглоно. Энэ заалтыг зөрчсөн этгээд бусдад учруулсан гэм хорыг энэ хуулийн 497 дугаар зүйлд заасан журмын дагуу арилгана.

Оюуны өмчийн патентаар баталгаажсан нэр хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбогдох эсэх, хориглох заалтад хамаарах эсэх асуудлыг тодорхой болгох зайлшгүй шаардлагатай.

Үнэлгээ хийх зүйл
27.5.Хуулийн этгээд нэрээ хуульд заасан журмын дагуу бүртгүүлнэ.

Иргэний хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд хуулийн этгээдийн нэртэй холбоотой нарийвчилсан, оновчтой зохицуулалт байхгүйн улмаас улсын бүртгэлд бүртгэхэд хүндрэл бэрхшээл гарч, хэрэг, маргаан үүсэх шалтгаан болдог.

Үнэлгээ хийх зүйл
27.6.Хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг хамгаалахад энэ хуулийн 21 дүгээр зүйлийн заалт нэгэн адил хамаарна.

Дээрх хэсэг дэх зохицуулалт нь хуулийн зорилготой нийцэж байгаа.

Үнэлэх зүйл
28 дугаар зүйл. Хуулийн этгээдийн оршин байгаа газар 28.1.Хуулийн этгээдийн ерөнхий захиргаа байршин байгаа газрыг түүний оршин байгаа газар гэнэ. 28.2. Хуулийн этгээд нь оршин байх нэг газар буюу хууль ёсны хаягтай байна.

Дээрх хэсгүүд дэх зохицуулалт нь хуулийн зорилготой нийцэж байгаа.

Үнэлгээ хийх зүйл
29.6. Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар хуулийн этгээдийн эрхгүй байна.

Иргэний хуульд 29.6 дахь хэсгээс гадна 7.1 дэх хэсэг “Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч нь иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгуулага байна” гэж, 143.3

дахь хэсэгт “Сууц өмчлөгчдийн холбоо хуулийн этгээдийн эрхгүй байна” гэж тусгагдсан. Энэ талаар өөр бусад зохицуулалт байхгүй.

Мөн бичил уурхайн нөхөрлөл, байгаль хамгаалах болон ойн нөхөрлөлүүд Иргэний хуулийн 481-д “бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөл”-өөр аймгийн засаг даргын тамгын газар бүртгэж байна.

Гэтэл хүчин төгөлдөр мөрдөж буй зарим хуульд хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад хамаарах байгууллагыг нэрлэсэн, оролцооны талаар тодорхойлсон байдаг. Тэдгээр байгууллагыг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэх эсэх, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын тодорхойлолт, эрх, үүргийн талаарх зохицуулалтыг Иргэний хуульд нарийвчлан зохицуулж оруулах нь зүйтэй.

Үнэлэх зүйл
31 дүгээр зүйл. Хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах 31.1 Хуулийн этгээдийн хөрөнгийг өмчлөгч буюу түүнээс эрх олгосон байгууллага, түүнчлэн үүсгэн байгуулах баримт бичгээр эрх олгосон байгууллагын шийдвэрээр хуулийн этгээдийг хуульд заасан журмын дагуу нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулж болно.

“Хуулийн этгээдийн хөрөнгийг өмчлөгч буюу түүнээс эрх олгосон байгууллага, түүнчлэн үүсгэн байгуулах баримт бичгээр эрх олгосон байгууллагын шийдвэрээр” гэдэг нь ойлгомжгүй, нуршсан томьёолол болжээ. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад хуулиар

- Хувьцаа эзэмшигчдийн хурал;
- Төлөөлөн удирдах зөвлөл;
- Бүх гишүүдийн хурал;
- Удирдах зөвлөл гэх мэт субъектүүдийг тодорхойлсон тул эрх бүхий этгээдийн шийдвэрээр гэж өөрчлөх шаардлагатай.

Үнэлгээ хийх зүйл
31.2.Хоёр буюу хэд хэдэн хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож, тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлагыг шинээр бий болсон хуулийн этгээдэд шилжүүлэхийг хуулийн этгээдийг нийлүүлэх гэнэ. 31.3. Хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг өөр хуулийн этгээдэд шилжүүлэхийг хуулийн этгээдийг нэгтгэх гэнэ. 31.4. Хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг шинээр үүсэх хоёр буюу түүнээс дээш хуулийн этгээдэд шилжүүлэхийг хуулийн этгээдийг хуваах гэнэ. 31.5. Хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоохгүйгээр түүний зарим эрх, үүрэг, хариуцлагыг шинээр байгуулагдсан хуулийн этгээдэд шилжүүлэхийг хуулийн этгээдийг тусгаарлах гэнэ. 31.6. Хуулийн этгээд нь зохион байгуулалтын төрөл, хэлбэр, үндсэн зорилгоо өөрчлөх замаар зохион байгуулагдаж болно.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд 2019 оны 09 дүгээр сараас хойш 26 хуулийн этгээдийг “нийлүүлэх” бүртгэл, 255 хуулийн этгээдийг “нэгтгэх” бүртгэл, 3 хуулийн этгээдийг “хуваах” бүртгэл, 108 хуулийн этгээдийг тусгаарлах бүртгэл, 160 хуулийн этгээдийг хэлбэрийг өөрчлөх бүртгэл тус тус хийгдсэн байна.

Холбоо, сан, хоршоо, нөхөрлөл, компани зэрэг хуулийн этгээдүүд нь төрөл, хэлбэрээ өөрчилж болох эсэх, хоршоо өөрчлөгдөж компани, нөхөрлөл, холбоо, сан болох боломжтой эсэх асуудал зохицуулалтгүй, маргаантай байна.

Компанийн тухай хуулийн 23.1-д хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани, хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хувьцаат компани болгох замаар компанийн хэлбэрийг өөрчилж болно гэж заасан байдаг. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 21.5-д “Хуулийн этгээдийн хэлбэр өөрчлөгдөх тохиолдолд тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг дуусгавар болсонд тооцож шинээр байгуулагдах хуулийн этгээдийн мэдээллийг улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэнэ.” гэж заасан нь хэлбэрээ өөрчилж буй хуулийн этгээдийг татан буулгаад шинээр мэдээллийн санд дахин бүртгэхээр ойлгогдож байна. Энэхүү заалт нь практикт хэрэглэгддэггүй.

Үнэлгээ хийх зүйл
32 дугаар зүйл. Хуулийн этгээдийг татан буулгах 32.1.Хуульд өөрөөр заагаагүй бол хуулийн этгээдийг дараахь үндэслэлээр татан буулгана: 32.1.1.өмчлөгч буюу түүнээс эрх олгосон байгууллагын шийдвэр, түүнчлэн хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичгээр эрх олгосон байгууллагын шийдвэр гарсан; 32.1.2.дампуурсанд тооцсон, хуулийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн, хуульд заасан бусад үндэслэлээр татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан; 32.1.3.үйл ажиллагаагаа явуулах хугацаа дууссан буюу зорилгодоо хүрсэн учир цаашид үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх шаардлагагүй гэсэн өөрийнх нь шийдвэр гарсан; 32.1.4.хуулийн этгээдийг үүсгэн байгуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан; 32.1.5.хуульд заасан бусад үндэслэл.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасаж буй зохицуулалтыг Иргэний хуульд илүү нарийвчлалтайгаар хуульчилж өгөх шаардлагатай байна.

32.2.Татан буулгах ажлыг энэ тухай шийдвэр гаргасан байгууллагаас томилсон комисс эрхлэн гүйцэтгэнэ. 32.3.Татан буулгах комисс нь хуулийн этгээд татан буугдсан тухай нийтэд мэдээлнэ. 32.4.Татан буулгах комиссоос нэхэмжлэгчдийн өргөдөл хүлээн авах хугацаа нь хуулийн этгээдийг татан буугдсан тухай нийтэд мэдээлснээс хойш хоёр сараас багагүй, зургаан сараас ихгүй байна. 32.5.Хуульд өөрөөр заагаагүй бол татан буугдаж байгаа хуулийн этгээдэд холбогдох шаардлагыг дараахь дарааллаар хангана: 32.5.1.бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан гэм хорыг арилгуулах, татварын өрийг хураах болон шүүхийн шийдвэрээр гаргуулах бусад төлбөр; 32.5.2.хэрэг гүйцэтгэгч буюу татан буулгах комисс, тэдгээртэй адилтгах бусад этгээдийн эрх, үүргийнхээ хүрээнд гүйцэтгэсэн үйл ажиллагааны зардал; 32.5.3.дампуурлын үед хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх явцад байгуулсан гэрээ, хэлцлийн дагуу гаргасан шаардлага; 32.5.4.хадгаламжийн албан журмын даатгалын нөхөн төлбөр; 32.5.5.хадгаламж эзэмшигчийн мөнгөн хөрөнгө; 32.5.6.хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдад төлөх хөдөлмөрийн хөлс; 32.5.7.хууль тогтоомжид заасны дагуу бусад этгээдтэй хийх тооцоо. 32.6.Татан буугдаж байгаа хуулийн этгээдэд холбогдох шаардлагыг хангахдаа эхний дарааллын төлбөрийг бүрэн барагдуулсны дараа түүний дараагийн дарааллын төлбөрийн шаардлагыг хангах зарчмыг баримтална. 32.7. Хуулийн этгээдэд байгаа мөнгөн хөрөнгө нь харилцагчдын шаардлагыг хангахад хүрэлцэхгүй бол татан буулгах комисс түүний бусад эд хөрөнгийг хуульд заасан журмын дагуу худалдаж, төлбөрийг барагдуулж болно. 32.8. Татан буугдаж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгө төлбөр төлөхөд хүрэлцэхгүй бол түүний эд хөрөнгийг төлбөл зохих төлбөрийн хэмжээнд хувь тэнцүүлэн зохих дарааллын дагуу харилцагчдад хуваарилна.

32.9. Харилцагчдын шаардлагыг хангасны дараа үлдсэн эд хөрөнгийг хууль ёсны өмчлөгчид, хууль буюу дүрэмд заасан бол эрх бүхий этгээдэд шилжүүлнэ.
32.10. Татан буугдаж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг хүлээж авах этгээд байхгүй бол төрийн өмчлөлд шилжүүлнэ.
32.11.Бүртгэх байгууллага хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хассан тухай нийтэд мэдээлнэ.
32.12. Хуульд өөрөөр заагаагүй бол хуулийн этгээдийг татан буулгахад энэ зүйлийг баримтална.

Дээрх хэсгүүд дэх зохицуулалт нь хуулийн зорилгодоо нийцэж байна.

Үнэлгээ хийх зүйл
33 дугаар зүйл.хуулийн этгээдийн төрөл
33.1.Ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл, компанийн хэлбэрээр байгуулна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд “7.1.Улсын бүртгэлийн байгууллага дараах хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрыг бүртгэнэ:

7.1.1.нөхөрлөл;
7.1.2.компани;
7.1.3холбоо /төрийн бус байгууллага/;
7.1.4.сан;
7.1.5.хоршоо;
7.1.6.шашны байгууллага;
7.1.7.нийтийн эрх зүйн хуулийн этгээд;
7.1.8.төрийн байгууллага, албан газар;
7.1.9.улсын төсөвт үйлдвэрийн газар;
7.1.10.аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар.
7.1.11.боловсролын сургалтын байгууллага /сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн, дээд боловсрол/
7.1.12.эрдэм шинжилгээний байгууллага” гэж заасны дагуу эдгээр байгууллагыг улсын бүртгэлд бүртгэж байна.

Иргэний хуульд хуулийн этгээд 5 хэлбэртэй байхаар, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд 12 хэлбэрийн хуулийн этгээдийг бүртгэхээр тус тус зөрүүтэй хуульчилсан ба эдгээр хуульд тусгагдаагүй

- Үндэсний хүмүүнлэгийн байгууллага;
- Үйлдвэрчний эвлэлийн байгууллага;
- Хэвлэл мэдээллийн байгууллага;
- Олон улсын гэрээ, хэлэлцээрээр байгуулагдсан засгийн газар хоорондын байгууллага, түүний төлөөлөгчийн газар;
- Төслийн нэгж зэрэг хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэж байна.

Төсвийн тухай хуулийн 17.1 дэх заалт “Олон улсын байгууллага, хандивлагч орноос Засгийн газрын шугамаар Монгол Улсад олгож байгаа зээл, тусламжаар хэрэгжүүлэх төслийн нэгж нь төсвийн байгууллага байна.” гэж заасны дагуу төслийн нэгжийг төрийн байгууллага, албан газар гэсэн хэлбэрээр бүртгэж байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэгдсэн хуулийн этгээдүүдийн статистик тоон мэдээг хүснэгтээр харуулав.

Зураг.1. *Хуулийн этгээдүүдийн статистик тоон мэдээ*

Д/Д	Хуулийн этгээдийн хэлбэр	Нийт	Үүнээс	нийт	Шинээр бүртгэсэн					Татан буугдсан					Улсын бүртгэлээс хасагдсан
					2020	2021	2022	2023	2024	2020	2021	2022	2023	2024	2023
1	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	227897			12238	13786	15339	15201	17751	119	92	95	51	5	23401
2	ГХО Хязгаарлагдмал хариуцлагатай компани	12400			100	114	206	351	573	4	3	4	2		982
3	Гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар	740			474	30	33	51	63	31	1	3	1		
4	ТБАГ	4601			82	70	64	43	100	1	1	1			
5	Үйлдвэрчний эвлэлийн байгууллага	1985			123	81	124	110	67		1				91
6	Хэвлэл мэдээллийн байгууллага	1068			6	6	2	1			1				390
7	Шашны байгууллага	641			27	41	13	7	7						17
8	Эрдэм шинжилгээний байгууллага	2							1						
9	Нийтийн эрх зүйн хуулийн этгээд	9				1	1	1	1						
10	Үндэсний хөмүүнлэгийн байгууллага	1													
11	Засгийн газрын хоорондын байгууллага	7			1	1	1	1	1						
12	Сан	2101			104	99	98	85	92	2	1	1	1		501
13	Улсын тусгай үйлдвэрийн газар	493			2	1	1	1	1						
14	Хувьцаат компани	333	ХК	235											4
			Нээлттэй	27		1	1	4							
			Хаалттай	19	2	1	2	1	1						
			ТӨХК	52				1							
15	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар	590	ОНӨААТҮГ	489	11	31	25	12	13						
			ТӨААТҮГ	101	2	1	1	1	1						
16	Нөхөрлөл	6521	БГБХН	2443	61	49	119	65	35	4	3	3	2		317
			ЗГБХН	3641	190	178	158	146	88	4	2		1	1	484
			ХХН	429	30	7	9	8	13						40
			ГХОХХН	8											
18	Терийн бус байгууллага	31094	НҮТББ	27041	1592	1441	1585	1402	1627	28	17	12	6	1	5849
			ГҮТББ	4053	186	176	228	238	243	2	2		1		789
19	Боловсрол сургалтын байгууллага	1216	БСБ	427											
			ХХК	196	18	10	20	16	22			1			
			Холбоо	131	15	6	7	7	7						1
			Терийн	462	13	14	6	12	33						
20	Хоршоо	14164	Хоршоо	13323	70	130	453	244	8008	2		2		4	481
			Дундын хоршоо	56	2		6	5	12						2
			ХЗХ	785	17	5	8	8	7	1		1			
		305863	**0**	**53918**	**15366**	**16280**	**18510**	**18022**	**28767**	**198**	**124**	**123**	**65**	**11**	**33349**

Үнэлгээ хийх зүйл
33.2. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны хэлбэрээр байгуулна.

Хоршооны тухай хуулийн 22.1.5, 24.4-д хоршооны ашгийн талаар заасан нь агуулгын хувьд ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж болохоор ойлгогдож байх тул Иргэний хуулийн 33.2 дахь хэсэгтэй зөрчилдөж байна.

Үнэлгээ хийх зүйл
36 дугаар зүйл.холбоо, сан, хоршоо 36.1. Нэгдмэл, тодорхой зорилго тавьсан хэд хэдэн этгээд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгуулсан, гишүүнчлэл бүхий хуулийн этгээдийг холбоо гэнэ. 36.2. Нэг буюу хэд хэдэн үүсгэн байгуулагч нийгэмд ашиг тустай, нэгдмэл зорилгод хүрэхийн тулд эд хөрөнгө төвлөрүүлэх замаар байгуулсан гишүүнчлэлгүй хуулийн этгээдийг сан гэнэ. 36.3. Холбоо, сангийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

Холбоо болон Сангийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдаагүй учир улсын бүртгэлд бүртгэхдээ Төрийн бус байгууллагын тухай хуулийн холбогдох заалтыг баримтлан бүртгэдэг. Энэ нь тухайн хуулийн этгээдийн зорилго, бүтэц, эрх, үүрэг, удирдлагын зохион байгуулалттай зөрчилддөг.

Үнэлгээ хийх зүйл
36.4. Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, хамтын удирдлага, хяналт бүхий дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ. 36.5. Хоршоог үүсгэн байгуулах, бүртгэх, хоршооны үйл ажиллагааг дуусгавар болгох, хоршооны гишүүнчлэл, хяналт болон хоршоотой холбоотой бусад харилцааг хуулиар зохицуулна. 36.6. Сүм хийд иргэний эрх зүйн харилцаанд оролцохдоо сангийн эрх зүйн байдлын талаархи хуулийн заалтыг мөрдөнө.

Сангийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдаагүй учир шашны байгууллагыг улсын бүртгэлд бүртгэхдээ Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийг мөрдөж байна.

Үнэлгээ хийх зүйл
37 дугаар зүйл.Сангийн тусгай зохицуулалт 37.1. Сангийн эрх барих байгууллага буюу удирдах зөвлөл нь хандивлагч, дэмжигч, тэдгээрийн томилсон төлөөллөөс бүрдэнэ. 37.2.Сангийн эрх барих байгууллага нь гүйцэтгэх удирдлага болон хяналтын байгууллагыг томилно. 37.3.Сангийн гүйцэтгэх удирдлага сангийн дүрэмд нийцсэн үйл ажиллагаа явуулж, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг эрх барих байгууллагаараа хэлэлцүүлэн хэвлүүлж, олон нийтэд түгээнэ.

Санг улсын бүртгэлд бүртгэхдээ Иргэний хуулийн 37, 38 дугаар зүйл, Төрийн бус байгууллагын 7 дугаар бүлгийг баримтлан бүртгэж байна.


Үнэлгээ хийх зүйл
38 дугаар зүйл. Санг татан буулгах журам 38.1.Татан буулгах ажлыг энэ тухай шийдвэр гаргасан байгууллагаас томилогдсон татан буулгах комисс эрхлэнэ. Онцгой тохиолдолд шүүхээс татан буулгах өөр байгууллага томилж болох бөгөөд тэрээр татан буулгах комиссийн гишүүдийн нэгэн адил хариуцлага хүлээнэ. 38.2.Санг татан буулгахдаа өдөр тутмын ажил хэргийг зогсоож, бэлэн байгаа эд хөрөнгийг мөнгөөр үнэлэн тодорхойлж, харилцагчидтай тооцоо хийнэ.

38.3.Энэ хуулийн 38.1-д заасны дагуу тооцоо хийсний дараа үлдсэн эд хөрөнгийг татан буугдсан сантай зорилго нэг буюу ижил төстэй зорилго бүхий нэг, эсхүл хэд хэдэн этгээдэд шилжүүлэх, тийм байгууллага байхгүй тохиолдолд төрийн өмчид шилжүүлэх шийдвэр гаргаж болно.

Хоёр.Статистик тоон мэдээ

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас статистик тоон мэдээг 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар гаргасан болно.


График.1. *Хуулийн этгээдийн хэлбэр*



Хүснэгт 4. *Хуулийн этгээдийн хэлбэр тоон үзүүлэлт*

Д/д	Хуулийн этгээдийн хэлбэр	Хэлбэр	Тоо
1.	Хувьцаат компани	ХК	**235**
		Нээлттэй	**27**
		Хаалттай	**19**
		ТӨХК	**51**
		ОӨХК	**1**
2.	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар	ОНӨААТҮГ	**489**
		ТӨААТҮГ	**101**
3.	Нөхөрлөл	БГБХН	**2443**
		ЗГБХН	**3641**
		ХХН	**429**
		ГХОХХН	**8**

4.	Төрийн бус байгууллага	НҮТББ	**27041**
		ГҮТББ	**4053**
5.	Боловсрол сургалтын байгууллага	БСБ	**427**
		ХХК	**196**
		Холбоо	**131**
		Төрийн	**462**
6.	Хоршоо	Хоршоо	**13323**
		Дундын хоршоо	**56**
		ХЗХ	**785**









Гурав. Харьцуулсан судалгаа (Иргэний хуулийн 33 дугаар зүйл: хуулийн этгээдийн төрөл)


3.1.Оросын холбооны улсын хуулийн этгээдийн төрөл:



3.2.Бүгд Найрамдах Казахстан улсын хуулийн этгээдийн төрөл




3.3.Бүгд Найрамдах Франц улсын хуулийн этгээдийн төрөл




3.4.Холбооны Бүгд Найрамдах Герман улсын хуулийн этгээдийн төрөл

Хувийн



Нийтийн




3.5.Монгол Улсын хуулийн этгээдийн төрөл

Ашгийн төлөө



Ашгийн төлөө бус



Дөрөв.Ерөнхий дүгнэлт

Иргэний хууль заасан хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх, татан буулгах, хасах зэрэг зохицуулалтыг холбогдох бусад хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуультай уялдаа холбоо, нийцлийг хангах, дурдсан зарим асуудлыг Иргэний хууль тухайлан зохицуулах хэрэгцээ шаардлага байна гэж үзлээ.

--oOo--

III ДЭД ХЭСЭГ. ХЭЛЦЭЛ

ТАВДУГААР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улс 1992 онд шинэ Үндсэн хуулиа баталснаас хойш эрх зүйн шинэчлэлт тасралтгүй явагдаж байна. Иргэний хууль 1994, 2002 онуудад шинэ үзэл баримтлалтайгаар батлагдсан. Хүчин үйлчилж байгаа 23 жилийн хугацаа нь шүүхийн буюу хууль хэрэглээний нэгдсэн практик, ойлголт төлөвшихөд урт хугацаа биш юм.

2002 оны Иргэний хууль нь нэр томьёо, системчлэлийн хувьд зарим талаараа дутагдалтай байгааг эс тооцвол харьцангуй сайн бичигдсэн хууль гэж судлаачид үздэгтэй санал нийлж байна.

Хэлцэлд хамаарах нийтлэг үндэслэлийг заасан Иргэний хуулийн хэм хэмжээнүүд нь нийгмийн харилцааг зохицуулах чадвараа алдсан эсэх, эсхүл хоцрогдсон эсэх, үзэл баримтлал буюу зарчмын шинжтэй өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага бий эсэх талаар дүн шинжилгээ хийлээ.

Мөн Иргэний хууль /2002 он/ нь нийгмийн суурь харилцааг зохицуулж байгаа, хувийн эрх зүйн үндэс болсон материаллаг эрх зүйн хэм хэмжээ тул үзэл баримтлалын шинжтэй өөрчлөлтөөс илүүтэй хэрэглээнд нэг мөр төлөвшүүлэх хэрэгцээ шаардлага байгаа гэж үзсэн болно.

Иргэний хуулийн ерөнхий ангийн хэм хэмжээнүүдийн хувьд арилжааны хууль тогтоомжийн суурь болох тул тусгайлан дурдсан зарим хэм хэмжээг эс тооцвол арилжааны хууль тогтоомжид тусгах шаардлагагүй гэж үзсэн болно.

Үнэлгээ хийх зүйл
39 дүгээр зүйл. Хэлцэл 39.1.Иргэний эрх, үүргийг үүсгэх, өөрчлөх, шилжүүлэх, дуусгавар болгох зорилгоор хүсэл зоригоо илэрхийлсэн иргэн, хуулийн этгээдийн үйлдэл /эс үйлдэхүй/-г хэлцэл гэнэ. 39.2.Нэг этгээд хүсэл зоригоо илэрхийлэн хэлцэл хийж болно.

Нэг.Хууль хэрэглээний практик

Хэлцэл гэдэг нь иргэний эрх, үүргийг үүсгэж, өөрчилж, дуусгавар болгоход чиглэсэн хэлцэл хийгч этгээдийн хүсэл зоригийн илэрхийлэл болсон эрх зүйн дагуу үйлдэл, үйл ажиллагааг хэлдэг байна.[40] Судлаач Д.Наранчимэгийн тодорхойлсон энэ тодорхойлолтын дагуу Иргэний хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийг үндсэндээ томьёолсон байдаг. Оросын Холбооны Улсын Иргэний хуулийн 153 дугаар зүйлд “Хэлцэл нь иргэн болон хуулийн этгээдийн эрх, үүргийг үүсгэх, өөрчлөх, дуусгавар болгох зорилготой үйлдлийг хэлнэ” гэж томьёолсон байна.

Хууль хэрэглээний практик судалгааг Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн хэмжээнд хийсэн ба тус шүүхэд шийдвэрлэгдэж буй нийт хэрэг нэхэмжлэлийн 60 орчим хувийг хэлцэл /гэрээ/-

[40] Д.Наранчимэг, (1999). Иргэний эрх зүйн үндсэн асуудал. Улаанбаатар: МУИС хэвлэл, 27 дахь тал

тэй холбоотой маргаан эзэлж байна. Тоймлон дурдвал хэлцлийг хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгож, үр дагаврыг арилгуулах, гэрээний үүргийг гүйцэтгүүлэх, татгалзах гэх мэт.

Иргэний хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийн зохицуулалт нь шүүхийн практикт хамгийн нийтлэг хэрэглэгддэг, Иргэний хуулийн ерөнхий ангийн чухал зохицуулалтуудын нэг юм. Хуулийн энэ хэсэгт "... иргэний эрх, үүргийг ..." гэсэн хэсэг хэл зүйн талаасаа буюу найруулгын хувьд оновчтой биш /эдийн болон эдийн бус баялагтай холбоотой/ боловч энэ хэллэгээрээ хэрэглээнд нэгэнт хэвшсэн, ойлголтын ноцтой зөрүү гарсан баримт олдоогүй тул "Иргэний" гэх бичвэрийг өөрчлөх шаардлагагүй юм.

Мөн хэлцэл хийх субъекыг тодорхойлохдоо: " ... иргэн, хуулийн этгээд ..." гэсэн нь харьяалалгүй хүн, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага зэргийг орхигдуулсан байх боловч мөн л энэ талаар хууль хэрэглээний түвшинд маргаан дагуулсан, зөрүүтэй хэрэглэсэн баримт олдоогүй болно. Энэ тохиолдолд тогтсон хэллэг, ухагдахууныг хэвээр хадгалах нь хууль хэрэглээний нэгдмэл байдал, төлөвшилд ач холбогдолтой гэж үзэж байна.

Иргэний хууль нь эрх зүйн хэм хэмжээний эрэмбийн хувьд хувийн эрх зүйн суурь харилцааг зохицуулсан салбар эрх зүйн суурь хэм хэмжээ байх тул бусад эрх зүйн зохицуулалттай зөрчилдөхгүй гэж үзэж байна.

Оросын Холбооны Улсын Иргэний хуулийн 153 дугаар зүйлд "Хэлцэл нь иргэн болон хуулийн этгээдийн эрх, үүргийг үүсгэх, өөрчлөх, дуусгавар болгох зорилготой үйлдлийг хэлнэ" гэж томъёолсон нь Монгол Улсын Иргэний хуулийн зохицуулалттай агуулгын хувьд ижил төстэй байна.

Япон улсын Иргэний хуулийн 91 дүгээр зүйлд " Хэлцлийн талууд хуульд заасан олон нийтийн хэв журамд харшлаагүй дүрмийг тогтоож, хүсэл зоригийг илэрхийлсэн бол уг дүрэм, хүсэл зоригийн илэрхийллийг дагана" гэж хэлцлийн агуулгыг тодорхойлжээ. Япон улсын хувьд хэлцэл гэх тухайлсан агуулга байхгүй боловч хэд хэдэн зүйлээр хэлцлийн агуулгыг тодорхойлсон байна. Энэ нь Монгол Улсын Иргэний хуулийн зохицуулалттай мөн ижил төстэй байна.

Хоёр. Ерөнхий дүгнэлт

Иргэний хуулийн 39.2-ийн хувьд ямар мөн үндэслэлээр ямар нэг өөрчлөлт хийх шаардлагагүй.

Үнэлгээ хийх зүйл
40 дүгээр зүйл. Хүсэл зоригийн илэрхийлэл хүчин төгөлдөр байх 40.1.Хүсэл зоригийн илэрхийлэл нь нөгөө тал түүнийг хүлээн авснаар хүчин төгөлдөр болно. 40.2.Нөгөө тал хүсэл зоригийн илэрхийллийг хүлээж авахаас урьдчилан буюу шууд татгалзсан бол хүсэл зоригийн илэрхийллийг хүчин төгөлдөр бус гэж тооцно. 40.3.Хэлцэл хийснээс хойш нас барсан, эсхүл эрх зүйн бүрэн чадамжгүй болсон этгээдийн урьд нь хийсэн хэлцэл, илэрхийлсэн хүсэл зоригийн илэрхийлэл хүчин төгөлдөр хэвээр байна.

Нэг. Хууль хэрэглээний практик

Хэлцэл хийх хүсэл зоригийн илэрхийлэл гэдэг нь хувь этгээдэд бүрэлдэн тогтсон эрх зүйн үр дагавар үүсгэх зорилго бүхий дотоод ухамсрыг гадагш илэрхийлж байгаа илэрхийллийг хэлдэг. Энэхүү илэрхийллийг гадаад болон дотоод хэмээн ангилж болох бөгөөд дотоод илэрхийлэл гэдэг нь хүсэл зориг бүрэлдэн тогтох үйл явц байдаг бол гадаад илэрхийлэл нь дотоод хүсэл зоригоо гадагш илэрхийлж буй хэлбэр юм. Хүсэл зоригийн илэрхийллийг нөгөө тал хүлээн авсан байх шаардлагатай болон шаардлагагүй илэрхийлэл гэж ангилах явдал бий.

Анхан шатны шүүх /Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүх/-ийн практикт хүсэл зоригийн илэрхийлэл хүчин төгөлдөр болсон эсэх талаарх маргаан багагүй шийдвэрлэгдэж байна. Тухайлбал гэрээ байгуулах болон гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах санал хэрэгжсэн эсэхтэй холбоотой маргаануудыг нэрлэж болно.

Мөн хууль хэрэглээний хувьд маргаан дагуулсан баримт олдоогүй ба хэрэглээнд нэгэнт тогтсон байна.

Иргэний хууль нь эрх зүйн хэм хэмжээний эрэмбийн хувьд хувийн эрх зүйн суурь харилцааг зохицуулсан салбар эрх зүйн суурь хэм хэмжээ байх тул бусад эрх зүйн зохицуулалттай зөрчилдөхгүй гэж үзэж байна.

Япон улсын Иргэний хуулийн 97 дугаар зүйлийн 97.1-д “Хүсэл зоригийн илэрхийлэл нөгөө талд хүрсэн мөчөөс эхлэн хүчин төгөлдөр болно” гэж заасан байна.

ХБНГУ-ын Иргэний хуулийн 130 дугаар зүйлд “Эсрэг талд хүрвэл зохих хүсэл зоригийн илэрхийллийг түүний эзгүйд хүргэсэн бол энэ нь нөгөө талд хүрснээр хүчин төгөлдөр болно” гэж заажээ.

Эдгээр улсын Иргэний хуулийн зохицуулалтууд нь Монгол Улсын Иргэний хуулийн зохицуулалттай агуулгын хувьд ижил төстэй байна.

Хоёр. Ерөнхий дүгнэлт

Иргэний хуулийн 40 дүгээр зүйлд хүсэл зоригийн илэрхийлэл хэдийд хүчин төгөлдөр болох талаар зохицуулсан байх ба энэ зүйлд “илэрхийлэл хүчин төгөлдөр байх” биш хүчин төгөлдөр болох гэж найруулах шаардлагатай гэж үзэж байна.

Мөн энэ зүйлд 2 тал хүсэл зоригоо илэрхийлж хийсэн хэлцэл буюу гэрээний хүсэл зоригийн илэрхийлэл хэдийд хүчин төгөлдөр болохыг зохицуулсан боловч нэг этгээд хүсэл зоригоо илэрхийлж хийсэн хэлцлийн хүсэл зориг хэдийд хүчин төгөлдөр болох талаар зохицуулаагүй байна.

Иргэний хуулийн 40 дүгээр зүйл нь мөн хуулийн ерөнхий ангийн зохицуулалт төдийгүй хувийн эрх зүйн харилцааны суурь хэм хэмжээ болохынхоо хувьд бүх төрлийн хэлцлээр илэрхийлсэн хүсэл зоригийн илэрхийллийг нийтлэг зохицуулах шаардлагатай.

Нэг этгээд хүсэл зоригоо илэрхийлсэн хэлцэл буюу гэрээслэл, бэлэг өгөх амлалттай холбоотой маргаан шүүхийн практикт багагүй тохиолддог тул нэг этгээдийн илэрхийлсэн хүсэл зориг хэзээ хүчин төгөлдөр болох талаар нэмж зохицуулах, эсхүл 40.1 дэх хэсэгт найруулгын өөрчлөлт оруулах шаардлагатай.

Одоо байгаа зохицуулалтуудыг хэвээр хадгалж, шинэ хэсэг нэмэх байдлаар оруулбал хууль хэрэглээний төлөвшлийн хувьд ач холбогдолтой гэж үзэж байна.

Үнэлгээ хийх зүйл
41 дүгээр зүйл. Хүсэл зоригийг тайлбарлах 41.1.Хүсэл зоригийн агуулгыг тайлбарлахдаа үгийн шууд утгыг анхаарна. 41.2.Хүсэл зоригийн илэрхийллийн утга ойлгомжгүй бол хүсэл зоригоо илэрхийлэгчийн хэрэгцээ, шаардлага, үг болон үйлдэл, эс үйлдэхүй, бусад нөхцөл, байдалд дүн шинжилгээ хийх замаар тайлбарлана.

Нэг. Хууль хэрэглээний практик

Аливаа этгээдүүдийн оюун санаанд бүрэлдэн тогтож буй хүсэл зориг гадагш илрэн гарахдаа тухайн улс орон, бүс нутагт тогтсон заншил, хэл яриа, ойлголт, ахуй соёл, түүнчлэн илэрхийлж буй хэлбэр үйлдэл гэх мэт хүчин зүйлийн улмаас харилцан өөр өөрөөр ойлгогдох тохиолдол элбэг байдаг. Энэ тохиолдолд хүсэл зоригийн илэрхийллийг тайлбарлах хэрэгцээ шаардлага бий болдог.

Хуулийн энэ хэсэг 2002 онд батлагдсанаасаа хойш одоо болтол зорилго ач холбогдлоо алдаагүй ба шүүхийн практикт нэгдсэн ойлголтоор хэрэгжиж, хэрэглээнд төлөвшсөн байгаа.

Иргэний хууль нь эрх зүйн хэм хэмжээний эрэмбийн хувьд хувийн эрх зүйн суурь харилцааг зохицуулсан салбар эрх зүйн суурь хэм хэмжээ байх тул бусад эрх зүйн зохицуулалттай зөрчилдөхгүй гэж үзэж байна.

ХБНГУ-ын Иргэний хуулийн 133 дугаар зүйлд “Хүсэл зоригийн илэрхийллийг тайлбарлахад холбогдох этгээдийн жинхэнэ буюу бодит хүслийг судлах ба илэрхийллийн шууд утгыг давуу хэмээн тооцохгүй” гэж заасан байгаа нь Монгол Улсын Иргэний хуулийн зохицуулалттай агуулгын хувьд ижил төстэй байна.

Хоёр. Ерөнхий дүгнэлт

Хүсэл зоригийг тайлбарлах бүхий л нөхцөл байдлуудыг харгалзан үзсэн зохицуулалт гэж үзэж байна. Энэ хэсгийг аливаа хэлбэрээр өөрчлөх засварлах шаардлагагүй.

Үнэлгээ хийх зүйл
42 дугаар зүйл. Хэлцлийн хэлбэр 42.1.Хэлцлийг хуульд заасан хэлбэрээр, хуульд заагаагүй бол талууд хэлэлцэн тохиролцож амаар буюу бичгээр хийнэ. 42.2.Энгийн хэлбэртэй бичгийн хэлцэл нь хүсэл зоригоо илэрхийлэгч этгээд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. 42.3.Ажил хэргийн хүрээнд тогтсон заншлын дагуу техникийн хэрэгслээр шууд хуулбарлан буулгасан гарын үсгийг түүний эхтэй адилтган үзэж болно.

42.4.Нотариатаар гэрчлүүлбэл зохих хэлцлийг хийхэд нотариат буюу хуульд заасан бусад этгээдээр гэрчлүүлнэ.
42.5.Нотариатаар гэрчлүүлбэл зохих хэлцлийг гэрчлээгүй байхад талуудын аль нэг үүргээ бүрэн буюу ихэнхийг нь гүйцэтгэсний дараа нөгөө тал үүнийг хүлээн зөвшөөрсөн боловч хэлцлийг нотариатаар гэрчлүүлэхээс татгалзвал үүргээ гүйцэтгэсэн талын нэхэмжлэлээр шүүх уг хэлцлийг хийсэнд тооцож болно.
42.6.Өвчин болон бичиг үсэг мэдэхгүйн улмаас гарын үсгээ өөрөө зурж чадахгүй этгээдийн итгэмжлэлээр өөр этгээд төлөөлөн хэлцэлд гарын үсэг зурж болно. Энэ тохиолдолд итгэмжлүүлсэн этгээдийн гарын үсгийг баталгаажуулсан байх бөгөөд өөр этгээдээр гарын үсэг зуруулах болсон шалтгааныг бичнэ.
42.7.Бичгээр хийсэн хэлцлийг хэд хэдэн хувь үйлдсэн бол талуудад үлдэх хувь дээр харилцан гарын үсгээ зурсан байвал хэлцэл хийсэн гэж үзнэ.
42.8.Талууд гол нөхцөлийн хувьд өөрийн хүсэл зоригоо бодит үйлдлээр илэрхийлж хэлцэл хийж болно.
42.9.Хууль буюу гэрээнд заасан тохиолдолд хэлцэл хийх тухай саналд хариу өгөхгүй байгааг хэлцэл хийхээр хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.
42.10.Энэ хуулийн 421.1-д зааснаас бусад тохиолдолд бичгээр хийх хуулийн шаардлагыг хангаагүй хэлцэл хүчин төгөлдөр бус байх бөгөөд энэ тохиолдолд талууд хэлцлээр авсан бүх зүйлээ харилцан буцааж өгнө.
42.11.Энэ хуулийн 421.1-д зааснаас бусад тохиолдолд бичгээр хийх хуулийн шаардлагыг зөрчсөн хэлцлийн талаар маргасан тохиолдолд энэ хуульд өөрөөр заагаагүй бол тэдгээр нь гэрчээр нотлох эрхээ алдах боловч нотолгооны бусад хэрэгслээр нотолж болно.

Нэг. Хууль хэрэглээний практик

Хэлцэл гэдэг нь эрх зүйн үр дагавар үүсгэхэд чиглэсэн иргэн, хуулийн этгээдийн үйлдэл эс үйлдэхүйг хэлдэг талаар дээр дурдсан. Үйлдэл, эс үйлдэхүй нь олон хэлбэрээр гадагш илэрхийлэгддэг тул хэлцлийн хэлбэрийн ойлголт бий болжээ. Тодруулбал хэлцэл хийх үйлдэл нь амаар бичгээр бодит үйлдлээр байж болохоос гадна эс үйлдэхүй хэлбэрээр байж болдог бөгөөд үүний нэг жишээ бол хэлцэл хийх тухай саналд хариу өгөхгүй байх явдал юм.

Түүнчлэн, хэлцэлд тавигдаж буй хэлбэрийн шаардлага бол нотолгооны ба анхааруулгын ач холбогдолтой байдаг. Энэ санааг Иргэний хуулийн ерөнхий ангийн энэ зүйлд тодотгож оруулах шаардлагатай. Энэ санааг оруулаагүйгээс тусгай ангийн гэрээнүүдэд тавигдах хэлбэрийн шаардлагыг шүүхийн практикт зөрүүтэй хэрэглэх явдал түгээмэл байдаг.

Шүүхийн практикт мөн энэ төрлийн маргаан багагүй шийдвэрлэгддэг бөгөөд бодит үйлдлээр хэлцэл хийх ойлголтын тухайд зөрүүтэй ойлголтууд практикт байдаг. Тухайлбал бодит үйлдлээр хэлцэл хийх ойлголтыг бичгээр хийх хэлцэлтэй андуурах тохиолдлууд байдаг. Мөн хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж үзэх тохиолдлуудад зөрүүтэй хэрэглэгдэх явдал бий. Түүнчлэн, Иргэний хуулийн 42 дугаар зүйлийн 42.6 дахь хэсгийн зохицуулалт дутагдах тохиолдол шүүхийн практикт гарч байсан болно. Иргэний хуулийн 42 дугаар зүйлийн 42.6-д: “Өвчин болон бичиг үсэг мэдэхгүйн улмаас гарын үсгээ өөрөө зурж чадахгүй этгээдийн итгэмжлэлээр өөр этгээд төлөөлөн хэлцэлд гарын үсэг зурж болно. Энэ тохиолдолд итгэмжлүүлсэн этгээдийн гарын үсгийг баталгаажуулсан байх бөгөөд өөр этгээдээр гарын үсэг зуруулах болсон шалтгааныг бичнэ.“ гэж заажээ. Өвчний улмаас гарын үсгээ зурж чадахгүйгээс гадна хүсэл зоригоо гадагш илэрхийлэх хязгаарлагдмал боломж бүхий этгээдийн тохиолдол шүүхийн практикт гарч байсан.

Иргэний хууль нь эрх зүйн хэм хэмжээний эрэмбийн хувьд хувийн эрх зүйн суурь харилцааг зохицуулсан салбар эрх зүйн суурь хэм хэмжээ байх тул бусад эрх зүйн зохицуулалттай зөрчилдөхгүй гэж үзэж байна.

ХБНГУ-ын Иргэний хуулийн 126-127 дугаар зүйлд хэлцлийн хэлбэрийг заасан байна. Хуулийн 129 дүгээр зүйлд хурууны хээг ашиглаж болохоор зохицуулсан байна.

ОХУ-ын Иргэний хуулийн 160-163 дугаар зүйлд хэлцэл хийх хэлбэрийн шаардлагыг хуульчилсан байна. Монгол Улсын Иргэний хуулийн 42.6 дахь хэсгийн зохицуулалт ОХУ-ын Иргэний хуулийн зохицуулалттай ижил байх боловч ОХУ-ын Иргэний хуульд ажилладаг байгууллага болон хэвтэн эмчлүүлж байгаа эмнэлгийн захиргаа энэ талаар гэрчилж болохоор заажээ.

Хоёр. Ерөнхий дүгнэлт

Иргэний хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Хуульд заасан хэлбэрээр” гэж оруулсан нь бодит үйлдлээр, цахим байдлаар гэх мэт бусад хэлцлийн хэлбэрүүдийг хамруулж байгаа тул зорилгодоо нийцэж байна гэж үзэж байна. Харин 42.2 дахь хэсэгт гарын үсэг, хурууны хээ, хувийн тэмдэг байж болох эсэхийг нэмж судлах шаардлагатай.

Энэ зүйлийн 42.5, 42.7, 42.10, 42.11 дэх хэсгийн зохицуулалтууд нь системчлэлийн хувьд энэ зүйлд байх нь зохимжгүй байна.

Үнэлгээ хийх зүйл
42[1] дүгээр зүйл. Цахим хэлбэрээр хийх хэлцэл 42[1].1. Хуульд зааснаар бүртгүүлэх, нотариатаар гэрчлүүлбэл зохих болон бичгээр хийхээр заасан хэлцлийг цахим хэлбэрээр хийж болно. 42[1].2.Хуульд өөрөөр заагаагүй бол цахим хэлбэрээр хийх хэлцэл нь талууд хүсэл зоригоо харилцан илэрхийлж, цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурснаар, эсхүл бусад байдлаар техникийн хэрэгсэл, программ хангамжийг ашиглан хүсэл зоригоо илэрхийлж, харилцан хүлээн зөвшөөрч, цахим гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

Нэг. Хууль хэрэглээний практик

Харьцангуй шинэ ойлголт бөгөөд нийгмийн хөгжилтэй холбоотойгоор цахим орчинд хэлцэл хийгч этгээдийн хүсэл зоригийн илэрхийллийг баталгаажуулах хэрэгцээ шаардлагатай холбоотой эрх зүйн зохицуулалт юм.

Монгол Улсын Иргэний хуульд 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар цахим хэлцлийн талаарх нэмэлт өөрчлөлт орсон ба дагалдах бусад хуулиуд хэрэгжиж эхлээгүй, техникийн дэд бүтэц шийдэгдээгүй /тоон гарын үсэг гэх мэт/-тэй холбоотойгоор шүүхийн практикт нэг мөр хууль хэрэглээний ойлголт тогтоогүй байна.

Монгол Улсын Иргэний хууль нь эрх зүйн хэм хэмжээний эрэмбийн хувьд хувийн эрх зүйн суурь харилцааг зохицуулсан салбар эрх зүйн суурь хэм хэмжээ байх тул бусад эрх зүйн зохицуулалттай зөрчилдөхгүй гэж үзэж байна.

ХБНГУ-ын Иргэний хуулийн 126а-д цахим хэлцлийн хэлбэрийг хуульчилсан байх ба энэ зохицуулалт нь Монгол Улсын Иргэний хуулийн зохицуулалттай агуулгын хувьд ижил төстэй байна.

Хоёр. Ерөнхий дүгнэлт

Системчлэлийн хувьд 42 дугаар зүйлд байх ёстой боловч шинэ тутам үүсэж байгаа нийгмийн харилцааг зохицуулсан хэм хэмжээ гэдэг үүднээс хууль тогтоогч бие даасан зүйл болгож оруулсан байж болох юм. Системчлэлийн алдаа нь хууль хэрэглээний түвшинд асуудал дагуулсан гэх баримт олдоогүй тул өөрчлөхгүй байх саналтай байна.

Энэ зүйлийн 42^1.2 дэх хэсэгт " ... цахим баримт бичиг ...", "... тоон гарын үсэг зурах ..." гэх ойлголтууд нь хэрэглээнд төлөвших явцад маргаан дагуулж болзошгүй байгааг анхаарах шаардлагатай. Цахим орчинд хадгалагдсан тоон мэдээлэл нь "цахим баримт" гэх ойлголтод хамаарах бөгөөд уг мэдээллийг баримт бичигт буулгасан бол тухайн баримт нь цахим биш бичмэл баримт болно.

Цахим төлөөллийн асуудлыг мөн анхаарах шаардлагатай буюу "Чат бот"-р дамжуулж хэлцэл хийх асуудлыг энэ хэсэгт, эсхүл Иргэний хуулийн Төлөөллийн харилцааг зохицуулсан хэсэгт оруулах.

Мөн 42^1.2 дахь хэсэгт "цахим гарын үсэг зурах", "тоон гарын үсэг зурах" зэрэг хэлбэрийн шаардлага тавьсан нь цаашид "цахим хэлцэл" гэх зохицуулалтын үндсэн зорилгыг алдагдуулж болох талтай.

Иргэд хоорондын хэрэглээний түвшинд цахим хэлцэл хийгээд төлөвшчихсөн, цахим хэлцэл хийхдээ цахим буюу тоон гарын үсэг зурдаггүй тул иргэд хоорондын гэрээнд хэлбэрийн шаардлагыг зөөлрүүлэх, харин арилжааны гэрээний түвшинд ялгамжтай байдлаар зохицуулах шаардлагатай .

Хуулийн энэ зүйлийн зохицуулалтыг Иргэний хууль, Арилжааны хуулиар ялгаж зохицуулах нь зүйтэй гэдэг саналыг гаргаж байна.

Үнэлгээ хийх зүйл
43 дугаар зүйл. Хэлцэл хийсэн гэж үзэх 43.1.Амаар хийх хэлцлийг дараахь тохиолдолд хийсэн гэж үзнэ: 43.1.1.хэлцлийн гол нөхцөлийн талаар талууд хэлэлцэн тохиролцсон; 43.1.2.хэлцэл хийснийг нотолсон пайз, тасалбар зэрэг хэрэглэж заншсан зүйлийг олгосон; 43.1.3.хууль буюу гэрээнд заасан бол хэлцэл хийх тухай саналд хариу өгөөгүй бөгөөд ийнхүү хариу өгөх тогтоосон хугацаа, эсхүл ердийн боломжит хугацаа өнгөрсөн. 43.2.Бичгээр хийх хэлцлийг дараахь тохиолдолд хийсэн гэж үзнэ: 43.2.1.талууд хүсэл зоригоо илэрхийлсэн баримт бичиг үйлдэж, гарын үсэг зурсан; 43.2.2.хэлцэл хийх тухай саналыг зөвшөөрсөн талын хүсэл зоригийг илэрхийлсэн захидал, цахилгаан, албан бичиг, телефакс, эдгээртэй адилтгах бусад баримт бичгийг нөгөө тал хүлээн авсан; 43.2.3.хуульд зааснаар бүртгүүлэх буюу нотариатаар гэрчлүүлбэл зохих хэлцлийг ийнхүү бүртгүүлсэн буюу гэрчлүүлсэн; 43.2.4.цахим хэлбэрээр хэлцэл хийх бол талууд хүсэл зоригоо илэрхийлсэн цахим баримт бичиг үйлдэж, Цахим гарын үсгийн тухай хуульд заасан цахим гарын үсэг зурсан.

43.3.Нэг талын хүсэл зоригийн илэрхийллийг нөгөө тал хүлээн авснаа өөрийн тодорхой үйлдлээр илэрхийлсэн бол уг хэлцлийг бодит үйлдлээр хийгдсэн гэж үзнэ. 43.4.Хэлцлийн агуулгыг тодорхойлох боломжгүй бол уг хэлцлийг хийгдээгүйд тооцно.

Нэг. Хууль хэрэглээний практик

Хэлцэл хийсэн гэж үзэх эсэх, мөн хэлцэл хэрэгжиж эхлэх цаг хугацаа болон үр дагаврыг тодорхойлоход ач холбогдол бүхий ухагдахуун юм.

Шүүхийн практикт хуулийн энэ зүйл багагүй хэрэглэгддэг ба цахим хэлцэл хийсэн гэж үзэх зохицуулалтаас бусад зохицуулалтын хувьд хууль хэрэглээний нэгдмэл ойлголт бүхий практик тогтсон байна.

Иргэний хууль нь эрх зүйн хэм хэмжээний эрэмбийн хувьд хувийн эрх зүйн суурь харилцааг зохицуулсан салбар эрх зүйн суурь хэм хэмжээ байх тул бусад эрх зүйн зохицуулалттай зөрчилдөхгүй гэж үзэж байна.

ХБНГУ-ын Иргэний хуулийн 125-132, 145-156 дугаар зүйлд агуулгын хувьд тусгалаа олсон байна. Манай улсын Иргэний хуулийн зохицуулалтуудтай ерөнхий ойлголтын түвшинд ижил байна.

Хоёр. Ерөнхий дүгнэлт

Хуулийн эдгээр зохицуулалт хэм хэмжээний үндсэн зорилгоо хангаж байгаа буюу ач холбогдлоо алдаагүй боловч системчлэлийн хувьд бие даасан зүйл байх эсэх, эсхүл Иргэний хуулийн 42 дугаар зүйлтэй нэгтгэх шаардлагатай эсэхийг цаашид нарийвчлан судлах шаардлагатай гэж үзэж байна.

Энэ зүйлийн 43.2.4 дэх хэсгийн зохицуулалт нь 42^{1}.2 дахь хэсгийн зохицуулалттай давхацсан шинжтэй байна.

Мөн энэ зүйлийн 43.3 дахь хэсгийн зохицуулалт нь нэг тал хүсэл зоригоо илэрхийлж хийсэн хэлцлийн тухайд байж болох эсэхийг цаашид судлах, хэрэв байж болохоор бол найруулгын засвар хийх, бие даасан хэсэг болгож оруулах, эсхүл хууль хэрэглээний түвшинд хэм хэмжээг төсөөтэй хэрэглэх байдлаар нөхөж болох эсэхийг шийдвэрлэх шаардлагатай.

Үнэлгээ хийх зүйл
44 дүгээр зүйл. Болзол тавьж хийсэн хэлцэл
45 дугаар зүйл. Болзол тавьж хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байх
46 дугаар зүйл. Болзол хүчин төгөлдөр бус болох
47 дугаар зүйл. Болзол хангагдсан гэж үзэх
48 дугаар зүйл. Болзол тавьж хэлцэл хийсэн этгээдийн үүрэг

Нэг. Хууль хэрэглээний практик

Ирээдүйд “хэлцэл хийх” буюу хэлцэл хэрэгжиж эхлэх, эсхүл дуусгавар болох цаг хугацааны урьдчилсан тохиролцоо юм. Болзол нь хэлцлийн хүчин төгөлдөр болох, эсхүл дуусгавар болох асуудлыг ирээдүйд бий болох тодорхойгүй үйл явдал /талууд мэдэх боломжгүй/-ын талаарх “тохиролцоо” бөгөөд зарим тохиолдолд цаг хугацааны шинжтэй болзол байж болдог. Талууд хэлцлийг хэрэгжүүлж эхлэх, эсхүл дуусгавар болгох талаар болзол тавьснаас хамаараад хойшлуулах болзол, өөрчлөгдөх болзол гэж ангилдаг.

Монгол Улсын шүүхийн болон хууль хэрэглээний практик /Иргэний хуулийн 44-48 дугаар зүйл/

Шүүхийн практикт гэрээ байгуулах болсон нөхцөл байдал өөрчлөгдөх /Иргэний хуулийн 220-р зүйл/ тохиолдол болон, цаг хугацаа заасан ердийн гэрээний тохиролцоо зэргийг болзол тавьсан хэлцэлтэй андуурч хэрэглэх тохиолдлууд гардаг.

Бусад эрх зүйн зохицуулалтуудтай зөрчилдөх боломжтой эсэх /Иргэний хуулийн 44-48 дугаар зүйл/

Иргэний хууль нь эрх зүйн хэм хэмжээний эрэмбийн хувьд хувийн эрх зүйн суурь харилцааг зохицуулсан салбар эрх зүйн суурь хэм хэмжээ байх тул бусад эрх зүйн зохицуулалттай зөрчилдөхгүй гэж үзэж байна.

ХБНГУ-ын Иргэний хуулийн 158-163 дугаар зүйлд зохицуулсан байх ба агуулгын хувьд Монгол Улсын Иргэний хуулийн зохицуулалтуудтай ижил байна.

Япон улсын Иргэний хуулийн 127-137 дугаар зүйлд зохицуулсан нь мөн агуулгын хувьд Монгол Улсын Иргэний хуультай ижил байна.

Хоёр. Ерөнхий дүгнэлт

Иргэний хуулийн 44 дүгээр зүйл

Хуулийн энэ зохицуулалт хэм хэмжээний үндсэн зорилгоо хангаж байгаа, ач холбогдлоо алдаагүй боловч зарим нэр томьёог тодотгох шаардлагатай гэж үзэж байна. Учир нь хуулийн энэ хэсгийг шүүхийн практикт зөрүүтэй хэрэглэх тохиолдол олон гардаг болно.

Тодруулбал, энэ зүйлийн 44.2, 44.3 дахь хэсгийн зохицуулалтыг бүхэлд нь хэл зүйн хувьд буюу найруулгын хувьд хялбаршуулан найруулах шаардлагатай. Эдгээр хэсэгт байгаа “хойшлуулах болзол”, “өөрчлөгдөх болзол” гэх ухагдахууныг өөрчилж, хэлцэл хэрэгжиж эхлэх, хэлцэл дуусгавар болохыг тайлбарласан байдлаар буюу энгийн байдлаар томъёолох шаардлагатай гэж үзэж байна.

Энэ зүйлийн 44.4 дэх хэсгийн зохицуулалтыг мөн адил энгийн байдлаар найруулах боломжтой байна. Тухайлбал, “энэ зүйлийн зохицуулалт үйлчлэхгүй” гэх биш харин “болзол тавьж хийсэн хэлцэл гэж үзэхгүй” гэх мэт.

Иргэний хуулийн 45 дугаар зүйл

Хуулийн 45, 46 дугаар зүйлийн зохицуулалтуудыг харьцуулан үзвэл энэ зүйлийн зохицуулалт нь “хэлцэл”-ийг бүхэлд нь хүчин төгөлдөр бус байх тохиолдлыг зохицуулсан гэж үзэхээр байна. Энэ тохиолдолд хуулийн энэ зүйлээр зохицуулсан харилцааг Иргэний хуулийн Иргэний хуулийн 56.1-ээр зохицуулах боломжтой боловч энэ нь хууль хэрэглээний хүндрэлийг дагуулах, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэх тул энэ зүйлд заасан зохицуулалтыг хөндөх шаардлагагүй гэж үзэж байна.

Харин болзлыг хойшлуулах, өөрчлөгдөх гэж онолын хувьд ангилсан байгаагаас үзвэл хойшлуулах болзол бүхий хэлцлийн хувьд 45.1 дэх хэсэг гарцаагүй үр нөлөөтэй байж болох ч өөрчлөгдөх болзол бүхий хэлцлийн хувьд “үндсэн хэлцэл” болзлоосоо хараат бусаар оршин тогтнох боломжтой эсэхийг иргэний эрх зүйн онолын үүднээс нарийвчлан судлах шаардлагатай.

Иргэний хуулийн 46 дугаар зүйл

Энэ зүйлийн 46.1, 46.2-т хугацаа заасан болон заагаагүй болзлын талаар зохицуулсан байна. Харин 46.2 дахь хэсгийн тухайд найруулгыг өөрчлөхгүй бол утга агуулгын хувьд “болзол хэдийд ч хэрэгжих” буюу хүн өөрөө хэрэгжүүлж болохоор бичигджээ. Хэрэв ийм ойлголт гарвал болзол тавьсан хэлцэл биш болох юм. Иймд 46.2-ын зохицуулалтыг “Үйл явдал болох хугацааг тодорхой заагаагүй бол болзол тухайн үйл явдлыг болох хүртэл хүчинтэй байх байна.” гэх мэтээр өөрчилж болно.

Иргэний хуулийн 47 дугаар зүйл

Хуулийн энэ зүйл хэрэглээний ач холбогдлоо алдаагүй, хэм хэмжээний зорилгоо хэрэгжүүлж байгаа. Харин болзол хангагдах нөхцөл, хүчин төгөлдөр бус байх гэх мэт болзол тавьж хийсэн хэлцэлтэй холбоотой зохицуулалтууд /44-48 дугаар зүйл/-ыг системчлэлийн хувьд хялбар, ойлгомжтой байдлаар байршуулбал хууль хэрэглээний хувьд хэрэглэхэд хялбар, ойлгомжтой болно гэж үзэж байна.

Иргэний хуулийн 48 дугаар зүйл

Хуулийн энэ зүйлийн нэршил /Болзол тавьж хэлцэл хийсэн этгээдийн үүрэг/ нь хэсгүүдийн зохицуулалттайгаа нийцэхгүй байна. Харин хэсгүүдэд заасан зохицуулалтуудыг дээр дурдсанаар системчлэлийн хувьд зөв байршуулах шаардлагатай. Бусдаар энэ зүйлийн зохицуулалтууд нь ач холбогдлоо алдаагүй эрх зүйн хэм хэмжээний зорилгодоо нийцэж байна гэж үзэж байна.

Үнэлгээ хийх зүйл
49 дүгээр зүйл. Биржийн хэлцэл 49.1.Биржийн гүйлгээнд оруулах эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрх /эд хөрөнгө, үнэт цаас гэх мэт/-ээ харилцан шилжүүлэх тухай хэлцлийг хууль тогтоомжид заасан журмын дагуу байгуулж, биржид бүртгүүлнэ. 49.2.Хууль, тухайн төрлийн хэлцлийн шинж байдалд харшлахгүй бол биржийн хэлцэлд түүний агуулгад нийцүүлэн зохих гэрээ /худалдах-худалдан авах, комиссийн зэрэг/-ний журмыг хэрэглэж болно. 49.3.Талуудын худалдааны нууцыг агуулсан, тэдний зөвшөөрөлгүйгээр мэдээлж болохгүй нөхцөлийг биржийн тухай хууль тогтоомжоор тодорхойлно. 49.4.Биржийн хэлцэл байгуулах, түүнээс үүсэх эрх, үүрэгтэй холбогдон гарсан маргааныг эрх бүхий байгууллага хянан хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд уг шийдвэрийн талаар талууд шүүхэд гомдол гаргаж болно.

Нэг. Хууль хэрэглээний практик

Бирж нь оруулах боломжтой, ижил бүтэцтэй, харилцаанд гол төлөв тоо, хэмжээ, эсхүл жингээр тодорхойлогдох бөгөөд ижил хэмжээтэй өөр баялгаар орлуулах боломжтой эд зүйлсийг худалдаалахад үйлчилдэг. Борлуулж байгаа бүтээгдэхүүнээс хамааранд үнэт цаасны, бараа бүтээгдэхүүний, валютын гэх мэт биржүүд байдаг. Биржийн хэлцэл нь Иргэний хуулийн зохицуулалтаар байгуулагдахгүй бөгөөд тусгайлсан хууль хэрэглэгдэнэ. Тодорхой тохиолдолд худалдах-худалдан авах болон комиссын гэрээний зохицуулалт төсөөтэй хэрэглэгддэг гэж үздэг.[41]

Монгол Улсын хувьд хөрөнгийн болон бусад арилжааны биржүүд харьцангуй хожуу үүссэнээс гадна нийгмийн хөгжлийн түвшин, хэрэгцээ шаардлагатай холбоотой биржийн гүйлгээ арилжаа бага хийгддэг тул шүүхийн практикт шийдвэрлэгдэж буй энэ төрлийн маргааны тоо цөөн байна. Сүүлийн үед ихсэх хандлагатай байгааг дурдах нь зүйтэй. Иргэний хуулийн энэ зохицуулалт нь ерөнхий хэм хэмжээ бөгөөд бусад нарийвчилсан хуулиар ихэнх харилцаа зохицуулагдаж байна.

Иргэний хууль нь эрх зүйн хэм хэмжээний эрэмбийн хувьд хувийн эрх зүйн суурь харилцааг зохицуулсан салбар эрх зүйн суурь хэм хэмжээ байх тул бусад эрх зүйн зохицуулалттай зөрчилдөхгүй гэж үзэж байна.

Бусад улс орны Иргэний хуульд биржийн хэлцлийг тухайлан зохицуулсан хэм хэмжээ байхгүй байна.

Хоёр. Ерөнхий дүгнэлт

Биржийн хэлцэл гэх ойлголтыг тухайн үед буюу 2002 онд ерөнхий байдлаар томьёолон оруулсан байна. Арилжааны төрөлжсөн хууль батлагдвал Иргэний хуульд биш тус хуульд оруулах шаардлагатай байж болох юм. Хуулийн 49 дүгээр зүйлийн 49.4-т заасан зохицуулалтын хэрэгжилтийг нарийвчлан судлах шаардлагатай.

Үнэлгээ хийх зүйл
50 дугаар зүйл. Зөвшөөрлөөр хийх хэлцэл
51 дүгээр зүйл. Зөвшөөрлөө хүчингүй болгох
52 дугаар зүйл. Зөвшөөрлийг буцааж хэрэглэхгүй байх нөхцөл
53 дугаар зүйл. Эрх олгогдоогүй этгээдийн үйлдэл хүчин төгөлдөр байх
54 дүгээр зүйл. Насанд хүрээгүй буюу 14-өөс 18 хүртэлх насны иргэн зөвшөөрөлгүй хийсэн хэлцэл
55 дугаар зүйл. Насанд хүрээгүй буюу 14-18 хүртэлх насны иргэний бие дааж хийх хэлцэл

Нэг. Хууль хэрэглээний практик

Энэхүү журмаар хүчин төгөлдөр үйлчлэх эсэх нь гуравдагч этгээдийн зөвшөөрлөөс хамаарах эрх зүйн үйлдэл буюу хэлцлийг зохицуулдаг байна. Зөвшөөрөл гэдэг нь хүлээн авахыг хүсэмжилсэн, санал болгосон шинж бүхий хүсэл зоригийг илэрхийлсэн мэдэгдэл юм. Зөвшөөрөл нь хожим дэмжих зөвшөөлөөр хийгдсэн хэлцлийг харилцан тохиролцсон агуулгын хүрээнд хүчин төгөлдөр болгодог бол зөвшөөрөл

[41] Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, Улаанбаатар 2010 он Мим ХХК /үүсмэл бүтээлийн эрх/, 85 дахь тал

олгохоос татгалзсанаар тухайн хэлцлийг хүчин төгөлдөр бус болгодог байна. Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд хэлцлийн агуулгыг өөрчлөх эрхгүй. Мөн хэсэгчилсэн зөвшөөрөл олгож болдог байна[42].

Хуулийн этгээдийн хийсэн хэлцэл болон эрх зүйн хязгаарлагдмал чадамжтай этгээдийн хийсэн хэлцэлтэй холбоотой маргаан шүүхийн практикт түгээмэл байдаг боловч хууль хэрэглээний түвшинд зөрүүтэй ойлголт байдаггүй.

Иргэний хууль нь эрх зүйн хэм хэмжээний эрэмбийн хувьд хувийн эрх зүйн суурь харилцааг зохицуулсан салбар эрх зүйн суурь хэм хэмжээ байх тул бусад эрх зүйн зохицуулалттай зөрчилдөхгүй гэж үзэж байна.

ХБНГУ-ын Иргэний хуулийн 107-112 дугаар зүйлд агуулгын хувьд энэ харилцааг зохицуулсан байна. Япон улсын Иргэний хуулийн 113-125 дугаар зүйлд агуулгын хувьд зохицуулсан байна. Эдгээр улсын эрх зүйн эх сурвалж нь Монгол Улсын Иргэний хуулийн зохицуулалттай агуулгын хувьд мөн ижил төстэй байна.

Хоёр. Ерөнхий дүгнэлт

Иргэний хуулийн 50-55 дугаар зүйлд заасан хэм хэмжээнүүд бүхэлдээ гуравдагч этгээдийн тусламжтайгаар хэлцэл хийхтэй холбоотой харилцааг зохицуулсан байх тул эдгээр зүйлүүдийг системчлэлийн хувьд нэгтгэж байршуулбал хууль хэрэглээний хувьд ойлгомжтой, хялбар болно.

Мөн Иргэний хуулийн Ерөнхий ангийн зохицуулалтуудын хувьд 7-14 насны хүүхдийн хиймэгц биелэх ахуйн шинжтэй хэлцлийн талаар энэ зүйлд нэмж зохицуулах хэрэгцээ шаардлага бий эсэхийг нарийвчлан судлах шаардлагатай.

5.1 Иргэний хуулийн 50 дугаар зүйл

Энэ зүйлийн хэрэглээний ач холбогдол алдагдаагүй, хэм хэмжээний зорилгоо хэрэгжүүлж байгаа ба хууль хэрэглээний маргаан дагуулсан талаарх баримт олдоогүй болно.

Иргэний хуулийн 51 дүгээр зүйл

Хууль хэрэглээний хувьд маргаан дагуулаагүй. Харин зүйл болон хэсгийн зохицуулалтуудыг харьцуулан унших замаар бүрэн ойлгогдохоор байгаа тул хэл зүйн найруулгын хувьд энийг ойлгомжтой байдлаар засах шаардлагатай.

Иргэний хуулийн 52 дугаар зүйл

Энэ зүйлийн нэршил болон 52.1 дэх хэсгийн зохицуулалт нь хэл найруулга, өгүүлбэр зүйн бүтцийн хувьд энгийн хүн уншиж ойлгоход хэтэрхий бэрхшээлтэй байна. Иймд монгол хэлний мэргэжилтний тусламж авах шаардлагатай.

[42] Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, Улаанбаатар 2010 он Мим ХХК /үүсмэл бүтээлийн эрх/, 86 дахь тал

Харин эрх зүйн хамгаалалтын хувьд энэ зүйлийн зохицуулалт нь зөвхөн шийдвэр гүйцэтгэгч болон дампуурлын хэрэг гүйцэтгэгч нарт үйлчлэх эсэх, эсхүл өөр бусад хэлцэл хийгч гуравдагч этгээдэд нийтлэг байдлаар үйлчлэх эсэхийг эрх зүйн онолын үүднээс нарийвчлан судлах шаардлагатай.

Иргэний хуулийн 53 дугаар зүйл

Энэ зүйлийн 53.1 дэх хэсгийн зохицуулалтад тодруулга хийх шаардлагатай. Учир нь 52 дугаар зүйлд зарим гуравдагч этгээдийн эрх хамгаалагдах тохиолдлыг буюу хэлцлийг буцаан хэрэглэх хязгаарыг хуульчилсан байгаатай энэ зүйлд заасныг уялдуулах шаардлагатай. Ийнхүү тодруулга хийхгүй бол хэм хэмжээний зөрчил үүсгэхээр байх ба хуульчдийн хувьд эдгээр хэм хэмжээг тайлбарлах замаар зөв хэрэглэж болох боловч хэрэглэгчийн хувьд төөрөгдөл үүсгэж болзошгүй байна.

Энэ зүйлд заасан зохицуулалт нь эрх зүйн хэм хэмжээний зорилгоо хэрэгжүүлж байгаа ба ач холбогдлоо алдаагүй болно.

Иргэний хуулийн 54 дүгээр зүйл

Энэ зүйлийн зохицуулалтууд нь зорилго, ач холбогдлоо алдаагүй боловч мөн хэл найруулгын хувьд энгийн хүн ойлгоход хүндрэлтэй байна.

Тодруулбал, энэ зүйлийн 54.1 дэх хэсгийн зохицуулалтын 2 дахь өгүүлбэрийг өөр байдлаар найруулахгүй бол хэлцэл хэрэгжиж эхлэх хугацааны талаар төөрөгдөл үүсэхээр байна. Бусад зохицуулалтын хувьд ойлгомжтой, хууль хэрэглээний хувьд маргаан дагуулсан баримт олдоогүй болно.

Иргэний хуулийн 55 дугаар зүйл

Энэ зүйл эрх зүйн зохицуулалтын үндсэн зорилгоо хангаж байгаагаас гадна ач холбогдлоо алдаагүй байна. Утга агуулгын хувьд өөрчлөн найруулах шаардлагагүй.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ. ХҮЧИН ТӨГӨЛДӨР БУС ХЭЛЦЭЛ

Иргэний хуулийн Зургадугаар бүлэгт тусгагдсан хүчин төгөлдөр бус хэлцлийн зохицуулалтуудын дараах гурван хэсэгт ангилан дүн шинжилгээ хийлээ:

I.Хүчин төгөлдөр бус хэлцлийн нийтлэг зохицуулалт
II.Тодорхой төрлийн хүчин төгөлдөр бус хэлцлийн талаар
III.Бусад асуудал

I.Хүчин төгөлдөр бус хэлцлийн нийтлэг зохицуулалт

Нэг.Онолын ойлголт

Хүчин төгөлдөр бус хэлцлийн институт нь иргэний гүйлгээний тогтвортой байдлыг хангах үүрэгтэй. Холбогдох зохицуулалтууд нь иргэний гүйлгээнд оролцогч шударга талын эрх, ашиг сонирхлыг хамгаалах үндсэн хэрэгсэл болно. Нөгөө талаар хүчин төгөлдөр бус байх хэлцлийн зохицуулалт дутмаг байгаа нь шударга бус этгээдүүд аливаа хэлцлийг хүчин төгөлдөр бус хэлцлийн институтээр дамжуулан үүргээ гүйцэтгэхээс

зайлсхийх боломжийг олгодог сөрөг талтай. Энэ нь сүүлийн үед янз бүрийн үндэслэлээр хэлцлийг хүчин төгөлдөр бус болгуулах маргаан ихсэх шинжтэй болж байгаагаар харагдана.

Хэлцлийг хүчин төгөлдөр бусд тооцох хууль зүйн боломжийг багасгах нь иргэний эрх зүйн харилцаанд оролцох шударга талын эрх, ашиг сонирхол хамгаалагдах учиртай.

Иргэний хуульд хүчин төгөлдөр бус байх буюу үнэмлэхүй[43] /Иргэний хуулийн 56 дугаар зүйл/ болон хүчин төгөлдөр бусад тооцуулах хэлцэл буюу харьцангуй[44] /Иргэний хуулийн 57-60 дугаар зүйл/ гэсэн онолын ангиллыг хэрэглэсэн.

Ийнхүү ангилсантай холбоотойгоор хууль тогтоогч 3 шалгуур тавьсан гэж дүгнэхээр байна. Үүнд:

1.Хүчин төгөлдөр бус хэлцлийг хүлээн зөвшөөрөх журам
2. Хүчин төгөлдөр бус хэлцэл гэж шаардах эрхтэй этгээдүүд /сонирхогч этгээд/
3. Хөөн хэлэлцэх хугацаа

Эхний шалгуур буюу хүчин төгөлдөр бус хэлцлийг хүлээн зөвшөөрөх журмын хүрээнд хүчин төгөлдөр бус байх хэлцлийг тооцуулах талаар шүүхэд нэхэмжлэл гаргахгүй бөгөөд Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.5 дахь хэсэгт түүний үр дагаврыг арилгуулахыг шаардах эрхийг олгосон. Харин хүчин төгөлдөр бусд тооцуулах хэлцлийн хувьд сонирхогч этгээд нь шүүхэд нэхэмжлэлийн 2 шаардлага гаргана. Үүнд: эхнийг нь уг хэлцлийг хүчин төгөлдөр бусд тооцуулж, улмаар дараагийнх нь буюу үр дагаврыг арилгуулахаар шаардах журмыг хууль тогтоогч тогтоосон гэж дүгнэхээр байна.

Энэ хэсэгт дараахь гурван асуудлыг авч үзнэ. Үүнд:
1.Хүчин төгөлдөр бус хэлцлий үр дагаврын зохицуулалтын дутмагшил
2. Хүчин төгөлдөр бус хэлцлийн улмаас хохирол нөхөн төлөхийг шаардах эрх

3. Хүчин төгөлдөр бус хэлцлийн дутагдлыг арилгах механизм

1. Хууль тогтоогч хүчин төгөлдөр бус хэлцлийн үр дагаврыг арилгуулахад хүчин төгөлдөр бус хэлцлийн дагуу шилжүүлсэн бүх зүйлээ харилцан буцааж өгөх, боломжгүй бол үнийг төлөх /Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.5/ болон хүчин төгөлдөр бус хэлцлийн улмаас учирсан хохирлыг /Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.6/ гаргуулах хэм хэмжээг нийтлэг зохицуулалтын хүрээнд хуульчилсан. Харин тэдгээрийг байршуулахдаа Иргэний хуулийн 56 дугаар зүйл буюу “Хүчин төгөлдөр бус байх хэлцэл”-ийн зохицуулалтад хамааруулсан нь системчлэлийн хувьд алдаатай болжээ.

Түүнчлэн хүчин төгөлдөр бус хэлцлийн үр дагаварт “юу шаардаж болох”-ыг хууль тогтоогч хэлцлээр шилжүүсэн бүх зүйлийг харилцан буцаах, буцаах боломжгүй бол үнийг төлөх” гэж тодорхойлжээ. Талуудын хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус болсон бол уг хэлцлээр хэн алинаасаа шилжүүлж авсан зүйлийг талууд өмчлөх, эзэмших эрхийн үндэслэл үгүй болно. Хүчин төгөлдөр бус хэлцлийн институтийн хүрээнд асуудлыг нэг мөр шийдвэрлэхийн тулд талуудад хэн алинаасаа авсан зүйлийг буцаан өгөх нь нэн

[43] Д.Наранчимэг, Иргэний эрх зүйн үндсэн асуудал, 1 дэвтэр, Улаанбаатар, 1999, 40 дэх тал
[44] Мөн тэнд

тэргүүнд хамаарах үүрэг боловч цаг хугацаа, эд хөрөнгийн элэгдэл хорогдол, эд хөрөнгөд засан сайжруулалт хийгдсэн зэрэг байдлуудаас шалтгаалж хэлцлийн дагуу шилжүүлж авсан эд хөрөнгийн байдалд өөрчлөлт орох, эсхүл устаж үгүй болох нөхцөл бий болно.

Ийнхүү реституцийн дагуу өгсөн авсан зүйлийг харилцан буцааж өгөх үед эд хөрөнгөд өөрчлөлт орсон нөхцөл байдлын хүрээнд тайлбар хийхэд Иргэний хуулийн 492-496 дугаар зүйлд заасан үндэслэлгүйгээр хөрөнгөжснөөс үүсэх үүргийн зохицуулалтыг хэрэглэдэгтэй холбоотойгоор мөн хуулийн 56 дугаар зүйлийн 56.5 дахь хэсэгт заасан зохицуулалтыг өөрчлөн найруулах боломжтой боловч томьёоллын хувьд өргөн хүрээтэй болохоор байна.

2. Харин хүчин төгөлдөр бус хэлцлийн улмаас хохирол учирсан талд Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.6 дахь хэсэгт зааснаар **хохирол шаардах эрхийг** хуульчлахдаа иргэний эрх зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл болсон гэм буруутай этгээд хариуцлага хүлээхээр заасан боловч уг этгээдийн гэм буруугийн хэлбэрээс шалтгаалж хариуцлагаас чөлөөлөх эсэх зохицуулалт орхигдсон гэж дүгнэхээр байна.

3.Түүнчлэн онолд хүчин төгөлдөр бус хэлцлийн дутагдлыг арилгах[45] эрх зүйн механизмыг хүчин төгөлдөр бус хэлцлийн үр дагаврыг арилгах **тусгай зохицуулалт** гэж үздэг. Хүчин төгөлдөр бус хэлцлийн дутагдлыг арилгах эрх зүйн механизмын үндэс суурь нь үнэнч шударгын зарчимд тулгуурладаг байна. Тусгай зохицуулалтын хүрээнд хууль тогтоогч Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь хэсэгт “.Энэ хуулийн 56.1.2-56.1.4, 56.1.8-д заасан хэлцлийг хийсэн этгээд уг хэлцлээр илэрхийлсэн хүсэл зоригоо хүчин төгөлдөр болохыг хожим хүлээн зөвшөөрч, хуульд заасан хэлбэрээр илэрхийлсэн бол шинээр хийсэнтэй адилтгаж хүчин төгөлдөр хэлцэл гэж үзнэ” гэж томьёолсон. Хууль тогтоогч энэ механизмыг хэрэглэх нөхцөлийг:

A. Хүсэл зоригийн илэрхийллийн алдаа: Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.2 /дүр үзүүлэн хийсэн хэлцэл/, 56.1.3 өөр хэлцлийг халхавчлах зорилгоор хийсэн хэлцэл, 56.1.4 / үнэн санаанаасаа бус, хөнгөмсгөөр хандаж, түүнийгээр илэрнэ гэж урьдаас тооцож, тодорхой хүсэл зориг илэрхийлэн хийсэн хэлцэл/,
B. Хэлцэлд тавигдах хэлбэрийн алдаа: Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.8 /хуулиар тогтоосон хэлбэрийг зөрчсөн, хуульд заасан тохиолдолд зохих этгээдийн зөвшөөрөлгүй хийсэн хэлцэл/ тус тус тодорхойлсон гэж дүгнэж болно.

Харин хэлцлийн нэг тал үүргийг гүйцэтгэсэн, хэлцлийн нэг тал хэлцэлд тавигдах хэлбэрийн шаардлагыг хангуулахаас зайлсхийх зэргийг тооцоогүй байна.

Хэлцлийн дутагдлыг арилгахдаа хэлцлийг шинээр хийсэнтэй адилтгана гэсэн шийдлийг гаргасан боловч цаг хугацааны хувьд алдаатай хэлцлийн анхны огноогоор, эсхүл шинээр адилтгаж алдааг зассан үеэс хэлцэл хүчин төгөлдөр болох талаар огт дурдаагүй байна.

[45] Германы Иргэний эрх зүйн хууль хэрэглээний практикт “Heilung” гэж хэрэглэдэг байна. ХБНГУын Иргэний төрөлжсөн хуулийн 311b зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрт “Энэхүү хэлбэрийн шаардлага хангаагүй гэрээ нь хожим өмчийн хэлцэл хийгдсэн, улмаар шилжүүлгийг улсын бүртгэлд бүртгүүлсэн нөхцөлд бүхэлдээ хүчин төгөлдөр болно” гэж заажээ. ХБНГУ-ын Иргэний хууль /кодификацийн бүрэн эх/, орч. Б.Буянхишиг, Улаанбаатар, “Соёмбо принтинг” 2017, 67 дахь тал

Мөн хууль тогтоогч энэ техникийг хүчин төгөлдөр бус гэж тооцож болох хэлцэлд хэрэглэхгүй гэж тогтоосныг одоогоор буруу гэх үндэслэлийг судлаачид дурдаагүй.

Дээр дурдсан үлдсэн 2 шалгуурын хүрээнд 3 дахь хэсэгт тухайлан дүгнэлт өгөх болно.

Хоёр.Хууль хэрэглээний практик

А. 1963 оны Иргэний хуульд үнэмлэхүй хүчин төгөлдөр бус хэлцлийг "Хүчин төгөлдөр бус хэлцэл" гэх, харьцангуй хүчин төгөлдөр бус хэлцлийг "Сонирхогч этгээдийн нэхэмжлэлээр хүчингүйд тооцож болох хэлцэл" гэж тодорхойлсон нэр томьёо хэрэглэсэн байна. Аль аль ангиллын хүрээнд хамаарах хэлцлийг жагсааж, тус бүрт нь 5 үндэслэлийг оруулахаар тодорхойлсон техник хэрэглэсэн нь 2002 оны Иргэний хуулийн 56.1-д заасан үнэмлэхүй хүчин төгөлдөр бус хэлцлийн зохицуулалтад хадгалагджээ[46].

Харин хүчин төгөлдөр бус хэлцлийн үр дагаврыг арилгахдаа үндэслэл тус бүрт харилцан адилгүй шийдвэрлэсэн. Үр дагаврыг арилгахад улсын орлого болгох иргэний эрх зүйн хариуцлагын талаарх шийдлийг үл харгалзан дүгнэвэл хүчин төгөлдөр бус хэлцэл хийсэн талууд хэлцлийн дагуу авсан зүйлээ харилцан буцаах, боломжгүй бол үнийг төлөх, зарим тохиолдол[47]-д зардал, хохирол арилгуулах зохицуулалттай байжээ.

Б.1994 оны Иргэний хуульд Хүчин төгөлдөр бус хэлцэл /43 дугаар зүйл/, Сонирхогч этгээдийн нэхэмжлэлээр хүчин төгөлдөр бус гэж тооцож болох хэлцэл /44 дүгээр зүйл/ гэсэн 2 ангилал байжээ.

Уг хүчин төгөлдөр бус хэлцлийн үр дагаврыг тус тусад нь зохицуулсан байна. Хүчин төгөлдөр бус хэлцлийн үр дагаврыг сонирхогч этгээд арилгуулахыг шаардах эрхтэй гэсэн ерөнхий агуулгаар тодорхойлсныг 2002 оны Иргэний хуульд дэлгэрүүлж хүчин төгөлдөр бус хэлцлийн дагуу шилжүүлж авсан зүйлийг буцаах, боломжгүй бол үнийн төлөхөөр дэлгэрүүлж зохицуулсан.

Харин харьцангүй хүчин төгөлдөр бус хэлцлийн үр дагаврыг 1994 оны Иргэний хуульд зохицуулахдаа улсын орлогод эд хөрөнгийн хураахаас бусад хэсгийг дүгнэвэл хэлцлээр авсан зүйлсийг талууд хэн алиндаа буцаан шилжүүлэх, шилжүүлэх боломжгүй бол үнийг төлөхөөр заажээ.[48] Энэ зохицуулалтын хүрээнд талууд өгсөн авснаа харилцан буцаах талаар ойлгомжтой тодорхойлогдсон боловч шилжүүлэгдэх эд зүйлс бүрэн хэмжээгээр буюу үр шим, олсон орлого, алдагдал, зардал гэх зэрэг бусад үр дагаврыг тооцохгүй байгаагаараа учир дутагдалтай байжээ.

Энэхүү дутагдлыг 2002 оны Иргэний хуульд залруулаагүй. Харин үүнийг шүүхийн практикаас харвал дэлгэрүүлж тайлбарлаж байна. Жишээлбэл: Монгол Улсын дээд

---

[46] 2002 оны Иргэний хуулийн 56.1 дэх хэсгийн жагсаалт 10 болж өргөжсөн бөгөөд 1962 оны Иргэний хуульд харьцангүй хүчин төгөлдөр бус хэлцэлд хамааруулж байсан зарим үндэслэлийг үнэмлэхүй хүчин төгөлдөр хэлцэлд оруулжээ.

[47] 1963 оны Иргэний хуулийн 35 дугаар зүйл /Эрх олгох, үүрэг бий болгох чадваргүй этгээдийн хийсэн хүчин төгөлдөр бус хэлцлээс үүсэх холбогдол/, 36 дугаар зүйл /Төөрөгдлөөс болж хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус болсноос үүсэх холбогдол/, 37 дугаар зүйл /Хууран мэхлэх, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх буюу гачигдснаас, түүнчлэн төлөөлж байгаа этгээдтэй хорт санаагаар тохиролцон хийсэн хэлцэл хүчингүй болсноос үүсэх холбогдол/, 38 дугаар зүйл /15-аас 18 хүртэлх насны хүмүүсийн хийсэн хэлцэл хүчингүй болсноос үүсэх холбогдол, 39 дүгээр зүйл /өөрийн үйл ажиллагааг ойлгон, зөв удирдаж чадахгүй иргэний хийсэн хэлцэл хүчингүй болсноос үүсэх холбогдол/

шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 001/ХТ2024/00001 тоот тогтоолоор[49] Дундговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 139/ШШ2023/00286 дугаар шийдвэр, Дундговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 218/МА2023/00016 дугаар магадлалтай, И.Б-н нэхэмжлэлтэй Г.Ц-д холбогдох худалдах-худалдан авах гэрээг хүчин төгөлдөр бусд тооцож, байрны үнэ 35,000,000 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлтэй иргэний хэргийг хянажээ. Анхан шатны шүүх талуудын хооронд байгуулагдсан худалдах худалдан авах гэрээг Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.2-т заасан дүр үзүүлэн хийсэн хэлцэл гэж зөв дүгнэж, харин хэлцлээр авсан зүйлийг харилцан буцаан өгөх үүргийн хүрээнд орон сууцыг буцаах боломжгүй /гуравдагч этгээдийн өмчлөлд шилжүүлэгдсэн/ тул үнийг нь төлүүлэхээр шийдвэрлэсэнд хяналтын шатны шүүх уг дүгнэлтэд Иргэний хуулийн 493 дугаар зүйлийн 493.2 дахь хэсэгт заасныг зөрчөөгүй байна гэжээ. Иймд практикт хүчин төгөлдөр бус байх хэлцлийн үр дагаврыг арилгуулах хүрээнд тусгай зохицуулалт хэрэглэсэн гэж дүгнэхээр байна.

В. Харин хүчин төгөлдөр бус хэлцлийн дутагдлыг арилгах зохицуулалтын хүрээнд шүүхийн шийдвэр олоогүй болно.

Гурав.Бусад эрх зүйн зохицуулалттай нийцэж байгаа эсэх

А. Хүчин төгөлдөр бус хэлцэлийн үр дагаврыг шаардах эрхийн хүрээнд:

Хүчин төгөлдөр бус хэлцлийн үр дагавар гэдэгт “ хэлцлээр авсан зүйлийг харилцан буцааж өгөх, өгөх боломжгүй бол үнийг төлөх”-өөр өөр үр дагаврыг хууль тогтоогч тодорхойлоогүй. Иргэний хуулийн 56.6 дахь хэсэгт заасан хохирол шаардах эрх нь хэлцлийн зүйлийг харилцан буцааж өгөх хүрээнд үр шим, орлого болон эд зүйлсд орсон өөрчлөлтийн асуудлыг бүрэн шийдвэрлэхгүйгээс гадна хохирол шаардах эрхэд эсрэг талын гэм буруугийн байдлыг харгалзан үздэг. Иймд гэм буруугүй гэж тооцогдсон тохиолдолд хохирол нөхөн төлөх үүргээс чөлөөлөгдвөл хүчин төгөлдөр бус хэлцлийн дагуу буцаан шилжүүлэгдэх эд хөрөнгөд орсон өөрчлөлтийг хэрхэх асуудал орхигдсон гэж дүгнэнэ.

Талуудын хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус болсон бол уг хэлцлээр хэн алинаасаа шилжүүлж авсан зүйлийн хүрээнд дээр дурдснаар уг зүйлийг өмчлөх, эзэмших эрхийн үндэслэл байхгүй болно. Эд зүйлийг эзэмших, өмчлөх эрхгүй этгээдийн эзэмшлээс жинхэнэ өмчлөгч, эсхүл эзэмшигч өөрийн эд зүйлийг шаардах эрхийг Иргэний хуулийн 106 дугаар зүйлийн 106.1 /эзэмшигч 106.4-өөр дамжиж/ дэх хэсэгт зааснаар эдэлнэ.

Түүнчлэн суурь хэлцэл үгүй болсон бол өмчлөгч, эсхүл хууль ёсны эзэмшигч нь эд зүйлээ шаардах эрхийг Иргэний хуулийн 492-496 дугаар зүйлд зааснаар хэрэгжүүлж болно. Үндэслэлгүйгээр хөрөнгөжнөөс үүсэх үүргийн хүрээнд хууль тогтоогч эд зүйлийг буцаан шилжүүлэх үед тухайн эд зүйлд өөрчлөлт /засан сайжруулсан бол үнэ нь өсөх, үр шим, ашиг олох, ашиглалт явагдсан бол элэгдэл хорогдол бий болох, дахин

[49] https://supremecourt.mn/mn/printc?id=41018, энэ тогтоолд анхан болон давж заалдах шатны шүүхээс шийдвэр гаргахдаа Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 гэсэн ерөнхий зохицуулалтыг баримталсныг хяналтын шатны шүүхээс залруулаагүй байгааг дурдаж, энэ хэсэг судалгаанд хамаарахгүй гэх үүднээс дүгнээгүй болно.

боловсруулагдсан байх г.м/ орсон байдлыг харгалзан шаардах эрхийн хүрээг нарийвчлан тодорхойлсон байдаг.

Иймд хэлцэл хүчин төгөлдөр бус болсноос үүсэх бусдын эзэмшилд үндэслэлгүйгээр байгаа эд зүйлээ өмчлөгч. эсхүл хууль ёсны эзэмшигчийн шаардах эрх Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.5, 106 дугаар зүйлийн 106.1, 492-496 дугаар зүйлд зааснаар үүсч буй тул хууль хэрэглээний хувьд өрсөлдөх зохицуулалтууд болжээ.

Б. Хүчин төгөлдөр бус хэлцлийн улмаар учирсан хохирлын зохицуулалтын хүрээнд өрсөлдөх хэм хэмжээ байхгүй гэж дүгнэлээ.

В. Түүнчлэн хүчин төгөлдөр бус хэлцлийн дутагдлыг арилгах зохицуулалтын хүрээнд өрсөлдөх хэм хэмжээ байхгүй гэж дүгнэлээ.

Дөрөв.Харьцуулсан судалгаа

А.ОХУын Иргэний хуулийн зохих заалтуудтай харьцуулсан судалгаа

1. ОХУ-ын 1994 оны Иргэний хууль[50]д хүчин төгөлдөр бус байх хэлцлийг үнэмлэхүй болон харьцангүй хүчин төгөлдөр бус хэлцэл гэж ангилдаг. ОХУ-ын Иргэний хуулийн 166 дугаар зүйлд хүчин төгөлдөр хэлцэл нь маргаж болох буюу шүүхэд нэхэмжлэл гаргаж хүчин төгөлдөр бус тооцуулдаг /оспоримая сделка/ болон анхнаасаа хүчин төгөлдөр бус байх /ничтожная сделка/ хэлцлийн ангиллыг зааж, тус бүрт нь тодорхойлолт өгчээ.

Мөн хуулийн 167 дугаар зүйлд хүчин төгөлдөр бус хэлцлийн үр дагаврын нийтлэг зохицуулалтыг тодорхойлсон нь хууль хэрэглээний хувьд тодорхой байхаас гадна иргэд, хуулийн этгээдэд хуулийг таниж мэдэх, хэрэгжүүлэхэд ойлгомжтой байх байдлыг хангасан, оновчтой шийдэл болжээ.

Хүчин төгөлдөр бусд тооцуулах хэлцлийн үндэслэлийн талаар мэдэж байсан эсхүл мэдэх боломжтой байсан талыг хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцуулсны дараа ч түүнийг үйлдэлдээ үнэнч шударга хандаагүй гэж хуульд тодорхойлсон байдаг нь хүчин төгөлдөр бус хэлцлийн институтын зорилгыг хангасан байна. Холбогдох шууд зохицуулалт[51] манай Иргэний хуульд байхгүй болно.

Түүнчлэн ОХУ-ын Иргэний хуульд хүчин төгөлдөр бус байх хэлцлийн зохицуулалтыг жагсаалтаар шийдвэрлээгүй, харин үндэслэл бүрийг тухайлан зохицуулж, урьдчилсан нөхцлийг тодорхойлсноор нэмэлт тайлбар төдийлэн шаардагдахгүй байх байдлыг хангасан.

2. ОХУ-ын Иргэний хуулийн 167 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт хүчин төгөлдөр бус хэлцлийн үр дагаварыг арилгах зохицуулалт нь манай Иргэний хуулийн 56.5 дахь хэсэгт заасантай ижил боловч буцаан шилжүүлэх зүйлийг натураар буюу бодитоор шилжүүлэх гэж тодорхойлсоноос гадна хаалтанд шилжүүлэх зүйлд эд хөрөнгийн ашиглалт, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээ хамаарахаар дэлгэрүүлсэн байна.

[50] ОХУ-ын Иргэний хууль гэсэн нэр томьёог хэрэглэв. Уг нь Иргэний кодекс учир төрөлжсөн хууль гэж хэрэглэх нь зохимжтой

[51] Холбогдох шударга бус үйлдлийг Монгол Улсын Иргэний хуулийн 13 дугаар зүйлд зааснаар тайлбарлах боломжтой боловч хүчин төгөлдөр бус хэлцлийн институтын хүрээнд зохицуулах нь Иргэний хуулийн 13 дугаар зүйлд заасан үнэнч шударгын зарчмыг дэмжих, дэлгэрүүлэх зохицуулалт болох учиртай.

Мөн реституцийг хэрэглэхгүй байх нөхцөлийг хууль болон ёс суртахууны үндсэн зарчимд харшилсан бол гэж тодорхойлсон нь оновчтой гэж үзэхээр байна. Холбогдох зохицуулалт манай Иргэний хуульд байхгүй болно.

3. Хүчин төгөлдөр бус хэлцлийн дутагдлыг арилгах талаарх ОХУ-ын Иргэний хуулийн холбогдох зохицуулалтууд ойлгомжтой тодорхойлогджээ. Жишээлбэл: ОХУ-ын Иргэний хуулийн 172 дугаар зүйл “14 нас хүрээгүй этгээдийн хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байх”-ийн 2 дахь заалтад 14 насанд хүрээгүй этгээдийн хийсэн хэлцэл тэдгээрийн ашиг сонирхолд нийцэж байвал уг хэлцлийг түүний эцэг эх, үрчилсэн этгээд эсхүл асран хамгаалагчийн шаардлагаар шүүх хүчин төгөлдөр гэж хүлээн зөвшөөрч болдог байна.

Б. ХБНГУ-ын Иргэний төрөлжсөн хуулийн зохих заалтуудтай харьцуулсан судалгаа

1. ХБНГУ-ын Иргэний төрөлжсөн хуульд хүчин төгөлдөр бус хэлцлийн ангиллыг хэрэглээгүйгээс гадна хүчин төгөлдөр бус хэлцлийн талаар тусгайлан бүлэг, хэсэг гаргаж зохицуулаагүй. Уг хуулийн 3 дахь хэсэг “Хэлцэл”-д 1.Эрх зүйн чадамж, 2.Хүсэл зоригийн илэрхийлэл, 3.Гэрээ, 4.Нөхцөл болон хугацаа, 5.Төлөөлөл болон эрх хэмжээ, 6.Урьдчилсан болон дараа өгөх зөвшөөрөл гэж хуваасан дэд хэсгүүдэд холбогдох зохицуулалтын хүрээнд хэлцэлийн дутмагшил бий болсон тохиолдол бүрийг зохицуулсан байна. Жишээлбэл: эрх зүйн чадамжийн талаар зохицуулсан 104-110 дахь заалтуудын хүрээнд 105 дугаар зүйлд эрх зүйн чадамжгүй этгээдийн хүсэл зоригийн илэрхийлэл хүчин төгөлдөр бус; 107 дугаар зүйлд 7-оос дээш насны хүүхдийн хийх хэлцэл хүчин төгөлдөр болох нь түүний хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрлөөс хамаарах гэх зэргээр зохицуулсан бол 116-144 дүгээр зүйлд зохицуулсан “Хүсэл зоригийн илэрхийлэл” хэсэгт: 125 дугаар зүйлд хуулиар тогтоосон хэлбэрийн шаардлага хангаагүй хэлцэл хүчин төгөлдөр бус гэх зэргээр байршуулсан. Иймд холбогдох зохицуулалт тус бүрийн хүрээнд хэлцлийн хүчин төгөлдөр эсэх асуудлыг зохицуулах эсхүл ОХУ болон манай улсын Иргэний хуульд хүчин төгөлдөр бус хэлцлийг тусгайлан зохицуулах эсэх бол хууль тогтоогчийн шийдэл болно. Иймд ХБНГУ-ын Иргэний төрөлжсөн хуулийн системчлэлийг илүү гэж үзээгүй болно.

2. ХБНГУ-ын Иргэний төрөлжсөн хуульд хүчин төгөлдөр бус хэлцлийг ангилаагүйгээс гадна түүний үр дагаврыг арилгахад үндэслэлгүйгээр хөрөнгөжихөөс үүсэх үүргийн хүрээнд зохицуулсан байна.

Харин хүчин төгөлдөр бус хэлцлийн улмаас холбогдох этгээдэд хохирол учирсан бол хүчин төгөлдөр бус хэлцлийн зохицуулалтын дараагийн заалтаар уг хохирлыг арилгуулахыг шаардах эрхийг олгосон заалтыг системчлэлийн хүрээнд байршуулсан байна. Жишээлбэл: Хүсэл зоригийн илэрхийллийн дутмагшлаас хэлцэл хүчин төгөлдөр бус болсон /хуулийн 116 нуугдмал алдаа, 117 дүр үзүүлэн хийсэн хэлцэл, 118 үнэн санаанаасаа бус хийсэн хэлцэл/-той холбоотойгоор хохирол учирсан бол хуулийн 112 дугаар зүйлд шаардах эрхийг олгосон байна.

3. Харьцуулсан судалгааны хүрээнд хүчин төгөлдөр бус хэлцлийн дутагдлыг арилгасан заалтыг жишээ болгон дурдвал: ХБНГУ-ын Иргэний төрөлжсөн хуулийн 311b зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрт “Энэхүү хэлбэрийн шаардлага хангаагүй гэрээ нь хожим өмчийн хэлцэл хийгдсэн, улмаар шилжүүлгийг улсын бүртгэлд бүртгүүлсэн нөхцөлд бүхэлдээ хүчин төгөлдөр болно” гэж заажээ. Иймд Иргэний хуулийн 56 дугаар

зүйлийн 56.3 дахь хэсгийн зохицуулалтад цаг хугацааг тодруулж тусгах шаардлага байна.

Тав.Ерөнхий дүгнэлт, санал

1.Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.3, 56.5, 56.6 дахь зүйлүүдийг хүчин төгөлдөр бус хэлцлийн нийтлэг зохицуулалтын хүрээнд тусад нь өөр заалтаар зохицуулах.

2.Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.5 дахь хэсэгт хүчин төгөлдөр бус хэлцлийн үр дагаврыг үндэслэлгүйгээр хөрөнгөжсөнтэй холбоотой заалтын дагуу гаргуулах эрхтэй гэж томьёолох.

3.Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь хэсэгт заасан хүчин төгөлдөр бус байх хэлцлийн дутагдлыг арилгуулах ерөнхий зохицуулалтай холбоотойгоор нарийвчилсан зохицуулалтуудыг үүргийн эрх зүйн хүрээнд нэмж зохицуулах.

II. Тодорхой төрлийн хүчин төгөлдөр бус хэлцлийн талаар

Нэг.Хууль хэрэглээний практик

Энэ хэсэгт хүчин төгөлдөр бус хэлцлийн төрлүүдээс сонгож дүгнэлт хийлээ.

А. Хэлцэл агуулгын хувьд дутагдалтай байх тохиолдолд хууль зөрчсөн буюу нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан /Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.1/ хэлцэлд орно. Үндэслэл бүрийг тусад нь авч үзье.

а. Хууль зөрчсөн хэлцэл

Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.1-д хууль зөрчсөн хэлцэл хүчин төгөлдөр байхаар зохицуулжээ. Шүүхэд хэлцлийг хууль зөрчсөн хүчин төгөлдөр бус байх үндэслэлээр нэхэмжлэл гаргах явдал ихэссэн. Ингэснээр иргэний гүйлгээ тогтвортой байх, урьдчилан таамаглах боломжтой байх нөхцөл хөндөгдөнө. Иймд Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.1-д заасан “хууль зөрчсөн” гэх үндэслэлийг тодруулах шаардлагатай.

Иргэний эрх зүйн харилцааг хэлцлийн үндсэн дээр үүсэхэд тавигдах шаардлага нь хуульд заасан хэлцлийг хийх, эсхүл агуулгын хувьд хуульд харшлахгүй хэлцэл хийх байдал юм. Монгол Улсын дээд шүүхийн 2010 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн “Иргэний хуулийн 5, 6, 7 дугаар бүлгийн зарим зүйл, заалтын тайлбарлах тухай” 17 дугаар тогтоол[52]-ын 5.1-д “Хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.1.-д заасан "хууль зөрчсөн" гэж хуулийн хориглох хэм хэмжээг зөрчсөн, эсхүл хуулийн шаардлагыг хангаагүй хэлцэл хамаарах ба энэ зөрчил нь хэлцлийн эрх зүйн үндэслэлтэй байх зарчимд нийцэхгүй байхыг хэлнэ” гэж тайлбарлажээ.

Түүнчлэн Иргэний хуулийн тайлбар[53]аас үзвэл хуулиар хориглосон зүйл хэлцлийн обьект болохгүй байна. Жишээлбэл: иргэний гүйлгээнээс хасагдсан эд юмс дээр иргэд

[52] https://legalinfo.mn/mn/detail?lawId=16468170319731
[53] Ё.Кают нар, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/ Улаанбаатар, Интерпресс, 2005 он, 202 дахь тал

хэлцэл хийж болохгүй. Иймд хэлцлийг хуулиар хориглодоггүй, харин хуулиар хориглосон эд зүйл дээр хэлцэл хийхийг зөвшөөрдөггүй[54] байна.

Улмаар хууль зөрчсөн биш харин хуулийн хориглолтыг /хорио/ зөрчсөн хэлцэл хүчин төгөлдөр бус байх талаар судлаачид үндэслэл гаргаж тайлбарлаж байгаагаас гадна гадаад улсын хуульд ч мөн утгаар томьёолжээ. Энэ утгаар Герман улсын Иргэний төрөлжсөн хуулийн 134 дүгээр зүйлд "Хуулийн хориг зөрчсөн хэлцэл хүчин төгөлдөр бус байна" /Ein Rechtsgeschäft, das gegen ein gesetzliches Verbot verstößt, ist nichtig, wenn sich nicht aus dem Gesetz ein anderes ergibt/[55] гэж зохицуулжээ. Австри улсын Иргэний төрөлжсөн хуулийн 879 дүгээр зүйлийн 1. (1)-д "Хуулийн хориглолт эсхүл ёс суртахуун зөрчсөн гэрээ хүчин төгөлдөр бус байна" /Ein Vertrag, der gegen ein gesetzliches Verbot oder gegen die guten Sitten verstößt, ist nichtig/[56] гэж тус тус заасан байна.

Дээрх зохицуулалтуудаас үзвэл хүчин төгөлдөр бус байх хэлцлийн талаарх хэд хэдэн дүгнэлт хийж болно. Нэгдүгээрт, хуулийн императив заалтыг зөрчсөн хэлцэл бус харин хуульд тодорхой заасан хориглолтыг зөрсөн байх, хоёрдугаарт хуулийн хорионы заалт нь зарчмын хувьд үл зөвшөөрөгдөх үйлдэл тогтоосон байх[57] гэж тодорхойлно.

Харин Монгол Улсын дээд шүүхийн тайлбараас Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.1-д заасан "хууль зөрчсөн" хэлцэлд "[эсхүл] хуулийн шаардлагыг хангаагүй хэлцэл…"-ийг хамааруулж тайлбарласныг практикт төдийлэн хэрэглэхгүй байгааг дурдах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл хуулийн шаардлага хангаагүй хэлцэлд агуулга болон хэлбэрийн аль шаардлага хамаарахыг тайлбарлаагүйгээс гадна Иргэний хуулийн 56.1 дэх хэсэгт тухайлан заасан агуулгын болон хэлцлийн шаардлага хангаагүйгээс хэлцэл хүчин төгөлдөр бус байх зохицуулалттай давхцсан эсхүл энд нэрлэн заагдаагүй бусад ямар хэлцэл байж болохыг дэлгэрүүлэн тайлбарлаагүй болно.

б. Нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан хэлцэл

Мөн Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.1-д зохицуулсан. Нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан хэлцлийг "Хууль зөрчсөн" хэлцэлтэй хамт нэг жагсаалтад өгөгдсөн байгаа ба тэдгээрийг тусад нь зохицуулах нь зохимжтой. Харин томьёоллын хувьд Герман улсын Иргэний төрөлжсөн хуулийн 138 дугаар зүйл[58], Австри улсын Иргэний төрөлжсөн хуулийн 879 дүгээр зүйл[59]-д ижил төстэйгээр зохицуулсан байна.

Энэ хэм хэмжээний хувьд хэрэглээний хүндрэл практикт гараагүй. Шинжлэх ухааны тайлбар, сурах бичиг[60]т хууль хэрэглээний тайлбарыг өргөн хүрээгээр өгсөн байна.[61]

[54] Мөн тэнд
[55] https://www.gesetze-im-internet.de/bgb/__134.html
[56] https://www.jusline.at/gesetz/abgb/paragraf/879
[57] Ё.Кают нар, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/ Улаанбаатар, Интерпресс, 2005 он, 202 дахь тал
[58] https://www.gesetze-im-internet.de/bgb/__138.html
[59] https://www.jusline.at/gesetz/abgb/paragraf/879
[60] Т.Мэндсайхан,Гэрээний эрх зүй, Улаанбаатар, 2021
[61] Ё.Кают нар, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/ Улаанбаатар, Интерпресс, 2005 он, 203-206 дахь тал

Б. Дараах хэлцлүүдийг Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэгт заасан хүчин төгөлдөр бус байх хэлцэл гэхээс илүүтэйгээр хүчин төгөлдөр бусд тооцох хэлцэлд хамааруулан зохицуулах нь зүйтэй.

Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.2-т “дүр үзүүлэн хийсэн хэлцэл”, 56.1.3-т “өөр хэлцлийг халхавчлах зорилгоор хийсэн хэлцэл”, 56.1.4-т “үнэн санаанаасаа бус, хөнгөмсгөөр хандаж, түүнийгээ илэрнэ гэж урьдаас тооцож, тодорхой хүсэл зориг илэрхийлэн хийсэн хэлцэл”, 56.1.8-д хуулиар тогтоосон хэлбэрийг зөрчсөн, хуульд заасан тохиолдолд зохих этгээдийн зөвшөөрөлгүй хийсэн хэлцлийг нэрлэн заасан байна.

Энд нэрлэн заасан хэлцлийг хийсэн этгээд уг хэлцлээр илэрхийлсэн хүсэл зоригоо хүчин төгөлдөр болохыг хожим хүлээн зөвшөөрч, хуульд заасан хэлбэрээр илэрхийлсэн бол шинээр хийсэнтэй адилтгаж хүчин төгөлдөр хэлцэл гэж үзэхээр мөн хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь хэсэгт заажээ. Өөрөөр хэлбэл, дээрх хэлцлүүд дэх алдаа, дутагдлыг залруулах боломжтой байна.

а.Түүнчлэн Монгол Улсын Иргэний хуулийн тайлбарт Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.2-т заасан дүр үзүүлэн хийсэн хэлцлийн эрх зүйн үр дагаврыг хэлцлийг хийхэд хууран мэхэлсэн /Иргэний хуулийн 59 дүгээр зүйл/, эсхүл ноцтой төөрөгдөл /Иргэний хуулийн 58 дугаар зүйл/-ийн улмаас хэлцэл хийгдсэн бол хүчин төгөлдөр бусд тооцуулах шаардах эрхтэй[62] гэж тайлбарлагдсан байдлаас дүгнэвэл онолын ангиллаар уг хэлцэл харьцангуй хүчин төгөлдөр бус хэлцэлд хамаарагдана гэсэн дүгнэлтэд хүрлээ.

б.Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.4-т үнэн санаанаасаа бус, хөнгөмсгөөр хандаж, түүнийгээ илэрнэ гэж урьдаас тооцож, тодорхой хүсэл зориг илэрхийлэн хийсэн хэлцлийг хүчин төгөлдөр бус байхаар зохицуулжээ.

Хүсэл зоригийн илэрхийллийг хүлээн авч буй талд уг хүсэл зоргийн илэрхийлэл шударга, зохих ёсоор ойлгох боломжтой байхаар илэрхийлэгдэх ёстой. Гэтэл хүсэл зориг илэрхийлж буй тал хөнгөмсөг, хайхрамжгүй хандаж буйг хүсэл зоргийг хүлээж авч буй тал хэрхэн таамаглаж ойлгох нь асуудал юм. Иймд судлаачид хөнгөмсөг, хайхрамжгүй хандаж буй нь бодитой илэрхий байх тохиолдолд хэлцэл хүчин төгөлдөр бус байх боломжтой, харин хөнгөмсөг, хайхрамжгүй хандаж байгаа нь илэрхий бус байх тохиолдолд уг хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцуулах хэлцэлд хамааруулах санал[63] гаргаж байгааг үндэслэлтэй гэж үзэж байна.

г.Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.8-д “хуулиар тогтоосон хэлбэр зөрчсөн, хуульд заасан тохиолдолд зохих этгээдийн зөвшөөрөлгүй хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байх” 2 урьдчилсан нөхцөлийг тодорхойлжээ.

1.Хуулиар тогтоосон хэлбэр зөрчсөн хэлцлийн талаар

1.1. Бичгийн хэлбэр зөрчсөн хэлцэл

Монгол Улсын дээд шүүхийн 2010 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн “Иргэний хулийн 5, 6, 7 дугаар бүлгийн зарим зүйл, заалтын тайлбарлах тухай” 17 дугаар тогтоол -ын 5.5-д “Мөн зүйлийн 56.1.8-д заасан "хуулиар тогтоосон хэлбэрийг зөрчсөн" гэдэг нь

[62] Ё.Кают нар, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/ Улаанбаатар, Интерпресс, 2005 он, 209 дэх тал
[63] Ё.Кают нар, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/ Улаанбаатар, Интерпресс, 2005 он, 211 дэх тал

хуулийн 42 дугаар зүйлийн 42.10-т заасан шаардлагад хамааралтай ба энэхүү хэлбэрийн шаардлагад энгийн бичгийн хэлбэрээс гадна нотариатаар болон эрх бүхий этгээдээр гэрчлүүлэх, улсын бүртгэлд бүртгүүлэх хэлбэрийг мөн хамааруулан үзнэ" гэж өргөн хүрээгээр тайлбарласан.

Иргэний хуулийн 64.2 итгэмжлэл, 132.2 гэрлэгчийн хөрөнгийн эрхтэй холбогдсон гэрээ, 156.3 барьцааны гэрээ, 313.3 санхүүгийн түрээсийн гэрээ, 318.3 түрээсийн гэрээ, 411.10 зуучлах онцгой эрхийн гэрээ, 431.3 даатгалын гэрээ, 523.3 гэрээслэлийг бичгээр хийгээгүй тохиолдолд хүчин төгөлдөр бус байхаар хуульд тухайлан заасан тул эдгээр гэрээ, хэлцлийг дахин Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.1-д зааснаар хүчин төгөлдөр бус байх хэлцэл гэж дүгнэх шаардлагагүй. Үүнийг баталж Иргэний хуулийн 42.10 дахь хэсэгт бичгээр хийх хуулийн шаардлагыг биелүүлээгүй хэлцэл хүчин төгөлдөр бус байхаар хуульд заасан бол хэлцэл хүчин төгөлдөр бус байна гэж тодруулсан зохицуулалтыг хийсэн байна.

Мөн Иргэний хуулийн 232.7 анз, 263.3 зээлээр худалдах худалдан авах гэрээ, 282.3 зээлийн хүүгийн талаар гэрээг бичгээр байгуулаагүй бол шаардах эрхийг алдахаар зохицуулсан тул тэдгээрийн хүчин төгөлдөр байдлын талаар маргах шаардлагагүй.

Түүчлэн зарим тохиолдолд буюу хэлбэрийн шаардлагыг зөрчсөн атлаа үүргийг гүйцэтгэсэн бол хуульд заасан тодорхой хэлбэрэр гэрээ хийхийг шаардахгүй гэж Иргэний хуулийн 199.3 дахь хэсэгт заасан.

Иргэний хуулийн 234.2 баталгааны гэрээ, 235.5 фидуци, 279.4 тусгай зориулалттай хисэн бэлэглэлийн гэрээ, 294.6 орон сууц хөлслөх гэрээг цуцлах шаардлага, 296.2 орон сууц хөлслөх гэрээний хугацаа сунгах хүсэлт, 330.3 хөдөө аж ахуйн зориулалттай газрын түрээсийн гэрээний хугацаа сунгах тухай санал болон татгалзал, 335.1 франчайз, 338[1].2 мерчендайз, 384.2 тээвэрлэлийн гэрээний зүйл болох ачааны доголдлын талаар гаргах гомдлын шаардлага, 406.2 хөрөнгө итгэмжлэх гэрээ, 408.3 илгээмжийн гэрээнээс татгалзах татгалзал, 402.2 зээлийн гэрээнд зуучлах гэрээ, 419.3 комисс, худалдааны төлөөлөгч тусгай шагнал авахад урьдчилан гаргах баталгаа, 451.2 банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээс олгох зээлийн гэрээ, 454.3 хадгаламжийн гэрээ, 457.5 банкны баталгааны дагуу мөнгөн төлбөр төлөхийг шаардах, 459.1 батлан даалтын гэрээ, 483.4 асран тэтгэх гэрээ зэргийг бичгээр хийх талаар хуульд заасан боловч бичгээр хийгээгүй тохиолдолд уг хэлцэл, гэрээг хийсэн эсэх[64]ийн талаар маргаан гарч болох бөгөөд энэ тохиолдолд Иргэний хуулийн 42.11 дэх хэсэгт зааснаар гэрчээр нотлуулахаас өөр нотлох баримтаар нотлосон тохиолдолд хүчин төгөлдөр гэж тооцно.

Дээрхээс дүгнэвэл хуульд хүчин төгөлдөр бус гэж шууд зааснаас бусад бичгээр хийх хэлцэлийн хувьд маргаан гарвал хүчин төгөлдөр бусад тооцуулах техник хэрэглэхээр байна.

1.2. Нотариат болон бусад этгээдээр гэрчлүүлэх хэлбэр зөрчсөн хэлцэл

Нотариатчаар гэрчлүүлэх шаардлагыг зөрчсөн хэлцэлийн үүргийг бүрэн буюу ихэнхийг гүйцэтгэсний дараа нөгөө тал үүнийг зөвшөөрсөн боловч хэлцлийг нотариатчаар гэрчлүүлэхээс татгалзвал үүрэг гүйцэтгэсэн талын нэхэмжлэлээр шүүх хэлцлийг хийсэнд тооцоно.

[64] Ё.Кают нар, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/ Улаанбаатар, Интерпресс, 2005 он, 152 дэх тал

1.3. Улсын бүртгэлд бүртгүүлэх хэлбэр зөрчсөн хэлцэл

2. Зохих этгээдийн зөвшөөрөлгүй хийсэн хэлцэл

Монгол Улсын дээд шүүхийн 2010 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн “Иргэний хуулийн 5, 6, 7 дугаар бүлгийн зарим зүйл, заалтын тайлбарлах тухай” 17 дугаар тогтоол -ын 5.5-д "зохих этгээдийн зөвшөөрөлгүй хийсэн хэлцэл" гэдэгт тухайн хэлцлийг хийхэд тодорхой этгээдийн зөвшөөрлийг авах хуулиар тогтоосон шаардлага зөрчигдсөн байхыг ойлгох бөгөөд уг хэлцэлд хуулийн 50 дугаар зүйлийн зохицуулалт хамаарна”гэжээ.

Иргэний хуулийн 50.1 дэх хэсэгт хэлцэл хүчин төгөлдөр байх зайлшгүй нөхцөл болсон зөвшөөрөл олгох эрх, үүрэг бүхий гуравдагч этгээд уг зөвшөөрлийг олгосон буюу олгохоос татгалсан тухайгаа хэлцэлийн талуудад нэгэн адил мэдээлнэ гэжээ. Энэ хэм хэмжээнд зөвшөөрөл олгох эрх, үүрэг бүхий гуравдагч этгээдийг хуулиар тодорхойлохоор заах байсныг орхигдуулсныг Монгол Улсын дээд шүүхийн тайлбараар хийдлийг нөхсөн байна.

Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд нь иргэн болон хуулийн этгээдийн эрх бүхий этгээд байна. Иймд тус тусад нь дүгнэлт өгнө.

2.1. Зөвшөөрөл олгох зохих этгээд нь иргэн байх тохиолдол

Хуульд зааснаар гуравдагч этгээд-иргэний зөвшөөрлийн хүрээнд Иргэний хуулийн 54 дүгээр зүйлд заасан насанд хүрээгүй иргэний зөвшөөрөлгүй хийсэн хэлцэлд хамаарахаар байна. Хэлцэл хийсэн нөгөө тал насанд хүрээгүй иргэнтэй хэлцэл хийснийг мэдсэн, мэдэх боломжтой байхаас хэлцлийн хүчин төгөлдөр байдал шалтгаална.

2.2. Зөвшөөрөл олгох зохих этгээд нь хуулийн этгээд байх тохиолдол

Хуулийн этгээд зохих этгээдийн зөвшөөрөлгүйгээр хэлцэл хийсэн гэх нөхцөлд хуулийн этгээдийг хэлцэлд төлөөлөх этгээд /иргэн, хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар, итгэмжлэлээр эрхийг шилжүүлсэн хуулийн этгээд гэх зэргээр аль нь ч байж болно/ өөрт нь тухайн эрх хэмжээ олгогдоогүй эсхүл олгогдсон эрх хэмжээг хэтрүүлэх байдал хамаарна. Энэ нөхцөл байдал хуулийн этгээдийн дотоод зохион байгуулалттай холбоотой. Уг нөхцөл байдлыг хэлцэлд оролцогч талд мэдэх боломжгүй тохиолдолд эрх, ашиг сонирхлыг нь хамгаалах учиртай бөгөөд эсрэгээрээ энэ талаар мэдсэн, мэдэх боломжтой нөхцөлд хэлцэл хийгдсэн бол хэлцэл хүчин төгөлдөр гэж маргах эрхгүй байхаар нарийвчлан заах шаардлагатай. Иймд хэлцэл хийгч нөгөө тал хэлцэл хийгч этгээд зөвшөөрөл авах байсантай холбоотойгоор хэлцлийн хүчин төгөлдөр байдлыг тогтоох бол харьцангүй хүчин төгөлдөр хэлцлийн хүрээгээр тодорхойлох нь зүйтэй.

В. Хүчин төгөлдөр бус байх хэлцэл болон хүчин төгөлдөр бусд тооцох хэлцлийн талаар нэхэмжлэл гаргах этгээдийг хууль тогтоогч “сонирхогч этгээд” гэх нэр нэр томьёоны техник хэрэглэжээ.

Монгол Улсын дээд шүүхийн 2010 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн “Иргэний хулийн 5, 6, 7 дугаар бүлгийн зарим зүйл, заалтын тайлбарлах тухай” 17 дугаар тогтоол -ын 5.8-д “Энэ зүйлийн 56.3, 57 дугаар зүйлийн 57.3-т заасан "сонирхогч этгээд" гэдэгт хэлцэл хийсэн тал эсхүл гуравдагч этгээдийн аль аль нь хамаарна” гэж тайлбарлажээ. Уг тогтоолд заасан Иргэний хуулийн 56.3 гэснийг 56.4 гэж ойлгохоор байна. Учир нь

Иргэний хуулийн 56.3 дахь хэсэгт сонирхогч этгээдийн талаар дурдагдаагүй, харин 56.4 дэх хэсэгт хүчин төгөлдөр бус хэлцлийн үр дагаврыг арилгуулахаар шаардах эрхтэй этгээдийг сонирхогч этгээд гэж тодорхойлсон байгааг тэмдэглэх нь зүйтэй. Иймд цаашид хийх дүгнэлт Иргэний хуулийн 56.4 дэх хэсэгт заасан “сонирхогч этгээд”-д мөн хамаарна.

Үүнд хэлцэл хийсэн талуудаас гадна эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн гуравдагч этгээд гаргах боломжтой.

Хоёр.Ерөнхий дүгнэлт, санал

1. Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.1-д заасан “хууль зөрчсөн хэлцэл” гэх томьёоллыг “хуулиар хориглосон” гэж өөрчлөх.
2. Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.1-д заасан “нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг зөрчсөн хэлцэл”-ийг “хууль зөрсөн хэлцэл”-ийн зохицуулалтаас тусад нь зохицуулах.
3. Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.2-т “дүр үзүүлэн хийсэн хэлцэл”, 56.1.3-т “өөр хэлцлийг халхавчлах зорилгоор хийсэн хэлцэл”, 56.1.4-т “үнэн санаанаасаа бус, хөнгөмсгөөр хандаж, түүнийгээ илэрнэ гэж урьдаас тооцож, тодорхой хүсэл зориг илэрхийлэн хийсэн хэлцэл”, 56.1.8-д хуулиар тогтоосон хэлбэрийг зөрчсөн, хуульд заасан тохиолдолд зохих этгээдийн зөвшөөрөлгүй хийсэн хэлцлүүдийг хүчин төгөлдөр бусд тооцох хэлцэлд хамааруулах.

III.Бусад асуудал

Нэг.Хууль хэрэглээний практик

А. “Сонирхогч этгээд” хүчин төгөлдөр бус байх хэлцлийн хүрээнд өргөн хүрээгээр буюу хэн ч байж болохоор /ИХ56.4/ тайлбарлагддаг бол хүчин төгөлдөр бусд тооцуулах хэлцэлд /ИХ58.7- хэлцлийн талууд, гуравдагч этгээд, ИХ 58.3, 58.4-гуравдагч этгээд, сонирхогч этгээд/ харьцангуй явцуу хүрээгээр тайлбарлагдаж байна.

Б.Хөөн хэлэлцэх хугацааны талаарх асуудал нь анхаарал татсан, бэрхшээлтэй асуудал байдаг. Онолын хувьд ч хүчин төгөлдөр бус хэлцэл хөөн хэлэлцэх хугацаанаас хамаарч хүчинтэй болох талаар дурдаагүй байдаг. Герман улсад “эрх байхгүй болсон” /die Verwirkung/ гэх онол, англи америкийн эрх зүйн системд процессын татгалзах эрхийг хязгаарлах /Estoppel/ гэх онолыг үндэслэн шүүх нь хүчин төгөлдөр бус хэлцэл гэж эш татаж тайлбар гаргах талуудын эрхийг хязгаарладаг байна. Эдгээр үр дагавар нь хэлцэл хийгдээд тодорхой цаг хугацаа өнгөрсөн, эсхүл хэлцэл хийгч тал нь өмнө нь нөгөө талдаа хэлцлийг хүчин төгөлдөр гэдгийг зөвшөөрсөн үндэслэлийг ойлгуулж байсантай холбож тайлбарлагддаг байна.

В. Хүчин төгөлдөр бус байх хэлцэл /ИХ-ийн 56/-ийн зохицуулалтад хөөн хэлэлцэх хугацааны талаар зохицуулаагүй тул ИХ-ийн 75 дугаар зүйлийн 75.1-д заасан ердийн хөөн хэлэлцэх хугацаа 10 жил байх хугацааг хэрэглэж байна. Харин хүчин төгөлдөр бус гэж тооцож болох ИХ-ийн 58.6-д нөгөө талдаа “нэн даруй” мэдэгдэх, 59.1-д хууль заасан үндэслэл байгааг мэдснээс хойш нэг жилийн дотор нөгөө талдаа гомдлын шаардлага гаргах, 60.3-т заасан нөхцлийн хүрээнд хэлцэл хийснээс хойш эсрэг талдаа 1 жилийн дотор гомдлын шаардлага гаргах гэсэн хугацаануудыг зохицуулжээ.

Иймд шүүхээс хэлцэл хүчин төрөлдөр бусд тооцуулах хөөн хэлэлцэх хугацаанууды “нэн даруй”, нэг жилийн дотор гомдлын шаардлага гаргаснаас хойш ИХ-ийн 75.1 дэх хэсэгт заасан ерөнхий хугацаа болох 10 жилийг тоолохоор байна.

Хоёр.Ерөнхий дүгнэлт, санал

1. “Сонирхогч этгээд”-үүдийн эрх, ашиг сонирхол хөндөгдсөн гэх шалгууураар хүчин төгөлдөр бус хэлцлийн үр дагаврыг шаарддаг байгаар зохицуулах.
2. Хөөн хэлцэлцэх хугацааг хүчин төгөлдөр бус хэлцлийн агуулгаас хамаарч өөр өөрөөр зохицуулах. Жишээ нь: ИХ-ийн 75.1-д заасан 10 жилийн хугацаанаас богино буюу 3 жил болгох, мөн хэлцэл биелэгдээд 3 жил болсон бол хөөн хэлэлцэх хугацаа байхгүй байх г.м.

ДОЛДУГААР БҮЛЭГ. ТӨЛӨӨЛӨЛ

Судалгааны энэ хэсэгт Иргэний хуулийн долдугаар бүлэгт зохицуулсан төлөөллийн асуудлын 63, 65, 68, 70 зүйлд дүн шинжилгээ хийж өнөөгийн нөхцөл байдлыг судалж, практикт тулгарч буй хүндрэл бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэн ололтыг бататган дүгнэх цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтын боломжит хувилбарыг тодорхойлох, Арилжааны хуульд тухайн харилцаа хэрхэн тусгагдах зэрэг асуудлыг хөндөн ерөнхий санал, зөвлөмж боловсруулаа.

2002 оны ИХ-д төлөөлөл гэх ойлголтыг тодорхойлоогүй ч хэлцлийг төлөөлөгчөөр дамжуулан хийхийг хуульчилсан байна. Өөрөөр хэлбэл хэн нэгэн этгээд бусдын нэрийн өмнөөс хэлцэл хийхийг төлөөлөл гэж ойлгохоор байна. Төлөөлөл гэдэг нь нэг этгээд (төлөөлөгч) нь түүнд олгогдсон эрх мэдлийн хүрээнд өөр этгээд (төлөөлүүлэгч)-ийн нэрийн өмнөөс хэлцэл хийх зэрэг эрх зүйн үйлдлийг хийж, түүний үр дүнд төлөөлүүлэгчийн иргэний эрх, үүрэг үүсгэх, дуусгавар болох эсвэл өөрчлөгдөх ойлголт юм. Төлөөллийн харилцаанд төлөөлүүлэгч (иргэн, хуулийн этгээд) төлөөлөгч (хууль ёсны төлөөлөгч- эцэг, эх, харгалзан дэмжигч, асран хамгаалагч, хуулийн этгээдийн удирдах байгууллага буюу гүйцэтгэх удирдлага) болон гуравдагч этгээд оролцоно.

2002 оны ИХ-ийн 62-70 дугаар зүйлд төлөөлөлтэй холбоотой харилцааг зохицуулсан. Эдгээр нь хууль зүйн техникийн хувьд дэс дараалалтай нарийвчлан зохицуулагдсан ба төлөөлөх бүрэн эрхийг бичгээр болон амаар мэдэгдсэн тохиолдолд төлөөлөх эрх олгогдох, төлөөлөх бүрэн эрхгүй этгээд хэлцэл хийх, төлөөлүүлэгчийн хүсэл зоригийн илэрхийллийн давуу байдал, төлөөлөгч өөртэйгөө хэлцэл хийхгүй байх зэрэг шинэлэг олон зохицуулалтыг тусгасан. Мөн итгэмжлэл олгосон мэт тооцох тохиолдлын талаар шударга гуравдагч этгээдийн итгэл үнэмшлийг хамгаалсан зохицуулалтыг шинээр тусгасан нь чухал ач холбогдолтой болсон.

2002 оны ИХ-д төлөөлөлтэй холбоотой олон чухал шинэ ойлголтуудыг тусгасан хэдий ч зарим төрлийн зохицуулалтыг илүү нарийвчлан тусгах боломжтой гэж дүгнэж болохоор байна. Тухайлбал, төлөөлөх эрхийг хэтрүүлэн хэрэглэх, хэд хэдэн этгээдийг нэг этгээд төлөөлөх, төлөөлөх эрхийг бусдад шилжүүлэх буюу үндсэн болон дэд итгэмжлэл, төлөөлөгч өөртэйгээ хэлцэл хийх онцгой нөхцөлийг тодорхойлох зэрэг асуудлыг дурдаж болно.

Хүснэгт 5. Харьцуулалт

1994 ОНЫ ИРГЭНИЙ ХУУЛЬ	2002 ОНЫ ИРГЭНИЙ ХУУЛЬ
58 дугаар зүйл.Төлөөлөгч *1.Иргэн ба хуулийн этгээд өөрөө биечлэн хийхээр хуульд зааснаас бусад хэлцлийг төлөөлөгчөөр дамжуулан хийж болно.* *2.Эрхийн бүрэн чадамжгүй, зарим болон хэсэгчилсэн чадамжтай иргэний нэрийн өмнөөс тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч-эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хэлцэл хийнэ.* *3.Бусдын ашиг сонирхлын үүднээс боловч өөрийн нэрийн өмнөөс ажиллаж байгаа этгээд /үнэ хаялцуулах ажиллагааны хөтлөгч, дампуурлын үе дэх хэрэг гүйцэтгэгч, зуучлагч, гэрээслэл биелүүлэгч зэрэг/, түүнчлэн ирээдүйд хийгдэх*	***63 дугаар зүйл. Төлөөлөгч*** *63.1.Итгэмжлэлээр төлөөлөхөд төлөөлөгч нь иргэний эрх зүйн бүрэн, бүрэн бус, эсхүл хязгаарлагдмал чадамжтай иргэн болон хуулийн этгээд байж болно.* *63.2.Төлөөлөгч төлөөлүүлэгчээс олгосон бүрэн эрхийн хүрээнд, түүний нэрийн өмнөөс гуравдагч этгээдтэй хэлцэл хийх бөгөөд уг хэлцлээс үүсэх эрх, үүрэг нь гагцхүү төлөөлүүлэгчид бий болно.* *63.3.Төлөөлөгч нь бүрэн эрхээ шударгаар, төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэгтэй.*

хэлцлийн талаар хэлэлцээ хийх эрх олгогдсон этгээдийг төлөөлөгч гэж үзэхгүй.	*63.4.Энэ хуулийн 63.3-т заасан үүргээ биелүүлээгүйгээс төлөөлүүлэгчид учирсан гэм хорыг төлөөлөгч хариуцан арилгах үүрэгтэй.*
Тусгагдаагүй	***65 дугаар зүйл. Төлөөлөх бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх*** *65.1.Нэг этгээд өөрийгөө төлөөлөх бүрэн эрхтэй гэсэн ойлголтыг нөгөө этгээдэд өгөхөөр нөхцөл бүрдүүлснээс нөгөө этгээд нь төлөөлөх бүрэн эрхтэй гэж ойлгон түүнийг шударгаар төлөөлөн гуравдагч этгээдтэй хэлцэл хийсэн бол өөрийгөө төлөөлүүлэхээр ойлголт өгсөн этгээд төлөөлсөн этгээдийн бүрэн эрхгүй байсныг ашиглаж болохгүй.* *65.2.Төлөөлөгч нь бусдыг төлөөлж байгаагаа мэдэгдэлгүйгээр хэлцэл хийсэн бол түүнтэй хэлцэл хийсэн этгээд бусдыг төлөөлж байгаа этгээдтэй хэлцэл хийж байгаагаа мэдэх ёстой байсан тохиолдолд төлөөлүүлэгчид хэлцлийн үр дагавар үүснэ.* *65.3.Хэлцлийн нөгөө талд хэнтэй хэлцэл хийж байгаа нь ач холбогдолгүй байсан бол энэ хуулийн 65.2 нэгэн адил хамаарна.*
59 дүгээр зүйл.Төлөөлөгчийн бүрэн эрх *1.Төлөөлөгчийн бүрэн эрх нь хууль, захиргааны шийдвэр буюу итгэмжлэлд үндэслэсэн байна.* *2.Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс олгосон бүрэн эрхийг хэтрүүлж болохгүй.* *3.Төлөөлүүлэгчийн нэрийн өмнөөс төлөөлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд хийсэн хэлцэл нь төлөөлүүлэгчийн эрх, үүргийг бий болгох, өөрчлөх буюу дуусгавар болгоно.* *4.Төлөөлөх эрхгүй этгээдээс хийсэн буюу төлөөлөгч бүрэн эрхээ хэтрүүлэн хийсэн хэлцлийг төлөөлүүлэгч хүлээн зөвшөөрвөл хүчин төгөлдөр байна. Энэхүү хэлцлийг ийнхүү хүлээн зөвшөөрсөн үеэс эхлэн хүчин төгөлдөр гэж үзнэ.*	***68 дугаар зүйл. Төлөөлөх бүрэн эрхгүй этгээдийн хийсэн хэлцэл*** *68.1.Төлөөлөх бүрэн эрхгүй этгээд бусдын нэрийн өмнөөс гуравдагч этгээдтэй дур мэдэн хэлцэл хийсэн бол уг хэлцэл хүчин төгөлдөр байх эсэх нь төлөөлүүлсэн этгээдийн зөвшөөрлөөс шалтгаална.* *68.2.Хэрэв хэлцэл хийгч гуравдагч этгээд нь төлөөлүүлсэн этгээдээс уг хэлцлийг дэмжсэн зөвшөөрөл олгохыг хүсвэл түүнд зөвшөөрөл олгож болно.* *68.3.Зөвшөөрлийг 14 хоногийн дотор олгоно. Энэ хугацаанд хариу өгөөгүй бол зөвшөөрөл олгохоос татгалзсан гэж үзнэ.* *68.4.Хэлцэл хийгч гуравдагч этгээд хэлцэл хийх үедээ төлөөлөгчийн бүрэн эрхгүй болохыг мэдэж байснаас бусад тохиолдолд төлөөлүүлсэн этгээдээс уг хэлцлийг дэмжсэн зөвшөөрлийг олгохоос өмнө хэлцлээсээ татгалзах эрхтэй.*
Тусгагдаагүй	***70 дугаар зүйл. Төлөөлөгч өөртэйгээ хэлцэл хийхгүй байх*** *70.1.Төлөөлөгч нь төлөөлүүлэгчийн нэрийн өмнөөс өөртэйгөө, түүнчлэн гуравдагч этгээдийн нэрээр өөрөө төлөөлүүлэгчтэй хэлцэл хийхийг хориглоно.*

I.Иргэний хуулийн 63 дугаар зүйлийн хэрэгжилтийн үнэлгээ

Үнэлгээ хийх зүйл
63 дугаар зүйл. Төлөөлөгч 63.1.Итгэмжлэлээр төлөөлөхөд төлөөлөгч нь иргэний эрх зүйн бүрэн, бүрэн бус, эсхүл хязгаарлагдмал чадамжтай иргэн болон хуулийн этгээд байж болно. 63.2.Төлөөлөгч төлөөлүүлэгчээс олгосон бүрэн эрхийн хүрээнд, түүний нэрийн өмнөөс гуравдагч этгээдтэй хэлцэл хийх бөгөөд уг хэлцлээс үүсэх эрх, үүрэг нь гагцхүү төлөөлүүлэгчид бий болно.

63.3.Төлөөлөгч нь бүрэн эрхээ шударгаар, төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэгтэй.
63.4.Энэ хуулийн 63.3-т заасан үүргээ биелүүлээгүйгээс төлөөлүүлэгчид учирсан гэм хорыг төлөөлөгч хариуцан арилгах үүрэгтэй.
63.5.Хууль ёсны төлөөлөгчийнх нь зөвшөөрлийг авалгүйгээр иргэний эрх зүйн бүрэн бус буюу хязгаарлагдмал чадамжтай иргэнээр төлөөлүүлсэн этгээд нь ийнхүү төлөөлүүлснээс бусдад учруулсан гэм хорыг өөрөө хариуцна.

Төлөөлөх бүрэн эрх гэдэг нь өөр нэг этгээдийг хүчин төгөлдөр төлөөлөх, төлөөлүүлэгчид үйлчлэл бий болох хүсэл зоригийг илэрхийлэх болон хүсэл зоригийг илэрхийллийг хүлээн авах эрх байдаг[65].

Төлөөлөгчийн хийсэн хэлцлийн үр дагавар төлөөлүүлэгчид үүсэхийн тулд төлөөлөгч нь дан ганц өөрийн хүсэл зоригийг илэрхийлсэн байх, төлөөлөл ил тод байх зарчмыг хангасан байхаас гадна төлөөлөх бүрэн эрхтэй байж үйл ажиллагаа явуулсан байх ёстой. Төлөөлөл нь хуульд заасан үндэслэл, эсхүл итгэмжлэлийн үндсэн дээр үүсдэг.

ИХ-ийн 63.1 дэх хэсэгт итгэмжлэлээр төлөөлөгч болох боломжтой субъектүүдийг нэрлэсэн байна. Мөн ИХ-ийн 63.2 дэх хэсэгт төлөөллийн харилцаанд төлөөлүүлэгчид эрх, үүрэг үүсэх нөхцөлийг тодорхойлсон байна. Ингэхийн тулд төлөөлөгч эрх зүйн үр дагаварт чиглэсэн хүсэл зоригийг төлөөлүүлэгчийн нэрийн өмнөөс хийж буйгаа гуравдагч этгээдэд ил болгож мэдэгдэх шаардлагатай байдаг. *Үүнийг төлөөллийн харилцаан дахь ил тод (илэрхий) байх зарчим гэж нэрлэдэг.* Өөрөөр хэлбэл ИХ-ийн 63.2 нь төлөөлөгч заавал төлөөлүүлэгчийг нэрлэн дурдах бус тухайн нөхцөл байдлаас хэний өмнөөс хэлцэл хийж байгаа нь тодорхой болсон тохиолдолд ч илэрхий ил тод байх зарчимд нийцсэнд тооцох боломжтой юм[66].

Төлөөллийн харилцаанд төлөөлүүлэгчийн ба төлөөлөгчийн хоорондын харилцааг дотоод, төлөөлүүлэгч ба гуравдагч этгээдийн хоорондын харилцааг гадаад гэж нэрлэдэг. *ИХ-ийн зохицуулалтаас үзэхэд төлөөлүүлэгч, гуравдагч этгээдийн эрх ашгийг хамгаалахад илүү анхаарал хандуулсан байна*. Тухайлбал, ИХ-ийн 63.3 болон 63.4 дэх хэсэгт төлөөлөгч нь бүрэн эрхээ шударгаар, төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлэх ба энэхүү үүргээ биелүүлээгүйгээс төлөөлүүлэгчид учирсан гэм хорыг хариуцан арилгах үүрэг хүлээхээр хуульчилсан байна.

ИХ-ийн 63 дугаар зүйлд итгэмжлэлээр төлөөлөх боломжтой субъектүүдийг тодорхойлсон ба төлөөллийн харилцаанд дахь илэрхий ил тод байдлын зарчим болон төлөөлөгч нь бүрэн эрхээ шударгаар хэрэгжүүлэх зарчмыг[67] тусгаж хэрэгжүүлж чадаагүй тохиолдолд үүсэх эрх зүйн үр дагаврыг хуульчилсан байна. Төлөөлөгчийн илэрхий ил тод байх зарчим болон төлөөлөгч бүрэн эрхээ шударгаар биелүүлэх зарчим нь 2002 оны ИХ-д шинээр оруулсан зохицуулалт юм.

Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ нь судалгааны ажлын нэг төрөл болохын хувьд хууль тайлбарлах эрх зүйд чухал ач холбогдолтой. Энэ хүрээнд шүүхийн шийдвэрийн цахим санг ашиглан ИХ-ийн 63 дугаар зүйлийг хэрэглэсэн УДШ-ын нийт 26 тогтоолыг түүвэрлэн авсан болно. *Иргэний хуулийн 63 дугаар зүйлийг зорилгодоо хүрсэн түвшинг шалгуур болгон үнэлж үзэхэд хууль хэрэглээний хувьд эргэлзээтэй, зөрүүтэй байдал үүсгэхээргүй байна үзсэн болно*.

[65] Э.Байгаль, Иргэний эрх зүйн ерөнхий анги, Уб, 2011 он 244-р тал
[66] Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн удиртгал, хоёрдугаар хэвлэл, Уб, 2014 он, 240-р тал.
[67] ХБНГУ-ын Иргэний хуулийн 164-р зүйлд төлөөллийн харилцаан дахь ил тод байх зарчим тусгагдсан байдаг.

II.Иргэний хуулийн 65 дугаар зүйлийн хэрэгжилтийн үнэлгээ

Үнэлэх зүйл
65 дугаар зүйл. Төлөөлөх бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх 65.1.Нэг этгээд өөрийгөө төлөөлөх бүрэн эрхтэй гэсэн ойлголтыг нөгөө этгээдэд өгөхөөр нөхцөл бүрдүүлснээс нөгөө этгээд нь төлөөлөх бүрэн эрхтэй гэж ойлгон түүнийг шударгаар төлөөлөн гуравдагч этгээдтэй хэлцэл хийсэн бол өөрийгөө төлөөлүүлэхээр ойлголт өгсөн этгээд төлөөлсөн этгээдийн бүрэн эрхгүй байсныг ашиглаж болохгүй. 65.2.Төлөөлөгч нь бусдыг төлөөлж байгаагаа мэдэгдэлгүйгээр хэлцэл хийсэн бол түүнтэй хэлцэл хийсэн этгээд бусдыг төлөөлж байгаа этгээдтэй хэлцэл хийж байгаагаа мэдэх ёстой байсан тохиолдолд төлөөлүүлэгчид хэлцлийн үр дагавар үүснэ. 65.3.Хэлцлийн нөгөө талд хэнтэй хэлцэл хийж байгаа нь ач холбогдолгүй байсан бол энэ хуулийн 65.2 нэгэн адил хамаарна.

Нэг.Онолын ойлголт

Төлөөллийн харилцаанд гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалах зарчим: Төлөөлөгч нь төлөөлүүлэгчийн олгосон бүрэн эрхийг хүлээн авсан дотоод (төлөөлөгч ба төлөөлүүлэгчийн хоорондын) харилцаа болон тухайн бүрэн эрхийн хүрээнд төлөөллийг хэрэгжүүлж буй гадаад (төлөөлөгч ба гуравдагч этгээд хоорондын) харилцаа гэж ангилдаг[68]. Өөрөөр хэлбэл дотоодын харилцааны тухай мэдээгүй, эсхүл мэдэх боломжгүй гуравдагч этгээдийн эрх ашгийг хамгаалан гэрээ хүчин төгөлдөр хэвээр үлдээх, улмаар гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалах нь чухлаар тавигдана.

ИХ-ийн 65.1 дэх хэсгийн зохицуулалт нь төлөөлүүлэгч бүрэн эрх олгоогүй ч төлөөлөх бүрэн эрхтэй гэсэн ойлголтыг нөгөө этгээдэд өгөхөөр нөхцөл бүрдүүлснээс төлөөлөх бүрэн эрхтэй гэж ойлгон түүнийг шударгаар төлөөлсөн бөгөөд нөгөө тал болох гуравдагч этгээд үүнд итгэн хэлцэл хийсэн тохиолдолд төлөөлөгчийн хийсэн хэлцлийн үр дагавраас төлөөлүүлэгч татгалзах эрхгүй байх агуулга юм[69]. Энэ нь төлөөлүүлэгч анхаарал болгоомжгүйн улмаас бусдад төлөөлөх эрхтэй мэт ойлголтыг төрүүлсэн учраас хэлцлийн үр дагаврыг өөрөө хариуцах хэрэгтэй гэсэн санаа юм.

ИХ-ийн 65.1 дэх хэсгийн агуулгаас үзэхэд гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалах гэхээсээ илүү төлөөлөх үйлдэл хийсэн этгээдийн итгэл үнэмшлийг хамгаалах зорилго харагдаж байна. Иймд ИХ-ийн 65.1 дэх хэсэг гуравдагч этгээдийн итгэл үнэмшлийг хамгаалах зорилгодоо хангалттай хүрч чадахгүй байна гэж дүгнэж болно. Зарим судлаачдын зүгээс ИХ-д төлөөллөөс үүдэн гуравдагч этгээдийн эрхийг хамгаалсан шууд зохицуулалт байхгүй[70] гэж онцолсон байдаг. Мөн ИХ-ийн 65.1 дэх хэсэгт гадаад илэрхийлэлд итгэсэн гуравдагч этгээдийг хамгаалах зарчим тодорхой түвшинд туссан гэдгийг хүлээн зөвшөөрсөн судлаачид цөөнгүй байна. Иймд дээрх зохицуулалтыг шүүхийн практикт хэрхэн тайлбарлан хэрэглэж байгаад дүн шинжилгээ хийх нь чухал юм.

Төлөөлөх эрхтэй хэмээн итгэж үнэмшсэн гуравдагч этгээдийг хамгаалах үзлийг илэрхий бүрэн эрхийн онолоор (apparent authority) тайлбарладаг[71]. Дээрх онолын хүрээнд төлөөлөх бүрэн эрхгүй этгээд (falsus procurator) гэрээ байгуулж тэрхүү төлөөлөл

[68] Ц.Оюунчимэг, "Иргэний эрх зүйн харилцаа дахь төлөөлөл", *Хууль дээдлэх ёс сэтгүүл,* № 1, (2004)
[69] Б.Тэмүүлэн нар, Иргэний эрх зүйн ерөнхий анги, Уб, 2013 он, 226-р тал
[70] Т.Мэндсайхан, "Гэрээний эрх зүй", Уб, 2021 он, 135-р тал
[71] Дэлгэрүүлэн үзэх, Г.Дабааням нар, "Иргэний хуулийн төлөөллийн харилцаан дахь итгэл үнэмшлийг хамгаалах зохицуулалт, түүний хэрэглээ", *ХЗҮХ Судалгааны тайлангийн эмхэтгэл*, XVII боть, Уб, 2024 он, 386-р тал.

нь хүчин төгөлдөр болсны улмаас хэлцлийн нөгөө тал болох гуравдагч этгээдийн эрх ашиг зөрчигдөх нөхцөл бүрддэг гэж үздэг. Иймд төлөөлөх бүрэн эрхгүй этгээдийн хийсэн хэлцлийг тодорхой нөхцөл бүрдсэн тохиолдолд хүчин төгөлдөр гэж үзэн итгэмжлэл олгосон гэж тооцон хэлцлийг хүчин төгөлдөр хэвээр үлдээх нь арилжааны хэлцлийн түргэн шуурхай байх зарчимд нийцдэг байна.

Итгэмжлэл олгосон гэж тооцох тохиолдол: Төлөөлөгч өөрт нь бүрэн эрх олгосон гэж ойлгоод төлөөлүүлэгчийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдтэй тодорхой хэлцэл хийх явдал цөөнгүй байдаг. Ийм үед зарим тохиолдолд төлөөлөх эрх олгогдоогүй байхад хэлцэл хийсэн тохиолдолд төлөөлөх эрх олгосон гэж тооцож болох үндэслэлүүд байдаг. Үүнд:

i. Төлөөлүүлэгч төлөөлөгчид бүрэн эрх олгосон мэт ойлголт төрүүлснээр төлөөлөх бүрэн эрх үүсэх

ii. Итгэмжлэлийг зөвшөөрсөн мэт дүр эсгэх (эс үйлдэхүйгээр зөвшөөрөх

iii. Төлөөлүүлэгч өөрийн хайхрамжгүй байдлын улмаас төлөөлөх эрх үүсгэх (итгэмжлэл олгосон мэт дүр үзүүлж, хийсвэр ойлголт төрүүлэх

Итгэмжлэл олгосон гэж тооцож болох дээрх бүх тохиолдлуудад ИХ-ийн 65 дугаар зүйлийг тайлбарлан хэрэглэж болох эсэх онолын болон шүүхийн практикт тодорхой болоогүй гэж дүгнэх болохоор байна[72].

Хоёр.Хууль хэрэглээний практик

Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

1	***Шүүхийн шийдвэр 1:*** *НИХДЗШШ 2016.10.17 №1746* ***Хэргийн товч агуулга:*** *Нэхэмжлэгч нь хариуцагч компаниас үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгө худалдан авах гэрээг байгуулж, хариуцагч компани үл хөдлөх хөрөнгийг нэхэмжлэгчид шилжүүлэн өгсөн. Ингэхдээ хариуцагч компанийг төлөөлж санхүү эрхэлсэн захирал тус гэрээг байгуулсан. Нэхэмжлэгч компанийн зүгээс гэрээнд заасан талбайгаас зөрүүтэй гэдэг үндэслэлээр зөрүүг гаргуулахыг шаардсан бол хариуцагч компанийн зүгээс тус гэрээг компанийг төлөөлөх эрхгүй этгээд болох санхүү эрхэлсэн захирал байгуулсан тул хүчин төгөлдөр бус гэж маргасан.* ***Шийдвэрийн агуулга:*** *Шүүх дараах үндэслэлээр нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн.* *Нэхэмжлэгч Ж.Баттөр өөрийн нэхэмжлэлийн шаардлагаа нотлох зорилгоор шүүхэд гаргаж өгсөн хариуцагч "Сандэй" ХХК-ийн санхүү эрхэлсэн захирал Д.Ариунаатай байгуулсан хэлцэл гэх бариимтад "... тус талбайд дахин хэмжилт хийснээр 7 559 м.кв-аар багассаны зөрүү болох 16 630 ам.доллар /ханш-1700/ 28 271 000 төгрөгийг төлж барагдуулахаар тохиролцов" гэж заан талууд гарын үсэг зурсан байгаа нь тэдгээрийн хооронд Иргэний хуулийн39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт заасны дагуу хүсэл зоригоо илэрхийлэн хэлцэл хийгдсэн, уг хэлцэл нь мөн хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт заасны дагуу хүчин төгөлдөр болсон гэж үзэх үндэслэлтэй юм.* *Харин хариуцагч компанийн зүгээс дээрх хэлцлийг хүчин төгөлдөр бус хэлцэлд тооцуулахаар сөрөг нэхэмжлэл гаргахдаа шаардлагын үндэслэлээ "тус компанийн санхүү эрхэлсэн захирал Д.Ариунаа нь "Орон сууцны барилгын доторх сууцны талбай тооцох аргачлал MNS 6058:2009" стандартын дагуу хийсэн хэмжилтийг үндэслэн хэлцэл хийсэн. Гэтэл уг стандартын дагуу үйлдвэр, үйлчилгээний зориулалттай талбайд хэмжил хийх үндэслэлгүй тул хариуцагч нь Иргэний хуулийн 58 дугаар зүйлийн 58.3.3-т зааснаар хэлцэл хийх гол үндэслэл болсон эрхийн талаар ноцтой төөрөгдсөн" гэж тайлбарлах боловч хариуцагч байгууллагын хувьд уг хэлцлийг байгуулах үндэслэл, эрхийн талаар төөрөгдсөн, энэ талаар мэдсэн даруйдаа гэрээний нөгөө талд*

[72] Г.Дававаням нар, мөн тэнд *"ИХ-ийн 65.1 дэх хэсгийг тайлбарлана хэрэглэсэн УДШ-ийн 26 шийдвэрт дүн шинжилгээ хийсэн судалгааны тайланг дэлгэрүүлэн үзнэ үү"*

	Иргэний хуулийн 58 дугаар зүйлийн 58.6 дахь хэсэгт заасны дагуу мэдэгдсэн гэх байдал хэргийн бариmтаар тогтоогдохгүй байна. Иймд хариуцагчийн гаргасан хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцуулах тухай сөрөг нэхэмжлэлийг хангах хууль үндэслэлгүй юм. *Хариуцагч компанийн санхүү эрхэлсэн захирал Д.Ариунаа нь компанийг төлөөлөн хэлцэл хийх эрхтэй гэж үзсэн, нэхэмжлэгчийн компанид гаргасан хүсэлтэд хариу өгч хэлцэл хийхдээ тус компанийн санхүүгийн тэмдэг хэрэглэсэн зэргээс үзэхэд хариуцагч компанийг төлөөлөх эрхгүй этгээд хэлцэл хийсэн гэх тайлбар, татгалзал нь Иргэний хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэгт нийцэхгүй.*
2	***Шүүхийн шийдвэр 2:*** *УДШ 2018.02.02 №001/ХТ2018/170* ***Хэргийн товч агуулга:*** *Нэхэмжлэгч компани нь хариуцагч компанийн дэд захиралтай ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, холбогдох ажлыг хүлээлгэн өгч, хариуцагч компани гэрээний төлбөрийн хагасыг төлсөн. Хариуцагч компанийг төлөөлж гэрээг компанийн дэд захирал байгуулсан.* *Нэхэмжлэгч компани хариуцагч компаниас ажил гүйцэтгэх гэрээний үлдэгдэл төлбөрийг шаардсан бол, хариуцагч компани тус ажил гүйцэтгэх гэрээг компанийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд байгуулсан гэдэг үндэслэлээр татгалзсан байна.* ***Шийдвэрийн агуулга:*** *Шүүх дараах үндэслэлээр нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн. Нэхэмжлэгчээр гэрээнд заасан ажлыг гүйцэтгүүлж байсан болохыг хариуцагч компанийн гүйцэтгэх захирал буюу итгэмжлэлгүй төлөөлөх эрх бүхий этгээд болох Н.А нь мэдэж байсан болох нь зохигчид, гэрч нарын мэдүүлэг, хөлс төлсөн баримт зэргээр тогтоогдож байна. Түүнчлэн ажил гүйцэтгэх гэрээг заавал бичгийн хэлбэрээр байгуулахыг хуулиар зохицуулаагүй болон хариуцагч компанийн дэд захирлын байгуулсан уг гэрээний дагуу хариуцагч "Ч б" ХХК-иас нэхэмжлэгчид ажлын хөлс төлсөн болохыг тус компанийн гүйцэтгэх захирал Н.А үгүйсгээгүй, гүйцэтгэх захирлаар гарын үсэг зуруулах боломжгүй байсан гэх хариуцагч Ө.Г-ын тайлбар зэргээр хариуцагч компанийг төлөөлөх эрхгүй этгээд гэрээ байгуулсан гэж үзэхгүй бөгөөд түүнд Иргэний хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэгт зааснаар хэлцэл төлөөлж хийх бүрэн эрхийг амаар олгосон гэж үзнэ.* *Иргэний хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.-д зааснаар нэг этгээд өөрийгөө төлөөлөх бүрэн эрхтэй гэсэн ойлголтыг нөгөө этгээдэд өгөхөөр нөхцөл бүрдүүлснээс нөгөө этгээд нь төлөөлөх бүрэн эрхтэй гэж ойлгон түүнийг шударгаар төлөөлөн гуравдагч этгээдтэй хэлцэл хийсэн бол өөрийгөө төлөөлүүлэхээр ойлголт өгсөн этгээд төлөөлсөн этгээдийн бүрэн эрхгүй байсныг ашиглаж болохгүй тул компанийг төлөөлөх эрхгүй этгээд гэрээ байгуулсан гэх хариуцагч талын тайлбар болон гомдол хууль зүйн үндэслэлгүй байна*
3	***Шүүхийн шийдвэр 3:*** *УДШ 2019.03.14 №001/ХТ2019/354* ***Хэргийн товч агуулга:*** *Нэхэмжлэгч компани нь хариуцагч ОНӨААТҮГ-д шошго хэвлэж өгөх ажил гүйцэтгэх гэрээг байгуулжээ. Тус гэрээг ОНӨААТҮГ-ыг төлөөлж, борлуулалтын албаны дарга байгуулсан ба гэрээг үйлдвэрийн газрын даргаар батлуулжээ. Нэхэмжлэгч шошгыг бүрэн хэвлэж өгсөн боловч хариуцагч ОНӨААТҮГ гэрээний төлбөрийг бүрэн төлөөгүй байна. Иймд, нэхэмжлэгч компани гэрээний үлдэгдэл төлбөрийг шаардсан бол хариуцагч ОНӨААТҮГ-ийн зүгээс тухайн гэрээг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд байгуулсан учир хүчин төгөлдөр бус гэж татгалзсан байна.* ***Шийдвэрийн агуулга:*** *Шүүх дараах үндэслэлээр нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн.Дээрх гэрээг захиалагч талаас "Говь-Алтай аймгийн У" ОНӨААТҮГыг төлөөлж, борлуулалтын албаны дарга Ж.Б байгуулсан ба гэрээг тус үйлдвэрийн газрын дарга П.М баталсан байна. Тухайлбал, борлуулалтын албаны дарга үйлдвэрийн газрыг төлөөлөх бүрэн эрхгүй байсан ч түүний байгуулсан гэрээг тус үйлдвэрийн газрын захирал баталсан байх тул зохигчийн хоорондох ажил гүйцэтгэх гэрээг хүчин төгөлдөр бус хэлцэл гэж үзэхгүй.Иргэний хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.-д зааснаар нэг этгээд өөрийгөө төлөөлөх бүрэн эрхтэй гэсэн ойлголтыг нөгөө этгээдэд өгөхөөр нөхцөл бүрдүүлснээс нөгөө этгээд нь төлөөлөх бүрэн эрхтэй гэж ойлгон түүнийг шударгаар төлөөлөн гуравдагч этгээдтэй хэлцэл хийсэн бол өөрийгөө төлөөлүүлэхээр ойлголт өгсөн этгээд төлөөлсөн этгээдийн бүрэн эрхгүй байсныг ашиглаж болохгүй. Мөн хуулийн 68 дугаар зүйлийн 68.1.-д зааснаар төлөөлөх бүрэн эрхгүй этгээд бусдын нэрийн өмнөөс гуравдагч этгээдтэй дур мэдэн хэлцэл хийсэн бол уг хэлцэл хүчин төгөлдөр байх эсэх нь төлөөлүүлсэн этгээдийн зөвшөөрлөөс шалтгаална.*
4	***Шүүхийн шийдвэр 4:*** *УДШ 2022.12.06 №001/ХТ2022/1215* ***Хэргийн товч агуулга:*** *Нэхэмжлэгч нь хариуцагч компанитай орон сууц захиалгаар бариулах ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан. Тус гэрээг байгуулахад хариуцагч компанийг төлөөлж компанийн борлуулалтын менежер гэрээнд гарын үсэг зурсан. Нэхэмжлэгч орон сууцыг шилжүүлэн*

	өгөхийг шаардсан бол хариуцагч компанийн зүгээс төлөөлөх бүрэн эрхгүй этгээд хэлцэл байгуулсан гэж татгалзсан. ***Шийдвэрийн агуулга:*** *Шүүх дараах үндэслэлээр нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн. Үүнээс гадна хариуцагч ХХК-аас "компанийг төлөөлөх эрхгүй Г.Хангай гэрээг байгуулсан тул уг гэрээ байгуулагдаагүй"гэсэн тайлбарыг гаргажээ. Анхан болон давж заалдах шатны шүүх хариуцагч ХХК-д Г.Хангай нь борлуулалтын менежерээр ажиллаж байсан нь гэрчийн мэдүүлэг, 2018 оны 01 дүгээр сараас 2019 оны 12 дугаар сарыг дуусталх хугацааны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаагаар тогтоогдсон талаар хийсэн дүгнэлтийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн40.1, 40.2-т заасныг зөрчсөн гэж үзэхгүй.* *Иргэний хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д "Нэг этгээд өөрийгөө төлөөлөх бүрэн эрхтэй гэсэн ойлголтыг нөгөө этгээдэд өгөхөөр нөхцөл бүрдүүлснээс нөгөө этгээд нь төлөөлөх бүрэн эрхтэй гэж ойлгон түүнийг шударгаар төлөөлөн гуравдагч этгээдтэй хэлцэл хийсэн бол өөрийгөө төлөөлүүлэхээр ойлголт өгсөн этгээд төлөөлсөн этгээдийн бүрэн эрхгүй байсныг ашиглаж болохгүй" гэж заасан.* *<u>Хариуцагч ХХК нь өөрийгөө төлөөлөх бүрэн эрхтэй гэсэн ойлголтыг Г.Хангайд өгөх нөхцөлийг бүрдүүлснээр Г.Хангай нь төлөөлөх бүрэн эрхтэй гэж ойлгон хариуцагчийг төлөөлөн бусадтай, түүний дотор нэхэмжлэгчтэй хэлцэл хийсэн байх тул өөрийгөө төлөөлүүлэхээр ойлголт өгсөн хариуцагч ХХК нь Г.Хангайг бүрэн эрхгүй байсныг ашиглаж, компанийн нэрийн өмнөөс хийгдсэн 2018.10.12-ны өдрийн 19/10/157 тоот гэрээг байгуулагдаагүй гэж үзэхгүй талаар хийсэн шүүхийн дүгнэлтийг буруутгах боломжгүй</u>.*

Дээрх шүүхийн шийдвэрүүдээс үзэхэд шүүхээс хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ ИХ-ийн 65.1 дэх хэсгийг гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалах, гэрээ хэлцлийн хүчин төгөлдөр байдлыг хангах зорилгын хүрээнд хэрэглэдэг байна. Гэвч ИХ-ийн 65.1 дэх хэсэг хууль зүйн техникийн бичилтийн хувьд гуравдагч этгээдийг бус харин төлөөлөгчийн шударга байдлыг шаардах агуулга илэрхийлж байгаа. Мөн ИХ-ийн 65.1-г хэрэглэхдээ хэрхэн яаж, ямар үндэслэлээр хэрэглэж байгаа талаар тодорхой тайлбар дутмаг байх нь түгээмэл байна. Өөрөөр хэлбэл итгэмжлэл олгосон гэж тооцож болох урьдач нөхцөлийг тайлбарлахгүйгээр хэргийг шийдвэрлэдэг байна.

Дийлэнх шүүхийн шийдвэрт компанийн дотоод зохион байгуулалт, эрх мэдлийн хуваарилалтын асуудал хөндөгдсөн байна. Өөрөөр хэлбэл, компанийг гүйцэтгэх захирал итгэмжлэлгүйгээр төлөөлөх бүрэн эрхтэй хэдий ч компанийн эрх бүхий албан тушаалтан, нягтлан бодогч, борлуулалтын ажилтан, хуульч зэрэг хүмүүс компанийн нэрийн өмнөөс гэрээ, хэлцэл хийсэн тохиолдол түгээмэл байна.

Энэхүү асуудал нь зарчмын хувьд арилжааны эрх зүй дэх төлөөллийн харилцаа эсхүл компанийн эрх зүйн зохицуулалтад илүү хамаарах харилцаа бөгөөд тухайн тохиолдолд тохирсон зарчим, онол, зохицуулалтаар шийдвэрлэгдвэл зохистой. Гэвч арилжааны эрх зүй, компанийн эрх зүйн зохицуулалт дутмаг байгаа тул ИХ-ийн 65.1 дэх хэсэг гэсэн ерөнхий зохицуулалт үйлчилж байна гэж дүгнэж болно.

III.Иргэний хуулийн 68 дугаар зүйлийн хэрэгжилт

Үнэлгээ хийх зүйл
68 дугаар зүйл. Төлөөлөх бүрэн эрхгүй этгээдийн хийсэн хэлцэл
68.1.Төлөөлөх бүрэн эрхгүй этгээд бусдын нэрийн өмнөөс гуравдагч этгээдтэй дур мэдэн хэлцэл хийсэн бол уг хэлцэл хүчин төгөлдөр байх эсэх нь төлөөлүүлсэн этгээдийн зөвшөөрлөөс шалтгаална.
68.2.Хэрэв хэлцэл хийгч гуравдагч этгээд нь төлөөлүүлсэн этгээдээс уг хэлцлийг дэмжсэн зөвшөөрөл олгохыг хүсвэл түүнд зөвшөөрөл олгож болно.
68.3.Зөвшөөрлийг 14 хоногийн дотор олгоно. Энэ хугацаанд хариу өгөөгүй бол зөвшөөрөл олгохоос татгалзсан гэж үзнэ.
68.4.Хэлцэл хийгч гуравдагч этгээд хэлцэл хийх үедээ төлөөлөгчийн бүрэн эрхгүй болохыг мэдэж байснаас бусад тохиолдолд төлөөлүүлсэн этгээдээс уг хэлцлийг дэмжсэн зөвшөөрлийг олгохоос өмнө хэлцлээсээ татгалзах эрхтэй.

Арилжаа, бизнесийн харилцаанд хэлэлцээрийн явц, цаг хугацааны хүчин зүйл зэргээс хамаарч талуудын төлөөлөгчид эхэлж тохиролцоогоо бататгах зорилгоор гэрээ байгуулчихаад дараа нь удирдах байгууллагын зөвшөөрөл, төлөөлөгчдийн бүрэн эрхийг уг гэрээний агуулгад нийцүүлэн нэмж олгох аргыг өргөн ашигладаг. Өөрөөр хэлбэл төлөөлөх бүрэн эрхгүй этгээдийн хийсэн хэлцэл дараа нь хүчин төгөлдөр байх эсэх нь шууд төлөөлүүлсэн этгээдийн зөвшөөрлөөс хамааралтай болдог. *Төлөөлөх бүрэн эрхгүй төлөөлөгчийг **falsus procurator** гэж нэрлэдэг. Хэрэв төлөөлүүлэгч зөвшөөрөл олгоогүй тохиолдолд төлөөлүүлэгчид уг хэлцлээс үр дагавар үүсэх боломжгүй юм.*

ИХ-ийн 68 дугаар зүйлд төлөөлөх бүрэн эрхгүй этгээдийн хийсэн хэлцлийн эрх зүйн үр дагавар үүсгэх нөхцөлийг тодорхой ойлгомжтойгоор тусгасан байна.

1994 оны Иргэний хуулийн 59.4 дэх хэсэгт төлөөлөх эрхгүй этгээдийн хийсэн хэлцэл төлөөлүүлэгч хүлээн зөвшөөрсөн тохиолдолд хүчинтэй байх зохицуулалт тусагдсан байдаг хэдий ч 2002 оны ИХ-д зөвшөөрөл олгох хугацаа, гуравдагч этгээд хэлцэл хийх үедээ төлөөлөгчийн бүрэн эрхгүй болохыг мэдэж байснаас бусад тохиолдолд төлөөлүүлсэн этгээдээс уг хэлцлийг дэмжсэн зөвшөөрлийг олгохоос өмнө хэлцлээсээ татгалзах эрх зэрэг нэмэлт зохицуулалтыг тусгасан байна.

Иргэний хуулийн 68 дугаар зүйлийг зорилгодоо хүрсэн түвшинг шалгуур болгон үнэлж үзэхэд хууль хэрэглээний хувьд эргэлзээтэй, зөрүүтэй байдал үүсгэхээргүй байна үзсэн болно. Иймд ИХ-ийн 68 дугаар зүйлийг үнэлэх шаардлагагүй гэж үзсэн болно.

IV.Иргэний хуулийн 70 дугаар зүйлийн хэрэгжилт

Үнэлгээ хийх зүйл
70 дугаар зүйл. Төлөөлөгч өөртэйгээ хэлцэл хийхгүй байх 70.1.Төлөөлөгч нь төлөөлүүлэгчийн нэрийн өмнөөс өөртэйгөө, түүнчлэн гуравдагч этгээдийн нэрээр өөрөө төлөөлүүлэгчтэй хэлцэл хийхийг хориглоно.

Төлөөлөгч өөртэйгээ хэлцэл хийхийг хориглох зохицуулалтын гол зорилго нь хэлцлийн аль аль талд нэг этгээд байснаар хэлцэлд нөлөөлөх боломж бүрдэн улмаар сонирхлын зөрчил үүсдэг. Өөрөөр хэлбэл гэрээ байгуулсан этгээд нэг талынх нь төлөөлөгчөөр харин нөгөө талд өөрийн нэрийн өмнөөс оролцох тохиолдолд өөрөө өөртэйгээ хэлцэл хийх болдог. Мөн нэг этгээд гэрээний аль аль талын хувьд төлөөлөгчөөр оролцох үед өөртэйгээ хэлцэл хийх нөхцөл бүрдэх ба үүнийг давхар төлөөлөл гэдэг[73].Дээрх тохиолдолд хэлцлийн аль аль талд нэг этгээд байх нь сонирхлын зөрчлийг үүсгэж улмаар төлөөлүүлэгчийн эрх ашигт хохирол учруулах бодит нөхцөл бүрддэг байна.

ИХ-ийн 70 дугаар зүйлийн агуулгаас үзэхэд нь давхар төлөөлөл болон төлөөлөгч өөртэйгөө хэлцэл хийхийг хориглосноор төлөөлүүлэгчийг аливаа ашиг сонирхлын зөрчлөөс хамгаалах зорилготой байна. Төлөөлөгч өөртэйгээ хэлцэл хийхийг хориглосон зохицуулалт нь 2002 оны ИХ-д шинээр тусагдсан зохицуулалт бөгөөд ХБНГУ-ын Иргэний хуулийн 181-р зүйлд уг зохицуулалттай төсөөтэй зохицуулалт тусагдсан байна[74].

[73] Ё. Кают нар, Иргэний хуулийн тайлбар толь, Ерөнхий анги, 2018 он 120-р тал

[74] German Civil Code (BGB), **Section 181 Contracting with oneself,** *"Agents may not, unless otherwise permitted, enter into a legal transaction in the name of the principal with themselves in their own name or as the agent of a third party, unless the legal transaction consists solely in the performance of an obligation".*

Хориг үйлчлэхгүй онцгой тохиолдол

Бодит практик ялангуяа арилжаа бизнесийн үйл ажиллагаанд төлөөлөгч өөртэйгээ хэлцэл хийх зайлшгүй тохиолдолд гарахыг үгүйсгэхгүй. Тухайлбал, нэг гишүүнтэй ХХК-н хувьд гүйцэтгэх удирдлага нь нэг талаас өөрийгөө нөгөө талаас компанийг төлөөлөн хэлцэл хийсэн тохиолдолд төлөөлөгч өөртэйгээ хэлцэл хийх болно. Мөн хууль ёсны төлөөлөгчийн зүгээс насанд хүрээгүй хүүхдэд бэлэглэлийн замаар эд хөрөнгө шилжүүлэхэд төлөөлүүлэгч өөртэйгээ хэлцэл хийх нь тодорхой байна. Зарим тохиолдолд төлөөлөгч этгээдэд төлөөлүүлэгч нь өөртэйгээ хэлцэл хийх болон давхар төлөөлөх эрх олгосон буюу ИХ-ийн 70 дугаар зүйл хэрэгжихгүй байхаар тохиролцох тохиолдолд хуулийг хэрхэн тайлбарлан хэрэглэх нь тодорхойгүй байна. Түүнчлэн төлөөлүүлэгчид ашигтай тохиолдолд түүний зөвшөөрлөөр төлөөлөгч өөртэйгөө хэлцэл хийхийг зөвшөөрөх тохиолдолд гарах боломжтой. Тухайлбал, нэг гишүүнтэй ХХК-ийн гүйцэтгэх удирдлага өөрийн хувийн хөрөнгөөс компанид хүүгүй зээл олгох үйлдэл юм.

Иймд зарим тохиолдолд төлөөлүүлэгчид эрх зүйн хувьд хохиролгүй хэлцлийг төлөөлөгч төлөөлүүлэгчийн өмнөөс өөртэйгөө болон давхар төлөөлөх замаар хэлцэл хийх онцгой тохиолдлыг зөвшөөрөх нь ИХ-ийн 70 дугаар зүйлийн агуулгатай зөрчилдөхгүй ба практик хэрэглээнд илүү нийцнэ[75].

Зорилгодоо хүрсэн түвшинг шалгуур болгон үзэхэд ИХ-ийн 70 дугаар зүйлд төлөөлөгч өөртэйгөө хэлцэл хийхийг хориглосон зохицуулалт тусгасан нь төлөөлүүлэгчийн эрх ашгийг хамгаалсан чухал зохицуулалт болсон төдийгүй шүүхийн шийдвэрийн цахим санг ашиглан ИХ-ийн 70 дугаар зүйлийг хэрэглэсэн шийдвэрийг үзэхэд хууль хэрэглээний хувьд эргэлзээтэй, зөрүүтэй байдал үүсгэхээргүй байна гэж дүгнэж болно.

Харин төлөөлүүлэгчид хохиролгүй дээр дурдсан зарим төрлийн хэлцэлд төлөөлөгч өөртэйгөө хэлцэл хийхгүй байх хориглолт үйлчлэхгүй зохицуулалтыг ИХ-д нэмэлтээр тусгах боломжтой гэж дүгнэсэн болно.

V.Ерөнхий дүгнэлт, санал

Энэхүү товч үнэлгээний ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал” болон Ажлын хэсгийн судалгааны ажлын даалгаврыг баримтлан хийв.

Ажлын хэсгийн өгсөн чиглэлийн дагуу Иргэний хуулийн долдугаар бүлгийн Төлөөлөл хэсгийн 63, 65, 68, 70 зүйл заалтад дүн шинжилгээ хийхдээ зорилгодоо хүрсэн түвшин болон практикт нийцэж буй байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн удирдлага болгон хийлээ.

Нэгдүгээрт, ИХ-ийн 63 дугаар зүйлд итгэмжлэлээр төлөөлөх боломжтой субъектүүдийг тодорхойлсон ба төлөөллийн харилцаанд дахь илэрхий ил тод байдлын зарчим болон төлөөлөгч нь бүрэн эрхээ шударгаар хэрэгжүүлэх зарчмыг тусгаж хэрэгжүүлж чадаагүй тохиолдолд үүсэх эрх зүйн үр дагаврыг хуульчилсан байна. Хууль хэрэглээний хувьд эргэлзээтэй, зөрүүтэй байдал үүсгэхээргүй байна гэж үзсэн ба ИХ-ийн 63 дугаар зүйл зорилгодоо хүрсэн шалгуур үзүүлэлтийг хангасан гэж дүгнэж байна.

Хоёрдугаарт, ИХ-ийн 65.1 дэх хэсгийн агуулга болон бичилтийн хувьд гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалах гэхээсээ илүү төлөөлөх үйлдэл хийсэн этгээдийн итгэл үнэмшлийг хамгаалах гэсэн зорилго харагдаж байна. Иймд ИХ-ийн 65.1 дэх хэсэг

[75] Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн удиртгал, хоёрдугаар хэвлэл, Уб, 2014, 24-р тал.

гуравдагч этгээдийн итгэл үнэмшлийг хамгаалах зорилгодоо хангалттай хүрч чадахгүй байна гэж дүгнэж болно. Мөн итгэмжлэл олгосон гэж тооцож болох тохиолдлуудад ИХ-ийн 65 дугаар зүйлийг тайлбарлан хэрэглэж болох эсэх нь онолын болон шүүхийн практикт тодорхой болоогүй гэж дүгнэж болохоор байна. Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ хийхэд ИХ-ийн 65.1 дэх хэсэг зорилгодоо хангалттай хүрч чадахгүй байгаа ба компани, арилжааны эрх зүйн илүү тусгай зохицуулалт шаардлагатай байна.

Гуравдугаарт, ИХ-ийн 68 дугаар зүйлд төлөөлөх бүрэн эрхгүй этгээдийн хийсэн хэлцлийн эрх зүйн үр дагавар үүсгэх нөхцөлийг тодорхой ойлгомжтойгоор тусгасан ба зорилгодоо хүрсэн, практикт нийцэж байгаа гэж дүгнэсэн болно.

Дөрөвдүгээрт, ИХ-ийн 70 дугаар зүйлд давхар төлөөлөл болон төлөөлөгч өөртэйгөө хэлцэл хийхийг хориглосноор төлөөлүүлэгчийг аливаа ашиг сонирхлын зөрчлөөс хамгаалах зохицуулалтыг тусгаж өгсөн байна. Шүүхийн шийдвэрийн цахим санг ашиглан ИХ-ийн 70 дугаар зүйлийг хэрэглэсэн шүүхийн шийдвэрийг үзэхэд хууль хэрэглээний хувьд эргэлзээтэй, зөрүүтэй байдал үүсгэхээргүй байна гэж дүгнэсэн болно.

Тавдугаарт, ИХ-ийн 62-70 дугаар зүйлд иргэний эрх зүйн харилцаа дахь төлөөллийн харилцааг зохицуулсан. Уг зохицуулалт нь арилжаа эрхлэгчдийн *(хувираа арилжаа эрхлэгч, арилжаа эрхлэгч хуулийн этгээд)* хооронд хэлцэлд төлөөлөхтэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулаагүй юм. Өөрөөр хэлбэл хуулийн этгээдийг төлөөлөх харилцаанд гүйцэтгэх захирал компанийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй гэсэн ерөнхий зохицуулалтаас өөр нарийвчилсан зохицуулалт байхгүй байна. Гэвч бодит байдал дээр компанийн бусад эрх бүхий албан тушаалтан (дэд захирал, ерөнхий менежер гэх мэт) бусадтай гэрээ байгуулах, хэлцэл хийх тохиолдолд тэдгээрийн бүрэн эрхийг тодорхойлоогүйгээс арилжаа бизнесийн салбар дахь хэлцлийн найдвартай, түргэн шуурхай байдал алдагдахад хүрч байна.

Энэхүү үнэлгээнд үндэслэн дараах саналыг дэвшүүлэв:

1. ИХ-д төлөөлөгч төлөөлөх эрхийг хэтрүүлэн хэрэглэх, хэд хэдэн этгээдийг нэг этгээд төлөөлөх, төлөөлөх эрхийг бусдад шилжүүлэх зэрэг ойлголтыг шинээх тусгах;
2. ИХ-д төлөөлөгч өөртэйгээ хэлцэл хийх онцгой нөхцөлийг тодорхойлон тусгах;
3. ИХ-ийн 65.1 дэх хэсгийг гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалах онолын үүднээс өөрчлөн найруулах;
4. ИХ-ийн төлөөллийн харилцаанд арилжаа эрхлэгчийн (хувираа арилжаа эрхлэгч, ашгийн төлөө хуулийн этгээд) төлөөллийн харилцааг шинээр тусгах;
5. ИХ-д ашгийн төлөө хуулийн этгээдийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх бүрэн эрх олгох, хэлцэлд төлөөлөх бүрэн эрх олгох зэрэг арилжааны төлөөллийг харилцааг шинээр тусгах.

--oOo--

IV ДЭД ХЭСЭГ. ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙ ДЭХ ХУГАЦАА

НАЙМДУГААР БҮЛЭГ. ХУГАЦААГ ТОДОРХОЙЛОХ, ТООЛОХ

Судалгааны энэ хэсэгт Иргэний хуулийн наймдугаар бүлэгт зохицуулсан хугацаа тодорхойлдох, тоолох тухай 72, 73 дугаар зүйлд дүн шинжилгээ хийж өнөөгийн нөхцөл байдлыг судалж, практикт тулгарч буй хүндрэл бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэн ололтыг бататган дүгнэх цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтын боломжит хувилбарыг тодорхойлохыг зорьлоо.

I.Иргэний хуулийн 72 дугаар зүйлийн хэрэгжилтийн үнэлгээ

Үнэлгээ хийх зүйл
72 дугаар зүйл. Хугацаа тоолох журам 72.1.Хугацааг тоолохдоо тогтоосон он, сар, өдрөөс, эсхүл уул хугацаа улиран өнгөрсөн буюу үйл явдал болж өнгөрсний дараахь өдөр, цагаас эхлэн тоолно. 72.2.Тоолох хугацааны эцсийн өдөр ажлын бус өдөр байвал түүний дараагийн ажлын өдөр уг хугацаа дуусна. 72.3.Хугацааг ямар нэгэн үүрэг гүйцэтгэхийн тулд тогтоосон бөгөөд хэлцэлд өөрөөр заагаагүй бол хугацааны эцсийн өдрийн хорин дөрвөн цагийн дотор уг үүргийг гүйцэтгэсэн байна. 72.4.Үүргийг ямар нэгэн байгууллагад гүйцэтгэх ёстой байсан бол зохих журмаар тогтоосон уг байгууллагын ажлын өдөр буюу үйлдвэрлэлийн ажиллагаа дуусах эцсийн цагийн дотор гүйцэтгэнэ. 72.5.Баримт бичгийг тогтоосон хугацааны эцсийн өдрийн хорин дөрвөн цагийн дотор шуудан, харилцаа холбооны байгууллагад шилжүүлсэн бол түүнийг хугацаанд нь гүйцэтгэсэн гэж үзнэ. 72.6.Цаг хугацааг тоолохдоо хуанлийн жилийг арван хоёр сараар, хагас жилийг зургаан сараар, улирлыг гурван сараар, хоногийг хорин дөрвөн цагаар тоолно. 72.7.Хугацааг сунгах тохиолдолд хугацаа дууссан үеэс шинэ хугацааг тоолно.

Хугацаа тоолох журмаас практикт ач холбогдол өндөртэй нь хуулийн 72.7 дугаар зүйлд заасан хугацааг сунгах зохицуулалт байх ба хуульд “хугацааг сунгах тохиолдолд хугацаа дууссан үеэс шинэ хугацааг тоолно.” гэж заасан. Дээрх зохицуулалт нь зээлийн гэрээний үндсэн үүрэг болох хүү шаардах, эсхүл түүнтэй холбоотойгоор алданги шаардах маргаанд хэрэглэгдсэн байх бөгөөд холбогдох шүүхийн шийдвэрүүдээс дурдвал:

УДШ-ийн 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 001/ХТ2019/00064 тогтоолд[76]:

....Иргэний хуулийн 72 дугаар зүйлийн 72.7.-д “хугацааг сунгах тохиолдолд хугацаа дууссан үеэс шинэ хугацааг тоолно” гэж зохицуулсан тул ***үндсэн гэрээний хугацаа дуусахаас өмнө хугацааг сунгаж, хугацаа дууссан үеэс сунгасан хугацааг тоолох учиртай.***

Хариуцагчийн 17 000 000 төгрөгийг хүлээн авсан зээлийн гэрээний хугацаа 2012 оны 12 дугаар сарын 11-ний өдөр дууссан байхад 2015 оны 10 дугаар сард гэрээний хугацаа сунгасан тухай нэмэлт гэрээ байгуулсан нь хуулийн дээрх заалтад нийцэхгүй болно. Давж заалдах шатны шүүх талууд харилцан тохиролцож зээлийн гэрээний хугацааг сунгасан нь хууль зөрчөөгүй гэж дүгнэхдээ хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, хэрэгт цугларсан нотлох бариmтыг хуульд заасан журмын дагуу үнэлээгүй байна.

[76] УДШ-ийн 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 001/ХТ2019/00064 тогтоол, https://shuukh.mn/single_case/5780?start_date=&end_date=&id=3&court_cat=1&bb=

Иймд магадлал хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагад нийцээгүй тул магадлалыг эс зөвшөөрсөн хариуцагчийн гомдол үндэслэлтэй.

Талуудын хооронд байгуулагдсан "Зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ" нь Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.1.-д зааснаар хүчин төгөлдөр бус байх хэлцэл тул тус гэрээг үндэслэн алданги гаргуулахыг хүссэн нэхэмжлэгчийн гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэв...

Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 210/МА2019/01590 тогтоолд:[77]

2018 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн зээлийн гэрээний дагуу шаардах эрх үүсэхгүй. Уг гэрээгээр талууд мөнгө харилцан өгч авалцаагүй, өмнөх гэрээний хугацааг сунгасан байх бөгөөд 2018 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн гэрээний хугацаа 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр дууссан байхад уг гэрээний хугацааг 2018 оны 12 дугаар сарын 24-ний өдөр 2018 оны 01 дүгээр сарын 07-ны өдрөөс 1 жилийн хугацаагаар сунгасан нь Иргэний хуулийн 72 дугаар сарын 72.7 дахь хэсэгт заасантай нийцэхгүй байна.

Талууд өмнөх гэрээний хугацааг сунгах хүсэл зоригтой байсан бол Иргэний хуулийн 72 дугаар зүйлийн 72.7 дахь хэсэгт "хугацааг сунгах тохиолдолд хугацаа дууссан үеэс шинэ хугацааг тоолно" гэж заасны дагуу ***гэрээний хугацаа дуусах үед энэ талаар тохиролцох ёстой байжээ.***

УДШ-ийн 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 001/ХТ2019/00230 тоот тогтоолд[78]:

Талууд 2017 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн гэрээгээр гэрээний хугацааг 2017 оны 2 дугаар сарын 19-ний өдрөөс 3 дугаар сарын 19-ний өдөр хүртэл 1 сараар, 4 дүгээр сарын 19-ний өдөр 3 дугаар сарын 19-ний өдрөөс 5 дугаар сарын 19-ний өдөр хүртэл 2 сараар, 8 дугаар сарын 28-ний өдөр 2 дугаар сарын 19-ний өдрөөс 10 дугаар сарын 19-ний өдөр хүртэл хугацаагаар тус тус сунгажээ /хэргийн 7-9 дүгээр тал/.

Иргэний хуулийн 72 дугаар зүйлийн 72.7.-т зааснаар ***хугацааг сунгах тохиолдолд хугацаа дууссан үеэс шинэ хугацааг тоолох*** *ба хэлэлцэн тохирсон хэлбэрээр үүргийн харилцаа үүсэхэд гэрээг тохирсон хэлбэрээр байгуулахаар мөн хуулийн 199 дүгээр зүйлийн 199.2.-т заасан тул зохигчид гэрээний хугацааг 2017 оны 3 дугаар сарын 19-ний өдөр хүртэл сунгасан гэж үзнэ.*

Гэрээний хугацаа дуусах үед буюу 2017 оны 3 дугаар сарын 19-ний өдөр хариуцагч нь зээл, хүүд нийт 33.600.000 төгрөг төлөх байснаас төлсөн 12.875.000 төгрөгийг хасч тооцвол 20.725.000 төгрөг төлөх үүрэгтэй ба алдангийг гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 хувиар тооцоход 10.362.500 төгрөг байна.

Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 06 сарын 13-ны өдрийн 210/МА2022/01126 тоот тогтоолд:

[77] https://shuukh.mn/single_case/23495?start_date=&end_date=&id=2&court_cat=1&bb=
[78] УДШ-ийн 2019 оны 02 сарын 19 өдрийн 001/ХТ2019/00230 тогтоол https://shuukh.mn/single_case/5830?start_date=&end_date=&id=3&court_cat=1&bb=

1.б. ... ХХК болон ....- нарын хооронд байгуулагдсан 2012 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 848 дугаартай зээлийн гэрээний хугацаа 2013 оны 03 дугаар сарын 15-ны өдөр дуусгавар болжээ. 2014 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 2014/15 дугаар зээлийн гэрээний сунгалтаар дээрх гэрээний хугацааг мөн оны 09 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл сунгасан гэж зээлийн гэрээний хугацааг шинээр тоолох үндэслэлгүй байна. Учир нь зээлдэгчийн зээлийн төлбөрийг буцаан төлөх үүрэг Иргэний хуулийн 78 дугаар зүйлийн 78.1.1-д зааснаар түр зогссон гэж үзнэ.

1.в. Иргэний хуулийн 76 дугаар зүйлийн 76.1 дэх хэсэгт Хөөн хэлэлцэх хугацааг шаардах эрх үүссэн үеэс эхлэн тоолно гэж заасан тул хариуцагч ....-гийн зээлийн гэрээний хугацаа дуусгавар болсон 2014 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс гэрээний гүйцэтгэх үүргийг шаардах эрхийн хөөн хэлэлцэх хугацаа тоологдох учиртай.

Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн 75.2.1-д Гэрээний үүрэгтэй холбоотой шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа гурван жил гэж заасан. Иймд 2014 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 2014/15 дугаартай зээлийн гэрээний сунгалтад ...сунгалтын эхлэх огноо 2014.03.15... хугацаа 6 сар, зээлийн дуусан огноо 2014.09.15... гэж тусгасан хугацаанаас нэхэмжлэгчийн зээлийн гэрээний үүргийг шаардах хөөн хэлэлцэх хугацааг тоолвол 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр дууссан байна. Иймд мөн хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэгт зааснаар зээлийн гэрээний үүрэгт 27,354,706 төгрөгийг ....-гөөс шаардах эрхгүй юм.

Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 06 дугаар сарын 19 өдрийн 102/ШШ2020/02006 тоот шийдвэрт[79]:

*Иргэний хуулийн 72 дугаар зүйлийн 72.7 дахь хэсэгт "Хугацааг сунгах тохиолдолд хугацаа дууссан үеэс шинэ хугацааг тоолно" гэж заасан ба **үүнийг талуудын гэрээгээр тогтоосон хугацаа дууссан өдрөөс дахин хугацаа сунгахаар талуудыг тохиролцсоныг ойлгоно.** Зохигчийн байгуулсан зээлийн гэрээний хугацаа 2019 оны 8 дугаар сарын 26-ны өдөр дууссан ба уг өдрөөс хугацааг сунгаагүй тохиолдолд хугацаа сунгасан гэж үзэхгүй. Иймд ковид-19 цар тахлын улмаас эдийн засгийн нөхцөл байдал хүндэрсний улмаас гэрээний хугацаа сунгах хүсэлтийг хүлээн авааагүй гэсэн хариуцагчийн тайлбар үндэслэлгүй байгааг дурдах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, 2019 оны 8 дугаар сарын 26-ны өдөр дууссан гэрээний хугацааг 2020 оны 1 дүгээр сард сунгах эсэх асуудлыг тохиролцох хууль зүйн боломжгүй гэж ойлгоно.*

Дээрхээс дүгнэхэд, практикт гэрээний хугацаа дууссанаас хойш талууд харилцан тохиролцож, гэрээг сунгахаар нөхөн хэлцэл хийх тохиолдолд ИХ-ийн 72.7 дугаар зүйлийг үндэслэж, талуудын тохиролцоог хуульд заасан журамд нийцэхгүй гэж шүүхээс үзэж байна.

Гэвч уг шүүхийн практикийг үндэслэлгүй гэж үзэх дараах хэд хэдэн шалтгаан байгаа юм. *Нэгдүгээрт,* хууль тогтоогч ИХ-ийн 72.7 дугаар зүйлээр "гэрээ сунгах журам"-ыг тогтоохыг зорьсон уу, эсхүл хугацаа тоолох журмыг тогтоосон уу гэдэгт тайлбар байхгүй; *хоёрдугаарт,* иргэний эрх зүйн харилцааны оролцогчдын гэрээ байгуулах чөлөөт байдлын зарчмыг харгалзан үзээгүй; *гуравдугаарт,* гэрээ сунгах

[79] Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 06 сарын 19 өдрийн 102/ШШ2020/02006 шийдвэр.
https://shuukh.mn/single_case/111151?start_date=&end_date=&id=1&court_cat=1&bb=1

хүсэлтийг хүлээн зөвшөөрч гэрээг сунгахаар тохиролцсон үүрэг гүйцэтгэгчид шударга бус, *дөрөвдүгээрт,* гэрээ байгуулсанд тооцох ерөнхий ангийн зохицуулалтыг авч үзээгүй зэрэг болно.

Монгол Улсын Иргэний хуулийн тайлбарт зааснаар 72.7 дугаар зүйлийн дагуу талууд гэрээний хугацааг сунгах тохиолдолд анхны тогтоосон хугацааг дууссан үеэс шинэ хугацааг тоолох ёстой[80] гэх зохицуулалтыг агуулсан байна. Тус тайлбарын жишээ хэсэгт зааснаар талууд 1 сарын хугацаатай зээлийн гэрээг 10 сарын 05-ны өдөр байгуулсан бөгөөд 11 сарын 01-ний өдөр гэрээг дахин нэг сараар сунгахаар тохиролцсон бол сунгасан хугацааг 11 сарын 01-ний өдөр буюу гэрээнд өөрчлөлт оруулсан өдрөөр бус гэрээний өмнөх хугацаа дууссан өдрөөс буюу 11 сарын 05-ны өдрөөс тоолно. Эндээс талууд гэрээний хугацаанд өөрчлөлт оруулах шийдвэрийг гэрээний хугацаа дуусахаас өмнө гаргаж болно гэдгийг харж болохоор байна. Үүнтэй адилаар гэрээний эрх чөлөөт байдлын дагуу гэрээний хугацаа дууссаны дараа ч мөн гэрээг сунгах тохиролцоог хийх бүрэн эрх чөлөө талуудад бий гэж үзэж байна.

Монгол Улсын Иргэний хуулийн 72.7 дугаар зүйл нь ХБНГУ-ын Иргэний хуулийн 190 дүгээр зүйлтэй адил.[81] 190 дүгээр зүйлд хугацааг сунгах тохиолдолд өмнөх хугацаа дууссан үеэс шинэ хугацааг тоолно гэжээ. Герман улсын Иргэний хуулийн тайлбарыг үзвэл, тус улсын Иргэний хуулийн 187-193 дахь хэсэгт заасан хугацаа тоолох журамд холбогдох зохицуулалт нь талууд гэрээ байгуулахдаа цаг хугацааны хувьд хоёрдмол, тодорхой бус тохиролцоо хийсэн бол тухайн тодорхой бус илэрхийллийг тайлбарлах зорилготой байна.[82] 190 дүгээр зүйлийн тайлбарт тусгайлан зааснаар, талууд гэрээний хугацааг зөвхөн хугацаа дуусахаас өмнө бус мөн дараа нь ч сунгахаар тохиролцох боломжтой бөгөөд аль ч тохиолдолд өмнөх хугацаа дууссан үеэс шинэ хугацааг тоолно.[83] Гэрээг сунгах тохиролцоо хийсэн өдөр нь ач холбогдолтой биш талаар мөн тусгайлан тэмдэглэсэн байна.[84] Хамгийн гол нь гэрээний хугацаа дууссаны дараа тохиролцсон шинэ хугацаа нь өмнөх гэрээний сунгалт уу эсхүл бие даасан шинэ хугацаа юу гэдгийг хугацаа тоолж эхлэх зохицуулалтын дагуу тодорхойлох нь чухал бөгөөд энэ тухайн нэг тохиолдлын хувьд тодорхойлогдоно.[85]

Хэдийгээр ИХ-ийн 72.7 дугаар зүйл нь гэрээний хугацаа сунгах журмыг зохицуулаагүй бөгөөд шүүхийн практикт гэрээний хугацаа сунгасан эсэхэд холбогдох маргааныг шийдвэрлэхдээ 72.7 дугаар зүйлийг талуудын харилцааны тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор ашигласан байж болох ч хууль хэрэглээний хувьд шүүмжлэлтэй байна. Өөрөөр хэлбэл, ИХ-ийн 72.7 дугаар зүйлийг гагцхүү гэрээний хугацаа дууссан өдөр гэрээг сунгах ёстой гэх агуулгаар хэрэглэх ёсгүй юм.

II.Иргэний хуулийн 73 дугаар зүйлийн хэрэгжилт

Үнэлгээ хийх зүйл
73 дугаар зүйл. Хугацаа тоолж дуусах

[80] Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Ерөнхий анги), 305 дахь тал.
[81] ХБНГУ-ын Иргэний хууль, 190 дүгээр зүйл.
[82] MüKoBGB/Grothe, 10th ed. 2025, BGB § 186
[83] MüKoBGB/Grothe, 10th ed. 2025, BGB § 190
[84] MüKoBGB/Grothe, 10th ed. 2025, BGB § 190
[85] *Ibid*.

73.1.Жил, хагас жил, улирал, сараар тогтоосон хугацаа нь уг хугацаа дуусах сарын мөн өдөр дуусна. Хугацаа дуусах сарын мөн өдөр байхгүй бол уг хугацаа тухайн сарын эцсийн өдөр дуусна.
73.2.Хуанлийн жил нь нэгдүгээр сарын нэгний өдрөөс эхэлж арван хоёрдугаар дугаар сарын гучин нэгний өдрөөр дуусна.
73.3.Долоо хоног, хоногоор тогтоосон хугацаа уг хугацаа дуусах өдрийн мөн цагт дуусна.
73.4.Гаригаар тогтоосон хугацаа тухайн товлосон гариг дуусах эцсийн цагт дуусна.
73.5.Цагаар тогтоосон хугацаа уг хугацаа дуусах цагийн мөн хоромд дуусна.

Практикт төлбөр төлөх хугацааг жилээр тогтоосон тохиолдолд шүүхээс шаардах эрх үүссэн хугацаа, цаашлаад хөөн хэлэлцэх хугацааг тогтооход ИХ-ийн 73 дугаар зүйлийг голчлон хэрэглэж байна. Хуулийн 73 дугаар зүйл дээрх тохиолдолд ач холбогдолтой байх бөгөөд шүүхээс нэг мөр тайлбарлаж, хэрэглэж байна. Иймд уг зүйл, холбогдол заалтыг практикт хүндрэл бэрхшээл учруулаагүй гэж дүгнэв.

Дүгнэлт

ИХ-ийн 8 дугаар бүлэг дэх хугацаа тодорхойлох, тоолох, дуусах журамд холбогдох зохицуулалт нь харьцангуй тодорхой тул практикт хүндрэл бэрхшээл учруулахгүй нь бага боловч боловч анхан, давж заалдах, дээд шатны шүүх зэргээс харилцан адилгүй тайлбарлаж хэрэглэх тохиолдол цөөнгүй гарчээ. Тухайлбал, ИХ-ийн 72.7-т “хугацааг сунгах тохиолдолд хугацаа дууссан үеэс шинэ хугацааг тоолно” гэж заасныг гэрээ сунгах журамтай адилтгаж, гагцхүү хугацаа дууссан өдөр талууд гэрээг сунгахаар харилцан тохиролцох ёстой мэтээр тайлбарласан нь шүүмжлэлтэй байна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦАА

Иргэний хуулийн 74-82 дугаар зүйлд хөөн хэлэлцэх хугацаанд хамаарах зохицуулалт тусгажээ. Иргэн, хуулийн этгээдээс зөрчигдсөн эрхээ хамгаалуулахын тулд шүүх, арбитрт нэхэмжлэл гаргах эрх олгогдсон, хуулиар тогтоосон хугацааг хөөн хэлэлцэх хугацаа гэнэ.[86] Маргаантай нөхцөл байдлуудыг урт удаан цаг хугацаа өнгөрсний дараа шаардлагатай хэмжээнд үнэн бодитоор тогтоох хүндрэлтэй байдаг тул хөөн хэлэлцэх хугацааг иргэний эрх зүйд хэрэглэдэг. Энэ нь нөгөө талаас өөрийн эрхийг хамгаалах арга хэмжээг цаг тухайд нь авч байхыг анхааруулж байгаа юм.[87] Өөрөөр хэлбэл, хөөн хэлэлцэх хугацаа нь нэгдүгээрт, урт удаан хугацаа өнгөрсөн, нотлоход хүндрэлтэй шаардлагаас үүрэг гүйцэтгэгчийг хамгаалах, хоёрдугаарт, нотлох баримт гаргах боломжтой үед шүүхэд хандах хөшүүрэг болох олон чухал ач холбогдолтой.

I.Иргэний хуулийн 74 дүгээр зүйлийн хэрэгжилтийн үнэлгээ

Үнэлгээ хийх зүйл
74 дүгээр зүйл. Хөөн хэлэлцэх хугацаа хамаарах шаардах эрх
74.1.Хуульд хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүйгээр зааснаас бусад тохиолдолд өөр этгээдээс ямар нэг үйлдэл хийх буюу хийхгүй байхыг шаардах эрх хөөн хэлэлцэх хугацаатай байна.
74.2.Хуульд өөрөөр заагаагүй бол хөөн хэлэлцэх хугацаа эдийн бус хөрөнгөд хамаарахгүй.
74.3.Хуульд тусгайлан заасан бол эд хөрөнгийн зарим эрхэд хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй.

Иргэний хуулийн 74 дүгээр зүйлд хөөн хэлэлцэх хугацаа тооцохгүй байх шаардах эрхийг тодорхойлжээ. Хуулийн 74.2 болон 74.3 дахь хэсэгт зааснаар хуульд өөрөөр заагаагүй бол “эдийн бус хөрөнгө” болон “эд хөрөнгийн зарим эрх”-д хөөн хэлэлцэх хугацаа тооцохгүй. Гэвч тусгай хуульд эдийн бус хөрөнгөд холбогдох эрхэд хөөн хэлэлцэх хугацааг тухайлан тогтоосон. Жишээлбэл, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 32.3-т “*Энэ хуулийн 32.1.2, 32.1.3-т заасан хүсэлтийг бүртгэгдсэн барааны тэмдэг, газар зүйн заалт энэ хуулийн 3.1.14-т заасан албан ёсны тогтмол хэвлэлд хэвлэгдсэнээс хойш нэг жилийн дотор Маргаан шийдвэрлэх комисст гаргана*.” гэж заасныг энд тэмдэглэж болох юм. Гэвч хөөн хэлэлцэх тусгай хугацааг авч үзэхдээ тусгай хуульд заагаагүй бол ИХ-д заасан хөөн хэлэлцэх хугацаа тасалдах, түр зогсох зохицуулалтыг мөн шалгах нь зүйтэй.

Дээрхээс бусад тохиолдолд аливаа шаардах эрхэд хөөн хэлэлцэх хугацаа заавал тооцох үндэслэлийг хуулийн 74.1 дүгээр зүйлд тусгажээ. Уг хөөн хэлэлцэх хугацаа (statute limitations) тооцох зохицуулалтыг анхан болон давж заалдах шатны шүүхээс харилцан адилгүй шийдвэрлэх тохиолдол гарч байна. УДШ-ээс тус зүйл заалтыг нэгдсэн байдлаар ойлгож хэрэглэж байх бөгөөд үүнтэй холбоотойгоор УДШ-ийн 2018 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 001/ХТ2018/01680 тоот тогтоол[88] шүүхээс “шаардах эрх”-д хөөн хэлэлцэх хугацаа тооцохгүй байх хуулийн зохицуулалтыг хэрхэн хэрэглэх талаар тайлбар өгснийг дурдвал:

> *...Түүнчлэн шүүхээс шийдвэрийнхээ үндэслэх нь: хэсэгтээ буюу шийдвэрийн 9 дэх хуудсанд “Нотариатын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-т зааснаар нэхэмжлэгч П.М, М.Э, М.Ч нарын шаардах эрхийг хуульчилж өгсөн байна” гэж дүгнэсэн атлаа Иргэний хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2-т заасан “Хуульд*

[86] Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Ерөнхий анги), 302 дахь тал.
[87] Мөн тэнд, 302 дахь тал.
[88] УДШ-ийн 2018 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 001/ХТ2018/01680 тоот тогтоол, https://shuukh.mn/single_case/5387?start_date=&end_date=&id=3&court_cat=1&bb=

өөрөөр заагаагүй бол хөөн хэлэлцэх хугацаа эдийн бус хөрөнгөнд хамаарахгүй", 84 дүгээр зүйлийн 84.5-д "Эзэмшигч этгээддээ ашиг өгөх, эсхүл бусдаас шаардах эрх олгох эрх буюу шаардлага, оюуны үнэт зүйл нь эдийн бус хөрөнгөнд хамаарна" гэснийг зөв тайлбарлаж хэрэглээгүй. Өөрөөр хэлбэл нотариатын тухай хуулиар нотариатч заавал татгалзахаар үүрэг болгон заасан үйлдлийг Б.А нотариатч зөрчиж гэрчлэх үйлдлийг хийсэн ба энэ үйлдэл нь нэхэмжлэгч нарын эрхийг зөрчсөн бөгөөд уг хууль зөрчиж хийсэн нотариатын үйлдлийг хүчингүйд тооцуулахаар шүүхэд хандаж болох "шаардах эрх"-ыг Нотариатын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дугаар заалтаар "хуулиар шаардах эрхийг олгосон" нь ***Иргэний хуулийн 84 дүгээр зүйлийн 84.5-д "... бусдаас шаардах эрх олгох эрх буюу шаардлага ... нь эдийн бус хөрөнгөнд хамаарна" гэх ойлголтод шууд хамаарах бөгөөд "энэ шаардах эрх нь эдийн бус хөрөнгөнд хамаарах" утгаараа Иргэний хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2-т заасан "... хөөн хэлэлцэх хугацаа эдийн бус хөрөнгөнд хамаарахгүй"*** *гэсэн ойлголтоор тайлбарлагдах, хэрэглэгдэх ёстой байхад уг хуулийн зүйл, заалтуудыг хэрэглээгүй. Түүнчлэн өмгөөлөгч нараас шүүх хурал дээр энэ талаар тайлбарласан байхад шүүхээс шийдвэртээ тайлбар, дүгнэлт хийлгүй орхигдуулсан...*

Ийнхүү хөөн хэлэлцэх хугацаа дууссан нь үүрэг гүйцэтгэгчид үүргээ гүйцэтгэхээс татгалзах боломжийг олгож байгаа юм.[89] Өөрөөр хэлбэл, үүрэг гүйцэтгүүлэгч шаардах эрхээ хэрэгжүүлсэн бөгөөд хөөн хэлэлцэх хугацаа дууссан тохиолдолд үүрэг гүйцэтгэгч шаардлагыг хүлээн зөвшөөрч болно. Эндээс үзвэл хөөн хэлэлцэх хугацаа дууссан эсэхийг шүүхийн санаачилгаар бус хариу тайлбарын үндсэн дээр тогтоох ёстой.[90] Практикт шүүгчийн санаачилгаар хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэж тогтоох тохиолдол цөөнгүй байгааг анхаарах нь зүйтэй.

ИХ-ийн 74.1-ийн дагуу зөвхөн шаардах эрхэд л хөөн хэлэлцэх хугацаа гэсэн ухагдахуун хамааралтай. Шаардах эрхээс бусад субъекьтив эрхийн хувьд хөөн хэлэлцэх хугацаа дуусна гэсэн ойлголт байхгүй. Гэсэн хэдий ч хуульд өөрөөр заагаагүй бол туйлын эрхийн зөрчилтэй холбоотой үүдэж буй шаардах эрхүүд хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалтыг хэрэглэх нь бий.[91]

ХБНГУ-ын Иргэний хуулийн тайлбарт зааснаар, туйлын эрх болох өмчлөл нь шаардах эрхээс ялгаатай. Өмчлөл нь эд хөрөнгийн эрхтэй адилгүй нь, хөөн хэлэлцэх хугацаа өмчлөлд үйлчлэхгүй гэжээ.[92] Хэдийгээр өмчлөл хөөн хэлэлцэх хугацаагүй ч, өөрийн өмчлөлийн зүйлээ хэн нэгний хууль бус эзэмшлээс шаардах эрхэд хөөн хэлэлцэх хугацаа тооцож байна. Мөн хууль ёсны эзэмшил нь мөн адил шаардах эрх биш бөгөөд өмчлөгчөөс өмчлөлийг шилжүүлэхийг шаардах эрхийн хугацаа нь дууссан ч өмчлөгч хууль ёсны эзэмшигчээс нэгэнт хууль ёсоор худалдсан, эзэмшил шилжүүлсэн эд хөрөнгөө буцаан шаардах боломжгүй[93] гэжээ.

Өмчлөл, эзэмшилд холбогдох хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой маргааныг шүүхээс хэрхэн шийдвэрлэж буй практиктийг судалж үзэхэд, хэдийгээр анхан болон

[89] MüKoBGB/Grothe, 10th ed. 2025, BGB § 194
[90] MüKoBGB/Grothe, 10th ed. 2025, BGB § 194
[91] Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн удиртгал, (хоёрдугаар хэвлэл Уб.,2014 он) , 283 дахь тал.
[92] MüKoBGB/Grothe, 10th ed. 2025, BGB § 194 Absolute rights.
[93] MüKoBGB/Grothe, 10th ed. 2025, BGB § 194 Absolute rights.

давж заалдах шатны шүүхийн шийдвэрүүд харилцан адилгүй байх ч УДШ-ээс нэгдмэл байдлаар хуулийг тайлбарлан хэрэглэж байна. Сайн жишиг болохуйц УДШ-ийн шийдвэрийн хэсэг[94], хэргийн үйл баримтаас дурдвал:

> *...Нэхэмжлэгч Т хариуцагч Хд холбогдуулан хууль бус эзэмшлээс газар чөлөөлүүлэхээр нэхэмжлэл гаргасан ба нэхэмжлэлийн үндэслэлээ: "...сумын Засаг даргын 2003.04.29-ний өдрийн 30 тоот шийдвэрийг үндэслэж олгосон ... дугаартай Газар эзэмших эрхийн гэрчилгээгээр маргаж буй газрыг 60 жилийн хугацаатай эзэмшдэг. Гэтэл Х нь дээрх газрыг дур мэдэн эзэмшиж, миний эзэмшлийн газрыг чөлөөлж өгөхгүй байна. Иймд миний зөрчигдсөн эрхийг сэргээж, Хын хууль бус эзэмшлээс газрыг албадан чөлөөлж өгнө үү..." гэж тайлбарласан,*
>
> *Хариуцагч Х тайлбартаа: "...Миний амьдран суугаа хашаа байшинг анх 2001 онд буюу одоогоос 16 жилийн өмнө иргэн В.Х, А гэдэг хүнд худалдсан. А нь 2004 онд Г гэдэг хүнд худалдсан. Гөвс миний бие 2009 онд худалдан авсан юм. ...Т нь тус хашаа байшинд амьдран суудаггүй байсан, ...Би ямар нэгэн хууль журам зөрчөөгүй, бусдын эрх ашигт хохирол учруулаагүй, энэ хашаа байшинг шударгаар эзэмшиж байгаа, ...2001 оноос хойш тус хашаа, байшин олон айл дамжин худалдагдсан байхад Т нь олон жилийн дараа нэхэмжлэл гаргасныг хүлээн зөвшөөрөхгүй байна. Би уг газрыг худалдаж авсан байхад намайг залилж газрыг минь авах гэж байгаа нь хуулийн үндэслэлгүй..." гэж маргажээ.*
>
> *Анхан шатны шүүх үндсэн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, хариуцагчийн сөрөг нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэхдээ: ".....Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн 75.1-д зааснаар ...хөөн хэлэлцэх ерөнхий хугацаа 10 жил байх бөгөөд Т нь бусдын хууль бус өмчлөлөөс өөрийн эд хөрөнгийг нэхэмжлэх хөөн хэлэлцэх хугацаа 2012.08.22-ны өдөр дууссан...*
>
> *Давж заалдах шатны шүүх: "...нэхэмжлэгч Т 2017.02.01-ний өдрийн 000664163 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээг олгосон үеэс эхлэн эрх нь зөрчигдсөн талаар мэдсэн. ...Иймд Тгийн шаардах эрх зөрчигдсөн үеийг Сэлэнгэ аймаг дахь сум дундын шүүхийн 2003.03.14-ний өдрийн 60 дугаартай шүүхийн шийдвэр гарсан үеэс эхлэн тооцож Иргэний хуулийн 75 дугаар зүйлд зааснаар шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацааг хэтрүүлсэн гэсэн анхан шатны шүүхийн дүгнэлт хуулийн үндэслэлгүй....*
>
> *10. Дээр дурдснаар хоёр шатны шүүх үйл бариmтыг өөр өөрөөр дүгнэж, зөрүүтэй шийдвэр гаргасан, нотлох бариmтыг үнэлэх хуульд заасан журмыг зөрчсөн нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн гэх үндэслэлээр гаргасан хариуцагч, түүний өмгөөлөгч нарын гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.1, 172.2.2-т заасан шаардлагад нийцсэн гэж үзэн хэргийг хянан хэлэлцлээ.*
>
> *11. Нэхэмжлэгч Т хариуцагч Хд холбогдуулан ... газрыг хариуцагчийн хууль бус эзэмшлээс чөлөөлүүлэхээр нэхэмжлэлийн шаардлага гаргажээ.*
>
> *Иймд нэхэмжлэгч нь маргаж буй хөрөнгийн өмчлөгч, эсхүл шударга эзэмшигч байхаас гадна хариуцагчийн эзэмшил хууль бус байхыг шаардана....*

[94] УДШ-ийн 2023 оны 06 сарын 22 өдрийн 001/ХТ2023/00129 дугаартай тогтоол https://shuukh.mn/single_case/10259?daterange=2023/01/01%20-%202023/10/25%20&id=3&court_cat=1&bb=1

11.2. Иргэний хуулийн 76 дугаар зүйлийн 76.1-д хөөн хэлэлцэх хугацааг шаардах эрх үүссэн үеэс эхлэн тоолно, 76.2-т хуульд өөрөөр заагаагүй бол шаардах эрх нь эрх зөрчигдсөн, эрх зөрчигдсөн тухай мэдсэн, эсхүл мэдэх ёстой байсан, түүнчлэн гомдлын шаардлага гаргах буюу баталгаат хугацаа тогтоосон бол гомдлын шаардлагын хариуг авсан буюу эдгээр хугацаа дууссан үеэс үүснэ гэж заасан.

Сэлэнгэ аймгийн сум дундын 1-р шүүхийн 2003.03.14-ний өдрийн №60 дугаартай шийдвэрээр маргаж буй газар бусдын эзэмшилд шилжсэн нь тогтоогдсон тул нэхэмжлэгч Тг энэ үед эрхээ зөрчигдсөн гэж мэдсэн, эсхүл мэдэх ёстой байсан гэж үзэх ба түүний шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацааг тухайн үеэс тоолох тул "...өөрийн нэр дээр газар эзэмших эрхтэй болохоо огт мэдээгүй байж байгаад 2017 онд эмэг эхээсээ сонсож, эрхээ зөрчигдсөнийг мэдсэн..." гэх тайлбар хэргийн нөхцөл байдлаар үгүйсгэгдэж байна гэх анхан шатны шүүхийн дүгнэлт хэрэгт цугларсан нотлох бариmтад тулгуурласан байна.

Өөрөөр хэлбэл, М.Хг 2002 оны 10 дугаар сард хашаа, байшингаа Ц.Ад худалдах үед тус хаягт хамаарах газарт тусад нь газар эзэмших гэрчилгээ олгогдоогүй байсан, дээрх хашааны талбайд хамаарах газар, тус газар дээр барьсан барилгын хамт бүхэлдээ худалдан авсан Ц.Агийн эзэмшил, өмчлөлд шилжсэн үйл баримт 2003 оны №60 дугаартай шийдвэрээр тогтоогдсон байх тул нэхэмжлэгч Т нь эрхээ зөрчигдсөн гэдгийг 2003 оноос мэдсэн байна...

Дээрх шийдвэрээс үзвэл Монгол Улсад өмчлөгч өөрийн өмчлөлийг бусдын хууль бус эзэмшлээс шаардах хөөн хэлэлцэх хугацаа 10 жил гэж тооцсон УДШ шийдвэр үндэслэлтэй байгаа хэдий ч анхан шатны болон давж заалдах шатны шүүхүүд харилцан адилгүй дүгнэлтүүд өгсөн нь шүүмжлэлтэй байна.

II.Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн хэрэгжилтийн үнэлгээ

ИХ-ийн 75 дугаар зүйлд хөөн хэлэлцэх ерөнхий болон тусгай хугацааг тогтоосон. Хуулийн 75.2 дугаар зүйлд тусгай хугацааг тогтоосон бөгөөд ийнхүү зааснаас бусад бүх тохиолдолд хөөн хэлэлцэх ерөнхий хугацаа 10 жил байхаар зохицуулалт хийжээ.[95]

Үнэлгээ хийх зүйл
75 дугаар зүйл. Хөөн хэлэлцэх ерөнхий болон тусгай хугацаа
75.1.Хуульд өөрөөр заагаагүй бол хөөн хэлэлцэх ерөнхий хугацаа арван жил байна.
75.2.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол дараахь тохиолдолд хөөн хэлэлцэх тусгай хугацаа үйлчилнэ:
75.2.1.гэрээний үүрэгтэй холбоотой шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа гурван жил;
75.2.2.үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой гэрээний үүрэгт шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа зургаан жил;
75.2.3.тогтсон хугацааны туршид гүйцэтгэх үүрэгтэй холбогдон шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа гурван жил;
75.2.4.бусдын эд хөрөнгөд гэм хор учруулснаас үүсэх үүрэгтэй холбоотой шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа таван жил.
75.3.Талуудын хүсэлтээр шүүх хөөн хэлэлцэх хугацаа, түүнийг тоолох журмыг өөрчилж болно.

Хөөн хэлэлцэх хугацаа тогтоох нь Үндсэн хуульд заасан өмчийн эрхэд шууд хамаарах тул хууль тогтоогч хөөн хэлэлцэх хугацааг тогтоохдоо үүрэг гүйцэтгүүлэгчийн ашиг сонирхлыг тэнцвэртэйгээр авч үзэх ёстой гэж үздэг. Өөрөөр хэлбэл, хөөн хэлэлцэх хугацааг тогтоохдоо үүрэг гүйцэтгүүлэгчид шаардлага гаргах боломжтой гэдгээ мэдэх,

[95] ИХ 75.1 дүгээр зүйл.

нотлох баримт цуглуулах, шүүхэд хандахад хангалттай хэмжээний хугацаа олгосон байх ёстой юм. Ийм ч учраас шаардах эрх үүссэн, эсхүл мэдсэн хугацаа нь хөөн хэлэлцэх хугацааг тоолоход чухал ач холбогдолтой байдаг. Гэвч иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хоорондох харилцааг гэнэтийн саад тотгоргүй, тодорхой байлгах үүднээс эдийн засгийн ач холбогдолтой зарим хөрөнгөд холбогдох хөөн хэлэлцэх хугацаа ердийн хугацаанаас богино байдлаар тогтоож, ингэснээр иргэний эрх зүйн оролцогчдын анхаарлыг хандуулах зорилгод үйлчилдэг.

ХБНГУ-ын Иргэний хуульд зааснаар хөөн хэлэлцэх ердийн хугацаа 3 жил байх бол зарим онцгой шаардах эрхүүдэд хөөн хэлэлцэх хугацааг 10 эсхүл 30 жилээр тогтоосон нь Монгол Улсын Иргэний хуулиас өөр байна. Манай Иргэний хуульд өмнө өгүүлснээр ерөнхий хугацааг 10 жил байхаар тогтоосон бол бусад тусгай хугацааг илүү богиноор тогтоосон байна.

Эндээс гэрээний үүрэгт холбогдох хөөн хэлэлцэх хугацаа 3 жил байх хуулийн зохицуулалтыг практикт нэг мөр тайлбарлан хэрэглэж байна. Жишээ болгон УДШ-ийн 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 001/ХТ2022/00087 тоот тогтоолыг[96] авч үзвэл:

> *...9.2. Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн 75.2.1.-д зааснаар гэрээний үүрэгтэй холбоотой шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа гурван жил байна.*
>
> *Зохигчийн хооронд эд хөрөнгө хөлслөх гэрээний эрх зүйн харилцаа үүссэн гэж үзсэн тул гэрээний үүрэгтэй холбоотой шаардлага гаргах хугацааг гурван жилээр тооцно. Хариуцагч нь нэхэмжлэгчийн ...подъёомыг 2016.01 дүгээр сард надад хэлэлгүй, хүлээлгэж өгөлгүйгээр хашаанд буулгасан байсан... гэх тайлбарыг үгүйсгэсэн үндэслэл, тайлбараа бариментаар нотлоогүй тул эд хөрөнгө хүлээлгэн өгсөн хугацааг 2016.01 дүгээр сар гэж тооцох бөгөөд нэхэмжлэгч нь 2018.12.26-ны өдөр шүүхэд нэхэмжлэл гаргасан байх тул хуульд заасан шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн гэх хариуцагчийн гомдол үндэслэлгүй…*

Харин үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой маргаанд Иргэний хуульд заасан 10 жилийн ердийн хугацааг, эсхүл үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой гэрээний үүрэгт шаардлага гаргах 6 жилийн хөөн хэлэлцэх хугацааг практикт харилцан адилгүйгээр хэрэглэж байна.

Хуулийн зохицуулалтад догматик байдлаар дүн шинжилгээ хийхэд, үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой гэрээний үүрэгт шаардлага гаргах эрх 6 жил, харин гэрээтэй холбоогүй бусад өмчийн шаардах эрхэд 10 жилийн хөөн хэлэлцэх хугацаа тоолохоор байгаа юм. Тухайлбал, нэхэмжлэгч, хариуцагч талуудын хооронд гэрээний үүргийн харилцаа үүсээгүй тохиолдолд ИХ-ийн 106.1 дэх хэсгийн дагуу бусдын хууль бус эзэмшлээс өмчөө шаардах хөөн хэлэлцэх хугацааг 10 жил гэж тооцсон УДШ-ийн шийдвэрийг өмнөх хэсэгт дурдсан.[97]

Үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой шаардлагыг амжилттай хэрэгжүүлэх эсэх нь зөвхөн үүрэг гүйцэтгэгчээс хамааралтай байдаггүй. Тухайлбал, кадастрын зураг гаргах, татвар төлөх зэргээс болж үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг авах, бүртгэлийг өөрчлөх

[96] УДШ-ийн 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 001/ХТ2022/00087 тоот тогтоол, https://shuukh.mn/single_case/9207?start_date=&end_date=&id=3&court_cat=1&bb=1

[97] УДШ-ийн 2023 оны 06 сарын 22 өдрийн 001/ХТ2023/00129 дугаартай тогтоол https://shuukh.mn/single_case/10259?daterange=2023/01/01%20-%202023/10/25%20&id=3&court_cat=1&bb=1

процесс удааширдаг. Иймд өөрөөс шалтгаалах бүх үйлдлийг хийсэн үүрэг гүйцэтгэгчийн эсрэг шаардлага гаргахыг үүрэг гүйцэтгүүлэгчээс шаардах ёсгүй гэж үздэг тул үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэхтэй холбоотойгоор хөөн хэлэлцэх хугацааг 10 жил байхаар ХБНГУ-ын Иргэний хуулийн 196 дугаар зүйлд тусгажээ.

Гэвч анхан шатны шүүхээс үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой шаардлагад хамаарах хөөн хэлэлцэх хугацааг 3 жил тогтоосон тохиолдол цөөнгүй байгаа нь шүүмжлэлтэй байна. Тухайлбал[98], дараах магадлалаар анхан шатны буруу дүгнэлтийг хүчингүй болгосон.

> *Анхан шатны шүүх дээрх үйл баримттай холбогдуулан "АС" ХХК-ийг Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн 75.2.1-д заасан гэрээний үүрэгтэй холбоотой шаардлага гаргах гурван жилийн хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн гэх үндэслэлээр нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь үндэслэлгүй болно.*
>
> *Баянгол дүүргийн 6 дугаар хороо, 10 дугаар хороолол, 45 дугаар байрны 30 тоот 90.4 м.кв орон сууцны өмчлөх эрхийн гэрчилгээг С.Г-ын нэр дээр гаргуулахыг даалгах тухай нэхэмжлэлийн шаардлагад хамаарах хөөн хэлэлцэх хугацааг буруу тооцсон. Нэхэмжлэгч "АС" ХХК нь 2007 оны 6 дугаар сарын 06-ны өдөр иргэн Н.Номтойбаяртай худалдах худалдан авах гэрээ байгуулж, орон сууцыг худалдсан ба худалдан авагч тал тухайн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээг С.Г-ын нэр дээр гаргуулахаар харилцан тохиролцсон үйл баримт тогтоогдсон байна. /1хх 86-87/...*
>
> *Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн 75.2.2-т үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой гэрээний үүрэгт шаардлага гаргахад үйлчлэх хөөн хэлэлцэх хугацаа зургаан жил байхаар тусгайлан зохицуулсан байх тул нэхэмжлэгч С.Г өөрийн эзэмшил, ашиглалтад гэрээний дагуу бодитойгоор шилжүүлэн авсан үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой бичиг бариmтыг гаргуулахаар шаардах эрхэд хамаарах хөөн хэлэлцэх хугацааг хэтрүүлсэн гэж үзэхгүй. Өөрөөр хэлбэл, Иргэний хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэгт зааснаар тогтоосон журмаар нэхэмжлэл гаргасан үндэслэлээр хөөн хэлэлцэх хугацаа тасалдах бөгөөд мөн хуулийн 79.7 дахь хэсэгт зааснаар хугацааг дахин шинээр тоолох журамтай.*

Түүнчлэн хуулийн 75 дугаар зүйлд хэлцэл хүчин төгөлдөр бусад тооцуулахад хөөн хэлэлцэх хугацааг тооцох зохицуулалт байхгүй. Өөрөөр хэлбэл, гэрээний эрх зүйн харилцаа үүсгэснээс 3 жилийн хугацаанд шаардах эрхийн хөөн хэлэлцэх хугацаа тоолох байтал хэлцэл хүчин төгөлдөр бусад тооцуулахад хөөн хэлэлцэх хугацаагүй эсхүл хугацаатай мэт шүүхийн шийдвэрүүдэд харилцан адилгүй байдлаар шийдвэрлэж байна. Зарим шүүхийн шийдвэрт "Анхнаасаа хүчин төгөлдөр бус хэлцлийн тухайд хөөн хэлэлцэх хугацаа тооцохгүй" гэсэн агуулга бүхий тайлбарууд байна.

Хэлцэл хүчин төгөлдөр бусад тооцуулах эрх нь мөн чанарын хувьд шаардах эрх биш ба ИХ-ийн 186.1-ийн тодорхойлолтод багтдаггүй харьцангуй эрх тул энд хөөн хэлэлцэх хугацаа шууд тооцох байдлаар хуулийн 75 дугаар зүйлийг хэрэглэх боломжгүй байна. Иймд харьцангуй эрхийн хүрээнд хөөн хэлэлцэх хугацааны дотор байх ямар гэрээ хийсэн болох, түүнийг нь хүчингүй эсхүл хүчинтэй гэдгийг нь тооцох хугацааг мөн хөөн хэлэлцэх хугацаа гэж нэрлэх үү? эсвэл хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт энэ

[98] Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 01 сарын 17 өдрийн 212 дугаартай магадлал. https://shuukh.mn/single_case/8033?start_date=&end_date=&id=2&court_cat=1&bb=

эрхүүдэд нэгэн адил үйлчлэх эсэх талаар 75 дугаар зүйлд зохицуулж хугацаатай болгох нь зүйтэй гэж үзэж байна.

Мөн зарим онцгой шаардах эрхүүдэд ердийн хугацаанаас илүү урт хугацаагаар хөөн хэлэлцэх хугацаа тогтоох ёстой гэж үзэж байна. Тухайлбал, ХБНГУ-ын Иргэний хуульд санаатайгаар гэм хор учруулсан үүдсэн хохирлыг нэхэмжлэх хөөн хэлэлцэх хугацаа тус хуулийн 197 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэгт зааснаар 30 жил байх бөгөөд үүнд гэмт хэргийн улмаас учирсан гэм хор хамаарахаар байна. Энэ нь гэмт хэргийн улмаас үүссэн аливаа хохирлоо шаардаж буй хохирогчийн эрхийг хамгаалахад туйлын ач холбогдолтой байна.

Практикт гэм хороос үүдсэн хохирлыг нэхэмжлэх эрхийн хөөн хэлэлцэх хугацааг Иргэний хуулийн 75.2.4 дэх хэсгийг буюу “бусдын эд хөрөнгөд гэм хор учруулснаас үүсэх үүрэгтэй холбоотой шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа таван жил” гэж заасныг үндэслэн тогтоож байгаа нь цөөнгүй байна. Жишээлбэл, гэмт хэргийн улмаас хүний амь насыг хохироож, Иргэний хуулийн 497, 508 дугаар зүйлийн дагуу оршуулгын зардал, эд хөрөнгөд учирсан хохирол, сэтгэл санааны хохиролд нийт 278,352,040 төгрөгийг шаардсан хэргийг анхан шатны[99] шүүхээс шийдвэрлэхдээ 75.2.4 дэх зүйлийг үндэслэсэн хэдий ч 79.1-д зааснаар хөөн хэлэлцэх хугацаа тасалдсан гэж шийдвэрлэжээ.

> *... Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн 75.2.4 дэх хэсэгт “бусдын эд хөрөнгөд гэм хор учруулснаас үүсэх үүрэгтэй холбоотой шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа таван жил “ байхаар хуульчилсан хэдий ч энэ хуулийн 76 дугаар зүйлийн 76.2 дах хэсэгт зааснаар хөөн хэлэлцэх хугацааг эрх зөрчигдсөн үеэс тоолохоор заасан бөгөөд Ц.Аын нэхэмжлэлтэй Б.Бд холбогдох иргэний хэргийн тухайд шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа нь мөн хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1-д зааснаар тасалдсан байна...*

Иймд Иргэний хуулийн 75.2.4 дэх хэсэг гагцхүү “бусдын эд хөрөнгө”-өөр хязгаарлагдаж байгааг анхааран авч үзэж, гэмт хэргийн эсхүл санаатайгаар бусдын эрүүл мэнд, амь нас, нэр төр, алдар хүндэд гэм хор учруулсанд холбогдох хөөн хэлэлцэх хугацааг уртасгаж, хуульд тодорхой тусгах нь практикт учирч болох хүндрэл, бэрхшээлийг бууруулах чухал ач холбогдолтой байж болохоор байна.

Бусдын амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүндэд учруулсан гэм хорт холбогдох хөөн хэлэлцэх хугацаанаас гадна ХБНГУ-ын 197 дугаар зүйлд зааснаар шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр үүрэг болгосон үүрэг, хүүхдийн тэтгэмж төлөх үүрэг, нийтийн эрх зүйн дагуу үүсэх үүрэг, тухайлбал татвар төлөхтэй гэх мэт, мөн буцаан шаардах (өмчлөл, эд хөрөнгийн эрх эсхүл гэрээний улмаас буцаан шаардах тохиолдол хамаарахгүй) хөөн хэлэлцэх хугацаа 30 жил байхаар тогтоожээ. Хөөн хэлэлцэх хугацаа шаардах эрх үүссэн үеэс тодорхойлогдоно.

III.Иргэний хуулийн 76 дугаар зүйлийн хэрэгжилтийн үнэлгээ

Иргэний хуулийн 76.1-д хөөн хэлэлцэх хугацааг шаардах эрх үүссэн үеэс эхлэн тоолохоор заасан. Харин 76.2 дахь хэсэг шаардах эрх хэдийнээс үүсэх талаар чухал

[99] Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 03 сарын 14 өдрийн 184/ШШ2019/0070 дугаарт шийдвэр, https://shuukh.mn/single_case/83251?start_date=&end_date=&id=1&court_cat=1&bb=

зохицуулалтыг агуулсан байна. Хуульд өөрөөр заагаагүй бол шаардах эрх нь эрх зөрчигдсөн, эрх зөрчигдсөн тухай мэдсэн, эсхүл мэдэх ёстой байсан, түүнчлэн гомдлын шаардлага гаргах буюу баталгаат хугацаа тогтоосон бол гомдлын шаардлагын хариуг авсан буюу эдгээр хугацаа дууссан үеэс үүснэ.

Үнэлгээ хийх зүйл
76 дугаар зүйл. Хөөн хэлэлцэх хугацааг тоолох 76.1.Хөөн хэлэлцэх хугацааг шаардах эрх үүссэн үеэс эхлэн тоолно. 76.2.Хуульд өөрөөр заагаагүй бол шаардах эрх нь эрх зөрчигдсөн, эрх зөрчигдсөн тухай мэдсэн, эсхүл мэдэх ёстой байсан, түүнчлэн гомдлын шаардлага гаргах буюу баталгаат хугацаа тогтоосон бол гомдлын шаардлагын хариуг авсан буюу эдгээр хугацаа дууссан үеэс үүснэ. 76.3.Тодорхой үйлдэл хийхээс татгалзах үүрэгтэй холбогдсон шаардлагад хөөн хэлэлцэх хугацааг уг шаардлага зөрчигдсөн үеэс эхлэн тоолно. 76.4.Шаардах эрх нь нэхэмжлэгчийн үйлдлээс шалтгаалах бол хөөн хэлэлцэх хугацааг нэхэмжлэгч уг үйлдлийг хийх ёстой байсан үеэс эхлэн тоолно. 76.5.Сөрөг үүргийн хөөн хэлэлцэх хугацааг үндсэн үүргийг гүйцэтгэсэн үеэс эхлэн тоолно.

ХБНГУ-ын Иргэний хуулийн 199 дүгээр зүйлд хөөн хэлэлцэх хугацааг тоолж эхлэх талаар зохицуулсан. Энд хууль тогтоогч үүрэг гүйцэтгүүлэгч шаардах эрхээ зөрчигдсөн эсэхийг мэдэх үүрэгтэй гэсэн байр суурийг хадгалж, ийнхүү мэдсэн үеэс хөөн хэлэлцэх хугацааг тоолохоор зохицуулжээ.[100] Ийнхүү мэдсэнээс гадна хэт хайхрамжгүй хандсан (grossly negligent ignorance) тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг тоолохоор зохицуулсан нь Монгол Улсын ИХ-ын холбогдох хэсгийн “мэдэх ёстой байсан” гэх элементтэй төсөөтэй. Гэвч ХБНГУ-ын хуульд шаардах эрх үүссэн эсхүл мэдэх ёстой байсан жилийн сүүлийн өдрөөс хөөн хэлэлцэх хугацааг тоолж эхлэхээр тусгайлан зохицуулсан нь зарим талаараа ач холбогдолтой байна.

Цаашлаад бусдын нэр төр, алдар нэр, амь нас, эрүүл мэндэд учруулсан гэм хорыг шаардах эрхэд холбогдох хөөн хэлэлцэх 30 жилийн хугацаа нь гэмтэл учруулсан буюу гэм хор учирсан үеэс тоологдохоор тусгасан байна. Дээрхээс бусад төрлийн хуулиас үүдэх хохирлыг шаардах эрхийн хөөн хэлэлцэх хугацаа хуульд зааснаас хамаарч 10 эсхүл 30 жил байхаар тусгасан байна.[101] Харин гэрээний үүрэгтэй холбоотой хохирлыг шаардахад ердийн хугацааг баримтална гэж үзэж байна.

Ийнхүү уртасгасан тусгай хугацааг хөөн хэлэлцэх хугацааг тоолоход үүрэг гүйцэтгүүлэгчийн мэдсэн эсхүл мэдэх ёстой байсан гэх мэдэх элемент ач холбогдолгүй байх бөгөөд хуулийн 199 дүгээр зүйлд зааснаар хохирол учирсан үеэс тоолно. Эндээс дүгнэвэл хугацааг тоолох журам нь ердийн болон тусгай хугацаанд (maximum limitation periods) өөр өөр байна. Монгол Улсын Иргэний хуулийн 76.1 болон 76.2 дугаар зүйлийг дээрх байдлаар ялгамжтай хэрэглэх зохицуулалт байхгүй байх бөгөөд ихэвчлэн 76.1 дэх хэсгийг тодотгон тайлбарлахад 76.2 дугаар зүйлийг ашиглаж байна. Өмнөх хэсэгт өгүүлснээр тодорхой онцгой шаардах эрх, тухайлбал, гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүндэд учрах хохирлыг шаардах хөөн хэлэлцэх хугацааг уртаар тогтоох тохиолдолд ердийн болон тусгай уртасгасан хөөн хэлэлцэх хугацаанд үйлчлэх харилцан адилгүй журам шаардлагатай байж болзошгүй.

IV.Иргэний хуулийн 77 дугаар зүйлийн хэрэгжилтийн үнэлгээ

[100] MüKoBGB/Grothe, 10th ed. 2025, BGB § 199
[101] ХБНГУ-ын Иргэний хууль, 199.3 дахь хэсэг.

Үнэлгээ хийх зүйл
77 дугаар зүйл. Нэмэгдэл үүргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болох 77.1.Үндсэн үүргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссанаар нэмэгдэл үүрэг /анз, барьцаа, дэнчин, батлан даалт, баталгаа зэрэг/-ийн хөөн хэлэлцэх хугацаа нэгэн зэрэг дуусна.

Иргэний хуулийн 77.1 дүгээр зүйлд “үндсэн үүргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссанаар нэмэгдэл үүрэг /анз, барьцаа, дэнчин, батлан даалт, баталгаа зэрэг/-ийн хөөн хэлэлцэх хугацаа нэгэн зэрэг дуусна” гэж заасан нь аливаа нэмэгдэл үүрэг нь ямагт үндэн үүрэгтэй зэрэгцэн оршдш ба бие даасан үүрэг болж чаддаггүйтэй холбоотой.[102] Практик дахь дээрх заалтын хэрэглээ харьцангуй нэгдмэл байна. Жишээ болгон давж заалдах шатны шүүхийн нэгэн магадлалыг [103] авч үзвэл:

> *..Харин худалдагч нь худалдан авагчид өмчлөх эрхийн гэрчилгээг гаргаж өгөх үүргээ биелүүлээгүй зөрчил үргэлжилсэн хэвээр буюу эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэн өгөх үндсэн үүрэгт хамаарах хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй байхад нэхэмжлэгч нь гэрээний 3.1, 3.3-т заасан уг үүрэгтэй холбоотой алданги төлөх нэмэлт үүргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэж анхан шатны шүүх үндэслэлгүй дүгнэж, уг шаардлагыг хэрэгсэхгүй болгосон нь буруу байх боловч энэ талаар нэхэмжлэгч давж заалдах гомдол гаргаагүй тул хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны диспозитов зарчмын хүрээнд давж заалдах шатны шүүхээс энэ талаар шийдвэрт өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэв...*

Үндсэн үүрэг болон түүний нэмэгдэл үүргийг шаардах хөөн хэлэлцэх хугацаа нэгдмэл байх зохицуулалтыг практикт харьцангуй нэгдмэл байдлаар тайлбарлан хэрэглэж байх тул хуулийн 77 дугаар зүйлийг практикт хүндрэл, бэрхшээл учруулаагүй гэж дүгнэв.

V.Иргэний хуулийн 78 дугаар зүйлийн хэрэгжилтийн үнэлгээ

Үнэлгээ хийх зүйл
78 дугаар зүйл. Хөөн хэлэлцэх хугацаа түр зогсох 78.1.Дараахь тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа түр зогсоно: 78.1.1.үүргийн гүйцэтгэлийг хойшлуулсан бол ийнхүү хойшлуулсан хугацаанд; 78.1.2.үүрэг гүйцэтгэгч үүргийг гүйцэтгэхээс татгалзсаныг үүрэг гүйцэтгүүлэгч хүлээн зөвшөөрсөн хугацаанд; 78.1.3.хөөн хэлэлцэх хугацаа дуусахын өмнөх зургаан сарын дотор гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас эрх бүхий этгээд шүүхэд хандах боломжгүй байсан, эсхүл шүүх үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжгүй болсон бол энэхүү нөхцөл байдал арилах хүртэл хугацаанд; 78.1.4.гэрлэгчдийн хоорондын шаардлага нь гэрлэлт хүчин төгөлдөр байх хугацаанд; 78.1.5.эцэг, эх, хүүхдийн хоорондын шаардлагын тухайд хүүхдийн насанд хүрэх хүртэл; 78.1.6.асран хамгаалагч, харгалзан дэмжигч, түүний асрамжинд байгаа хүмүүсийн хоорондын шаардлага нь асран хамгаалалт, харгалзан дэмжилт хүчин төгөлдөр байгаа хугацаанд; 78.1.7.тухайн харилцааг зохицуулж байгаа эрх зүйн актын үйлчлэлийг түдгэлзүүлсэн хугацаанд. 78.2.Энэ хуулийн 209 дүгээр зүйл энэ хуулийн 78.1.2-т хамаарахгүй. 78.3.Хөөн хэлэлцэх хугацааг түр зогсоох нөхцөл байдал арилсан үеэс эхлэн хугацааг үргэлжлүүлэн тоолно. Хэрэв үлдсэн хугацаа гурван сараас бага бол гурван сар хүртэл, хөөн хэлэлцэх хугацаа нь зургаан сараас бага бол үлдсэн хөөн хэлэлцэх хугацаагаар тус тус сунгана.

[102] Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Ерөнхий анги), 317 дахь тал.
[103] Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 05 сарын 19 өдрийн 1192 дугаартай магадлал.

78.4.Хэрэв иргэний эрх зүйн чадамжгүй буюу бүрэн бус чадамжтай этгээдэд хууль ёсны төлөөлөгч байхгүй бөгөөд хөөн хэлэлцэх хугацаа нь тэдгээрийн хууль ёсны ашиг сонирхолд харшлахаар бол тухайн этгээд иргэний эрх зүйн чадамжтай болсон, эсхүл хууль ёсны төлөөлөгч томилогдсоноос хойш зургаан сарын дотор хөөн хэлэлцэх хугацааг тоолохгүй.

Иргэний хуулийн 78 дугаар зүйлд хөөн хэлэлцэх хугацаа түр зогсох 7 үндэслэл нь зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар эрх бүхий байгууллагад хандах үед тулгарч болзошгүй саад бэрхшээлүүд юм. Хөөн хэлэлцэх хугацаа түр зогссон (suspension) бол ийнхүү түр зогсох болсон нөхцөл байдал арилсан үеэс үргэлжлүүлэн тоолох бол хөөн хэлэлцэх хугацаа тасалдах (recommencement) үед өмнө өнгөрсөн хугацааг тооцолгүйгээр хугацааг дахин шинээр тооцдог болно. Хөөн хэлэлцэх хугацааг түр зогсоох нөхцөл байдал арилсан үеэс эхлэн хугацааг үргэлжлүүлэн тоолно. Хэрэв үлдсэн хугацаа гурван сараас бага бол гурван сар хүртэл, хөөн хэлэлцэх хугацаа нь зургаан сараас бага бол үлдсэн хөөн хэлэлцэх хугацаагаар тус тус сунгана. Цаашлаад Хэрэв иргэний эрх зүйн чадамжгүй буюу бүрэн бус чадамжтай этгээдэд хууль ёсны төлөөлөгч байхгүй бөгөөд хөөн хэлэлцэх хугацаа нь тэдгээрийн хууль ёсны ашиг сонирхолд харшлахаар бол тухайн этгээд иргэний эрх зүйн чадамжтай болсон, эсхүл хууль ёсны төлөөлөгч томилогдсоноос хойш зургаан сарын дотор хөөн хэлэлцэх хугацааг тоолохгүй.[104]

78.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “үүрэг гүйцэтгэгч үүргийг гүйцэтгэхээс татгалзсаныг үүрэг гүйцэтгүүлэгч хүлээн зөвшөөрсөн хугацаанд” гэх нөхцөл байдал нь тодорхой шалтгаантайгаар тодорхой хугацаанд үүргээ гүйцэтгэх боломжгүй болсныг үүрэг гүйцэтгүүлэгч хүлээн зөвшөөрч тодорхой хугацаа олгох тохиолдол бөгөөд үүнд ИХ-ийн 209.1 дүгээр зүйлд заасан үүрэг гүйцэтгэхээс татгалзах тохиолдол хамаарахгүй талаар хуулийн 78.2 дахь хэсэгт тодорхой заажээ. Монгол Улсын ИХ-ийн 78.1.2 дахь үндэслэл нь ХБНГУ-ын Иргэний хуулийн 205 дугаар зүйлд тусгагджээ.

Шүүхийн практикийг тодруулахаар 50 гаруй шүүхийн шийдвэрийг судалж үзэхэд хөөн хэлэлцэх хугацаа дууссан эсхүл түр зогссон эсхүл тасалдсан эсэх дээр маргасан ихэнх тохиолдолд шүүхээс “уг хугацаа зогссон гэх үндэслэл хэргийн баримтаар тогтоогдоогүй, нэхэмжлэгч уг байдлаа нотолсон баримтыг шүүхэд ирүүлээгүй байна” гэх үндэслэлээр шийдвэрлэжээ. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгч хөөн хэлэлцэх хугацаа түр зогссон эсхүл тасалдсан гэж үзсэн бол түүнийг нотлох үүрэгтэй гэж үзэж байгааг үгүйсгэх боломжгүй юм.

Үүнээс гадна, ХБНГУ-ын Иргэний хуулийн хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэх үндэслэлийн нэгт “талууд хэлэлцээр явуулах (negotiation)” нөхцөл байдлыг багтаасан нь Монгол Улсын зохицуулалтаас ялгаатай байна. Хэлэлцээр нь шүүхийн маргаан үүсгэхээс сэргийлэх зорилготой тул хөөн хэлэлцэх хугацаанд баригдах нь зохимжгүй бөгөөд энэ тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэх нь хэлэлцээр амжилттай болоход чухал нөлөөтэй гэж үздэг байна.[105] Цаашлаад хэлэлцээр эхлүүлсэн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэх нь үүрэг гүйцэтгэгчтэй харилцан тохиролцохыг хүссэн үүрэг гүйцэтгүүлэгчид шударга.[106] Ялангуяа, арилжааны эрх зүйн харилцаанд чухал ач холбогдолтой байж болох учир дээрх төрлийн үндэслэлийг Монгол Улсын Иргэний хуульд нэмэлтээр оруулахыг зөвлөж байна.

[104] Иргэний хуулийн 78.4 дүгээр зүйл.
[105] MüKoBGB/Grothe, 10th ed. 2025, BGB § 203 Rn. 3, 4
[106] MüKoBGB/Grothe, 10th ed. 2025, BGB § 203 Rn. 3, 4

Хуулийн 82.4 дэх хэсэгт “Шүүх, арбитр хөөн хэлэлцэх хугацаа өнгөрснийг хүндэтгэн үзэх шалтгаантай гэж үзвэл уг хугацааг сэргээж, зөрчигдсөн эрхийг хамгаалж болно.” гэж заасан ч хүндэтгэн үзэх шалтгаан мөн эсэхийг шийдвэрлэх нь шүүгчийн бүрэн эрхэд хамаарч байна.Түүнчлэн, хуулийн 78 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан “хөөн хэлэлцэх хугацаа дуусахын өмнөх зургаан сарын дотор гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас эрх бүхий этгээд шүүхэд хандах боломжгүй байсан” гэх үндэслэл дэх “гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал”-д юуг хамааруулах нь хангалттай тодорхой биш байна. Тухайлбал, нэхэмжлэгч нь эрүүгийн хэрэгт яллагдан, чанга дэглэмтэй хорих ангид ял эдэлж байсантай холбоотойгоор шүүхэд нэхэмжлэл гаргаж чадаагүй тохиолдол гарсан байна.[107] Нэхэмжлэгч хоригдож байх хугацаандаа удаа дараа нэхэмжлэл гаргах боломжтой эсэхийг асуухад татгалзсан хариу авчээ.

ХБНГУ-ын Иргэний хуулийн 206 дугаар зүйлд “давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал”-ын улмаас хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэх үндэслэлийг тусгасан хэдий ч бусад хүндэтгэн үзэх шалтгааныг тухайн зүйлд багтаан тайлбарласан байна. Тухайлбал, хүнд өвчин, эмгэг108, хуулийн этгээд бүртгэлээс хасагдах109, эрх бүхий байгууллага, шүүхийн буруугаас шийдвэрийг хожуу гардан авах гэх мэт нөхцөл байдлыг хүндэтгэн үзэж болохуйц гэж, хариуцагчийн хаяг олдоогүй эсхүл хариуцагч дампуурсан эсхүл нэхэмжлэгч хорих ял эдэлж байсан зэрэг үйл баримтыг хэрэгт ач холбогдолгүй буюу хүндэтгэсэн үзэх шалтгаан бус гэж үзсэн байна.

Зарчмын хувьд үүрэг гүйцэтгэгчийн ашиг сонирхлын үүднээс “гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал”-ыг хэт өргөнөөр тодорхойлохгүй байх ёстой.[110] Иймд “тохиолдлын” шинж чанартай нөхцөл байдлыг хамааруулан авч үзэх нь зохилтой.[111] Хэдийгээр гэмт хэрэг үйлдэж, хорих ял авсан нь нэхэмжлэгчийн буруутай үйлдлийн улмаас үүдэлтэй бөгөөд уг гэмт хэргийг тохиолдлын шинж чанартай гэж үзэхгүй ч[112] ямар ч тохиолдолд алдаа эсхүл хүнд суртал гаргасан төрийн албан хаагчийн бурууг хэн нэгэнд хамаатуулж болохгүй. Иймд дээрх тохиолдлыг шүүхээс шийдвэрлэхдээ “нэхэмжлэгч хоригдож байх хугацаандаа удаа дараа нэхэмжлэл гаргах боломжтой эсэхийг асуухад татгалзсан хариу авсан” үйл баримтад дүгнэлт өгөх шаардлагатай байсан ч хангалттай үндэслэл бүхий дүгнэлт өгч чадаагүй байна.

VI.Иргэний хуулийн 79 дүгээр зүйлийн хэрэгжилтийн үнэлгээ

Үнэлгээ хийх зүйл
79 дүгээр зүйл. Хөөн хэлэлцэх хугацаа тасалдах 79.1.Тогтоосон журмаар нэхэмжлэл гаргасан, эсхүл үүрэг хүлээсэн этгээд эрх бүхий этгээдэд урьдчилгаа олгох, хүү төлөх, баталгаа гаргах буюу бусад хэлбэрээр шаардлагыг хүлээн зөвшөөрсөн бол хөөн хэлэлцэх хугацаа тасалдана.

[107] Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 12 сарын 14 өдрийн 210/ма2018/02460 дугаартай магадлал https://shuukh.mn/single_case/22230?start_date=&end_date=&id=2&court_cat=1&bb=1
[108] MüKoBGB/Grothe, 10th ed. 2025, BGB § 206 Rn. 9
[109] MüKoBGB/Grothe, 10th ed. 2025, BGB § 206 Rn. 9
[110] MüKoBGB/Grothe, 10th ed. 2025, BGB § 206 Rn. 1, 2
[111] MüKoBGB/Grothe, 10th ed. 2025, BGB § 206 Rn. 3, 4
[112] MüKoBGB/Grothe, 10th ed. 2025, BGB § 206 Rn. 9

79.2.Шүүхэд нэхэмжлэл гаргасан бол хөөн хэлэлцэх хугацааны тасалдал нь шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох, эсхүл хэрэг шийдвэрлэх ажиллагаа бусад хэлбэрээр дуусгавар болох хүртэл үргэлжилнэ.
79.3.Талууд эвлэрсэн, эсхүл хэрэг шийдвэрлэх ажиллагааг цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон бол талууд болон шүүхээс явуулсан сүүлийн ажиллагаа дуусгавар болсноор хөөн хэлэлцэх хугацааны тасалдал зогсоно.
79.4.Энэ хуулийн 79.3-т заасан тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг шинээр эхлэн тоолох боловч талуудын аль нэг нь хэрэг шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэхээр бол шаардлага гаргасны нэгэн адил үзэж хөөн хэлэлцэх хугацаа дахин тасалдана.
79.5.Эрх бүхий этгээд гаргасан шаардлагаасаа татгалзсан буюу шүүхийн шийдвэрээр шаардлагыг хэрэгсэхгүй болгосон бол хөөн хэлэлцэх хугацааг тасалдсан гэж үзэхгүй.
79.6.Эрх бүхий этгээд зургаан сарын дотор шинэ нэхэмжлэл гаргавал анхны шаардлага гаргасан өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг тасалдсанд тооцно. Энэ хугацаанд энэ хуулийн 78.1.3, 78.4-т заасан журам нэгэн адил үйлчилнэ.
79.7.Хөөн хэлэлцэх хугацаа тасалдсан бол өмнө өнгөрсөн хугацааг тооцохгүй, хугацааг дахин шинээр эхлэн тоолно.

Иргэний хуулийн 79 дүгээр зүйлд зааснаар дараах тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа тасалдах бөгөөд ийнхүү хөөн хэлэлцэх хугацаа тасалдсан бол өмнө өнгөрсөн хугацааг тооцохгүй, хугацааг дахин шинээр эхлэн тоолно. Үүнд:

- Тогтоосон журмаар нэхэмжлэл гаргасан, эсхүл
- Үүрэг хүлээсэн этгээд эрх бүхий этгээдэд урьдчилгаа олгох, хүү төлөх, баталгаа гаргах буюу бусад хэлбэрээр шаардлагыг хүлээн зөвшөөрсөн бол хөөн хэлэлцэх хугацаа тасалдана.

Хөөн хэлэлцэх хугацаа тасалдах нэг үндэслэл нь дээр зааснаас үүрэг бүхий этгээд үүргээ хүлээн зөвшөөрөх явдал юм. Үүний тулд үүрэг хүлээсэн этгээдээс үүргээ хүлээн зөвшөөрсөн аливаа зан үйлийг ойлгож болох бөгөөд хуульд заасан эсхүл заагаагүй олон хэлбэрээр илэрч болно.[113] Ийнхүү үүрэг гүйцэтгэгч үүрэг гүйцэтгэх ёстой гэдгээ үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээх зөвшөөрсөн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг тасалдсанд тооцож шинээр тооцох нь талуудын хоорондох итгэлцлийг хангах зорилготой.[114] Иймч учраас ИХ-ийн 82.2 дахь хэсэгт “Хөөн хэлэлцэх хугацаа өнгөрснийг үүрэг гүйцэтгэгч мэдээгүй байхдаа үүргийн гүйцэтгэлийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд үүргийн гүйцэтгэлээс татгалзах эрхгүй.” гэж, 82.3 дахь хэсэгт “Үүрэг гүйцэтгэгч нь хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн болохыг мэдээгүй байхдаа үүргээ гүйцэтгэсэн бол гүйцэтгэсэн үүргээ буцааж шаардах эрхгүй.” хэмээн тус тус заажээ.

Иргэний хуулийн 79.1 дүгээр зүйлд заасан “шаардлагыг хүлээн зөвшөөрөх” нь ИХ-ийн 466-д заасан тооцоо нийлэх гэрээ эсхүл өрийг хүлээн зөвшөөрөх зэргээс ялгаатай нь заавал мөрдөгдөх шинжтэй (binding) шаардахгүй.[115] Талууд үнийн дүн дээр санал зөрөлдсөн байж болох бөгөөд энэ тохиолдолд бусад хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ. Цаашлаад төлөх ёстой үүргээс хэсэгчлэн гүйцэтгэснээр төлснөөр үүргийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэж, тасалдсанд тооцно. Урьдчилгаа олгох, хүү төлөх, баталгаа гаргах нь үүргийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх нөхцөл байж болно. Гэвч ийнхүү хөөн хэлэлцэх хугацаа тасалдаж шинэ хугацаа тоолж эхэлснийг нотлох үүрэг нэхэмжлэгчид үүснэ.[116] Дээрхээс гадна хуульд заагаагүй бусад хэлбэрээр үүргийг хүлээн зөвшөөрч

[113] Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Ерөнхий анги), 323 дахь тал.
[114] MüKoBGB/Grothe BGB § 212 Rn. 6, 7
[115] MüKoBGB/Grothe BGB § 212 Rn. 6, 7
[116] MüKoBGB/Grothe, 10th ed. 2025, BGB § 212 Rn. 13

болох бөгөөд тухайн тохиолдол бүрт шийдэгдэж байна.[117] Шүүхийн практик дахь шаардлагыг хүлээн зөвшөөрсөн талаарх маргааныг тодруулбал:

> *...талууд 2012 оны 08 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан зээлийн гэрээний хугацаа нь 2014 оны 08 дугаар сарын 22-ны өдөр дууссан байх боловч хариуцагч нь сүүлийн байдлаар 2016 оны 03 дугаар сарын 24-ний өдөр зээлийн хүүгийн төлбөрт 240,000 төгрөг төлсөн энэ үеэс хөөн хэлэлцэх хугацааг тоолно. Иргэний хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэгт "...үүрэг хүлээсэн этгээд эрх бүхий этгээдэд ... хүү төлөх ...буюу бусад хэлбэрээр шаардлагыг хүлээн зөвшөөрсөн бол хөөн хэлэлцэх хугацаа тасалдана" гэж заасан бөгөөд мөн хуулийн 79.7 дахь хэсэгт "хөөн хэлэлцэх хугацаа тасалдсан бол өмнө өнгөрсөн хугацааг тооцохгүй, хугацааг шинээр тоолно" гэж заасан...*[118]
>
> *Хариуцагч Г.С нь нэхэмжлэгч байгууллагад 2019 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр гаргасан хүсэлтдээ ЗГ1905026573, ЗГ1905025400 тоот зээлийн гэрээний үүргийг төлж барагдуулна гэжээ.*
>
> *Мөн дээрх зээлийн гэрээний үүргээс 2019 оны 7 дугаар сарын 03, 2019 оны 10 дугаар сарын 31, 2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдрүүдэд төлөлт хийж байсан болох нь хүү тооцооллын хүснэгт болон талуудын тайлбараар нотлогдож байна.*
>
> *Иймд Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн 75.2.1-т зааснаар гэрээний үүрэгтэй холбоотой шаардлага гаргах гурван жил дууссан байна гэж үзэх боломжгүй байна...*[119]
>
> *4.4 Зохигчдын хэн аль нь Д х ХХК-ийн 2019 оноос хойшхи төлөгдөөгүй үлдсэн төлбөрийг дараа жилийн төлөх төлбөрт оруулж тооцон явсаар 2023 оны 03 дугаар сард талууд тооцооны үлдэгдлийн баталгаагаар нийт төлөх өр төлбөрийг баталгаажуулсан болохыг тайлбарласан.*
>
> *Хариуцагч Д х ХХК-ийн зүгээс шүүх хуралдаанд ...2019 онд үүссэн өр төлбөрийг шаардах хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэж тайлбарласан нь Иргэний хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1-т Тогтоосон журмаар нэхэмжлэл гаргасан, эсхүл үүрэг хүлээсэн этгээд эрх бүхий этгээдэд урьдчилгаа олгох, хүү төлөх, баталгаа гаргах буюу бусад хэлбэрээр шаардлагыг хүлээн зөвшөөрсөн бол хөөн хэлэлцэх хугацаа тасалдана гэж заасантай нийцэхгүй байна.*
>
> *Талууд өмнөх оны өр төлбөрийг дараа ондоо шилжүүлж явах замаар хөөн хэлэлцэх хугацаа тасалдаж явсаар 2023 оны 3 дугаар сард тооцоо нийлэх замаар өр төлбөртэй болохоо Д х ХХК нь илэрхийлсэн байна. Иймд хариуцагчаас гаргасан гэрээний үүрэг шаардах хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх татгалзал үндэслэлгүй*[120]*…*

---

[117] MüKoBGB/Grothe, 10th ed. 2025, BGB § 212 Rn. 15-18

[118] Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 08 сарын 25 өдрийн 210/МА2023/01660 дугаартай магадлал, https://shuukh.mn/single_case/28151?start_date=&end_date=&id=2&court_cat=1&bb=

[119] Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 08 сарын 19 өдрийн 102/ШШ2020/02337 дугаартай шийдвэр, https://shuukh.mn/single_case/99762?start_date=&end_date=&id=1&court_cat=1&bb=

[120] Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 09 сарын 26 өдрийн 101/ШШ2023/04178 дугаартай шийдвэр, https://shuukh.mn/single_case/129071?start_date=&end_date=&id=1&court_cat=1&bb=

10. Хэрэгт авагдсан нотлох бариmтуудаас үзэхэд нэхэмжлэгч “С в” ХХК нь “К” ХХК-тай бетон зуурмаг нийлүүлэх гэрээг амаар байгуулж, 2015 оны 6 дугаар сараас бетон зуурмаг нийлүүлсэн байх бөгөөд гэрээний дагуу нэхэмжлэгч нь 129,125,000 төгрөгийн үнэ бүхий 911 м3 бетон зуурмаг бэлтгэн нийлүүлсэн, хариуцагч нь үнээс 52,970,000 төгрөгийг төлсөн. Улмаар гэрээний талууд 2017.01.26-ны өдөр тооцоо нийлж акт үйлдэн, 2015.06.25-ны өдрөөс 2017.01.26-ны өдрийг дуусталх хугацааны өглөг, авлагын үлдэгдлийг 76,155,000 төгрөг болохыг баталж, өрийн үлдэгдлийг данс буюу бэлнээр нэхэмжлэн авахаар тохиролцсон байна.

Анхан шатны шүүх хуулийн дээрх зохицуулалтыг маргаанд зөв тайлбарлан хэрэглэж, ...зохигчийн 2017.01.26-ны өдрийн тооцоо нийлсэн актаар зуурмагийн үлдэгдэл 76,155,000 төгрөгийг төлөх хугацааг тухайлан тохироогүй тул Иргэний хуулийн 208 дугаар зүйлийн 208.2-т “Үүрэг гүйцэтгэх хугацаа тогтоогоогүй буюу болзол тавиагүй, үүргийн шинж чанараас шалтгаалан түүнийг тодорхойлох боломжгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг хэдийд ч шаардах эрхтэй, үүрэг гүйцэтгэгч нэн даруй гүйцэтгэх үүрэгтэй байна” гэж зааснаар нэхэмжлэгч “С в” ХХК нь үүргийг хэдийд ч хариуцагчаас шаардах эрхтэй, харин хариуцагч нь мөн зүйлийн 208.3-т заасны дагуу үүргийн гүйцэтгэлийг шаардсан өдрөөс хойш 10 хоногийн дотор төлөх үүрэг хүлээнэ гэж дүгнэсэн нь үндэслэлтэй байна.

Тодруулбал, хэргийн бариmтаар нэхэмжлэгч нь үлдэгдэл төлбөрийн 76,155,000 төгрөгийг төлөхийг шаардаж 2021.06.21-ний өдөр хариуцагчид шаардлага хүргүүлсэн нь тогтоогдсон, анхан шатны шүүх ...хуульд зааснаар хариуцагч нь төлбөрийг шаардсанаас хойш 10 хоногийн дотор буюу 2021.07.01-ний өдрийн дотор гүйцэтгэх ёстой байсан, энэ өдрөөс хугацааг тоолоход хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болоогүй гэж дүгнэн, нэхэмжилсэн төлбөрийн 76,155,000 төгрөгийг хариуцагч “К” ХХК-аас гаргуулж нэхэмжлэгчид олгохоор шийдвэрлэсэн нь хуульд нийцжээ.

Дээрх шийдвэрүүдээс дүгнэвэл, хөөн хэлэлцэх хугацаа тасалдсан эсэхийг дүгнэхдээ шүүхээс ИХ-ийн 79.1-ийг харьцангуй нэгдмэл байдлаар тайлбарлаж байх боловч сүүлийн хэргийн хувьд ямар учраас тооцоо нийлэх актад хөөн хэлэлцэх хугацаа үйлчлэхгүй мэт тайлбарлан хэрэглэсэн нь тодорхой бус байна.

Дүгнэвэл, талууд тооцоо нийлэх замаар өр төлбөрийг хүлээн зөвшөөрч буй гэдгээ илэрхийлж баталгаажуулсан бол ИХ-ийн 79.1-т заасан эрх зүйн үр дагаврыг үүсгэхэд чиглэсэн байх бөгөөд энэ тохиолдолд тооцоо нийлсэн өдрөөс 3 жилийн хугацааг тоолох нь зүйтэй гэж үзэж байна.

Харин тогтоосон журмаар нэхэмжлэл гаргана гэдэгт ИХШХШтХ-ын дагуу нэхэмжлэлийг харъяалах шатны шүүхэд эсхүл Арбитрын тухай хуулийн дагуу арбитрт нэхэмжлэл гаргахыг хэлнэ. Шүүхэд нэхэмжлэл гаргасан бол хөөн хэлэлцэх хугацааны тасалдал нь шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох[121], эсхүл хэрэг шийдвэрлэх ажиллагаа бусад хэлбэрээр дуусгавар болох хүртэл үргэлжилнэ. Талууд эвлэрсэн, эсхүл хэрэг шийдвэрлэх ажиллагааг цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон бол талууд болон шүүхээс явуулсан сүүлийн ажиллагаа дуусгавар болсноор хөөн хэлэлцэх хугацааны тасалдал зогсоно.

[121] Иргэний хуулийн 79.5.Эрх бүхий этгээд гаргасан шаардлагаасаа татгалзсан буюу шүүхийн шийдвэрээр шаардлагыг хэрэгсэхгүй болгосон бол хөөн хэлэлцэх хугацааг тасалдсан гэж үзэхгүй.

Иргэний хуулийн 79 дүгээр зүйлд зааснаар тогтоосон журмаар нэхэмжлэл гаргасан талаарх шүүхийн практикийг тодруулбал:

> *....Шүүх хөөн хэлэлцэх хугацааг тооцож үзэхэд зээлийн гэрээний үндсэн хугацаа 2018.4.14-ний өдөр дуусаж, энэ өдрөөс нэхэмжлэгчийн шаардах эрх үүсэж байна. Шаардах эрх үүссэн өдрөөс Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн 75.2.1-т заасан 3 жилийн хугацааг тоолоход 2021.4.14-ний өдөр дуусах байсан боловч Иргэний хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1-т "Тогтоосон журмаар нэхэмжлэл гаргасан, эсхүл үүрэг хүлээсэн этгээд эрх бүхий этгээдэд урьдчилгаа олгох, хүү төлөх, баталгаа гаргах буюу бусад хэлбэрээр шаардлагыг хүлээн зөвшөөрсөн бол хөөн хэлэлцэх хугацаа тасалдана, 79.2-т "Шүүхэд нэхэмжлэл гаргасан бол хөөн хэлэлцэх хугацааны тасалдал нь шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох, эсхүл хэрэг шийдвэрлэх ажиллагаа бусад хэлбэрээр дуусгавар болох хүртэл үргэлжилнэ" гэж зааснаар нэхэмжлэгч А банк зээлдэгчийг эрэн сурвалжлуулах тухай хүсэлтийг 2020 оны 8 дугаар сарын 04-ний өдөр шүүхэд гаргаснаар хөөн хэлэлцэх хугацаа тасалдсан гэж үзнэ. Иймд хариуцагчийн хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн, нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй гэсэн тайлбар нь үндэслэлгүй байна гэж үзэж нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн болно...*[122]

> *Хэрэгт авагдсан бариmтаар хариуцагч нь худалдан авсан бүтээгдэхүүний үнээс 4,000,000 төгрөгийг 2016.10.11-ний өдөр төлсөн тул шаардах эрхийн хугацаа 2019.10.11-нд дуусахаар байх бөгөөд нэхэмжлэгч нь 2019.10.10-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх дэх Эвлэрүүлэн зуучлагчид хандаж, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулсан боловч хариуцагч "Б д" ХХК-ийн захирал Ө.Ганболд хамтарсан уулзалтад хүрэлцэн ирээгүй үндэслэлээр Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй болсон гэж үзэж дуусгавар болгосон болох нь Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх дэх Эвлэрүүлэн зуучлагч Н.Оюунчимэгийн Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа дуусгавар болгосон тухай №358 дугаартай тэмдэглэлээр тогтоогджээ.*

> *Хариуцагч худалдан авсан эд хөрөнгийн үнийг төлөөгүй үндэслэлээр нэхэмжлэгч нь Эвлэрүүлэн зуучлагчид хандсаныг Иргэний хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1-д заасан тогтоосон журмаар нэхэмжлэл гаргасан гэж үзэх тул Эвлэрүүлэн зуучлагчид хандсан 2019.10.10-ны өдрөөс хөөн хэлэлцэх хугацаа тасалдана....*[123]

Дээр дурдсанаар шүүхэд нэхэмжлэл гаргасан боловч шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан эсхүл хариуцагчийг эрэн сурвалжлуулах тухай хүсэлт гаргасан эсхүл эвлэрүүлэн зуучлагчид хандсан боловч эвлэрүүлэн зуучлал амжилтгүй болж ажиллагаа дуусгавар болсон тохиолдлууд нь ИХ-ийн 79.1-т заасан хөөн хэлэлцэх хугацаа тасалдах эрх зүйн үр дагаврыг үүсгэнэ гэж үзэж байна. Хуулийн 79.3 дахь хэсэгт "Талууд эвлэрсэн, эсхүл хэрэг шийдвэрлэх ажиллагааг цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон бол талууд болон шүүхээс явуулсан сүүлийн ажиллагаа дуусгавар болсноор хөөн хэлэлцэх хугацааны тасалдал зогсоно" гэж заасан бөгөөд хэрэг шийдвэрлэх ажиллагааг цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон гэдэгт ИХШХШтХ-ийн 65 дугаар зүйлийн дагуу нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах, 117 дугаар зүйлийн дагуу хэргийг хэрэгсэхгүй

---

[122] Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 10 сарын 27 өдрийн 103/ШШ2022/00446 дугаартай шийдвэр, https://shuukh.mn/single_case/123765?daterange=2022-01-01%20-%202023-05-01&id=1&court_cat=1&bb=1

[123] Улсын дээд шүүхийн 2022 оны 06 сарын 16 өдрийн 001/ХТ2022/00742 дугаартай тогтоол, https://shuukh.mn/single_case/9566?start_date=&end_date=&id=3&court_cat=1&bb=

болгох, 100.2 дугаар зүйлийн дагуу нэхэмжлэлийг буцаасан зэрэг хамаарна гэж[124], гэвч нэхэмжлэлийн бүрдүүлбэр дутуу, харъяаллын бус шүүхэд эсхүл өөр байгууллагад гаргасан гэх зэрэг тогтоосон журам зөрчсөн тохиолдолд 79.1-т хамаарахгүй гэж тус тус тайлбарлажээ.[125]

ИХШХШтХ-ийн 117.1-т “Энэ хуулийн 65.1.9-д заасан үндэслэл иргэний хэрэг үүсгэснээс хойш, 65.1.1, 65.1.3-65.1.8, 65.1.10-д заасан үндэслэл хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх үед тогтоогдвол хэргийг хэрэгсэхгүй болгоно. Энэ тухай шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.” гэж заасан бөгөөд үүнд:

- 65.1.1.энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан хэргийн харьяалал зөрчсөн;
- 65.1.3.шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлүүлэх талаар хуульд заасан журмыг нэхэмжлэгч зөрчсөн ба энэ журмыг хэрэглэх боломжтой байвал;
- 65.1.4.нэхэмжлэгч нь эрх зүйн бүрэн чадамжгүй этгээд байвал;
- 65.1.5.нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан;
- 65.1.6.нэхэмжлэлд дурдсан үйл баримт, зохигчийн гэм буруугийн талаар хуулийн хүчин төгөлдөр шүүхийн болон арбитрын шийдвэр, эсхүл нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан, түүнчлэн хэргийг хэрэгсэхгүй болгосон хуулийн хүчин төгөлдөр шүүхийн болон арбитрын шийдвэр буюу шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж байгаа;
- 65.1.7.зохигчийн маргаж байгаа зүйл ба түүний үндэслэлийн талаархи өөр хэргийг шүүх шийдвэрлэж байгаа;
- 65.1.8.уг нэхэмжлэлтэй холбоотой хэргийг эрүүгийн журмаар шалгаж байгаа;
- 65.1.10.зохигч болох хүн нас барсан, хуулийн этгээд татан буугдсан тохиолдолд маргаж байгаа шаардлага буюу маргаантай үүрэг нь эрх залгамжлагчид шилжээгүй зэрэг хамаарна.

Иймд дээрх тайлбарыг үндэслэвэл дараах тохиолдолд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан бол хөөн хэлэлцэх хугацаа тасалдахааргүй байна. Үүнд:

- 65.1.2.энэ хуулийн 14, 15, 16, 19 дүгээр зүйлд заасан шүүхийн харьяалал зөрчсөн;
- 65.1.9.хариуцагчийн хаяг тодорхойгүй;
- 65.1.11.энэ хуулийн 62 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй байвал.

Гадаад улсын жишгийг судалбал, ХБНГУ-ын 2002 оны Иргэний хуулийн шинэчлэлтээс өмнө хуульд заасан арга хэмжээг авах (legal action) тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг тасалдсан гэж үзэж, хугацааг дахин тоолдог байсан боловч энэ нь төдийлөн ач холбогдолгүй талаар шүүмжлэгдсэний улмаас дээрх тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа түр зогсохоор Иргэний хуульд өөрчлөлт оруулжээ.[126] Хөөн хэлэлцэх хугацаа тасалдах дээрх үндэслэл нь үүрэг гүйцэтгүүлэгч хуульд заасан журмаар процесс ажиллагаа эхлүүлсэн байх үед хөөн хэлэлцэх хугацаа дуусахаас хамгаалах зорилготой бөгөөд энэхүү зорилгод хөөн хэлэлцэх хугацаа тасалдах бус түр зогсох зохицуулалт хангалттай гэж үзсэн байна.[127] Иймд 2002 оноос хойш хуульд заасан арга хэмжээг авах тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа түр зогсох үр дагавартай байгаа бөгөөд ХБНГУ-ын Иргэний хуулийн 204 дүгээр зүйлд дараах хэд хэдэн төрлийн хуульд заасан арга хэмжээг дурджээ. Хуульд заасан арга хэмжээ (legal action) гэдэгт шүүхэд нэхэмжлэл

[124] Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Ерөнхий анги), 323 дахь тал.
[125] Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Ерөнхий анги), 323 дахь тал.
[126] MüKoBGB/Grothe, 10th ed. 2025, BGB § 204 Rn. 1, 2
[127] MüKoBGB/Grothe, 10th ed. 2025, BGB § 204 Rn. 1, 2

гаргах, сөрөг нэхэмжлэл гаргах, төрийн эсхүл эрх бүхий маргаан таслах зөвлөлд хүсэлт гаргах, үнэлгээний ажиллагааг эхлүүлэх, дампуурлын хэрэгт нэхэмжлэл гаргах, урьдчилсан шийдвэрлэх ажиллагаа шаардлагатай бол ийнхүү журмын дагуу эхлүүлэх, арбитрт хандах, харъяалал нь тодорхойгүй тул ийнхүү тодорхой болгохоор дээд шүүхэд хандах зэрэг олон төрлийн арга хэмжээ хамаарч байна. Энэ нь Монгол Улсын ИХ-ийн 79.1 дэх хэсэг дэх “тогтоосон журмаар нэхэмжлэл гаргах”-тай адил агуулгыг багтааж байгаа боловч өөр эрх зүйн үр дагаврыг үүсгэхээр байна. Хуульд заасан арга хэмжээг эхлүүлж, процесс ажиллагаа дуусаж, шийдвэр гарснаас 6 сарын дараа хөөн хэлэлцэх хугацааг түр зогссон үеэс үргэлжлүүлэн тооцно.[128]

Харин тус улсын Иргэний хуулийн 212 дугаар зүйлд хөөн хэлэлцэх хугацааг тасалдах 2 үндсэн тохиолдлыг дурдсан бөгөөд нэгдүгээрт, үүрэг гүйцэтгэгч шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, хоёрдугаарт шүүхийн эсхүл захиргааны шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг эхлүүлсэн зэрэг болно. Шүүхийн болон захиргааны шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг эхлүүлсэн (enforcement action) гэдэг нь шийдвэр гүйцэтгэлээр хязгаарлагдаж байна.[129] Үүрэг гүйцэтгүүлэгчийн шийдвэр гүйцэтгэл эхлүүлэх шаардлага нь зохих журмын дагуу шийдвэрлэгдэж маргаангүй болсон гэж үзсэнтэй холбоотойгоор хөөн хэлэлцэх хугацааг тасалдсан гэж үзэж шинээр тоолох нь зүйтэй гэж үзсэн байна.[130]

Дүгнэвэл, ИХ-ийн 79.1 дүгээр зүйлд заасан ‘тогтоосон журмаар нэхэмжлэл гаргасан” гэх үндэслэл нь хөөн хэлэлцэх хугацаа түр зогсох үндэслэлд хамаарч болох бөгөөд энэ нь үүрэг гүйцэтгүүлэгчийн эрх зүйн байдлыг доройтуулахгүйгээр, талуудын хоорондох тэнцвэртэй байдлыг хадгалахад нөлөөтэй байж болохоор байна.

VII.Иргэний хуулийн 80 дугаар зүйлийн хэрэгжилтийн үнэлгээ

Үнэлгээ хийх зүйл
80 дугаар зүйл. Хуулийн хүчин төгөлдөр шаардлагын хөөн хэлэлцэх хугацаа 80.1.Тухайн шаардлагад хөөн хэлэлцэх богиносгосон хугацаа тогтоосон байсан ч шүүхийн шийдвэрийн үндсэн дээр уг шаардлага хуулийн хүчин төгөлдөр бол түүний хөөн хэлэлцэх хугацаа арван жил байна. 80.2.Хуулийн хүчин төгөлдөр шаардлага нь дахин давтагдах, ирээдүйд хийгдэх үүрэгт хамааралтай бол тухайн үүрэгт тогтоогдсон хөөн хэлэлцэх богиносгосон хугацаа хуулийн хүчин төгөлдөр байна.

Иргэний хуулийн 80.1 дэх хэсэгт “тухайн шаардлагад хөөн хэлэлцэх богиносгосон хугацаа тогтоосон байсан ч шүүхийн шийдвэрийн үндсэн дээр уг шаардлага хуулийн хүчин төгөлдөр бол түүний хөөн хэлэлцэх хугацаа арван жил байна” гэж, 80.2 дахь хэсэгт “хуулийн хүчин төгөлдөр шаардлага нь дахин давтагдах, ирээдүйд хийгдэх үүрэгт хамааралтай бол тухайн үүрэгт тогтоогдсон хөөн хэлэлцэх богиносгосон хугацаа хуулийн хүчин төгөлдөр байна.” гэж заасан. ИХ-ийн 80.1 дэх хэсэгт шүүхийн шийдвэр гарсан бол хөөн хэлэлцэх хугацаа 10 жил байх зохицуулалт нь ХБНГУ-ын Иргэний хуулийн 197.3 дахь хэсэгт заасан “хуулийн хүчин төгөлдөр шаардлага”, мөн 197. 4 дэх хэсэгт заасан “шийдвэр гүйцэтгэл шууд явуулах боломжтой шаардлага”-ын хөөн хэлэлцэх хугацааг 30 жилээр тогтоосон байгаатай адил байна. 197.3 дахь хэсэгт заасан хуулийн хуулийн хүчин төгөлдөр шаардлагад гадаад эсхүл дотоодын шүүх, арбитр, эрх бүхий байгууллагын хүчин төгөлдөр шийдвэр бүхий шаардлага хамаарахаар[131] байна.

[128] MüKoBGB/Grothe, 10th ed. 2025, BGB § 204 Rn. 1, 2
[129] MüKoBGB/Grothe, 10th ed. 2025, BGB § 204 Rn. 1, 2
[130] MüKoBGB/Grothe, 10th ed. 2025, BGB § 212
[131] MüKoBGB/Grothe, 10th ed. 2025, BGB § 197 Rn. 15, 16

Холбогдох зохицуулалтыг хэрэглэх практик харьцангуй нэгдмэл байх боловч нэгэн эдрээтэй хэргийн хүрээнд 3 шатны шүүхээс хөөн хэлэлцэх хугацаатай холбоотойгоор 3 өөр дүгнэлт өгсөн нь анхаарал татаж байна. Тодруулбал, төрийн албан хаагчийн удаа дараагийн буруутай үйл ажиллагааны улмаас гэм хор учирсан бөгөөд нийт хоёр шүүхийн шийдвэрээр нийт 11,487,905 төгрөгийг нэхэмжлэгчид олгохоор шийдвэрлэсэн. Дээрх шийдвэрүүдийг үндэслэж төрөөс хохирлыг тус бүр барагдуулсан бөгөөд буцаан шаардах эрх төрд шилжсэн. УДШ-ээс дээрх маргааныг дараах байдлаар шийдвэрлэжээ.[132]

> *...17.Анхан шатны шүүх нэхэмжлэгчийн шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацааг Улсын Дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх хуралдааны 2015.06.22-ны өдрийн 158 дугаар тогтоол гарсан үеэс, давж заалдах шатны шүүх Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 101/ШШ2016/01355 дугаар шийдвэр гарсан өдрөөс эхэлж тоолно гэж өөр өөрөөр дүгнэсэн, эдгээр дүгнэлтийн аль аль нь үндэслэлгүй болжээ.*
>
> *Учир нь дээр дурдсан шүүхийн хоёр удаагийн шийдвэрийн дагуу нийт 11,487,905 төгрөгийг олгохоор шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрт заасан мөнгийг Ө.Н-д төлснөөр гэм хорыг арилгасан гэж үзэх бөгөөд энэ нөхцөлд хохирлыг буруутай этгээдээс шаардах эрх үүснэ.*
>
> *18.Харин Улсын дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүхийн 2015 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 158 дугаар тогтоолын дагуу Ө.Нд 2014.06.17-ны өдрөөс 2014.12.04-ний өдөр хүртэлх хугацааны цалин, нөхөн олговорт 3,456,666 төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэсний дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017.11.20-ны өдрийн А/277 дугаар тушаалаар хөрөнгийг шийдвэрлэж, улмаар 2017.12.07-ны өдөр олгосон нь хэрэгт авагдсан бариmтаар тогтоогдсон байх тул энэ хугацаанаас хөөн хэлэлцэх хугацааг тоолбол 5 жилийн хугацаа 2022.12.07-ны өдөр дууссан байна. Нэхэмжлэгч шүүхэд 2024.01.15-ны өдөр нэхэмжлэл гаргасан, иймээс хариуцагч Иргэний хуулийн 82 дугаар зүйлийн 82.1-д зааснаар төлбөр төлөхөөс татгалзах эрхтэй тул энэхүү 3,456,666 төгрөгийн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгоно.*
>
> *19.Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 101/ШШ2016/01355 дугаар шийдвэрээр Ө.Нгийн ажилд эгүүлэн тогтоох хүртэлх ажилгүй байсан 2014.12.05-ны өдрөөс 2015.12.18-ны өдрийг хүртэл хугацааны олговорт 8,031,239 төгрөгийг гаргуулж шийдвэрлэсний дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021.04.08-ны өдрийн А/80 дугаар "Хөрөнгө хуваарилах тухай" тушаал гарч Ө.Нд мөнгийг олгож, гэм хорыг бүрэн арилгаснаар төрд уг хэмжээний хохирол бодитой учирсан байна. Тийм учраас энэ үеэс дээрх 8,031,239 төгрөгийг шаардах эрх үүсэх бөгөөд нэхэмжлэгч хуульд заасан таван жилийн хугацаанд нэхэмжлэлээ гаргасан тул дээрх мөнгийг хариуцагчаас гаргуулж нэхэмжлэгчид олгох нь Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д заасантай нийцнэ.*

Энэ хэргийн хүрээнд УДШ-ээс хариуцагчийн өмнөөс иргэнд учруулсан гэм хорыг төр барагдуулсан өдрөөс богиносгосон хугацаагаар хөөн хэлэлцэх хугацааг тоолох ёстой гэж үзсэн нь үндэслэлтэй байж болох юм.

---

[132] Улсын дээд шүүхийн 2024 оны 12 сарын 10 өдрийн 001/ХТ2024/00292 дугаартай тогтоол, https://shuukh.mn/single_case/10668?daterange=2024/01/01%20-%202024/12/14%20&id=3&court_cat=1&bb=1

Гэвч төрөөс хохирлыг төлснөөр гэм хорыг арилгасан гэж үзэж, энэ нөхцөлд хохирлыг буруутай этгээдээс шаардах эрх үүсэх ба уг шинэ шаардах эрхэд хөөн хэлэлцэх хугацааг шинээр тоолох ёстой гэсэн логик нь зарим төрлийн харилцаа, тухайлбал даатгалын маргаан, даатгагчийн буцаан шаардах эрхэд сөргөөр нөлөөлж болзошгүй. ХБНГУ-ын Иргэний хуулийн 197 дугаар зүйл хуулийн хүчин төгөлдөр шаардлагын хөөн хэлэлцэх хугацаа 30 жил байхаар заасан талаар өмнө дурдсан. Тайлбарт[133] зааснаар уг шаардах эрхээ бусдад шилжүүлсэн нь 30 жилийн хөөн хэлэлцэх хугацаанд нөлөөлөх ёсгүй гэжээ.

VIII.Ерөнхий дүгнэлт, санал

Хуулийн 75 дугаар зүйлд хэлцэл хүчин төгөлдөр бусад тооцуулахад хөөн хэлэлцэх хугацааг тооцох зохицуулалт байхгүйн улмаас практикт энэ тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаагүй эсхүл хугацаатай мэт шүүхийн шийдвэрүүдэд харилцан адилгүй байдлаар шийдвэрлэж байна. Хэлцэл хүчин төгөлдөр бусад тооцуулах эрх нь мөн чанарын хувьд шаардах эрх биш ба ИХ-ийн 186.1-ийн тодорхойлолтод багтдаггүй харьцангуй эрх тул энд хөөн хэлэлцэх хугацаа шууд тооцох байдлаар хуулийн 75 дугаар зүйлийг хэрэглэх боломжгүй байна.

Түүчнлэн харьцуулан судалсан ХБНГУ-ын Иргэний хуульд ердийн, тусгай, уртасгасан зэрэг нийт 3 төрлийн хөөн хэлэлцэх хугацааг шаардах эрхийн ач холбогдлыг нь үндэслэн тодорхойлсон байх бөгөөд тус бүрд холбогдох хөөн хэлэлцэх хугацаа тоолж эхлэх зохицуулалт харилцан адилгүй байна. Тухайлбал, бусдын амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүндэд учруулсан гэм хорын шаардлага 30 жилийн хөөн хэлэлцэх хугацаатай байхаар тусгасан байх ба гэм хор учруулсан үеэс хөөн хэлэлцэх хугацааг тоолно. Өөрөөр хэлбэл, энэ тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгчийн мэдэх элемент төдийлөн ач холбогдолгүй. Цаашлаад тус улсын 2002 оны Иргэний хуулийн шинэчлэлийн дараагаар “хуульд заасан арга хэмжээ”-г авах тухайлбал шүүх, арбитр нэхэмжлэл гаргах нөхцөл байдлыг хөөн хэлэлцэх хугацааг тасалдуулах бус түр зогсоох үр дагавартай байхаар өөрчилсөн байна. Түүнчлэн талууд хэлэлцээр эхлүүлэх нь хөөн хэлэлцэх хугацаа түр зогсох эрх зүйн үр дагавар үүсгэж байгаа нь практикт ач холбогдолтой зохицуулалт байхаар байна.

--oOo--

[133] MüKoBGB/Grothe, 10th ed. 2025, BGB § 197 Rn. 21, https://beck-2online-1beck-1de-19pf9wt7c1d4a.han.sub.uni-goettingen.de/?vpath=bibdata%2Fkomm%2FMuekoBGB_10_Band1%2FBGB%2Fcont%2FMuekoBGB%2EBGB%2Ep197%2EglII%2Egl4%2Eglf%2Ehtm

НОМ ЗҮЙ

Монгол хэл дээрх

Хууль тогтоомж

1. Монгол Улсын Иргэний хууль, 2002.
2. Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002.
3. Улсын бүртгэлийн ерөнхий хууль /2018 он/
4. Хуулийн этгээд улсын бүртгэлийн тухай хууль /2018 он/
5. .Компанийн тухай хууль /2014 он/
6. Хоршооны тухай хууль /2021 он/
7. Төр сүм хийдийн харилцааны тухай хууль /1993 он/
8. Төрийн бус байгууллагын тухай хууль /1997 он/
9. Нөхөрлөлийн тухай хууль /1995 он/
10. Төв банк /Монгол банк/-ны тухай хууль /1996 он/

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Ерөнхий анги) Хууль зүй үндэсний хүрээнлэнгийн 2021 оны “Монгол Улсын хууль тогтоомж дахь хуулийн этгээдийн ойлголт, нэр томъёоны хэрэглээ” судалгааны тайлан
2. Д. Батжаргал, Монголын иргэний эрх зүйн үндэс. Улаанбаатар: Хууль эрх зүйн академи. (2018).
3. Хууль зүй үндэсний хүрээнлэнгийн 2021 оны “Хуулийн этгээдийн эрхгүй байгууллага” судалгааны тайлан
4. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн сан
5. Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, МИМ ХХК УБ 2010 он
6. Улсын Дээд шүүхийн албан ёсны тайлбар, тогтоолууд
7. Иргэний эрх зүйн үндсэн асуудал, Д.Наранчимэг, УБ 1999 он.
8. Б. Гантөмөр, Монголын иргэний эрх зүйн онол. Улаанбаатар: Хууль зүйн судалгааны хүрээлэн. (2020).
9. С.Нарантуяа, Иргэний оршин суугаа газрын эрх зүйн ач холбогдол. Монголын хууль зүйн тойм, 5(2), 45-56. (2019).

Шүүхийн шийдвэр

1. УДШ-ийн 2019 оны 01 сарын 15-ны өдрийн 001/ХТ2019/00064 дугаартай тогтоол.
2. УДШ-ийн 2019 оны 02 сарын 19 өдрийн 001/ХТ2019/00230 дугаартай тогтоол.
3. УДШ-ийн 2018 оны 11 сарын 22-ны өдрийн 001/ХТ2018/01680 дугаартай тогтоол.
4. УДШ-ийн 2022 оны 01 сарын 18-ны өдрийн 001/ХТ2022/00087 дугаартай тогтоол.
5. УДШ-ийн 2023 оны 06 сарын 22 өдрийн 001/ХТ2023/00129 дугаартай тогтоол.
6. УДШ-ийн 2023 оны 06 сарын 22 өдрийн 001/ХТ2023/00129 дугаартай тогтоол.
7. УДШ-ийн 2024 оны 12 сарын 10 өдрийн 001/ХТ2024/00292 дугаартай тогтоол.

8. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 01 сарын 17 өдрийн 212 дугаартай магадлал.
9. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 05 сарын 19 өдрийн 1192 дугаартай магадлал.
10. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 12 сарын 14 өдрийн 210/ма2018/02460 дугаартай магадлал.
11. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 08 сарын 25 өдрийн 210/МА2023/01660 дугаартай магадлал.
12. Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 10 сарын 27 өдрийн 103/ШШ2022/00446 дугаартай шийдвэр.
13. Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 06 сарын 19 өдрийн 102/ШШ2020/02006 дугаартай шийдвэр.
14. Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 08 сарын 19 өдрийн 102/ШШ2020/02337 дугаартай шийдвэр.
15. Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 09 сарын 26 өдрийн 101/ШШ2023/04178 дугаартай шийдвэр.
16. Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 03 сарын 14 өдрийн 184/ШШ2019/0070 дугаартай шийдвэр.

Гадаад хэл дээрх

Хууль тогтоомж

1. Bürgerliches Gesetzbuch [BGB]. (1896). German Civil Code. Retrieved from https://www.gesetze-im-internet.de/bgb/
2. Code civil [French Civil Code]. (1804). Legifrance. Retrieved from https://www.legifrance.gouv.fr/
3. Cassation Civile, Clément Bayard v. Coquerel, France, Cour de cassation, 3 août 1915. Available in: Poplawski, L. (1933). Le droit de propriété et l'abus de droit. Paris: Dalloz.
4. Japanese Civil Code [Minpō]. (1896, amended). Ministry of Justice, Japan. Retrieved from https://www.japaneselawtranslation.go.jp/
5. Japanese Civil Code (2023). Tokyo: Ministry of Justice Japan.
6. Schweizerisches Zivilgesetzbuch [ZGB]. (1907). Swiss Civil Code. Retrieved from https://www.fedlex.admin.ch/
7. Mazeaud, D. (2010). Droit civil: Les obligations. Paris: Dalloz.
8. Münchener Kommentar zum BGB (2021). München: Beck Verlag.

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. MüKoBGB/Grothe, 10th ed. 2025, BGB.
1. Prosser, W. L. (1971). Handbook of the Law of Torts (4th ed.). St. Paul: West Publishing Co.
2. Restatement (Second) of Torts. (1979). American Law Institute.
3. Carbonnier, J. (1999). Droit civil. Paris: PUF.
4. Chemerinsky, E. (2017). Constitutional Law. New York: Wolters Kluwer.
5. Cornu, G. (2004). Droit civil: Introduction. Paris: Montchrestien.
6. Palandt, O. (2017). Bürgerliches Gesetzbuch. München: C.H. Beck.
7. Posner, R. A. (2014). The Problems of Jurisprudence. Cambridge, MA: Harvard University Press.

8. Sakurai, K. (2018). Comparative Civil Law Systems in East Asia. Tokyo: University of Tokyo Press.
9. Takeuchi, H. (2015). Japanese Civil Law: Its Development and Influences. Journal of Asian Law, 18(1), 33-55.
10. Zimmermann, R. (1996). The Law of Obligations: Roman Foundations of the Civilian Tradition. Oxford: Oxford University Press.